



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



# 2020-2021 оны хичээлийн ЖИЛИЙН ТАЙЛАН



Улаанбаатар хотын төвд байрлах МУСТ-ийн баруунд оршдог хичээлийн барилдаа нь 2020-2021 оны хичээлийн жилд олон улсын түвшинд хөгжсөн байна.

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН





**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

# **2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2021 он

Хянан тохиолдуулсан:

Захиргаа, хүний нөөцийн газрын дарга

Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газрын дарга

Н.Ганзориг

Ж.Арслан

Ө.Оюунхүү

Эмхэтгэсэн:

ЗХНГ-ын мэргэжилтэн

Ш.Доржсүрэн

Үсгийн гагнитур: Times New Roman

Хэвлэлийн хэмжээ: В5 /176х250/

Хэвлэлийн хуудас:33

Хэвлэсэн тоо: 220 ширхэг

ШУТИС, Хэвлэлийн газарт хэвлэв



## ГАРЧИГ

Өмнөх үг.....	7
<b>НЭГ. Удирдлага, зохион байгуулалт .....</b>	<b>10</b>
1.1. Удирдах зөвлөл.....	10
1.2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа.....	12
1.3. Захирлын зөвлөл .....	18
1.4. Төсөв, төлөвлөл.....	19
1.4.1. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний хэрэгжилт.....	20
1.4.2. Төвлөрсөн бус мэдээллийн статистик тайлан.....	22
1.4.3. Цахим сургалтын тоон үзүүлэлтүүд.....	36
1.4.4. Дээд боловсролын мэдээллийн систем .....	45
1.4.5. Төсөв, төсвийн тодотгол .....	46
1.4.6. Мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа .....	48
1.5. ШУТИС-ийн музейн тайлан.....	73
<b>ХОЁР. Сургалтын үйл ажиллагаа .....</b>	<b>78</b>
2.1.1. Бакалаврын сургалт .....	78
2.1.2. Цахим сургалт .....	78
2.1.3. Элсэлт .....	81
2.1.4. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт .....	82
2.1.5. Цагийн сургалт.....	85
2.1.6. ШУТИС-КООСЭН” технологийн коллеж .....	85
2.1.7. Ерөнхий боловсролын ахлах сургууль.....	87
2.1.8. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн сургалт.....	89
2.1.9. Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (GPA) .....	93
2.1.10. Хичээл бүрийн оюутны үнэлгээ .....	110
2.1.11. Төгсөлт.....	110
2.1.12. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл.....	116
2.1.13. Олон улсын магадлан итгэмжлэл.....	118
2.1.14. Хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагаа .....	119
2.2. Магистрын сургалтын үйл ажиллагаа .....	120
2.2.1. Магистрантурын элсэлтийн үйл ажиллагаа .....	121
2.2.2. Магистрантурын төгсөлтийн үйл ажиллагаа .....	122
2.2.3. Магистрантур төгсөгчдийн голч дүнгийн судалгаа.....	123
2.3. Докторын сургалтын үйл ажиллагаа.....	124
2.3.1. Докторантурын элсэлтийн үйл ажиллагаа.....	125
2.3.2. Магистр, докторын эрдэм шинжилгээний хурал .....	130
2.3.3. Докторантурын сургалтын төгсөлтийн үйл ажиллагаа.....	133
2.3.4. Докторын (Ph.D) зэрэг хамгаалж, төгссөн эрдэмтдийн мэдээлэл.....	134
2.3.5. Докторантурт суралцагчдын үнэлгээний голч дүнгийн судалгаа .....	136
2.4. Ахисан түвшний хөтөлбөрүүдээр боловсролын судлалын чиглэлийн хийгдсэн ажлууд.....	137
<b>ГУРАВ. Эрдэм шинжилгээ, инновац, технологи дамжуулалт.....</b>	<b>142</b>
3.1. Эрдэм шинжилгээний арга хэмжээ .....	142
3.2. Судалгаа, боловсруулалтын ажил.....	148
3.2.1. БШУЯ-ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл шутсангийн санхүүжилттэй ШУТИС-д хэрэгжиж байгаа төслүүд.....	151
3.2.2. ШУТИС-ийн технологийн сангийн санхүүжилттэй төсөл .....	154
3.2.3. Олон улсын санхүүжилттэй бусад төсөл.....	158
3.2.4. “Инженер технологийн дээд боловсрол” (MJEED)төсөл .....	161
3.2.5. Гэрээт ажил.....	173
3.2.6. Системийн сэтгэлгээ, систем динамикийн чиглэлээр .....	177



3.3. Судалгааны хүрээлэн.....	178
3.3.1. Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн .....	180
3.3.2. Уул уурхайн хүрээлэн.....	188
3.3.3. Ой модны сургалт судалгааны хүрээлэн .....	192
3.4. Эрдэм шинжилгээний хэвлэн нийтлэл.....	198
3.4.1. “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл” .....	199
3.4.2. “Манай эрдэмтэд” цуврал бүтээл.....	201
3.4.3. “Шинжлэх ухаан, технологи” үйлдвэрлэл, танин мэдэхүйн сэтгүүл .....	203
3.4.3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргадаг дотоодын болон олон улсын сэтгүүл .....	204
3.4.4. Бусад их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын сэтгүүлд нийтэлсэн бүтээл .....	207
3.4.5. Багш нарын туурвисан бүтээл.....	208
3.4.6. Нэг сэдэвт бүтээл /Монограф/ .....	209
3.4.7. Докторын судалгааны ажил.....	212
3.4.8. Сурах бичиг.....	213
3.4.9. Орчуулгын бүтээл.....	214
3.4.10. Гарын авлага .....	215
3.4.11. Цахим ном, сурах бичиг, гарын авлага.....	219
3.4.12. Эрдэм шинжилгээний төслийн тайлан .....	220
3.4. Эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа.....	234
3.5. Технологи дамжуулалт .....	237
3.5.1. Технологи дамжуулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ.....	237
3.5.2. ШУТИС-ийн оюуны өмчийн мэдээлэл .....	243
3.5.3. Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагаа .....	245
ДӨРӨВ. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа .....	250
4.1. ШУТИС-ийн багш, ажилтны гадаад томилолт, мэргэжил дээшлүүлэлт.....	250
4.2. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг .....	250
4.3. Гадаадын мэргэжилтэн, багш зочин профессор.....	251
4.4. Оюутан солилцоо, гадаадын тэтгэлэг .....	252
4.5. Гадаадын тэтгэлгүүд .....	253
4.6. Гадаадын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт .....	254
ТАВ. Оюутны хөгжил, үйлчилгээ .....	256
5.1. Хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа.....	256
5.1.1. “Танд тусалъя аян”, “Чиглүүлэгч оюутан” аян.....	256
5.1.2. “Хотын соёл” аян .....	257
5.1.3. Нэгдүгээр курсийн зөвлөх багш нарт зориулсан цахим сургалт .....	258
5.1.4. ШУТИС-ийн оюутны клубүүдийн үйл ажиллагаа .....	259
5.1.5. Клубүүдийн үйл ажиллагаа. ....	260
5.2. ШУТИС-ийн клубүүдийн өдөрлөг /намрын улирал/.....	263
5.3. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт .....	267
5.3.1. Төр болон нийгмийн үйлчилгээнд оюутныг хамруулсан байдал .....	267
5.3.2. Ректорын нэрэмжит тэтгэлэг.....	267
5.3.3. Нийтийн тээврээр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал .....	268
5.3.4. Төгсөгч оюутны анкет .....	268
5.4. Нэгдсэн арга хэмжээ .....	269
5.4.1. 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа .....	299
5.4.2. 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа .....	271
5.4.3. ШУТИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хурал “Эрдмийн ХХ чуулган” ....	273
5.4.4. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаан	275
5.4.5. Оюутны Урлагийн бага наадам .....	278



5.5. Олон нийт, нийгэмд чиглэсэн ажил .....	279
5.5.1. “Сүүдэр бүү тусга” аян .....	279
5.5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих .....	280
5.5.3. Төгсөгч оюутныг мөшгөх судалгаа .....	282
5.7. Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг .....	284
5.7.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ.....	285
5.7.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ .....	289
5.7.3. Ковид-19 корона вирусийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт тандалт .....	294
5.7.4. Орчны эрүүл ахуй ариутгал, халдваргүйжүүлэлт.....	296
<b>ЗУРГАА. Номын сангийн үйлчилгээ.....</b>	<b>298</b>
6.1. Шинжлэх ухаан, технологийн номын сан .....	298
6.2. Номын сангийн үйлчилгээ, фонд бүрдүүлэлт.....	299
6.3. Сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээ.....	302
<b>ДОЛОО. Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ, маркетинг олон нийттэй харилцах үйл ажиллагаа.....</b>	<b>308</b>
7.1. ШУТИС-ийн чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх .....	308
7.1.1. ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015-ын хэрэгжүүлэлт .....	309
7.1.2. ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааны гүйцэтгэл, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээ.....	311
7.1.3.“Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл”-өөс зохион байгуулж буй сургалт.....	313
7.1.4. ЭХС, БАС-ийн 2019-2020 оны сургалтын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийв.....	315
7.1.5. ШУТИС-ийн захирлын тушаалаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт.....	316
7.2. ШУТИС-ийн дотоод аудит .....	317
7.2.1. Хяналт шалгалтын ажлын талаар .....	317
7.2.2. Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн талаар.....	318
7.3. Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа.....	319
7.3.1. Мэргэжил сурталчлах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил.....	321
7.3.2. ШУТИС-ийн сурталчилгааны контент бэлтгэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил.....	324
7.3.3. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа.....	325
7.3.4. “ШУТИС-ийн ЦАГ” радиогийн цуврал нэвтрүүлэг, подкаст.....	330
7.3.5. ШУТИС-ийн албан ёсны цахим хуудас хөгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил.....	331
7.3.6. SCEINCE FM 94.1 ФМ радио.....	334
7.4. Нээлттэй боловсрол.....	337
7.4.1. Дээд боловсролын орчин үеийн хандлага, арга зүй, үр дүнд суурилсан боловсролын стандартыг түгээн дэлгэрүүлэх.....	337
7.4.2. ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрүүдэд шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх	340
7.4.3. Боловсрол судлалын чиглэлээр судалгаа хийж, гадаад, дотоодын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх.....	342
7.4.4. Багшлах боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, багшийг бэлтгэх, давтан сургах, хөгжүүлэх сургалтууд зохион байгуулах, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх системийг боловсронгуй болгон сайжруулах .....	343
7.4.5. Суралцахуйн дижитал технологи, дизайны чиглэлээр.....	346



НАЙМ. Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалт, байр ашиглалт.....	352
8.1. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба.....	352
8.2. Балансын үр дүн.....	354
8.3. Орлого үр дүн.....	358
8.4. Зарлага, үр дүн.....	364
8.5. Санхүүгийн үр дүн.....	371
8.6. Санхүүгийн тайлагналын аудитын үр дүн.....	376
8.7. Хөрөнгө оруулалт, хангамжийн талаар.....	380
8.7.1. Аж ахуй, эд хогшлын худалдан авалт.....	382
8.7.2. Өмч хөрөнгийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах.....	390
8.7.3. Газрын бүртгэлийн талаар хийгдсэн ажлууд.....	391
8.7.4. Сургалтын төлбөрийн болон бусад авлагыг багасгах тал дээрх ажлыг эрчимжүүлж бүрдэлдэхүүн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.....	392
8.8. Байр ашиглалтын талаар.....	392
8.8.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний чиглэлээр.....	393
8.8.2. Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын талаар	
8.8.3. Тайлант онд Удирдах зөвлөлийн 2020 оны 16 тоот тогтоолоор батлагдсан 2021 оны хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллалаа.....	394
8.8.4. Оюутны байр ашиглалт.....	394





## ӨМНӨХ ҮГ

ШУТИС-ийн Эрдмийн хамт олон 2020-2021 оны хичээлийн жилд “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, их сургууль, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх” үндсэн зорилго, зорилтуудыг дэвшүүлэн амжилттай ажиллалаа. Мөн Ардын хувьсгалын 100 жил, Монгол улсад орчин цагийн Боловсролын болон Шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг угтаж их сургуулийн хэмжээнд ухаалаг, эко, ногоон орчин бүрдүүлэх талаар манай профессор багш нар, ажилтнууд, оюутан суралцагчид олон сайхан ажлыг санаачлан хийж гүйцэтгэсэн байна.

Тухайн хичээлийн жилд Монгол улсад тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы дэглэм хэрэгжсэнтэй холбоотой бид сургалтын үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр зохион байгуулж, их сургуулийн профессор багш нар, оюутан залуучууд өөрсдийн бүхий л боломж, бололцоог дайчлан идэвхтэй ажилласан байна. Энэ хичээлийн жилийн цахим сургалтын онцлог, гол үр дүн бол шинэ арга зүй, агуулга, хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан, цахим сургалтын системээ хөгжүүлж боловсронгуй болгосон мөн элсэлт, төгсөлтийг цахим хэлбэрээр гүйцэтгэн, шинээр элсэгчдийн хуваарь сонголтыг улсын хэмжээнд цахимаар явуулсан явдал юм. Манай профессор багш нар урьд өмнөхөөс илүү хариуцлагатай, өндөр ачаалалтай ажиллаж, эх орны өнцөг булан бүрт суугаа оюутнууддаа бололцоотой бүх хэлбэрээр хичээлийн агуулга, сургалтын эх материалаа тасралтгүй хүргэж, цаашид цахим хичээлүүдээ улам хөгжүүлэх тал дээр хамтран зохих үр дүнд хүрлээ.

Тус их сургуульд орчин үеийн судалгааны тэргүүлэх лабораториуд, гарааны компаниуд шинээр байгуулах, Олон улсын Эрдэм шинжилгээний хурал, ШУТИС-ийн эрдмийн их Чуулганыг зохион байгуулах зэргээр эрдэм судлалын хөгжилд ахиц дэвшил гарсан жил боллоо. Судалгааны их сургуулийг хөгжүүлэх чиглэлээр бусад их сургуулиудад жишиг болохуйц, дээд боловсролын онол, арга зүйн асуудлаар цуврал нээлттэй хичээлүүдийг (МООС) шинээр бэлтгэж онлайн сургалт явуулах бэлтгэлийг хангасан байна.

ШУТИС-ийн удирдлагын зүгээс цахим сургалтын үед шаардах сургалтын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, их сургуулийн хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөхөд шаардлагатай эм, эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах, ШУТИС-ийн эмнэлгийн чадамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллав.

Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс профессор багш нар, ажилтнууд, оюутан суралцагчид урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад бүрэн хамрагдсанаар цаашид их сургуулийн хэмжээнд хичээл сургалтын болон бусад үйл ажиллагаа танхимын хэлбэрээр зохион байгуулагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн манай эрдэмтэн багш нар орчин үеийн агуулга, стандартад нийцүүлэн их сургуулийн үндсэн сурах бичгүүдийг шинэчлэн Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор 100 үндсэн сурах бичигтэй болох зорилт тавьж ажиллав.



2020-2021 оны хичээлийн жил “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн гарааны жил байлаа. Стратеги төлөвлөгөөний хүрээнд ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтны оролцоонд тулгуурлан 2030 онд дэлхийн шилдэг 1000 сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, төр бизнесийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэгч нь байх зорилго, зорилтууд дэвшүүлсэн юм.

Монгол улсын Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ШУТИС олон ажлуудыг манлайлан ажиллаж, гүйцэтгэлийг хангах зорилгоор тодорхой төлөвлөгөө гарган, холбогдох ажлын хэсгүүд байгуулсан байна. Тухайлбал, их сургуулийн элсэлтийн шалгалтын олон улсын агуулга, үнэлгээг (SAT г.м.) нэвтрүүлэх, их сургуулиуд оюутнаа өөрсдөө үнэлж элсүүлдэг байх тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулах, бэлтгэл ажлын талаар харьцуулсан судалгаа хийж, энэ талаар тодорхой санал боловсруулсан юм. Мөн их сургуулиуд дундын зарим нэгдсэн сурах бичиг боловсруулж гаргахад идэвхтэй хамтран ажиллаж байна. ШУТИС-ийн суралцагчдаас “Орлоготой оюутан хөтөлбөр”-ийн хүрээнд явуулсан судалгааны үр дүнг төрийн өмчийн 5 их сургуульд илгээж, хамтран ажиллах зарим арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

ШУТИС болон Рио Тинто компани, Оюу толгой компанитай хамтран хэрэгжүүлэх Уул уурхайн геотехникийн мэргэжил олгох, олон улсын судалгааны төв байгуулах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, холбогдох төслийн ажлыг эхлүүлээд байна. Энэхүү Рио Тинто болон Оюу толгой компанийн санхүүжилтээр хэрэгжих төслийн үр дүнд ШУТИС геотехникийн чиглэлээр олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй болно. Ингэснээр бид Азидаа өрсөлдөхүйц хэмжээний сургалт, судалгааны төв болох зорилгоо биелүүлэхэд нэг алхам ойртоод зогсохгүй дан ганц Монголоос гэлтгүй дэлхийн бусад орноос ч бас энэ чиглэлээр оюутан элсүүлж, уул уурхайн мэргэжилтнүүдийг бэлтгэх боломжтой болох юм.

Ийнхүү 2020-2021 оны хичээлийн жил ШУТИС-ийн цаашдын хөгжил, дэвшилд түлхэц өгсөн, зохих үр дүнтэй хичээлийн жил боллоо.

Хичээлийн шинэ жилд бид дээрх ололт, амжилтаа улам бататгаж, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, улмаар судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилтуудаа улам илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлэн ажиллах болно.

ШУТИС-ийн Эрхэм хүндэт профессор багш нар, ажилтнууд, оюутан суралцагчид та бүхэнд шинэ хичээлийн жилдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе!

РЕКТОР

Б.ОЧИРБАТ



# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

---

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## НЭГ. УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2020-2021 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод 10, орон нутагт 1, нийт 11 бүрэлдэхүүн сургууль, харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв, бүрэлдэхүүн 2, харьяа 2 хүрээлэн үйл ажиллагаа явууллаа.

ШУТИС-ийн захиргаа, удирдлагын түвшинд 5 газар, 8 алба, 4 төвтэй ажиллав. ШУТИС-ийн удирдлагын баг ШУТИС-ийн захирал, Сургалт, оюутны асуудал эрхэлсэн, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн 5 дэд захирал, Захиргаа, хүний нөөцийн газар, Сургалтын бодлого зохицуулалтын газар, Эрдэм шинжилгээ, инновацын газар, Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар, Хөрөнгө оруулалт, хангамжийн газар, Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба, Оюутны соёл, үйлчилгээний алба, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба, Маркетинг, олон нийттэй харилцах алба, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба, Байр ашиглалтын нэгдсэн алба, Нээлттэй боловсролын төв, Мэдээллийн технологийн төв, Технологи дамжуулах төв, Эрүүл мэнд, спортын төв, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, ШУТИС-Хэвлэлийн газартай тухайн хичээлийн жилд ажиллалаа.

### 1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/125 тоот тушаалаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсан.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлд хамт олныг төлөөлөх гишүүдийн саналыг бүрэлдэхүүн сургууль бусад нэгжүүдээс авч хамт олны цахим хурлаар хэлэлцүүлэн, ШУТИС-ийн Захирлын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/199 тоот тушаалаар баталж БШУЯ-ны Дээд боловсролын газарт уламжлав.



## ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.1

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
<b>I. Төрийн төлөөлөл</b>			
1	Дарга	Г.Ганбаяр	Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд
2	Дэд дарга	Г.Батнэмэх	Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	Д.Одгэрэл	Боловсрол, шинжлэх ухааны яамны Инновац, технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4		Б.Ерэн-Өлзий	Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
5		Б.Доржсэмбэд	Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга
6		Б.Анхбаяр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга
7		Л.Чой-Иш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
8		Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн худалдаа, зохицуулалтын хэлтсийн дарга
9		Г.Чинзориг	Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга
<b>II. Хамт олны төлөөлөл</b>			
10	Гишүүн	Н.Доржбалдан	Барилга, архитектурын сургуулийн Архитектурын сургуулийн ахлах багш
11		Ц.Тэнгис	Мэдээлэл холбооны технологийн сургуулийн Электроникийн салбарын дэд профессор
12		Ч.Ганбаатар	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрийн инженерчлэлийн салбарын дэд профессор
13		Д.Болор	“Эн Си Эс” ХХК-ийн гүйцэтгэх захирал
14		Л.Баяр-Эрдэнэ	“ШУТИС-Бидний бахархал” төгсөгч, дэмжигчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга
15		Б.Мягмарренчин	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн

Шинэчлэн баталсан Удирдах зөвлөлийн эхний хурал 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр болж, үүсгэн байгуулагчийн санал болгосон Боловсрол,



шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар хуралд оролцогч нийт гишүүдийн дэмжсэн саналаар сонгогдлоо. Удирдах зөвлөлийн дэд даргаар БШУЯ-ны Дээд боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батнэмэх, нарийн бичгийн даргаар ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзориг нарыг томилон ажиллуулав.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн зарим хурлыг цахимаар зохион байгуулсан.

ШУТИС-ийн Удирдах зөвлөл 2020-2021 оны хичээлийн жилд 6 удаа хуралдаж

1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нарыг сонгох
2. ШУТИС-ийн өнөөгийн байдал, хөгжлийн хөтөлбөрийн товч танилцуулга
3. ШУТИС-ийн 2020 оны төсвийн тодотгол
4. ШУТИС-ийн 2021 оны төсвийн төсөл
5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Дарханы технологийн сургуулийн Лицей сургуулийн талаар авах арга хэмжээний тухай
6. ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашдын төлөв (мэдээлэл)
7. Үйлдвэрлэлийн технологи судалгаа инновацын барилгын тухай
8. Цаг үеийн яаралтай асуудлаар
9. 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоо батлах тухай
10. 2021-2022 оны хичээлийн жилийн ШУТИС-ийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийг батлах тухай зэрэг асуудлыг хэлэлцэж, 10 тогтоол гаргаж, хурлын шийдвэрийг тухай бүрд нь их сургуулийн веб сайтаар дамжуулан мэдээлэл хүргэлээ.

Удирдах зөвлөлийн гишүүд 2020-2021 оны хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллав.

## **1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2020-2021 оны хичээлийн жилд Эрдмийн зөвлөл 3 удаа хуралдаж, сургалтын үйл ажиллагааг зохицуулах, эрдмийн ба хүндэт цол олгох, эрдэмтдийг ШУА-ийн салбар чуулганы гишүүнд нэр дэвшүүлэх, салбар, нэгжийн зохион байгуулалт зэрэг асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлэлээ. (Хүснэгт 1.2).



## ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал /2020-2021/

*Хүснэгт 1.2*

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1	Эрдмийн ба хүндэт цол олгох тухай	2020.09.28	№10,11,12
2	ШУА-ийн Бага чуулганы гишүүнд нэр дэвшүүлэх тухай	2020.10.22	№03
3	Эрдмийн ба хүндэт цол, сургалтын хөтөлбөр, мэргэжлийн нэр, индекс өөрчлөх, хөтөлбөрт мэргэжил нэмэх, зөвлөмж гаргах тухай	2021.07.01	№03,04,05,06,07 08,09,10,11,12

Түүнчлэн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд эрдэм шинжилгээний хуанли, төлөвлөгөөний дагуу асуудлуудыг 7 удаагийн хурлаар хэлэлцэж дараагийн шатны хуралд оруулсан байна (Хүснэгт 1.3).

## Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал /2020-2021/

*Хүснэгт 1.3*

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Үр дүн
<b><i>Инновацийн дэд зөвлөл</i></b>			
1	ШУА-ийн Бага чуулганы гишүүнд нэр дэвшүүлэх тухай	2020.10.22	Нийт 6 салбар чуулганд нэр дэвшиж буй 28 эрдэмтнийг хэлэлцүүлж дэмжив.
2	Төвүүдийн тайлан хэлэлцэх	2021.01.15	Төвүүдийн үйл ажиллагааг дүгнэж хэлэлцээд Захирлын зөвлөлийн хурлаар 41 төвийг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
3	Дотоод, гадаадын санхүүжилттэй төслүүдийн тайлан хэлэлцэх	2021.01.25	Нийт 32 төслийн явц болон эцсийн үр дүнг хэлэлцэн дүгнэв.
4	Хүрээлэнгийн үйл 2020 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх	2021.01.26	Бүрэлдэхүүн болон харьяа хүрээлэнгүүдийн тайланг хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг хэлэлцэв.
<b><i>Эрдмийн ба хүндэт цолны зөвлөл</i></b>			
1	Эрдмийн ба хүндэт цол олгох асуудал	2020.09.23	Хүндэт цол 1, профессор 7, дэд профессор 20 хүний асуудлыг хэлэлцэж дэмжив.
2	Эрдмийн ба хүндэт цол олгох журмын өөрчлөлтийг хэлэлцэх	2021.05.20	Журмын төслийг дэмжиж, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
3	Эрдмийн ба хүндэт цол олгох асуудал	2021.06.25	Хүндэт доктор-1, хүндэт профессор-4, профессор-17, дэд профессор-30 нэр дэвшигчдийг хэлэлцүүлж, шийдвэрлэв.



Тайлант онд ШУТИС-ийн хүндэт доктор 1, хүндэт профессор 5, профессор цолыг 24, дэд профессор цолыг 50 хүн тус тус хүртсэн байна (Хүснэгт 1.4).

**ШУТИС-ийн Хүндэт ба Эрдмийн цол хүртэгсэд  
/2020-2021/**

*Хүснэгт 1.4*

№	Овог нэр	Байгууллага	ЭЗ-ийн тогтоолын тогтоол
<b>Хүндэт доктор</b>			
1	Ёндон Отгонбаяр	Түүхийн ухааны доктор /Ph.D/	2021.07.01, №05
<b>Хүндэт профессор</b>			
1	Окава Хидео	Нийгата технологийн институтийн Ерөнхийлөгч	2020.09.28, №12
2	Ёошики Миками /Yoshiki Mikami/	"Япон, Каишигийн их сургуулийн дэд захирал	2021.07.01, №06
3	Мижид ОЮУНЦЭЦЭГ	БуХС, ахмад багш	2021.07.01, №07
4	Найдандорж НЯМЖАВ	БАС, ахмад багш	2021.07.01, №08
5	Дэмбэрэл ДУНГААМАА	Эрдэнэт цогцолбор дээд сургууль, ахлах багш	2021.07.01, №09
<b>Профессор</b>			
1	Пүрвээ ЖАРГАЛТУЯА	БуХС, Бизнесийн удирдлагын салбар	2020.09.28, №10
2	Бадарч БАЯРСҮРЭН	МехТС, Тээврийн салбар	2020.09.28, №10
3	Булднаа ДОЛГОР	БуХС, Нийгмийн ухааны салбар	2020.09.28, №10
4	Төмөрпүрэв НАМНАН	ШУТИС-ийн Эрдэм Шинжилгээ, Хамтын ажиллагаа дэд захирал	2020.09.28, №10
5	Оюунбилэг БАТ-ЭНХ	МХТС, Мэдээллийн технологийн салбар	2020.09.28, №10
6	Цагаан БААТАРХҮҮ	ШУТИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал	2020.09.28, №10
7	Данжхүү ЦОЛМОНБААТАР	МехТС, захирал	2020.09.28, №10
8	Гүрбазар БАТТҮВШИН	БАТС, Захирал	2021.07.01, №03
9	Чойжил БААСАНДАШ	БАТС, ЭНБД	2021.07.01, №03
10	Жамсран ГАНЧИМЭГ	БАТС, Бизнесийн удирдлага, менежментийн салбарын дэд профессор	2021.07.01, №03





11	Баясгалан ЦЭЦГЭЭ	БуХС, Технологийн менежментийн салбарын профессор	2021.07.01, №03
12	Бямбахишиг ПҮРЭВСҮРЭН	БуХС, Хүмүүнлэгийн салбарын профессор	2021.07.01, №03
13	Ядамсүрэн ОЮУНТУНГАЛАГ	БуХС, Технологийн менежментийн салбарын профессор	2021.07.01, №03
14	Сэрээнэн ЖАРГАЛАН	ГУУС, Геологи, гидрогеологийн салбарын эрхлэгч	2021.07.01, №03
15	Даш ОЮУНЦЭЦЭГ	ГУУС, Геодезийн салбарын эрхлэгч	2021.07.01, №03
16	Цэгмэд ЦЭВЭГЖАВ	МехТС, Тээврийн салбарын профессор	2021.07.01, №03
17	Норинпэл ЭРДЭНЭХҮҮ	МХТС, Дэд захирал	2021.07.01, №03
18	Баатар ЗОРИГТБААТАР	МХТС, Электроникийн салбарын профессор	2021.07.01, №03
19	Баяр БАТ-ЭРДЭНЭ	ЭХС, Цахилгаан техникийн салбарын эрхлэгч	2021.07.01, №03
20	Бямбаа СЭРГЭЛЭН	ЭХС, Цахилгааны инженерийн салбарын эрхлэгч	2021.07.01, №03
21	Түдэвдагва УРАНЧИМЭГ	ЭХС, Цахилгаан техникийн салбар	2021.07.01, №03
22	Батсуурь СҮХБАТ	ШУТИС-ийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	2021.07.01, №03
23	Ренчин ТӨРБАТ	Мэдээллийн технологийн төвийн захирал	2021.07.01, №03
24	Цэвэгсүрэн ОЮУН	Сургалтын бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн	2021.07.01, №03
<b>Дэд профессор</b>			
1	Буянбат НАРАНЦЭЦЭГ	ГУУС, Газрын тос, өрөмдлөгийн салбарын ахлах багш	2020.09.28, №11
2	Жадамба ГАНЦЭЦЭГ	ГХС, Англи хэлний тэнхимийн ахлах багш	2020.09.28, №11
3	Эрдэнээ ЭНХЦЭЦЭГ	ХШУС, Химийн инженерийн салбарын дэд профессор	2020.09.28, №11
4	Цагаанчулуун МӨНХ-ЭРДЭНЭ	ХШУС, Математикийн тэнхимийн ахлах багш	2020.09.28, №11
5	Ядам РЭНЧИНВАНЖИЛ	МехТС, Механик, мехатроникийн салбарын дэд профессор	2020.09.28, №11



6	Цэвээнжав ХҮРЭЛБААТАР	МХТС, Электроникийн салбарын дэд профессор	2020.09.28, №11
7	Жанцан НЯМАА	БуХС, Нийгмийн ухааны салбарын ахлах багш	2020.09.28, №11
8	Ичинноров БАЗАРРАГЧАА	МехТС, Тээврийн салбарын эрхлэгч	2020.09.28, №11
9	Алтангэрэл ХҮДЭР	МХТС, Компьютерийн ухааны салбарын дэд профессор	2020.09.28, №11
10	Багаа ХЭЭРИЙНБААТАР	Эрдэнэт цогцолбор сургууль, Эрчим хүч, мэдээллийн технологийн тэнхимийн ахлах багш	2020.09.28, №11
11	Бямбасүрэн БАТ-ЭРДЭНЭ	ЭХС, Инженерийн ахисан түвшний салбарын дэд профессор	2020.09.28, №11
12	Даянгялбаа ГАНБААТАР	БуХС, Дэд захирал	2020.09.28, №11
13	Бал ЭНХЦЭЦЭГ	Эрдэнэт цогцолбор сургууль, Суурь шинжлэх ухааны тэнхимийн багш	2020.09.28, №11
14	Төгрөг ЛХАГВАСҮРЭН	МХТС, Холбооны салбарын ахлах багш	2020.09.28, №11
15	Түмэн-Өлзий ГАНБАТ	МехТС, Техникийн механикийн тэнхимийн ахлах багш	2020.09.28, №11
16	Пунцагдаш ЭНХБААТАР	МехТС, Техникийн механикийн тэнхимийн ахлах багш	2020.09.28, №11
17	Чулуунбаатар АЛДАРМАА	ХШУС, Физикийн тэнхимийн эрхлэгч	2020.09.28, №11
18	Түмэн-Өлзий НАРАНМАНДАХ	МХТС, гэрээт багш	2020.09.28, №11
19	Шагдар ГАНБОЛД	МХТС, Холбооны салбарын дэд профессор	2020.09.28, №11
20	Дамдин ЭНХЖАРГАЛ	ХШУС, Төслийн удирдагч	2020.09.28, №11
21	Цэенбалжир ОЮУНЦАЦРАЛ	БАС, ЭНБД	2021.07.01, №04
22	Самбуу ХАСНАВЧ	БАС, ХБОИС-ын дэд профессор	2021.07.01, №04
23	Буянтөр ОЮУНТУНГАЛАГ	БАТС, Бизнесийн удирдлага, менежментийн салбарын эрхлэгч	2021.07.01, №04
24	Төмөрхүү УУГАНБАЯР	БАТС, Бизнесийн удирдлага, менежментийн салбарын дэд профессор	2021.07.01, №04



25	Дүгэрсүрэн БИНДИРЯА	БАТС, Бизнесийн удирдлага, менежментийн салбарын дэд профессор	2021.07.01, №04
26	Норовсамбуу МӨНХӨӨ	БАТС, Бизнесийн удирдлага, менежментийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
27	Оюунчимэг БОЛОРМАА	БуХС,ЭНБД	2021.07.01, №04
28	Лхагвасүрэн АМАРТҮВШИН	БуХС, Технологийн менежментийн салбарын дэд профессор	2021.07.01, №04
29	Ганбаатар НАРАН-ОЮУН	БуХС, Хүмүүнлэгийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
30	Домбон ЭНХБАТ	ГУУС, Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын дэд профессор	2021.07.01, №04
31	Гончигжав САРАНТУЯА	Геологи, гидрогеологийн салбарын дэд профессор	2021.07.01, №04
32	Баасандорж АЛТАНЗУЛ	ГУУС, Геологи, гидрогеологийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
33	Амаржаргал БААСАНЖАРГАЛ	ГУУС, Газрын тос, өрөмдлөгийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
34	Чойжин ЗОЛЗАЯА	ГХС, Англи хэлний тэнхимийн эрхлэгч	2021.07.01, №04
35	Лхагваа ЧОЙЖИЛМАА	ГХС, Ази судлалын тэнхимийн дэд профессор	2021.07.01, №04
36	Ганжуур УРАНЧИМЭГ	ГХС, Ази судлалын тэнхимийн ахлах багш	2021.07.01, №04
37	Чойжил ОЮУНГЭРЭЛ	ГХС, Ази судлалын тэнхимийн ахлах багш	2021.07.01, №04
38	Нямсүрэн ПҮРЭВДОРЖ	МехТС, ЭНБД	2021.07.01, №04
39	Дашдорж ЗОЛЗАЯА	МХТС, Компьютерийн ухааны салбарын ахлах багш	2021.07.01, №04
40	Хасбаатар МӨНХЗАЯА	ҮТС, Биотехнологи, шим тэжээлийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
41	Болд ТУНГАЛАГТАМИР	ХШУС, Дэд захирал	2021.07.01, №04
42	Юндэн ГАНЧИМЭГ	ХШУС,Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
43	Галя ЦЭРМАА	ХШУС,Физикийн тэнхимийн ахлах багш	2021.07.01, №04



44	Цэрэнсанги БАЙГАЛЬМАА	Физикийн тэнхимийн ахлах багш	2021.07.01, №04
45	Цогтбазар ЦЭЦЭГСҮРЭН	ХШУС, Математикийн тэнхимийн ахлах багш	2021.07.01, №04
46	Должинсүрэн БАЛДАНДОРЖ	ЭХС, Дулааны инженерийн салбарын ахлах багш	2021.07.01, №04
47	Хайнжамц ОТГОН-ЭРДЭНЭ	Маркетинг, олон нийттэй харилцах албаны дарга	2021.07.01, №04
48	Лхагвасүрэн БАЯР-ЭРДЭНЭ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал	2021.07.01, №04
49	Хүрэлбаатар ДЭЛГЭРСАЙХАН	Дотоод аудитын албаны дарга	2021.07.01, №04
50	Аюуш СҮНЖИДМАА	Нээлттэй боловсролын төвийн ахлах мэргэжилтэн	2021.07.01, №04

### 1.3. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах санал бүрэлдэхүүн сургууль, нэгж, захиргааны газар, албадаас авч, нэгтгэн батлуулав (Хавсралт 1).

Тайлант хугацаанд захирлын зөвлөлийн хурал батлагдсан төлөвлөгөөний дагуу 31 удаа хуралдаж элсэлтийн хяналтын тоо, төсөв, төсвийн тодотгол, төлөвлөгөө, тайлан баланс, цалин, элсэлт төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, бодлогын баримт бичиг, багш, ажилчдын нийгмийн асуудал, гадаад харилцаа, ахисан түвшний сургууль байгуулах тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл /хөтөлбөрүүд/-ийн явц, үр дүн, засвар тохижилтын ажил, эрдэм шинжилгээний болон сургалтын нэгдсэн хуанли, цаг үеийн асуудлыг хэлэлцсэн.

Дэлхий нийтэд цар тахлын халдвар дэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлыг онлайн болон танхимаар зохион байгуулсан.

Захирлын зөвлөлийн хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийг их сургуулийн <https://www.must.edu.mn/mn/content/t/5?page=2> цахим хуудаст байршуулан мэдээлэн ажиллаж байна.



## ШУТИС-ийн захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.5

Д/д	Овог нэр	Албан тушаал	Тайлбар
1	Б.Очирбат	ШУТИС-ийн Захирал	
2	Х.Энхжаргал	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал	
3	Т.Намнан	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
4	Б.Сүхбат	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	
5	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал	
6	Ц.Баатархүү	Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал	
7	Н.Ганзориг	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	
8	Э.Нинжгарав Б.Нарантуяа	БАС-ийн захирал	2020.09.18-ны өдрөөс
9	А.Энхбат	БуХС-ийн захирал	
10	Г.Баттүвшин	БАТС-ийн захирал	
11	Л.Пүрэв	ГУУС-ийн захирал	
12	Ц.Энхбаатар	ГХС-ийн захирал	
13	Ц.Батбаатар	ДаТС-ийн захирал	
14	Д.Цолмонбаатар	МехТС-ийн захирал	
15	Н.Чулуунбанди	МХТС-ийн захирал	
16	Ж.Туяацэцэг	ҮТС-ийн захирал	
17	Д.Ганхуяг	ХШУС-ийн захирал	
18	Ч.Мангалжалав	ЭХС-ийн захирал	
19	Д.Ганбат	НБТ-ийн захирал	
20	Д.Зоригтхүү	ЭЦДС-ийн захирал	
21	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга	
22	Б.Мягмарренчин	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн	

### 1.4. ТӨСӨВ, ТӨЛӨВЛӨЛТ

ШУТИС-ийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн ажлын хүрээнд дараах үндсэн ажлыг гүйцэтгэв. Үүнд:

1. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс 2020 оны төсвийн төслийн саналыг хүлээн авч нэгтгэн боловсруулж, Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах саналыг хүлээн авсан.
2. ШУТИС-ийн УЗ-ийн 2020 оны 12 сарын 07-ны өдрийн 14 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2021 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө



- оруулалт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.
3. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд 2020 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулж тараасан.
  4. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс батлагдсан төсөвт орлого зарлагын сарын хуваарь авч, нэгтгэн боловсруулж батлуулан тараав.
  5. ШУТИС-ийн УЗ-ийн 2020 оны 6 сарын 10-ны өдрийн 10 тоот тогтоолоор 2020 оны батлагдсан орлого, зарлагын төсөвт тодотгол хийгдэв.
  6. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 2020 оны тодотгосон орлого, зарлагын төсвийг баталгаажуулан нэгжүүдэд илгээв.
  7. ШУТИС-ийн хэмжээнд бүрэлдэхүүн сургуулиудын 2020-2021 оны хичээлийн жилүүдийн үйл ажиллагааны статистик үзүүлэлтүүдийг гаргаж ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 10 сарын 27-ны хурлаар хэлэлцүүлэв.
  8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч боловсруулан ШУТИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгтгэсэн төлөвлөгөөг батлуулав.
  9. ШУТИС-ийн цахим хуудасны бүтцийг 2020-2021 оны хичээлийн жилийн хавар, намрын улиралд шинэчлэхэд шаардлагатай статистик тоон мэдээллүүдийг бэлтгэн цахим хуудсанд байрлуулав.
  10. “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх чиглэлээр 2019-2020 оны хичээлийн жилд хийсэн ажлын тайланг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 06 сарын 22-ны хурлаар хэлэлцүүлэв.
  11. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 08 сарын 24-ний өдрийн 04 тоот тогтоолоор Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ хэлэлцүүлэн батлуулав.

#### **1.4.1. ШУТИС-2030 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав. Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтуудад ШУТИС-ийн чанарын бодлого, зарчмуудыг нийцүүлж, нэгтгэн ажилласан. Үүнд:


- Хэрэглэгчид төвлөрөх буюу суралцагч, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагад анхаарч, хангах, төвлөрөх
- Алсын хараатай манлайллыг бий болгох
- Стратеги төлөвлөлтийг хийхдээ багш ажилтан, суралцагчдыг оролцуулах



- Харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох
- Нийгмийн өмнө хариуцлагатай ажиллах зэрэг зарчмуудыг үндэс болгосон.

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх чиглэлээр 2019-2020 оны хичээлийн жилд хийсэн ажлын тайланг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 06 сарын 22-ны хурлаар хэлэлцүүлэв.

2020-2021 хичээлийн жилд “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр нийт 31 үндсэн ажил хийхээр төлөвлөсөн. ШУТИС-ийн бүх бүрэлдэхүүн сургууль, 5 газар, 8 алба, 4 төв “ШУТИС-2030” Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тухайн хичээлийн жилд хийсэн ажлын тайланг ирүүлсэн. Тайланг нэгтгэн дүгнэхэд гүйцэтгэл хангалтгүй байгаа зорилтууд дээр анхаарах ялангуяа номын сантай холбоотой ажил (чиглэл 1.2 зорилт дээр), инновацын эко систем бүрдүүлэх чиглэлд (3,1-3,2 зорилт) зэрэг хүний оролцоо заавал шаардагдсан хэсгүүдэд (4.3 ба 5.3 хэсгүүдэд) хангалтгүй үзүүлэлттэй (74%-76%) байна.



**Зураг 1.1. "ШУТИС-2030" стратеги төлөвлөгөөний  
2020-2021 оны хичээлийн жилийн гүйцэтгэл**

- “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний үр дүнг хагас жил бүр нэгж газар, алба, төвүүдийн үүрэг чиглэлийн хүрээнд дүгнэх жилийн ажлаа




тодорхой задлан харьцангуй дэлгэрэнгүй төлөвлөх шаардлагатай нь харагдаж байна.

- Үндсэн чиглэл 4 дээр зарим үзүүлэлт хангалтгүй гарсан нь цар тахалтай холбоотой оюутан, суралцагчид руу хандсан ажлууд (4.3 хэсэг), ISO стандарт нэвтрүүлэх чиглэлийн ажил (5.3 болон 5.6 хэсэг), гадаадад оюутан солилцооны ажилд 5.8 хэсэг) доголдол гарсан.
- Хичээлийн жилийн төгсгөлд “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд анализ хийж дутуу зүйлсийг дараа жилийн төлөвлөгөөнд нөхөж хийж байх
- 2020-2021 оны хичээлийн жилийн “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнг дунджаар 82% гэж үнэлсэн.

#### 1.4.2. ТӨВЛӨРСӨН БУС МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ТАЙЛАН


2018-2019 оны хичээлийн жилд нийтдээ 18057 оюутан суралцсан, 2019-2020 оны хичээлийн жилд 15414 оюутан, 2020-2021 оны хичээлийн жилд 13589 оюутан буюу 11,8% -иар буурсан байна. Нэг багшид ноогдох оюутны тоо: 2020-2021 оны хичээлийн жилд 14 оюутан байна.




■ 2018-2019 оны хичээлийн жил ■ 2019-2020 оны хичээлийн жил ■ 2020-2021 оны хичээлийн жил

*Зураг 1.2. ШУТИС-д бакалавр, магистр, докторын сургалтад суралцаж буй оюутны тоо (сүүлийн 3-н жилээр)*







**Зураг 1.3. 2020-2021 оны хичээлийн жилд суралцагчдыг курсээр ангилсан байдал**



**Зураг 1.4. Бакалаврт суралцагчдын тоо (сүүлийн 3-н жилээр)**



Зураг 1.5. Магистрт суралцагчдын тоо (сүүлийн 3 жилээр)



Зураг 1.6. Докторт суралцагчдын (сүүлийн 3 жилээр)



### Нийт суралцагчдын тоо /насны ангиллаар/

Хүснэгт 1.6

Насны ангилал	2018-2019 оны хичээлийн жил	2019-2020 оны хичээлийн жил	2020-2021 оны хичээлийн жил
16 хүртэл	13	54	-
16 настай	120	44	-
17 настай	1330	318	32
18 настай	3239	2896	495
19 настай	2968	2992	2565
20 настай	3132	2668	2753
21 настай	2285	2079	2435
22 настай	1324	1114	1691
23 настай	699	567	793
24 настай	443	358	438
25 настай	360	224	274
26 настай	279	187	186
27 настай	241	172	147
28 настай	235	193	126
29 настай	171	170	158
30-34 настай	653	794	760
35-39 настай	365	358	475
40-өөс дээш	200	226	261
<b>Бүгд</b>	<b>18057</b>	<b>15414</b>	<b>13589</b>


### Нийт суралцагчдын тоо /орон нутгаар/

Хүснэгт 1.7

Орон нутгийн харьяалал	2018-2019 оны хичээлийн жил	2019-2020 оны хичээлийн жил	2020-2021 оны хичээлийн жил
Архангай	1557	1162	926
Баян-Өлгий	278	177	162
Баянхонгор	403	333	328
Булган	430	347	322
Говь-Алтай	433	394	350
Дорноговь	279	248	227




Дорнод	424	368	357
Дундговь	310	285	252
Завхан	685	587	511
Өвөрхангай	868	771	660
Өмнөговь	292	281	264
Сүхбаатар	290	252	222
Сэлэнгэ	475	500	432
Төв	525	368	341
Увс	728	655	584
Ховд	594	436	357
Хөвсгөл	817	658	635
Хэнтий	436	378	351
Дархан-Уул	573	774	690
Улаанбаатар	6269	5349	4760
Орхон	1180	961	758
Говь-Сүмбэр	104	78	67
Гадаад	7	52	33
<b>Бүгд</b>	<b>18057</b>	<b>15414</b>	<b>13589</b>




**Зураг.1.7. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутан (бүрэлдэхүүн сургууль бүрээр)**




Улсаар нь авч үзвэл БНХАУ-ын суралцагч хамгийн олон байна. Гадаад оюутны тоо нь нийт суралцагчдын тоонд орсон болно.




Зураг 1.8. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутан (орон бүрээр)



Зураг 1.9. ШУТИС-ийн бакалаврын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)




**Зураг 1.10. ШУТИС-ийн магистрын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)**



**Зураг 1.11. ШУТИС-ийн докторын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)**




"ШУТИС-Коосэн"  
технологийн коллеж



- 2018-2019 оны хичээлийн жил
- 2019-2020 оны хичээлийн жил
- 2020-2021 оны хичээлийн жил

Шинжлэх ухаан технологийн  
ахлах сургууль




- 2018-2019 оны хичээлийн жил
- 2019-2020 оны хичээлийн жил
- 2020-2021 оны хичээлийн жил

**Зураг 1.12. "ШУТИС-Коосэн" ТК болон Ахлах сургуульд шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)**


**ШУТИС-ийг төгсөгчдийн мэдээлэл  
(сүүлийн 3 хичээлийн жилээр)**

Хүснэгт 1.8

№	Төрөл	2018-2019 хичээлийн жил	2019-2020 хичээлийн жил	2020-2021 хичээлийн жил
1	Бакалавр	2519	2394	2753
2	С Диплом /Бакалавр/	133	131	84
3	Магистрын төгсөлт	668	658	516
4	Докторын төгсөлт	59	22	7
5	ШУТАС	27	57	54
6	Дархан АС			
7	"ШУТИС-Коосэн" ТК	24	22	19
<b>БҮГД</b>		<b>3430</b>	<b>3284</b>	<b>73</b>



Зураг 1.13.. ШУТИС-ийг бакалавр мэргэжлээр төгсөгчид (сүүлийн 3-н жилээр)



- Удирдах ажилтан 4.18%
- Үндсэн багш 53.4%
- Сургалтын ажилтан 11.3%
- Захиргааны ажилтан 13%
- Аж ахуй үйлчилгээ 18.3%


Зураг 1.14.. ШУТИС-ийн нийт багш, ажиллагсад




## Нийт багш ажилтны тоо

Хүснэгт 1.9

Төлөв	Бүрэлдэхүүн сургууль	Ахлах сургууль	“ШУТИС-Коосэн” ТК	МСУТ	Хүрээлэн	Төв ШУТИС	БҮГД
Удирдах ажилтан	38	2	2	3	4	28	77
Үндсэн багш	917	21	16	30			984
Сургалтын ажилтан	195	3	1	1		8	208
Захиргааны ажилтан	98	4	3	4	20	109	238
Аж ахуй үйлчилгээ	210	3	1		7	115	336
<b>Нийт</b>	<b>1458</b>	<b>33</b>	<b>23</b>	<b>38</b>	<b>31</b>	<b>260</b>	<b>1843</b>



Зураг 1.15. ШУТИС-ийн нийт профессор багш нарын тоо (бүрэлдэхүүн сургуулиар)




- Салбар, тэнхимийн эрхлэгч 5%
- Профессор 4.3%
- Ахлах багш 37.4%
- Дадлагажигч багш 1.7%
- Зөвлөх профессор 2.2%
- Дэд профессор 9.4%
- Багш 40.3%

**Зураг 1.16. ШУТИС-ийн профессор багшийн ангилал (албан тушаалаар)**  
 \*-ШУТИС-ийн 11 бүрэлдэхүүн, 1 харьяа сургууль, ШУТАС, Да-АС, Ор-АС, МСУТ, “ШУТИС-Коосэн” ТК-ийн профессор багш нар бүгд багтсан.


**ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн  
 профессор багшийн тоо  
 (2021 оны 3 сарын 1-ний байдлаар)**

*Хүснэгт 1.10*

№	Бүрэлдэхүүн сургууль	Үндсэн багш	Үүнээс доктор зэрэгтэй багш
1	БАС	104	30
2	БУХС	96	45
3	БАТС	11	11
4	ГУУС	93	51
5	ДаТС	69	15
6	МехТС	72	41
7	МХТС	109	41
8	ҮТС	72	29
9	ХШУС	103	45
10	ЭХС	67	32
11	ГХС	83	24
12	ОрТС	38	7
13	ШУТИС-Коосэн	16	3
<b>БҮГД</b>		<b>933</b>	<b>374</b>



Зураг 1.17.а. ШУТИС-ийн эрдмийн зэрэг цолтой багшийн тоо



Зураг 1.17.б. ШУТИС-ийн доктор цолтой профессор багш нарын тоо (бүрэлдэхүүн сургуулиар)


**ШУТИС-ийн профессор багш нарын ангилал**
*Хүснэгт 1.11*

Он	Салбар, тэнхимийн эрхлэгч	Зөвлөх профессор	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Дадлагажигч багш	Нийт багш
2019	45	23	43	82	402	372	23	<b>990</b>
2020	46	20	36	84	380	366	18	<b>950</b>
2021	47	21	42	92	368	346	17	<b>933</b>


2020 оны 1 сарын байдлаар 13 бүрэлдэхүүн сургуулийн 953 үндсэн багш, үүн дээр 23 дадлагажигч багшийг нэмээд нийт 976 багш байсан болно. Үүний 402 буюу нийт багшийн 41,18% нь ахлах багш байгаагаас 141 (35.07%) нь докторын зэрэгтэй багш байна.

2021 оны 3 сарын байдлаар 11 бүрэлдэхүүн сургууль, 1 харья сургууль, “ШУТИС-Коосэн” ТК-ийн нийт 916 үндсэн багш, үүн дээр 17 дадлагажигч багш, нийт 933 багш байгаагаас 368 буюу нийт багшийн 39,44% нь ахлах багш ба тэдгээрийн 158 багш (43%) нь докторын зэрэгтэй багш байна.

Бүрэлдэхүүн сургуулийн 38 удирдах ажилтан, ШУТИС-ийн захиргааны 28 удирдах ажилтан, нийлээд 933 багш хичээл зааж байгаа ба ШУТИС-ийн хэмжээнд докторын зэрэгтэй багш 44,6%-ийг эзэлж байна.



**Зураг 1.18. ШУТИС-ийн доктор зэрэгтэй ахлах багшийн эзлэх хувь (2021 оны 3 сарын байдлаар 368 ахлах багш)**



**Зураг 1.19. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудын салбар тэнхимийн тоо**

2020-2021 оны хичээлийн жилд 12 бүрэлдэхүүн сургуулийн 36 салбар 11 тэнхимтэй үйл ажиллагаа явуулав.

### Бүрэлдэхүүн сургуулиудын орон тоо

Хүснэгт 1.12

№	Бүрэлдэхүүн сургууль	Удирдах ажилтны тоо	Захиргааны ажилтны тоо	Сургалтын ажилтны тоо	Үйлчилгээний ажилтны тоо	Багшийн тоо	НИЙТ оюутны тоо	Нэг багшид ноогдох оюутны тоо
1	БАС	3	8	14	23	104	2259	22
2	БУХС	3	8	13	24	96	1042	11
3	БАТС	3	3	2	2	11	459	42
4	ДаТС	3	7	17	22	69	1008	15
5	ГХС	4	5	6	1	83	187	2
6	ГУУС	3	10	25	18	93	1517	16



7	МехТС	3	10	22	28	72	1357	<b>19</b>
8	МХТС	4	11	20	23	109	1791	<b>16</b>
9	ҮТС	3	8	21	25	72	1302	<b>18</b>
10	ХШУС	3	5	21	13	103	362	<b>4</b>
11	ЭХС	3	8	22	12	67	1936	<b>29</b>
12	ЭрЦС	3	15	12	19	38	356	<b>9</b>
13	НБТ						13	
14	“ШУТИС-Коосэн” ТК	2	3	1	1	16	184	
	<b>нийт</b>	<b>40</b>	<b>109</b>	<b>196</b>	<b>218</b>	<b>933</b>	<b>13773</b>	
1	ШУТИС-ийн захиргаа	28	109	8	115			
2	АС	2	4	3	3	21	393	
3	МСҮТ	3	4	1		30	673	
4	Хүрээлэн	4	20		7			
	<b>БҮГД</b>	<b>77</b>	<b>238</b>	<b>208</b>	<b>336</b>	<b>984</b>	<b>14839</b>	

### 1.4.3. ЦАХИМ СУРГАЛТЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШУТИС-ийн хэмжээнд цар тахлаас хамааран сургалтын үйл ажиллагаа 2020 оны 11 сарын 11-нээс эхлэн цахим хэлбэрт шилжсэн. ШУТИС-ийн хэмжээнд намрын улиралд 1517 хичээлийн 51045 файл, хаврын улиралд 1517 хичээлийн 57488 файл системд байрлуулсан байна.

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд нийт 3968 хичээлд 110807 цахим хичээлийн файл системд оруулсан байна (Хүснэгт 1.13).


### ШУТИС-ийн профессор багш нарын цахим сургалтын системд оруулсан хичээлийн файлын тоо

*Хүснэгт 1.13*

Бүрэлдэхүүн сургууль	Хичээл	Лекц	Семинар	Лаборатори	Практик	Бие даалт	Бусад	Пост	Даалгаврын гүйцэтгэл	Е хичээл	Нийт
БАС	444	3,549	1,455	332	932	959	374	297	366	167	<b>8,431</b>
БУХС	312	4,464	3,474	128	142	382	693	122	300	153	<b>9,858</b>
ДаТС	588	5,770	3,610	1,558	1,946	935	275	184	303	155	<b>14,736</b>



ГХС	180	995	1,732	4	7,294	1,000	793	479	438	178	<b>12,913</b>
ГУУС	554	5,149	3,891	1,158	256	488	392	155	665	176	<b>12,330</b>
МехТ С	341	3,705	1,517	725	172	577	517	130	74	136	<b>7,553</b>
МХТС	333	4,992	3,104	2,512	48	549	612	315	412	140	<b>12,684</b>
ҮТС	420	2,810	950	1,363	36	209	174	145	81	30	<b>5,798</b>
ХШУС	190	4,570	2,910	1,839	450	983	1,044	398	802	99	<b>13,095</b>
ЭХС	453	6,161	2,245	1,048	137	435	529	216	372	191	<b>11,334</b>
БАТС	153	1,008	590	-	72	111	240	29	18	7	<b>2,075</b>
<b>нийт</b>	<b>396</b>	<b>4317</b>	<b>2547</b>	<b>1066</b>	<b>1148</b>	<b>6628</b>	<b>5643</b>	<b>247</b>	<b>383</b>	<b>143</b>	<b>11080</b>
	<b>8</b>	<b>3</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>5</b>			<b>0</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>7</b>



**Зураг 1.20. Цахим сургалтын системд оруулсан файлын тоо**

Нийт 3968 хичээлийн файлын 39%-ийг лекцийн материал, 23%-ийг семинар, 10%-ийг лаборатори, 6%-ийг бие даалт, 2%-ийг пост, 1%-ийг Е-хичээлийн файл эзэлж байна.


Нэмэлтээр оруулсан нийт хичээлийн файлын 33%-ийг лекцийн хичээлд, 19%-ийг семинар, 13%-ийг лаборатори, 5%-ийг бие даалтын хичээл дээр нэмэлтээр оруулсан байна (Хүснэгт 1.14).



**Профессор багш нарын цахим сургалтын системд оруулсан  
хичээлийн нэмэлт материалын тоо**


*Хүснэгт 1.14*

Бүрэлдэхүүн сургууль	Лекц	Семинар	Лаборатори	Практик	Бие даалт	Бусад	Нийт
БАС	2,194	789	396	801	287	412	<b>4,879</b>
БУХС	872	691	116	59	109	177	<b>2,024</b>
ДаТС	72	81	78	19	10	15	<b>275</b>
ГХС	435	1,084	28	3,162	351	610	<b>5,670</b>
ГУУС	443	286	197	35	75	217	<b>1,253</b>
МехТС	1,218	558	404	133	300	327	<b>2,940</b>
МХТС	1,248	776	419	11	92	311	<b>2,857</b>
ҮТС	301	171	489	41	20	133	<b>1,155</b>
ХШУС	1,064	214	736	511	101	805	<b>3,431</b>
ЭХС	1,295	367	692	170	143	391	<b>3,058</b>
БАТС	327	289	-	72	37	11	<b>736</b>
<b>НИЙТ</b>	<b>9,469</b>	<b>5,306</b>	<b>3,555</b>	<b>5,014</b>	<b>1,525</b>	<b>3,409</b>	<b>28,278</b>



*Зураг 1.21. Цахим сургалтын системд оруулсан  
нэмэлт материалын тоо*





**Зураг 1.22. Цахим сургалтын системд хэрэглэж буй компьютерын судалгаа (2021 оны 01 сарын байдлаар)**

Бүрэлдэхүүн сургуулиуд дээр нийт 2606 суурин компьютер, 575 зөөврийн компьютер, 128 ширхэг Айпад ашиглагдаж байна. Дунджаар нэг сургуульд 237 суурин, 53 зөөврийн компьютер хэрэглэгдэж байна.

### **Microsoft Office 365, Teams програмуудыг ШУТИС-ийн онлайн сургалтад нэвтрүүлж ажилласан талаар мэдээлэл**


ШУТИС-ийн UNIMIS системийг дэмжин, багш оюутнуудын харилцааг дижитал орчинд шилжүүлж сургалтыг холимог аргаар явуулах зорилгоор 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлаас хэрэглэж эхэлсэн Microsoft Office 365 системийг А1 лицензтэйгээр ашиглах ажлыг үргэлжлүүлэн хариуцаж ажилласан.

Microsoft Office 365 платформыг Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн 21119 оюутан 1800 багш Faculty болон Student лицензээр ашиглаж байна. Шинээр ДаТС-ийн бүртгэл болон бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын бүртгэл хийгдсэн. Нууц үгээ мартсан оюутан, багш нарын нууц үгийг сэргээх болон багш нарт системийг ашиглахад арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөж ажилласан. Нийт зөвлөгөө болон нууц үг сэргээх үйлчилгээг давхардсан тоогоор ойролцоогоор 8000 гаруй. Үүнээс зөвхөн нууц үг сэргээхэд давхардаагүй тоогоор 4800 оюутан хандаж сэргээлгэсэн байна.



MS Office 365 программыг ашиглахтай холбоотойгоор зөвхөн 2020.11.11 - 2020.12.21 хооронд 3000 гаруй утасны дуудлага /өдөр 50-100 дуудлага/ -д хариу өгч 1500 мэйл-д хариу өгч багш, оюутнуудын нууц үг сэргээх, хэрэглээтэй холбоотой үүссэн асуудалд хариу өгч шийдвэрлэсэн. 2020.12.09-ний өдрөөс бүртгэл болон нууц үг сэргээх процессыг өөрчлөн Microsoft Form ашиглан 963 оюутанд үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүний үр дүнд Microsoft office 365-д 15000 хэрэглэгч идэвхтэй байж өдөрт Microsoft Office-ийг 8700 хэрэглэгч Microsoft Teams-ийг 3000-4000 хэрэглэгч, OneDrive-ийг 8617 хэрэглэгч ашиглаж, 1,3 терабайт файл /227135 ширхэг/ хадгалагдсан байна. Microsoft Form-д 1023 form, асуулт-quiz үүсгэгдэж 5209 хэрэглэгч идэвхтэй ашигласан байна. Үүнээс 2020.11.11-ээс хойш 640 quiz үүсгэгдсэн байна. Microsoft Office 365 хэрэглэгчийн эрхээр “Testportal” тестийн апп ашиглан олон багш нар шалгалтуудаа зохион байгуулж авсан. ШУТИС-ийн нийт багш ажилтан, оюутнуудын ашиглаж буй Microsoft Teams аппликашинээр 2020-2021 оны хичээлийн жилд нийт 3137 бүлэгт хуваагдан 35 сая минутын аудио дуудлага, 29 сая минутын видео дуудлага, 6,7 сая минутын хугацаанд дэлгэцээ бусадтай хуваалцаж, 2515 уулзалт зохион байгуулагдан 824 удаа 1:1 дуудлага хийгдсэн байна.


### Microsoft Office 365 хэрэглэгчид



2020-2021 хичээлийн жилийн намрын улиралд Office 365-д багтдаг программуудыг ашигласан хэрэглэгчдийн өдөр тутмын дундаж хандалтын үзүүлэлт.



## Microsoft Teams-ийн хэрэглэгчдийн тоон үзүүлэлт




Microsoft Office 365-ийн 11,441 аппликашн ашиглаж /Microsoft Teams хамаарагдах/ Third-party - 1333 ширхэг гуравдагч аппликашн ашигласан байна.

## Microsoft OneDrive /Файл хадгалалт/

OneDrive files

**766.0K files stored** ▲ 9.9%


Latest number of files in OneDrive



Нийт хэрэглэгчдийн 4.9 ТВ файл хадгалагдсан байна. Үүнд багш нарын хичээлийн болон бусад файлууд, зарим видео файлууд багтсан болно.




## Microsoft Share



SharePoint-д нийт 28ТВ файл хадгалагдаж байна. Үүнд Microsoft Teams ашигласан хэрэглэгчдийн хоорондоо солилцсон файл /Video, Document, Audio/ болон бүх бичлэгүүд хамрагдсан.

## Microsoft Outlook



ШУТИС нь Google GSuite болон Microsoft Exchange үйлчилгээг хослуулан ашиглаж байгаа бөгөөд Microsoft Exchange үйлчилгээгээр дамжин өдөрт дамжуулагдаж буй е-мэйл болон идэвхтэй хэрэглэгчдийн тоо багтсан.


Өдөрт Microsoft Exchange үйлчилгээгээр дунджаар 312GB файл дамжуулагдаж 20,6 мянган е-мэйл солилцдог.

## Microsoft Forms уулзалт

Forms activity

**15.7K activities** ▼ 4.7%

Total forms created and responses submitted over the selected time period



2021 оны 5 сарын 15 хүртэл Microsoft Form программын ашиглан 15700 удаагийн уулзалт хийсэн байна.

### Гарын авлага, социал пост



Microsoft office 365-ийг ашиглах 50 хуудас бүхий гарын авлага, зарим нэг мэдээллийг хүргэхтэй холбоотойгоор 41 хуудас бүхий социал пост бэлтгэн ШУТИС-ийн багш, оюутнуудад зориулсан гарын авлага болон социал


постуудыг хийж багш, оюутнуудад Facebook /ШУТИС-багш, ШУТИС-ийн цахим хуудас/ -ээр дамжуулан хүргэсэн.

### Видео контент

Microsoft office 365-ийг ашиглах Видео контентыг Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн багш, оюутнуудад зориулсан 30 минутын видео контентыг Microsoft Teams, Forms, Exchange Outlook, Assignment зэрэг функцүүдийг ойлгомжтойгоор хийж багш, оюутнуудад Facebook /ШУТИС-багш, ШУТИС-ийн цахим хуудас/ хуудсаар дамжуулан хүргэсэн.

### Видео хичээл

КОВИД-19 цар тахлын үед ШУТИС-д олон оюутан судалдаг суурь ухааны 11 хичээлийн 148 лекц, семинарын нийт 3590 минут бүхий 59.8 цагийн видео хичээл Lightboard технологийг ашиглан чанартайгаар бэлтгэж хариуцсан салбар, тэнхим, профессор багш нарт нийтдээ 2.53 ТВ хэмжээтэй видео файлуудыг хүлээлгэн өгсөн.



Үүнд:


- Мэргэжлийн Япон хэл - 3 лекц (Нийт 22 минут)
- Механикийн зохион бүтээл -7 лекц (Нийт 143 минут)
- Математикийн - 23 лекц (Нийт 707 минут)
- Материалын эсэргүүцэл хичээл - 12 лекц (Нийт 179 минут)
- Монголын түүх хичээлийн - 2 лекц (Нийт 37 минут)

- Ердийн дифференциал тэгшитгэл – 14 лекц (Нийт 469 минут)
- Химийн хичээл -17 лекц (Нийт 522 минут)
- Магадлалын онол – 17 лекц (Нийт 466 минут)
- Физик – 28 лекц (Нийт 851 минут)
- Онолын механик – 5 лекц (Нийт 136 минут)
- Машины эд анги – 5 лекц (Нийт 58 минут)

#### 1.4.4. ДЭЭД БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

БШУС-ын сайдын 2020 оны 05 сарын 07-ны өдрийн А/223 тоот тушаалаар Төвлөрсөн бус мэдээллийн маягт шинэчлэгдэн ДБУМС-Дээд боловсролын мэдээллийн системд бүртгэл үүсгэж эхлэв.

Дээд боловсролын мэдээллийн систем (ДБУМС) нь – ШУТИС-ийн байгууллагын санхүү, сургалтын орчин, тусгай зөвшөөрөл, сургалтын хөтөлбөр, сургалтын агуулга, суралцагч, дүн үнэлгээ, төгсөлт, гадаад боловсрол, санхүүгийн дэмжлэг, ажилтан, багш, төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээ, төгсөгчийн судалгаа, лавлагаа, дата импорт, тайлан, асуулга зэргийг БСШУЯ-ны мэдээллийн санд судалгааны мэдээллээ оруулдаг систем бөгөөд үндсэн 22 хэсгээс бүрддэг (Зураг 1.23).



Зураг 1.23. Дээд боловсролын мэдээллийн системд нэвтэрсэн байдал



Үндсэн хэсгүүдэд хамаарагдах мэдээллийг 26 төрлийн асуулгатай “Асуулгын маягт”-ын дагуу 25 асуулгатай “Бүртгэлийн маягт”, 46 төрлийн судалгааг багтаасан “Дээд боловсролын салбарын статистикийн захиргааны маягт” гээд нийт 97 маягтыг заасан хугацаанд бүртгэж тухайн жилийн 10 сарын 15, 2 сарын 15, 2 сарын 20, 3 сарын 15, 7 сарын 25-ны өдрүүдэд багтаан Дээд боловсролын мэдээллийн системээс тайлан оруулсан.

#### **1.4.5. ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОДОТГОЛ**

ШУТИС-ийн 2020 оны төсөвт 2 удаа тодотгол хийсэн. ШУТИС-ийн УЗ-ийн 12 дугаар сарын 07-ны өдрийн 14 тоот тогтоолоор дараах үндэслэл шаардлагаар тодотгол хийж орлогын төсвийг 58,020.3 сая төгрөгөөр, зарлагыг 56,851.8 сая төгрөгөөр баталсан. Үүнээс гадна нийт хөрөнгө оруулалтын зардлаас нэн шаардлагатай 689.4 сая хөрөнгө оруулалтын ажлуудыг хийхээр, 579.4 сая төгрөгийн ажлуудыг хойшлуулахаар нийтдээ 3.4 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт худалдан авалт хийхээр батлуллаа.

- Цар тахлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой Монгол улсын шадар сайд, Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, БШУСайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны 08 дугаар сарын 5-ны өдрийн “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаал, Улсын Онцгой комиссын 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэр, Улсын Онцгой комиссын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 02 тоот “Албан даалгавар”-ын дагуу цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлыг хангах чиглэлээр орчны эрүүл ахуйг сайжруулах, багш нарын цахим хичээл бэлтгэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, цахим хичээл бэлтгэхэд анхаарах чиглэлийн дагуу арга хэмжээ авахад зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж засвар тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай болсон.
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгж, захиргаа нь БШУСайдын А/43, А/95 тоот тушаалуудын дагуу цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг явуулах болсноор зайлшгүй тулгамдсан бус, тэвчиж болох гадаад дотоод томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх, шатахуун, тээвэр, нэн шаардлагатай бус хөрөнгө оруулалт, худалдан авалт, урсгал засварын ажлуудыг бууруулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, гүйцэтгэх, түүнд хяналт тавьж ажиллах зайлшгүй шаардлага гарсан.





Нийт орлогын 59.6 хувь нь сургалтын төлбөрийн орлого байна. Нийт зардлын 61.2 хувь нь сургалттай холбоотой шууд зардал байна.

Цар тахалтай холбоотойгоор ШУТИС-ийн 2020 оны төсвөөс цар тахлын үед сургалтын үйл ажиллагааг цахимаар явуулахад шаардлагатай анги танхим, сургалтын орчныг бүрдүүлэх, багш нарт компьютер техник хэрэгсэл худалдан авах ажлын хүрээнд 585.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

ШУТИС-ийн 2021 оны төсвийг ШУТИС-ийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, хуулиар олгогдсон орлогын төрлүүд дээр нэмэлт орлогын даалгаврыг сургуулиудад даалгах, сургалтын орчны шинэчлэл хийх, Green university, цахим сургалтын платформ шинэчлэх, MUST Professors App+ERP систем хөгжүүлэлтийг хийхээр төсөвлөсөн онцлогтой төсөв байсан бөгөөд УЗ-ийн 12 дугаар сарын 17-ны өдрийн 16 тоот тогтоолоор төсвийн орлогыг 62,262.5 сая төгрөгөөр, зарлагыг 61,782.5 сая төгрөгөөр үүнээс 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хийхээр батлуулсан.

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтуудын хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг 2021 оны төсөвтэй уялдуулж 2022 оны төсвийг төслийн эхний хувилбарыг “Төсвийн программ”-ын дагуу гаргасан байгаа болно. Мэдээллийн технологийн төвтэй хамтран программчилсан бөгөөд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдээс ирүүлсэн саналын дагуу нэмэлт өөрчлөлтүүдийг хийж 2022 оны төсвийн төслийг боловсруулан нэгтгэл гарсан байна.

Төсвийн программд <http://203.217.139.9/Budget/#> линкээр ороход бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн төсөв боловсруулагдсан байгаа юм.

Түрэмэг	2022 Нийт дүн	Сургалт (Иажал,догд)	МСТГов	Оюутны байр	Ахлах сургууль	Гэрээт ажил, төсөл	Тур сургалт
Шилжих үлдэгдэл	300,000.0	0.0	0.0	0.0	0.0	300,000.0	0.0
> I. Сургалтын төлбөрийн орлого	0,079,914.2	0,079,914.2	0.0	0.0	0.0	0.0	0.0
> II. Тур сургалтын орлого	80,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	80,000.0
> III. Оюутны байрны орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
> IV. Эрдэм шинжилгээний орлого	448,000.0	0.0	0.0	0.0	0.0	448,000.0	0.0
> V. Туурхайн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
> VI. Буцаа орлого	38,000.0	38,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
> VII. Төсвөөс санхүүжилт	19,000.0	19,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
> VIII. Сургууль хоорондын кредит цаг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
> Санхүүжилт	7,119,402.5	7,119,402.5	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт орлого	14,051,318.7	13,258,318.7	0.0	0.0	0.0	748,000.0	80,000.0

Зураг 1.24. ШУТИС-ийн төсвийн программ хангамж



Тухайн программд бүрэлдэхүүн сургуулиудын орлого, зарлагын төсөв, цалингийн тооцооны хэсэг нь эксел программ руу хөрвөх, зарим зардлын задаргаануудад нэмэлт өөрчлөлтүүдийг нэмж хийсэн болно.

2021-2022 оны хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээний саналыг ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 8-ны хурлаар хэлэлцүүлж Удирдах зөвлөлд оруулан танилцуулсан.


#### **1.4.6. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн “ШУТИС-ийн Захиргааны бүтцэд өөрчлөлт оруулах тухай” 06 тоот тогтоол, 2018 оны 12-р сарын 21-ний өдрийн “ШУТИС-ийн зарим нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх тухай” 17 тоот тогтоолыг үндэслэн Мэдээллийн технологийн төвийг 2019 оны 01-р сарын 24-ний өдрийн А/24 тоот захирлын тушаалаар захиргааны бүтцэд шилжүүлсэн.

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний 5 тэргүүлэх чиглэл хариуцлагатай, хурдацтай өөрчлөлтөд нийцэх өндөр бүтээмжийн төлөө ухаалаг менежментийг явуулах ажиллах, суралцах судалгаа хийхэд тохиромжтой орчин дэд бүтцийг бүрдүүлж хэвийн байлгах зорилтын хүрээнд үндсэн 3 зорилтыг зорилго болгон ажиллаж байна. Үүнд:


- Их дээд сургуулийн удирдлагын мэдээллийн системийг процессын реинженерингтэй уялдуулан загварыг тодорхойлж боловсруулах;
- Бусад мэдээллийн системүүдийг улам боловсронгуй болгох;
- Мэдээллийн аюулгүй байдал хамгааллыг хангах;

Их, дээд сургуулийн удирдлагын мэдээллийн систем нь дараах үндсэн болон дэд модулиас бүрдэн ажиллаж байна.



Зураг 1.25. Их сургуулийн удирдлагын мэдээллийн системийн бүтэц

2020-2021 оны хичээлийн жилийн (хавар, намрын) зорилтын хүрээнд Мэдээллийн технологийн төв нь дараах 7-н багц ажил, программ хангамжуудыг хийж гүйцэтгэлээ.




Зураг 1.26.. Программ хангамжийн хөгжүүлэлт




Мэдээллийн технологийн хүрээнд шинээр хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ.

### 1. Цахим сургалтын вэб - Багш:

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутнуудад зориулсан зайн сургалтын систем нь хүртээмжтэй, нээлттэй, чанартай, сургалтын орчин бий болгох багш, оюутанд интернэт орчинд хичээл заах, оюутан зайгаар хичээл сурах боломжтой.



Зураг 1.27. ШУТИС-ийн багшийн веб хуудас.



Зураг 1.28. ШУТИС-ийн багшийн веб хуудас.



## Цахим сургалт

U.CS101 Алгоритм ба програмчлал / Programms Language of Algorithm / Кредит 3

Хичээлийн стандарт    Сэдэвчилсэн төлөвлөгөө    Сурах бичиг

**Товч тодорхойлолт**

Уг хичээлээр програмчлалын Си хэлэн дээр тулгуурлан бүтэцлэгдсэн програм хөгжүүлэх арга техникуудийг үзнэ. Сэдвүүд: Си хэл дээрх бүтэцлэгдсэн програмчлал, функц, массив, заагч, тэмдэгт мөр, хэлбэржүүлсэн оролт/гаралт, бүтэц, нэгдэл, тоочих төрөл, файл боловсруулалт, үндсэн өгөгдлийн бүтцүүд, хөрвүүлэгчийн директив.

**Хичээлийн зорилго**

Оюутанд олон улсад хүлээн зөвшөөрөгдөхийц компьютерийн суурь мэдлэгийг олгох. Оюутан нь сурах үйл ажиллагаандаа компьютерийг ашиглаж сурах болон хэрэглээний программуудыг ашиглах мэдлэг, чадвартай болгох.

**Оюутанд олгох мэдлэг**

Мэдээллийн Технологи, компьютерийн техник хангамж, програми хангамжийн ерөнхий мэдлэгийг буюу Олон Улсын Компьютерийн боловсролын гэрчилгээ(ОУКБГ-ICDL) олгох сургалтын эхний 1.2,3,4,6 модулийн агуулгад дуйцах мэдлэгийг оюутанд олгоно.

Чадвар

**Зураг 1.29. Хичээлийн мэдээлэл.**  
(Стандарт, леки, семинар, лаборатори, практик, бие даалтын сэдэвчилсэн төлөвлөгөө, сурах бичиг)

## 2. Цахим сургалтын шинэ программ, вэб - Оюутан:

Цахим сургалт

Нүүр

<p><b>G.DDA304</b> Бүтэцлэгдсэн төлөвлөгөө, борлуулалт</p> <p>Үнэ</p>	<p><b>G.DDA306</b> Хувьсаны загварчлал</p> <p>Үнэ</p>	<p><b>G.DDA307</b> Сүлжээний дагалцан</p> <p>Үнэ</p>
<p><b>G.DDA350</b> Ундэвэрлэлийн дагалца</p> <p>Үнэ</p>	<p><b>G.TSB304</b> Өмнөх бүтэцлэгдмүүний технологи</p> <p>Үнэ</p>	<p><b>G.TSB315</b> Сүлжээний хувьсаны зохион бүтээлт</p> <p>Үнэ</p>
<p><b>G.TSB316</b> Хуудсийн хувьсаны зохион бүтээлт, технологи</p> <p>Үнэ</p>		

Chat


- Anno Sthessa Just now
- Paul Mollie Admin
- Anno Mull Admin
- Paige Turner Admin
- Bob Pripples Admin
- Barb Ackus Admin
- Oreta Ulf Admin
- ra Member Admin
- Peta Scrips Admin
- ra Member Admin

**Зураг 1.30. Цахим сургалтын шинэ программ, вэб (хичээлийн файл)**




### 3. Шинэ хүний нөөцийн систем:

ШУТИС-ийн багш, ажилтан, албан хаагчдын мэдээллийг хадгалах цахим орчинг бий болгох хүний нөөцийн бүртгэлийн үйл ажиллагааг хөнгөвчлөх нь программын зорилго юм.




Зураг 1.31. Цахим сургалтын шинэ программ (хичээлийн файлын хэсэг)



Зураг 1.32. ШУТИС-ийн хүний нөөцийн бүртгэлийн программ хангамж.

#### 4. Шинэ эрдэм шинжилгээний цахим хуудас:



Зураг 1.33. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем.

#### Эрдэм шинжилгээний систем:

ШУТИС –ийн багш, албан хаагчдын өгүүлэл, нийтлэл, бүтээл, зохиогчийн эрх, төсөл гэх мэт эрдэм шинжилгээний холбогдолтой ажлуудыг бүртгэх бүртгэлийн систем. Эрдэм шинжилгээний ажлуудыг бүртгэж цахимаар хадгалах, В цагийн тооцоо гаргах баталгаажуулах зэрэг зүйлсийг хийнэ.



Зураг 1.34. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн системийн давуу тал



1. ШУТИС-ИЙН ЭШИ-ИЙН ДИНАМИК ВЭБИЙГ ШИНЭЧИЛСЭН ХӨГЖҮҮЛЭЛТ



- Танилцуулга
- Судалгааны орчин
- Бүх төсөл хөтөлбөрүүд
- Судалгааны үр дүнгийн нэгдсэн мэдээлийн сан
- Технологи, инноваци
- Түншлэл, хамтын ажиллагаа

2. ЭШИ-ИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ



- Нэвтрэх
- Үйл явдал, мэдээ мэдээлэл
- ЭШИ-ийн төлөвлөгөө, тайлан дүн
- Б цагийн тооцоо
- Цахим архив, тайлан инфографик
- Агуулга оруулалт, засвар, тестчлэл

*Зураг 1.35. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн системийн бүтэц*





*Зураг 1.36. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний статистик мэдээллийн хэсэг*

**5. Гар утасны аппликейшн-Оюутан:**

ШУТИС-ийн оюутнуудад сургалтын хүртээмжтэй, нээлттэй, чанартай, сургалтын орчин бий болгох бөгөөд оюутны аппликашин нь хичээлийн хуваарь харах, сонголт хийх, хичээлийн файлаа үзэх, бие даалт илгээх, нэмэлт даалгавар илгээх, хувийн мэдээлэл харах, төлбөрийн мэдээлэл харах зэрэг модулиудтай.





Зураг 1.37. ШУТИС-ийн оюутны аппликашин.



## 6. Гар утасны аппликашин – Багш:

ШУТИС-ийн багшид зориулсан багшийн вебийн чухал модулиудыг агуулсан гар утасны аппликашин юм.



Зураг 1.38. ШУТИС-ийн багшийн аппликашин.


## 7. QR бүртгэлийн систем & Админ:

ШУТИС –ийн багш, ажилтан, албан хаагчдын QR бүртгэлийн систем нь регистрийн дугаар, хэрэглэгчийн нэр, кодыг ашиглан бүртгэл хийнэ.



Зураг 1.39. ШУТИС –ийн багш, ажилтан, албан хаагчдын QR бүртгэлийн систем

## 8. Багшийн вэбд шинээр Төгсөлтийн комиссын гишүүдийг бүртгэх, шийдвэр, тогтоол хэвлэх программ хангамжийн модуль





*Зураг 1.40. ШУТИС –ийн төгсөлтийн комиссын программ хангамжийн бүтэц*

- Төгсөлтийн комиссын жагсаалт харагдах цонхны **гишүүд** дарна.
- Дараах цонх гарч ирэх бөгөөд комиссын гишүүн нэмэх товчлуур дээр дарахад төгсөлтийн комиссын гишүүн бүртгэх хэсэг харагдана.
- Бүртгэх хэсэгт комиссын гишүүний үүрэг болон багшийн кодыг оруулаад товчлуур дарж хадгална.
- Төгсөлтийн комисст комиссын гишүүдийн бүртгэл жагсаалтаар үүсэх ба тэмдэг дээр дарж бүртгэлээс устгана. Комиссын гишүүнээр бүртгэгдсэн багш нарын цагийн тооцоонд төгсөлтийн хичээл автоматаар орж кредит нь буцна
- Диплом хамгаалсны дараа төгсөлтийн комиссын шийдвэр, тогтоолыг хэвлэнэ.

### 8. Ухаалаг ШУТИС:

Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийг Green smart university болгон хөгжүүлэх ажлын хүрээнд техникийн судалгааг хийж ажилласан.



Зураг 1.41. ШУТИС-ийн үүдэнд байрлах ухаалаг самбар

### 9. Сургалтын албаны программ:

Сургалтын албаны программ нь оюутан анх элсэн ороход бүртгэлээс эхлээд хичээл сонголт, дүн, хавсралт хэвлэх зэрэг бүхий л үйл ажиллагааг явуулна. Мөн шаардлагатай тайлан нэгтгэлүүдийг гаргана.



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Сайн байна уу, Bilguun

Сургалтын албаны програм > Багшийн 70 онооны задаргаа

Нүүр

Лавлах

Тохируулга

Оюутан

Тодорхойлолт

Хичээлийн цагийн хуваарь

Мэргэжлийн тодорхойлолт

Хичээл

Хичээл сонголт

Дүнгийн бүртгэл

Буцах

Багшийн 70 онооны задаргаа - Бүртгэх

Багшийн код: Бүх багш

Хичээлийн задаргаа: Сонго

Үнэлгээний төрөл: Сонго, **Практик 1**, Семинар, Лаборатор, Практик

Оноо:

Хадгалах

**Зураг 1.42. Хичээлийн үнэлгээний задаргааны хэсэг /S.PT101 Хичээлийн 70 оноо задаргаа практик1 нэмэгдсэн/**

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Сайн байна уу, Bilguun

Сургалтын албаны програм > Дүнгийн онооны хуудас

Дүнгийн онооны хуудас

Угирал: Хавар

Суралцаж буй хэлбэр: Өдрийн анги

Багшийн код:

Хичээлийн код:

PDF-р хэвлэх

Excel рүү гаргах

Хэвлэх

Хичээлээр

Багшаар

**Excel рүү гаргах**

У хэвлэх

Хичээл сонголын нэрс

Багшийн үнэлгээний хуудас

Шалгалтын хуудас

Е-Сургалтын шалгалтын хуудас

Дүнгийн онооны хуудас

Оюутны сонголын нөхцөл

Оюутны дүнгийн жагсаалт

Үнэлгээний гом

Хавсралт

Оюутны сонголын хуудас

Эрх

**Зураг 1.43. Хичээлийн онооны хуудас хэвлэх хэсэг. (E, U хэвлэдэг болсон)**



ID	Оюутны код	Оюутны нэр	Сургууль	Сурвалж өгөх өдөр	Төлөөлөгч өдөр	Төлөөлөгч өдөр
1	A1000001	САНЖАА	АМРСАЙХАН	УХ9103205	Өдөйгөө өгч	2000.09.09
2	A1000002	МАРГАТ	ДАРХАН	БХ0901001	Өдөйгөө өгч	2010.09.18
3	A1000003	БАЛГААР	САЙНГААР	У30400030	Өдөйгөө өгч	2010.09.19
4	A1000004	БАЛГААР	МЭНДЭГЭЭ	ВХ0901002	Өдөйгөө өгч	2010.09.20
5	A1000005	БАЛГААР	БАЛГААР	НХ0901013	Өдөйгөө өгч	2007.09.14
6	A1000006	МАРГАТ	МАРГАТ	УТ9100012	Өдөйгөө өгч	2000.09.24
7	A1000007	МАРГАТ	ЗОСМА	Ч079100076	Өдөйгөө өгч	2010.02.19
8	A1000008	МАРГАТ	МАРГАТ	ХХ0900078	Өдөйгөө өгч	2010.02.19
9	A1000009	МАРГАТ	МАРГАТ	ЗТ9100019	Өдөйгөө өгч	2000.09.09

**Зураг 1.44. Бүртгэлд оюутан шинээр нэмэх хэсэг (Төв, Дархан, Орхон сургуульд шинээр оюутан нэмэхэд оюутны код давхардлыг шалгадаг болсон)**

**10. Багшийн цахим хуудас:**

Багш, ажилтнуудад зориулсан хувийн мэдээлэл, хичээлийн хуваарь, дүн оруулах, цагийн тооцоо бүхий мэдээлэл хүргэх, бүртгэх, хэвлэх боломжтой.

№	Оюутны код	Оюог нэр	Сургууль	Сөрөл I / 10	Сөрөл II / 10	Бусад / 50	Нийт
1				5,6	9,1		14,7
2				8,5	9,1		17,6

**Зураг 1.45. Оюутны хичээлийн явцыг үнэлсэн дүнг багшийн цахим хууданд баталгаажуулах хэсэг.**

ID	Оюутны код	Оюутны нэр	Шалгалтын 30.40 оноо
1			1
2			
3			
4			
5			
6			
7			

**Зураг 1.46. Оюутны 30 онооны шалгалтын дүнг багшийн цахим хуудаст оруулж баталгаажуулах хэлбэр**



2020-2021 Намрын улирлын бүх хичээлийн 70, 30 оноог багшийн цахим хуудаснаас нэгдсэн байдлаар хэвлэх хэсэг хийгдсэн.

## 11. Оюутны вэб

ШУТИС-ийн оюутнууд хичээл сонголтоо хийх болон дүн, бусад хэрэгцээт мэдээллүүдээ авах цахим хуудастай болсон.

1А улирал			1В улирал		
ID	Хичээлийн код	Хичээлийн нэр	ID	Хичээлийн код	Хичээлийн нэр
1	S.MT101	Математи I	1	S.MT102	Математи II
2	B.TM102	Микро эдийн засаг	2	B.TM103	Макро эдийн засаг
3	U.IT101	Мэдээллийн технологийн хэрэглээ I	3	S.ML103	Хэл ярианы соёл
4	S.BS102	Монголын Түүх	4	S.CE102	Харилцааны англи хэл
Нийт кредит: 12			5	S.PT101	Биеийн тамир
			6	S.CD101	Гамшгаас хамгаалалт менежмент
			Нийт кредит: 15		


2А улирал			2В улирал		
ID	Хичээлийн код	Хичээлийн нэр	ID	Хичээлийн код	Хичээлийн нэр
1	B.BA201	Менежментийн суурь ухаан	1	B.BA202	Маркетингийн үндэс
2	B.BA203	Санхүүгийн бүртгэл	2	B.BA205	Санхүүгийн менежмент
3	B.BA204	Бизнесийн эрх зүй	3	B.BA207	Бизнес төсөл
4	B.BA206	Бизнесийн харилцаа	4	B.TM201	Бизнесийн статистик

Зураг 1.47. ШУТИС-ийн оюутнууд хичээл сонголтын хуудас.

2020-2021 оны хаврын улиралд Биеийн тамирын хичээл сонгосон 1292 оюутанд Практикийн сонголт нэмсэн. Сонголт хийхэд практик сонгох өөрчлөлт хийсэн.


## 12. Номын сангийн цахим хуудас:

Шинжлэх ухаан, технологийн төв номын сангийн (ШУТТНС) шинжлэх ухаан, технологийн чиглэлийн мэдлэг мэдээллээр хангах, цахим мэдээллийн үйлчилгээ, сургалт судалгааны үйл ажиллагааг дэмжинэ.



Зураг 1.48. ШУТТНСангийн цахим хуудас





Зураг 1.49. ШУТТНСангийн цахим хуудасны хэрэглэгчийн хэсэг

### 13. Тестийн программ хангамж :

Онлайн тестийн программын гол зорилго бол оюутнууд нэгдсэн журмаар тестээ найдвартай, шуурхай өгч үр дүнгээ мэдэх болон багшийн бичиг цаастай зууралдах ажлыг арилгах, цаг заваа хэмнэн өөрийгөө хөгжүүлэх боломж нээх явдал юм.

Багш бүр хичээлийн тестийн мэдээллийн сантай байна.

- Бүх хичээлийн мэдээллийн сангаас нэгдсэн мэдээллийн сан бүрдэнэ.
- Багш нь тухайн хичээлийг зааж байгаа тохиолдолд бусад багш нарын тухайн хичээлийн тестийн санг ашиглах боломж бүрдэнэ.
- Оюутан шалгалтын дүнг тухайн үед харж хянах боломжтой.
- Хичээл, багш, оюутны тестийг нэгтгэн хянах боломжтой.

ОНЛАЙН ТЕСТИЙН СИСТЕМ

Системийн мэдээлэл: В.Ганзориг | Үйлэйн сан | Тусламж | Гарж  
Шинэчлэх: Улаан Төмөр замын Их Сургууль  
Мэдээллийн технологийн төв

Нүүр хуудас	Шалгалт хянах	Тест хөлийг	Тестийн мэдээлэл	Тайлан боловсруулалт	Бүртгэл, далавхууд	Мэдээлэл							
<b>Системийн эхлэл хуудас</b>													
№	Д/д	Хич.код	Хичээлийн нэр	Шалгалтын нэр	Шалгалтын төрөл	Шалгалт хянах	Шалгалт хөлийг	Багш	Үүсгэсэн огноо	Ба	Идэвхитэй жүжвэр	Аж	Х
1	19845	U.CS101	Алгоритм ба програмчлал	Python хэл сорил-1	Явцын сорил 1	Хянах	Хөлийг	F.EE22	2/8/2021 1:52:36 PM	□	□	□	□
2	19844	B.RS701	Орос хэл IV	ВСТУПИТЕЛЬНЫЙ ЭКЗАМЕН ПО РУССКОМУ ЯЗЫКУ ДЛЯ ИНОСТРАНЦЕВ	Бусад шалгалт	Хянах	Хөлийг	B.E579	2/4/2021 11:10:54 PM	□	□	□	□
3	19843	S.EL701	Англи хэл IV	English Test for newly enrolled master students	Бусад шалгалт	Хянах	Хөлийг	B.E561	2/4/2021 9:42:27 PM	□	□	□	□
4	19842	U.IT102	Мэдээллийн технологийн хэрэглээ II	Кредит шууд тооцох шалгалт	Кредит шууд тооцох шалгалт	Хянах	Хөлийг	F.IT43	1/27/2021 6:29:42 PM	□	□	□	□
5	19841	U.IT101	Мэдээллийн технологийн хэрэглээ I	Кредит шууд тооцох шалгалт	Кредит шууд тооцох шалгалт	Хянах	Хөлийг	F.IT43	1/27/2021 6:27:19 PM	□	□	□	□
6	19839	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
7	19838	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
8	19837	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
9	19836	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
10	19835	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
11	19834	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
12	19833	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
13	19832	S.MT101	Математик I	S.MT101 өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	E.MT47	1/22/2021 9:31:32 AM	□	□	□	□
14	19831	U.IT101	Мэдээллийн технологийн хэрэглээ I	Өвлийн улирлын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	F.IT43	1/21/2021 4:54:14 PM	□	□	□	□
15	19829	S.SS102	Монголын түүх	Монголын түүх өвлийн сургалтын шалгалт	Улирлын шалгалт	Хянах	Хөлийг	K.S569	1/21/2021 12:03:53 PM	□	□	□	□

Зураг 1.50. Намрын улиралд авсан шалгалтууд.



Нийт 316 шалгалт үүссэн. Намрын улиралд 39147 оюутанд, хаврын улиралд нийт 119 шалгалт үүссэн. ШУТИС-ийн хэмжээнд нийт 19341 оюутанд шалгалт үүссэн.

#### 14. ШУТИС цахим хуудас:

ШУТИС-ийн тухай мэдээлэл, сургуулийн хэмжээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээ, онцлох мэдээ, мэдээлэл, зарлал, статистик тоон үзүүлэлт зэргийг харах, дэд системүүд болон салбар сургуулийн цахим хуудаснуудын холбоос хаяг зэргийг харах зориулалттай.

The screenshot shows the ШУТИС website interface. At the top, there are logos for ШУТИС and the Mongolian University of Science and Technology. Below the logos is a navigation menu with items like "БИДНИЙ ТУХАЙ", "ЗАСАГЛАЛ", "СУРГАЛТ", "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ", "ОЮУТАН", "ХАМТЫН АЖИЛЛАГАА", and "САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРОУЛАЛТ".

On the right side, there are two buttons: "ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ" (blue) and "ЧУХАЛ ХОЛБООС" (yellow).

The main content area is divided into two sections:

- Left Section:** Contains radio buttons for "Дипломын дугаар" (selected) and "Регистрийн дугаар". Below it is a text input field with the placeholder "Дипломын эсвэл регистрийн дугаар оруулна уу !!". A "Хайх" (Search) button is located below the input field.
- Right Section:** A table displaying student information:
 

Овог:	БАТБАЯР
Нэр:	ГАНБАЯР
Регистр:	ГЙ89043016
Сургууль:	ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
Мэргэжил:	КОМПЬЮТЕРИЙН ТЕХНИК
Дипломын дугаар:	D201333381
Эзрэг:	БАКАЛАВР
Голч дүм:	2.42
Төгссөн он:	2013

Below the table, there is a section for "Байгууллагын нэр" (Institution Name) with a text input field containing "Байгууллага". Below the input field, there is a red error message: "Тодорхойлолт гаргаж өгөх байгууллагын нэрийг зөв алдаагүй оруулна уу!!". A "Хэвлэх" (Print) button is located below the error message. At the bottom of the page, there is a footer with the text "Гар утаснаас хэвлэж авахдаа google chrome хөтөч ашиглана уу !!".

*Зураг 1.51. ШУТИС-ийн төгсөгчдийн мэдээлэл хэвлэх хэсэг шинээр хийгдсэн*

#### 15. “ШУТИС-КООСЭН” Технологийн коллеж:


“ШУТИС-КООСЭН” технологийн коллежийн сургалтын алба, багш, оюутан, хүний нөөцийн программ, цахим сургалтын программ. /Өгөгдлийн баазыг төв сургуулийн баазтай ижил болгож бүрэлдэхүүн сургуулиудтай адилхан үйлдлүүдтэй болгох/

#### 16. Мэдээлэл холбоо технологийн сургуулийн Moodle системийн холболтын service хөгжүүлэлт:


Мэдээлэл холбоо технологийн сургуулийн багш нарын хичээлийн хуваарийг харуулах вэб сервис /REST/ бэлтгэсэн.

## 17. EDX.EDU.MN /засвар өөрчлөлтүүд/

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Нээлттэй боловсролын төвд зориулсан энэ сургалтын систем нь хүртээмжтэй, чанартай, сургалтын орчныг бий болгох



Зураг 1.52. НБТ-ийн цахим хуудасны шинэчлэлт.



Зураг 1.53. НБТ-ийн цахим хуудасны курсийн сургалт.

## 18. Элсэлтийн цахим хуудас:

ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагчийн мэдээллийг боловсролын үнэлгээний төвөөс татаж энэхүү татсан мэдээлэл дээр үндэслэж бүлэгт бүртгэх дараа нь мэргэжил сонголт хийлгэх цахим элсэлтийн систем. SSL нь хэрэглэгчээс сервер лүү илгээж байгаа мэдээллийг encrypt буюу



шифрлэж нууцлан илгээх бөгөөд серверээс хэрэглэгчид ирж байгаа мэдээллийг ямар нэг өөрчлөлтгүй, бүрэн бүтэн байдлыг хангах механизмыг агуулж байдаг.



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬАНЫ УЛААН ТҮГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



### Бүртгүүлэх хэсэг

Жич: 2021 оны элсэгчид хамрагдана. Анхаарна уу!  
2019, 2020 оны элсэгчийн хувьд энд дарж систем рүү 2019, 2020 оны ЭЕШ дугаар болон нууц үг ашиглан шууд нэвтэрч орно.

БҮТ бүртгэлийн дугаар буюу ЕШ дугаар:

БҮТ нэвтрэх нууц үг буюу ЕШ нууц үг:

БҮТ нэвтрэх нууц үг буюу ЕШ нууц үгээ давтаж оруулна уу:

Регистр:

Жижиг: УН89111533

Овог:

Жижиг: Бат

Нэр:

### БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ.

Элсэгч та 2019, 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалт оноогоо ашиглан бүртгүүлэх бол вэб сайтын дээр байрлах нэвтрэх товчин дээр эсвэл энд дарж 2019 эсвэл 2020 оны ЭЕШ дугаар болон нууц үг ашиглан нэвтэрч орно уу.  
Хэрэв 2021 онд элсэлтийн ерөнхий шалгалт өгч байгаа бол та бүртгүүлэхдээ боловсролын үнэлгээний төв рүү нэвтэрдэг ЭЕШ дугаар болон нууц үг эз оруулж бүртгүүлнэ үү!  
Элсэгч та бүртгүүлэхдээ БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ-рүү нэвтэрдэг ЕШ-ын Бүртгэлийн Дугаар, нууц үг оруулахыг анхаарна уу!  
Хэрэв та ЕШ-ын Бүртгэлийн Дугаар, нууц үгээ буруу оруулсан тохиолдолд таны онооны мэдээлэл болон үндсэн мэдээлэл татагдахгүй болохыг анхаарна уу!

#### БҮТ Бүртгэлийн дугаар

### Нэвтрэх хэсэг

ЭЕШ өгсөн он: 2019 2018 2017

Бүртгэлийн дугаар

Нууц үг

48265 12345


Нэвтрэх

> Бүртгэлийн дугаар, нууц үгээ мартсан

Зураг 1.54. ШУТИС-ийн бакалаврын элсэлтийн бүртгэлийн цахим хуудас



WWW.ELSELT.EDU.MN



**Гансүх Тэмүүлэн**  
ksetsuz27@gmail.com

Элсэгчийн үндсэн мэдээлэл

Системээс гарах

Бүртгүүлсэн бүлгүүд:  
I бүлэг Төлбөр төлөгдсөн

**Санамж**

Элсэгч та ШУТИС-ийн элсэлтийн бүх бүлэгт зөвхөн бүртгүүлж боломжтой. Элсэгч та хөг болон хэднч бүлэгт бүртгүүлсэн 15000 төгрөгийн бүртгэлийн хураамж төлнө. Бүлэг сонгож, бүртгэлийн хураамж төлжөөр бүртгэлийн үйл ажиллагаа дуусна.

Элсэгчийн ерөнхий шалгалтын оноо

Сонгох	Бүлэг	Суурь хичээл	Дагалдан хичээл	Тайлбар
<input checked="" type="checkbox"/>	I бүлэг	Математик, Физик, Хими, Англи хэл, Орос хэл	Математик, Физик, Хими, Англи хэл, Орос хэл, Нийгмийн тухай мэдлэг, Газар зүй, Монгол улсын түүх, Монгол хэл, Биологи	Төлбөр төлөгдсөн
<input type="checkbox"/>	II бүлэг	Математик, Англи хэл, Орос хэл	Математик, Физик, Хими, Англи хэл, Орос хэл, Нийгмийн тухай мэдлэг, Газар зүй, Монгол улсын түүх, Монгол хэл, Биологи	Та бүртгүүлж боломжтой
<input type="checkbox"/>	III бүлэг	Ур чадвар	Математик, Физик, Англи хэл, Орос хэл	Та бүртгүүлж боломжтой
<input type="checkbox"/>	IV бүлэг	Математик, Нийгмийн тухай мэдлэг	Математик, Физик, Хими, Англи хэл, Орос хэл, Нийгмийн тухай мэдлэг, Газар зүй, Монгол улсын түүх, Монгол хэл, Биологи	Та бүртгүүлж боломжтой

**Зураг 1.55. ШУТИС-ийн элсэлтийн бүлэг сонголт**

## 19. Мэдээллийн аюулгүй байдал сүлжээ:


### ○ Аюулгүй байдал

Сүлжээний орчинд хамгаалах төхөөрөмжийг суурилуулж, тохиргоо үүсгэж, дэд сүлжээний gateway-г бүрдүүлж менежмент хийсэн бөгөөд гол үүрэг нь сүлжээний урсгал дээр хяналт тавих (ACL-access control lists), шүүлт хийх үйлчилгээг балансалсан ба мөн бусад тохиргоо, төхөөрөмжүүдийг суурилуулж гүйцэтгэсэн.

- CISCO ISR 4461 Router
- Cisco ASA-5585X Firewall
- SSL
- Encryption
- Various type of Encryption tools

### ○ ШУТИС-ийн сүлжээний топологийг шинэчлэлт

ШУТИС-ийн сүлжээний үндсэн урсгалын удирдах Cisco ISR-4461 router төхөөрөмж суурилуулсантай холбоотой дараах нэмэлт шинэ тохируулгыг хийсэн.



Зураг 1.56. ШУТИС-ийн сүлжээний топологийг шинэчлэлт

Үүнд :

- Cisco Hierarchical Model загварыг тусгаж хэрэгжүүлсэн.

Сүлжээний менежментийн үндсэн төхөөрөмж бүр дээрх ачаалал (Load Balance) -ыг тодорхойлж өгсөн.

○ **ШУТИС-ийн 8-р байрны LAN сүлжээ**

Шинээр ашиглалтад орсон хичээлийн 8-байрны сүлжээний менежмент төхөөрөмжийн тохиргоо, хэрэглэгчдийг холбох угсралт, суурилуулалтын ажлыг бүрэн хийж, хэвийн горимд ажиллаж, ашиглаж байна.


Үүнд:

• **Сүлжээний менежмент дээр:**

- Cisco ISR4461 Router, ASA5585-X Firewall, Catalyst 3750 Switch дээрх тохиргоо
- 8-р байранд Cisco Catalyst 3550 Switch-ийн тохиргоог хийсэн.

• **Сүлжээний угсралт, суурилуулалтын ажил:**

- Байр хоорондын шилэн кабелийн холболт
- 8-р байрны давхар хоорондын босоо шугамын холболт
- Давхруудын эцсийн хэрэглэгчдийг холбох



### ○ ШУТИС-ийн оюутны 1 болон 3-р байрны Wireless LAN сүлжээ

Цар тахалтай холбоотой цахимаар хичээлийн улирлыг үргэлжлүүлэх захирамжийн дагуу ШУТИС-ийн оюутны 1 болон 3-р дотуур байранд оюутнуудад зориулсан төлбөргүй утасгүй интернэт нэвтрүүлэхтэй холбоотой ажлын хүрээнд:

Үүнд:

- Хэрэглэгчийн тоо, байрны хэмжээнээс хамаарсан техникийн тооцоо гаргасан
- Дотуур байрны бүтэц зохион байгуулалтаас хамаарч сүлжээний сувагчлал хийх талаар судалгаа хийсэн
- Uniltel-ийн инженертэй холбогдож сувагчлал болон тохиргооны талаар тохирсон
- Оюутны 1-р дотуур байран дээр утасгүй интернэтийн төхөөрөмжүүдийн тохиргоо (ШУТИС-ийн үндсэн сүлжээн дээр), суурилуулалт болон сувагчлалын ажил хийсэн
- Cloud WLAN Controller-оос удирдах боломжтой болгосон.

### *ШУТИС-ийн интернэтийн үндсэн урсгал*

*Хүснэгт 1.12*

№	Салбар	Гэрээний дугаар	Хурд
1	ШУТИС сургууль	ТӨВ 402824004	ТВ 250 to 150Mbps
2	МХТС	33157841	120mbps
3	ҮТС	407308485	20mbps
4	БУХС	407391449	80mbps
5	МИС	407539544	60mbps
6	Ахлах сургууль	33136811	10mbps
7	Дархан салбар	407525981	100mbps



○ **Хэрэглэгчийн мэйл хаяг**

Онлайн сургалтын орчинд багш, оюутнууд холбогдож ажиллахад мэйл хаяг зайлшгүй шаардлагатай юм. ШУТИС-ийн бүх оюутанд зориулсан must.edu.mn мэйл хаягийг Google –ийн GSuite багцаар үүсгэсэн. Google цахим сургалтын багц болох GSuite for Education нь боловсролын систем дэх мэдээллийн технологийн дэвшил, боловсролын тогтолцоог хөгжүүлэх, багшийг чадавхжуулж ажлын ачааллыг нь хөнгөвчлөх, сурагчдын цахим хэрэглээг эрүүлжүүлэх зорилготой багц юм. GSuite давуу тал нь их дээд сургуулиудад үнэ төлбөргүй ашиглах боломжтой.

○ **Оюутнуудад зориулсан и-мэйл эрх**

Цар тахлын үед оюутан онлайн хичээл үзэхэд mail user –ийн асуудал тулгарсан бөгөөд үүнийг нэвтрүүлэхэд үнэгүй (\*.edu.\*) домэйн ашиглах шаардлага гарсан. Үүний хүрээнд:

- Google G suite educational салбарын инженертэй холбогдож ШУТИС-ийн @must.edu.mn цахим шуудангийн хаягийн хэрэглэгчийн хязгаарыг 10000 хаягаар нэмсэн
- ШУТИС-ийн бүх бүрэлдэхүүн сургуулийн бакалавр, магистр, докторын нийт 7000 гаруй оюутан mail хаягийн бүртгэл хийсэн

Name	Email	Status	Last sign in	Email usage
ACHITKHUU GALBADRAKH	b181050685@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AGHSUREN TSENGELBAYAR	b181020066@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AIDANA KHUNANBAI	b181020051@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
ALTANSHAGAI TSOOTBAATAR	b181050614@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
ALTANSUKH GANSUKH	b181030226@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARBAYASGALAN BATBAYAR	b181030518@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARBAYASGALAN NARMAND...	b181030503@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARJARIGAL TSEGEEN	b181050680@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARJARIGAL DASHDORJ	b181050660@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARSANAA BUYANAA	b181030426@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARTAIWAN SULDBAATAR	b181050418@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB
AMARTUYSHIN BUYANKHISHIG	b181050634@must.edu.mn	Active	Hasn't signed in	0 GB

**Зураг 1.57. ШУТИС-ийн бакалавр, магистр, доктор оюутнуудын мэйл хаягийн бүртгэл**






### ○ Серверийн зоны хамгаалалтыг сайжруулах

Сүлжээний серверүүд болон дотоод хэрэглэгчдийн хамгаалалтыг сайжруулахын тулд тухайн серверийн үүрэг, зориулалтыг тусгайлан нарийвчлан ярилцаад, сервер бүр ACL (Access Control List)-ийг бичиж сайжруулсан. Үүний хүрээнд:

- Сервер рүү Remote хандалт хийх нарийвчилсан тохиргоо
- Тухайн серверийн үүрэг, зориулалтаас хамаарсан портуудын тохиргоо
- Дотоод сүлжээний хостууд руу чиглэсэн хандалтуудын тохиргоо


### TEIN Евро-Азийн боловсролын нэгдсэн сүлжээний WAN холболт

Erdemnet ISP холболтын хувьд “TEIN - Trans Eurasia Information Network” ШУТИС-ийн сүлжээнээс үнэ төлбөргүй өндөр хурдаар холбогдох гарц юм.




**Зураг 1.58. TEIN Евро-Азийн боловсролын нэгдсэн сүлжээний WAN холболт**

- Хичээлийн 1, 2, 8-р байрнуудын утасгүй сүлжээ



Зураг 1.59. ШУТИС-ийн хичээлийн байрны утасгүй сүлжээ.

- **Багш ажилчдын зайнаас хандаж ажиллахад зориулан Remote, VPN холболтуудыг тохируулсан.**




Зураг 1.60. ШУТИС-ийн багш ажилчдын зайнаас хандах утасгүй сүлжээ.

#### 1.4. ШУТИС-ИЙН МУЗЕЙН ТАЙЛАН

ШУТИС-ийн музей нь ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 3 ба 5-д дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх стратегийн хүрээнд таван төрлийн ажил төлөвлөн ажиллалаа.

##### Төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 3.1:

1. Музейд шинжлэх ухаан, технологи, инновац, танин мэдэхүйн танхимыг шинэчлэн байгуулах интерьер төлөвлөлт хийгдэж байна. Биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлээр бүрэлдэхүүн сургууль, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэм шинжилгээний төв болон эрдэмтэн багш, оюутнуудаас сургалт, техник, технологи, инновацын ач холбогдол бүхий зохион бүтээсэн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн техник, төрөл бүрийн аппаратууд, технологийн загваруудын үзмэр, биет бүтээлийн цуглуулга хийх ажил хийгдэж байна. Их сургуулийн эрдэмтэн профессор багш, ажилтан нараас Монгол Улсын төрийн дээд цол хүртсэн багш-алдартнууд, Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан багш-эрдэмтэн нийт 100 шахам хүнийг алдаршуулан мөнхжүүлэхээр сургуулийн түүхэнд хөрөг, намтартай нь үлдээх альбом бүтээж байна.
2. ШУТИС-ийн хотхоны кампусын макет бүтээх, хөрөнгийн асуудлыг сургуулийн Хөрөнгө оруулалт, хангамжийн газарт хүргүүлээд байна.
3. Сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийг харуулсан стендийн интерьер төлөвлөлтийг боловсруулж байна.
4. Шинжлэх ухаан, технологи, инновацын танхимд ШУТИС-ийн түүхэн замналын он цагийн хэлхээс хийж байрлуулсны гадна хүндэт зочин төлөөлөгчийн дурсамж бичих хүндэтгэлийн ширээ, сандал шинээр хийлгэлээ.



Зураг 1.61. ШУТИС-ийн түүхэн замналын он цагийн хэлхээс

5. “ШУТИС-2021 он” Мастер төлөвлөгөөг шинэчлэн ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх Хөгжлийн стратеги төлөвлөгөөнд ШУТИС-ийн хөгжлийн “философи” Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсийн агуулга өөрчлөгдсөнтэй холбогдуулан тэдгээрийг шинэчлэн хийв.



*Зураг 1.62. ШУТИС-ийн хөгжлийн “философи” Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсийн агуулга.*

6. Музейн байнгын үзмэрийн 4 танхимын хаягжилт, дэд хаягийг шинээр хийж, Геологи эрдэс, баялгийн дээжийг 4 витринд шинээр байрлуулан олон нийтэд дэгэн үзүүлж байна





**Зураг 1.63. ШУТИС-ийн музейн үзмэрийн танхимын хаягжилт**

МУИС, ПДС, ТИС, ШУТИС, тэдгээрийн бүрэлдэхүүнд ажиллаж байсан, ажиллаж байгаа факультет, сургууль, салбар, тэнхим, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн ойн тэмдэг, эмблем, медаль, дурсгалын эд зүйл цуглуулах, музейн үзмэр болгох ажил хийгдэж байна.

**Төлөвлөгөөний Тэргүүлэх чиглэл-5:** ОХУ-ын Москвагийн Үндэсний судалгааны техник, технологийн их сургууль-Н.Э.Бауманы нэрэмжит Техникийн Улсын Их Сургууль, Үндэсний судалгааны Барилгын Улсын Их Сургууль, Эрхүүгийн Үндэсний судалгааны Техникийн Улсын Их Сургуулийн музейнүүдтэй холбоо тогтоох ажил хийгдэж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан “Боловсролын цахим шилжилт” үзэсгэлэнгийн үйл ажиллагаатай танилцсан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ШУТИС-ийн музейд зочлов. Музейтэй танилцахад УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, дэд сайд Г.Ганбаяр, төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, албаны бусад хүмүүс оролцлоо.



*Зураг 1.64. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ШУТИС-ийн музейд зочлов.*

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл С.Клечески болон Оюу Толгой ХХК-ийн гүйцэтгэх захирал Армандо Торрес нар Музейд зочилж сургуулийн гарал үүсэл, хөгжлийн түүхэн замнал, Монголын эртний нүүдэлчдийн өв болох археологийн олдвор, Геологи, эрдэс баялгийн дээжтэй танилцав.



*Зураг 1.65. АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны төлөөлөгчид зочлов.*



# ХОЁРДУГААР БҮЛЭГ

---

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



## ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1.1. БАКАЛАВРЫН СУРГАЛТ

ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2020 оны 5-р сарын 26-ны өдрийн хурлаар батлагдсан 2020-2021 оны хичээлийн жилийн Сургалтын нэгдсэн хуанлийн дагуу бакалаврын түвшний сургалтын элсэлт, төгсөлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалт гэсэн сургалтын үндсэн үйл ажиллагааг зохион байгуулав.

### 2.1.2. Цахим сургалт

Цаг үеийн онцгой нөхцөл байдлаас хамааран намрын улиралд сургалт цахим-танхим-цахим гэсэн холимог хэлбэрээр, хаврын улиралд бүрэн цахимаар явагдсан учраас “Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д 1 удаа өөрчлөлт оруулан мөрдөж ажиллав. Мөн “Сургалтын нэгдсэн хуанли”-д 2 удаа өөрчлөлт оруулан сургалтын үндсэн үйл ажиллагаа элсэлт, төгсөлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалтыг тус тус хэвийн зохион байгуулав.

Өндөржүүлсэн бэлэн байдлын болон бүх нийтийн бэлэн байдал, онцгой нөхцөлд дээд байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцүүлэн ШУТИС-ийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Түр журам батлах тухай” А/47, ШУТИС-ийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/133, ШУТИС-ийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” /А147, ШУТИС-ийн захирлын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн авах тухай” А/186 тоот тушаал, ШУТИС-ийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/191, ШУТИС-ийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Цахим хичээл боловсруулах, хүлээн авах тухай” А/202, ШУТИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай ” А/12, ШУТИС-ийн захирлын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Түр журамд өөрчлөлт оруулах тухай” А/65, ШУТИС-ийн захирлын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “2020-2021







оны хичээлийн жилийн хаврын улирлын цахим сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/66 тоот тушаалуудаар зохицуулалт хийсэн.

Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах түр журмаар 2020-2021 оны хичээлийн жилд профессор багшийн эрдэм шинжилгээ, инновац /Б/ цагийн ноогдлыг 50 хувиар бууруулж, олон нийтийн үйлчилгээ /В/ цагийн ноогдлыг ажлын гүйцэтгэлээс үл хамааран бүрэн тооцсон.


2020-2021 онд бүртгэл-элсэлт-сургалт-явцын сорил-улирлын шалгалт-диплом хамгаалалтыг цахим хэлбэрээр явуулж, сургалтын бүхий л үйл ажиллагааг цахимжуулсан онцлог жил болсон.



*Зураг 2.1. Цахим сургалтын системд оруулсан файлын тоо*



**Зураг 2.2. Багш нарын цахим системд оруулсан файлын тоо /бүрэлдэхүүн сургуулиар/**



**Зураг 2.3. Цахим сургалтын системд оруулсан нэмэлт материалын тоо**



### 2.1.3.Элсэлт

ШУТИС-ийн Захирлын 2020 оны 04-р сарын 27-ны өдрийн А/62 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2020-2021 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн үйл ажиллагаа 05 сарын 15 -наас 07 сарын 22-ны хооронд элсэлтийн комисс зохион байгуулсан.

Элсэгчдийн бүртгэл, онооны жагсаалтыг тусгай программ хангамжийн тусламжтайгаар гарган, болзол хангасан элсэгчдийн цаашид суралцах цахим мэргэжлийн сонголтыг хийлгэв.


Элсэлтийн бүртгэл 2020 оны 05 сарын 15-наас 07 сарын 06-ны өдрүүдэд 24 цагийн турш [www.elselt.edu.mn](http://www.elselt.edu.mn) веб хаягаар хийгдэв.

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн баталсан хяналтын тооны дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад нийт 3317 оюутан шинээр элсэн суралцах болсон.

#### Шинээр элсэн орсон элсэгчид

*Хүснэгт 2.1*

Д/д	Сургууль	Тоо
1	Барилга, Архитектурын сургууль	474
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	300
3	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	210
4	Гадаад хэлний сургууль	78
5	Геологи, уул уурхайн сургууль	327
6	Механик, тээврийн сургууль	279
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	623
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	242
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	213
10	Эрчим хүчний сургууль	485
11	Эрдэнэт цогцолбор дээд сургууль	86



**Зураг 2.4. 2018-2019, 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд элсэгчдийн тоо**

#### **2.1.4. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт**

2020/21 оны хичээлийн жилийн намрын улиралд БАС-168, БУХС-77, ГХС-76, ГУУС-127, МТС-129, МХТС-102, ҮТС-192, ХШУС-61, ЭХС-130, нийт 894, хаврын улиралд БАС-107, БУХС-87, ГХС-71, ГУУС-98, МТС-114, МХТС-102, ҮТС-159, ХШУС-67, ЭХС-109 нийт 807 буюу бакалаврын түвшний 1701 хичээлийн, 252 дадлагын хуваарь гаргаж, хичээл сургалтын үйл ажиллагаанд хяналт хийж ажиллав.

#### **2.1.5. Цагийн сургалт**

Цагийн сургалтаар элсэгчдэд зориулан суралцахад тавигдах шаардлага, элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Элсэхийг хүсэгчдийн бүртгэлийг 2020 оны 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл бүртгэж, элсэлтийн шалгалтыг 10 сарын 22-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Цагийн сургалтаар ШУТИС-ийн захирлын 2020 оны 10 дугаар сарын 29-ний А/177, А/178 тоот тушаалаар 5 бүрэлдэхүүн сургуульд 9 мэргэжлээр нийт 192 суралцагч элсэн суралцав.



## 2020-2021 оны хичээлийн жилд цагийн сургалтаар элсэгчдийн тоо

Хүснэгт 2.6

Д.д	Сургууль	Мэргэжлийн нэр	ШУТИС ТӨГССӨН		ГАДНЫ СУРГУУЛЬ ТӨГССӨН			НИЙТ
			Бак. зэрэг	Дип. зэрэг	Бак. зэрэг	Дип.зэрэг	Техникч	
1	БАС	Иргэний ба үйлдвэрийн барилга	20	2	26	2		50
2	ЭХС	Цахилгаан системийн автоматжуулалт	2	2	3	2	7	16
3	ДаТС	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	1		1		6	8
		Иргэний ба үйлдвэрийн барилга		3	1		4	8
		Дулааны цахилгаан станц	2	2	1	1	2	8
		Цахилгаан систем	1		7	2	13	23
4	МехТС	Авто инженер			18	2	16	36
		Төмөр замын тээврийн менежмент	6		19	1		26
5	ҮТС	Хоол зүй, тэжээхүй ухаан	8		9			17
<b>НИЙТ</b>			<b>40</b>	<b>9</b>	<b>85</b>	<b>10</b>	<b>48</b>	<b>192</b>

2020-2021 оны хичээлийн жилд цагийн (эчнээ, орой) сургалтаар намрын улиралд 562, хаврын улиралд 370 суралцагч суралцсан.



**2020-2021 оны хичээлийн жилийн цагийн сургалтын суралцагчдын  
үнэлгээний голч дүнгийн судалгаа  
(мэргэжлээр)**

Хүснэгт 2.7

Бүрэлдэхүүн сургууль	Мэргэжил	Оюутны тоо	ҮГД	Оюутны тоо	ҮГД	
		Намар		Хавар		
БАС	Иргэний үйлдвэрийн ба	93	2.73	70	2.8	
ДаТС	Иргэний үйлдвэрийн барилга ба	16	2.41	15	2.74	
	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	27	2.66	17	2.64	
	Уул уурхайн ашиглалтын технологи	30	2.57	7	2.5	
	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	10	2.85	8	2.51	
	Үйлдвэрлэлийн механикжуулалт	10	3.12			
	Дулааны цахилгаан станц	52	3.35	25	3.04	
	Дулааны цахилгаан станц	9	3.21			
	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	10	2.24	7	2.43	
	Цахилгаан систем	70	2.39	52	2.26	
	Цахилгаан систем	4	1.35			
	МехТС	Машин үйлдвэрлэлийн технологи	8	2.93	7	3.14
		Авто машины ашиглалт, авто аж ахуй	56	3.12	47	3.11
Авто машины ашиглалт, авто аж ахуй		7	3.1	6	3.29	
Авионик		1	2.46			
Нисэх техникийн механик		1	1			
ҮТС	Хоол зүй, тэжээхүй ухаан	11	3	1	1.68	
	Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи	13	3.17	13	3.29	



ЭХС	Цахилгаан системийн автоматжуулалт	55	2.8	51	2.71
	Дулааны цахилгаан станц	14	2.47	12	2.62
ЭрЦДС	Уул уурхайн машин тоног төхөөрөмж	14	2.65	14	2.81
	Автомашин ашиглалт, авто аж ахуй	13	3.63	1	2.4
	Цахилгаан системийн автоматжуулалт	14	3.04	13	2.63
	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	24	2.85	4	2.51
<b>ШУТИС дундаж</b>		<b>562</b>	<b>2.88</b>	<b>370</b>	<b>2.87</b>

БШУЯ-ны Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд өмнөх боловсролын тухай бүртгэл мэдээлэл байхгүй оюутнуудын анкет, бусад холбогдох материалыг бүрдүүлэн системд бүртгүүлэхээр яаманд хүсэлт өгч, нэмэлт бүртгэл хийх ажлыг зохион байгууллаа.

### Цагийн сургалтын кредит дүйцүүлэлтийн тооцоо (Бүрэлдэхүүн сургуулиар)

Хүснэгт 2.8

д/д	Сургууль	Дүйцүүлсэн кредит	Төлсөн төлбөр [төг]
1	БАС	96	1725696
2	ДаТС	581	8311330
3	МехТС	24	431424
4	ЭХС	254	4675632
5	Эрдэнэт ЦДС	37	518000
<b>Нийт ШУТИС</b>		<b>992</b>	<b>15662082</b>

#### 2.1.6. “ШУТИС-Коосэн” технологийн коллеж

“ШУТИС-Коосэн” технологийн коллежид нийт 13 ангид 186 суралцагч, 13 үндсэн багш, намрын улиралд 25, хаврын улиралд 29 цагийн багштай сургалтын ажил явагдлаа. Намрын улирлын 104, хаврын улирлын 81 хичээлийн хуваарьт хяналт тавьж цагаар хичээл заах багш нарын тушаалыг улирал бүр гаргав. Намрын улирлын цахим, танхим, хаврын улирлын цахим сургалтын явцыг байнга хянаж, суралцагчдаас сургалтын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч боловсруулав.

“ШУТИС-Коосэн” технологийн коллежид элсэгчдэд зориулан элсүүлэн суралцахад тавигдах шаардлага, элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн тухай



мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулсан. Бүртгэлийг 2020 оны 6 дугаар сарын 2-ноос 6 дугаар сарын 15-ныг хүртэл бүртгэж, шалгалт зохион байгуулан захирлын 2020 оны 9 дүгээр сарын 22-ны А/150 тоот тушаалаар 3 мэргэжлээр 1 дүгээр ангид 46, 2-р ангид 15 нийт 61 суралцагч элсэлтийн шалгуурын болзлыг ханган элсэн суралцав.

### Суралцагчдын тоо

Хүснэгт 2.9

Хичээлийн жил	Суралцагчийн тоо					Бүгд	
	Анги	Курс					
		1	2	3	4		5
2017-2018 оны хичээлийн жил	Барилгын инженер	9	9	18	13		128
	Механик инженер	6	7	12	12		
	Цахилгааны инженер	12	13	17			
	Нийт сурагч, оюутан	27	29	47	25		
2018-2019 оны хичээлийн жил	Барилгын инженер	16	9	7	7	13	125
	Механик инженер		9	7	9		
	Цахилгааны инженер	13	10	13	12	12	
	Нийт сурагч, оюутан	29	28	27	16	25	
2019-2020 оны хичээлийн жил	Барилгын инженер	14	16	10	7	7	170
	Механик инженер	16		9	7	7	
	Цахилгааны инженер	22	20	11	12	12	
	Нийт сурагч, оюутан	52	36	30	26	26	
2020-2021 оны хичээлийн жил	Барилгын инженер	9	16	18	9	7	186
	Механик инженер	18	16		6	6	
	Цахилгааны инженер	19	24	17	9	12	
	Нийт сурагч, оюутан	46	56	35	24	25	

Өмнөх төгсөгчдөөс ШУТИС болон бусад их дээд сургуульд дэвшин суралцаж байгаа 31, япон улсын Коосэнд суралцаж буй 2 төгсөгч байна.

“ШУТИС-Коосэн” ТК-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг тооцож, үнэлэх журам"-ын төслийг Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний албанаас тавьсан шаардлагын дагуу бэлтгэж ажлын хэсэгт хэлэлцүүлэхээр илгээсэн.

2020-2021 оны хичээлийн жилд “Барилгын инженер” хөтөлбөрөөр 6, “Цахилгааны инженер” хөтөлбөрөөр 7, “Механик инженер” хөтөлбөрөөр 6, нийт 19 оюутны суралцсан хугацааны дүнгийн тулгалт хийж, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг бүрэн судалж, дипломын төслөө амжилттай хамгаалсан оюутны төгсөлтийн комиссын шийдвэрийн дагуу ШУТИС-ийн Захирлын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/110 тоот тушаал гаргуулж, мэргэжлийн диплом олгов. “Цахилгааны инженер” хөтөлбөрөөр суралцаж төгссөн Ганболдын Мөнхзориг, Мяндалын Тэмүүлэн





шалгарч, “ШИЛДЭГ ТӨГСӨГЧ” өргөмжлөл, нэг зуун мянган төгрөгөөр шагнагдсан. Төгсөлтийн ДБ тайлан гаргаж БШУЯ-нд хүргүүлэв.

### Төгсөгчдийн үнэлгээний голч дүн

*Хүснэгт 2.10*

Хөтөлбөрийн нэр	Төгсөгчийн тоо	Голч дүн
Барилгын инженер	6	3.52
Цахилгааны инженер	7	3.30
Механик инженер	6	3.38
Дундаж	19	3.32

2021-2022 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх журмыг боловсруулж, элсэлтийн вебд байршуулан, бүртгэлийн үйл ажиллагааг 5 дугаар сарын 12-ноос, 6 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл цахимаар явуулж, бүртгүүлэгчдээс элсэлтийн шалгалтыг GOOGLE CLASSROOM-ээр тэнцсэн бүртгүүлэгчдэд суралцах эрхийн бичиг олгов.

#### 2.1.7. Ерөнхий боловсролын ахлах сургууль

2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын ахлах сургуульд элсэгчдэд мэдээлэл өгөх зорилгоор элсүүлэн суралцахад тавигдах шаардлага, сургалтын танилцуулга, элсэлтийн журмыг бэлтгэн элсэгчдэд мэдээлэл хүргүүлсэн. Элсэхийг хүсэгчдийн бүртгэлийг 2020 оны 6 дугаар сарын 2-ноос 6 дугаар сарын 15-ныг хүртэл бүртгэж, шалгалт зохион байгуулан захирлын 2020 оны 9 дүгээр сарын 22-ны А/150 тоот тушаалаар 10-р ангид инженер, технологийн чиглэлээр 38, дизайны чиглэлээр 18 суралцагч, 11-р ангид 8 суралцагч элсэлтийн журамд заасан шалгуурыг ханган элсэн суралцав.

ШУТИС-ийн Ахлах сургууль нь 2020-2021 оны хичээлийн жилд үндсэн 10 багштайгаар хичээл сургалтын үйл ажиллагаагаа явууллаа. Энэ хичээлийн жил 20% нь танхимаар, 80% нь онлайнаар хичээл сургалтын үйл ажиллагаа зохион байгуулагдав.

Стандарт буюу ерөнхий эрдмийн хичээлүүдийн хөтөлбөр төлөвлөгөөг БШУЯ-аас жил бүр гардаг сургалтын төлөвлөгөө, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн боловсролын газар, Сүхбаатар дүүргийн боловсролын хэлтэс гэх мэт газруудаас ирдэг хяналт шалгалт, шаардлагын хүрээнд шинэчлэн сайжруулж сургалтын үйл ажиллагаа явуулав.

Ахлах сургууль Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2019.08.01-ний өдрийн А/491 тоот тушаал (стандарт сургалтын төлөвлөгөө), 2018.06.29-ны өдрийн А/425 (ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам) тоот тушаалуудыг харгалзан, сайжруулсан стандарт



сургалтын хөтөлбөрүүдийн дагуу шинэчлэн боловсруулж үнэлгээний шатлалыг харгалзан өөрчилсөн. Нийт суралцагчдаас хичээлийн жилийн эхэнд судлагдахуун бүрээр гарааны шалгалт авч үнэлгээг явцын болон улирлын дүн, захирлын нэрэмжит, хөндлөнгийн шалгалтын дүнгүүдтэй харьцуулалт хийж ахиц амжилтыг тооцон суралцагч, бүрээр тооцоо судалгаатай гарган, эцэг эх асран хамгаалагчдад мэдээлж хамтран ажилласан.

**Багш нарын цагийн ачаалал /жилээр/**

*Хүснэгт 2.11*

Нийт сургалтын цаг	Багшийн заах нормт цаг	Багшийн цагийн гүйцэтгэл	Илүү цаг	Дутуу цаг	Тайлбар
Сургууль, товийн нэр	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн индекс	Хөтөлбөрөөр элссэн докторантын тоо /хичээлийн жилээр/					Нийт элссэн
			2016/2017	2017/2018	2018/2019	2019/2020	2020-2021	
БАС	Архитектур	F07310201	1	0	3	1	0	5
	Халаалт, агаар сэлгэлт	F07320105	0	1	0	2	2	5
	Усан хангамж, ус цэвэрлэгээ	F07320103	0	3	1	1	3	8
	Барилгын инженер	F07320201	2	6	0	1	0	9
	Гүүрийн барилга	F07320202	0	0	1	0	0	1
	Усны барилга, байгууламж	F07320207	0	0	0	0	0	0
	Авто зам, авто замын барилга	F07320211	0	0	3	0	1	4
	Барилгын бүтээц эдлэлийн технологи	F07320209	0	0	2	1	3	6
	Барилгын үйлдвэрлэлийн технологи	F07320210	0	0	0	1	0	1
	Барилгын геотехник	F07320205	1	0	1	0	0	2
	Байгууламжийн шинжилгээ	F07320208	0	0	0	0	0	0
	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	F07320203	1	0	0	0	0	1
	Хөрсний механик ба буурь суурь	F07320209	0	0	1	0	2	3
	<b>Нийт</b>			<b>5</b>	<b>10</b>	<b>12</b>	<b>7</b>	<b>11</b>
БАТС	Бизнесийн удирдлага	F04130101	7	12	11	30	8	68
	Менежмент	F04130201	6	8	3	7	13	37
	Төрийн удирдлага	F04130301	2	0	1	0	2	5
	<b>Нийт</b>		<b>15</b>	<b>20</b>	<b>15</b>	<b>37</b>	<b>23</b>	<b>110</b>
БуХС	Соёл судлал	F03140101	0	0	2	0	1	3
	Нийгмийн ажил	F09230101	1	0	0	3	6	10
	<b>Нийт</b>		<b>1</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>13</b>
ГХС	Хэл шинжлэл	F02320201	0	0	4	1	1	6
	<b>Нийт</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>6</b>
ГУУС	Газрын тосны өрөмдлөг, олборлолт	F07240401	0	0	0	0	0	0
	Газрын тосны хадгалалт, тээвэрлэлт	F07240403	0	0	1	1	0	2



	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	F07240201	0	3	0	0	3	6
	Уул уурхайн маркшейдер	F07240104	0	2	0	0	2	4
	Уул уурхайн ашиглалтын технологи	F07240102	5	0	2	3	5	15
	Хайгуулын өрөмдлөгийн техник, технологи	F07240301	0	0	0	0	1	1
	Геологи	F05320301	5	3	1	1	4	14
	Гидрогеологи	F05320401	3	0	0	0	0	3
	Уул уурхайн машин тоног төхөөрөмж	F07150106	0	4	0	0	2	6
	Геодези	F05320101	0	3	2	1	1	7
	Инженер геологи	F05320403	0	0	0	1	0	1
	Геозкологи	F05320402	0	0	0	0	0	0
	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	F07130403	1	0	0	0	1	2
	Ашигт малтмалын эрэл хайгуул	F05320302	0	0	1	0	0	1
	Хийн дамжуулалт, хангамж	F07240403	0	0	0	0	0	0
	Уул уурхайн менежмент	F07240105	2	1	2	2	3	10
	<b>Нийт</b>		<b>16</b>	<b>16</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>22</b>	<b>73</b>
ДарТС	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	F07320203	0	0	1	4	0	5
	<b>Нийт</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>5</b>
МехТС	Мехатроник	F07140106	1	1	3	0	0	5
	Металлурги, машин үйлдвэрлэлийн технологи	F07150103	1	1	0	6	0	8
	Үйлдвэрлэлийн механикжуулалт	F07150101	1	2	1	2	0	6
	Инженер механик	F07150104	1	1	1	2	1	6
	Өргөн тээвэрлэх, барилга замын машин төхөөрөмж	F07150102	0	0	0	0	0	0
	Авто машины ашиглалт, авто аж ахуй	F07160101	2	3	3	2	1	11
	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт	F07150108	0	0	0	1	0	1
	<b>Нийт</b>		<b>6</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>13</b>	<b>2</b>	<b>37</b>
МХТС	Электроник	F07140101	1	2	1	1	0	5
	Мэдээллийн технологи	F06130401	7	2	4	3	1	17
	Утасгүй холбоо	F06190201	4	1	0	0	2	7
	Компьютерийн ухаан	F06130101	2	6	1	0	1	10



	Цахилгаан холбоо	F06190101	0	0	0	0	0	0
	Сүлжээний технологи	F06190301	1	0	0	0	1	2
	<b>Нийт</b>		<b>15</b>	<b>11</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>41</b>
ҮТС	Арьс шир боловсруулах үйлдвэрийн технологи	F07230301	0	1	0	0	0	1
	Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи	F07230402	0	0	2	1	0	3
	Хүнсний микробиологи	F07880208	0	0	0	0	0	0
	Хүнсний биотехнологи	F07880207	0	1	0	0	1	2
	Хүнсний хими технологи	F07880207	0	0	0	1	0	1
	Хүнс үйлдвэрлэлийн технологи	F07210104	2	0	0	0	1	3
	Хоол зүй, шим судлал	F07210201	2	0	1	1	2	6
	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	F07210105	0	0	0	0	1	1
	Хүнсний үйлдвэрлэлийн машин аппарат	F07140202	0	0	1	1	0	2
	Үйлдвэрлэлийн дизайн	F02120301	0	0	3	2	1	6
	Ойн аж ахуй, зохион байгуулалт	F08210101	0	0	0	0	0	0
	<b>Нийт</b>		<b>4</b>	<b>2</b>	<b>7</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>25</b>
ХШУС	Газрын тосны боловсруулалтын технологи	F07110203	1	1	0	0	1	3
	Нүүрсний боловсруулалтын хими технологи	F07110202	2	0	0	0	0	2
	Химийн технологи	F07110201	0	1	0	0	2	3
	Силикатын химийн технологи	F07110204	0	1	0	0	0	1
	Ховор ба үнэт металлын химийн технологи	F07110205	0	0	1	0	0	1
	Физик технологи	F07180102	0	0	1	1	0	2
	Инженер физик	F07180102	0	0	0	0	0	0
	Хэрэглээний математик	F05480101	0	0	0	0	1	1
	<b>Нийт</b>		<b>3</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>13</b>
ЭХС	Дулаан хангамж систем	F07130204	1	1	0	3	1	6
	Дулааны цахилгаан станц	F07130201	3	0	1	0	3	7
	Технологийн процесс ба үйлдвэрлэлийн автоматжуулалт	F07130406	1	1	1	1	1	5
	Цахилгаан станц, шугам сүлжээ, цахилгаан эрчим хүчний систем ба түүний удирдлага	F07130503	2	2	3	0	2	9





	Цахилгаан системийн автоматжуулалт	F07130405	3	0	1	1	2	7
	Цахилгаан хангамж ба цогцолборууд	F07130504	0	1	0	0	1	2
	Сэргээгдэх эрчим хүч	F07130101	1	1	2	1	2	7
	Үйлдвэрийн экологийн инженер	F07120201	0	0	0	0	0	0
	<b>Нийт</b>		<b>11</b>	<b>6</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>12</b>	<b>43</b>
НБТ	Боловсрол судлал	F01110101	6	7	7	2	3	25
	<b>Нийт</b>		<b>6</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>25</b>
	<b>Нийт</b>		<b>82</b>	<b>83</b>	<b>81</b>	<b>94</b>	<b>96</b>	<b>436</b>

### 2.3.2. Магистр, докторын эрдэм шинжилгээний хурал

2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд "Магистр, докторын Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах удирдамж"-ийг боловсруулан ШУТИС-ийн Захирлын 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлуулж, ШУТИС-ийн магистр, доктор оюутны Эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 22-23 өдрүүдэд цахимаар зохион байгууллаа.

2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд зохион байгуулсан магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг техникийн (магистр, доктор), нийгэм, хүмүүнлэгийн (магистр, доктор), байгалийн ухааны (магистр, доктор) чиглэлээр 5 салбар хуралдааны хэлбэрээр зохион байгуулсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хуралд ирсэн 49 илтгэлээс техникийн ухааны чиглэлээр 24, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр 19, байгалийн ухааны чиглэлээр 6 илтгэлийг тус тус хэлэлцүүлж, магистр 9, доктор 8 оюутны илтгэлийг шилдгээр шалгаруулж батламж, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, их сургуулийн Захирлын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан кредитийн урамшууллыг тус тус олгосон. Магистр, доктор оюутны Эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн илтгэлүүдийг хянан магадалж, 21(6) 283 дугаар бүхий 46.25х.х эмхэтгэлийг хэвлэн гаргалаа.



**Зураг 2.16. Магистр, доктор оюутны Эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн илтгэлүүдийн батламжийн загвар**



**Магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний  
хуралд шалгарсан илтгэл**

*Хүснэгт 2.32*

д/ д	Овог, нэр	Сургууль, төв	Илтгэлийн сэдэв	Эзэлсэн байр
<b>ТЕХНИКИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
1	С.Тулгач	ЭХС	Тархмал бага чадлын “Ухаахудаг” цахилгаан станцын динамик тогтворжилтыг дээшлүүлэх	I
2	Ц.Цэлмэг	МХТС	Гольфын цохиурын савалтад шинжилгээ хийх төхөөрөмжийн хөгжүүлэлт	II
3	Б.Золбаяр	МехТС	Уурхайн өргүүрийн цохилт шингээгчийн угсралт, байршилтын судалгаа	III
<b>ТЕХНИКИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
1	Н.Одонтуяа	БАС	Суумтгай буурьт төсөллөх геосинтетик арматурчлалтай хөрсөн дэрний штампын туршилтын дүн	I
2	Б.Басбиш	БАС	Өрөмдмөл-цутгамал гадсан шонг хэвтээ ачааллаар туршсан судалгааны дүн	II
3	Г.Ганбаатар	МехТС	Мөхлөгт материалыг ялган ангилах төхөөрөмжийн хийцийн судалгаа хөгжүүлэлт	III
<b>НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
1	Т.Баатархүү	МХТС	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрийн хөгжүүлэлт	I
2	Ж.Мөнхдэлгэр	БуХС	Монгол шагайн харвааны нэгэн төрлийг тодруулах нь	II
3	Б.Сэлэнгэсайхан	ДарТС	Effectiveness of e-learning in teaching english	III
<b>НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
	П.Баасанжаргал	БАТС	Хүн амын чөлөөт цагийн үйл ажиллагаанд хийсэн судалгаа	I
	Б.Сонинцэцэг	ГХС	Үндэсний монгол бичгийн хэрэглээний орчныг бий болгох нь суралцагч бичиг үсэгтээ идэвхийлэн суралцахад нөлөөлөх нь	II
	Э.Сувд	НБТ	Инженерийн боловсролд орон зайн төсөөлөх чадварын үүрэг	III




<b>БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР /магистрант/</b>				
	М.Ганхуяг	ГУУС	Зөөлөнгийн алт-мөнгө, полиметаллын ордын геологийн тогтоц, структур геохимийн загвар	I
	Б.Номин	ҮТС	Үр тарианы ариутгалд наномөнгөний бэлдмэлийг ашигласан судалгааны үр дүн	II
	А.Гомбосүрэн	ХШУС	Гүн сургалтын аргаар тээврийн хэрэгслийн дугаар таамаглах	III
<b>БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР /докторант/</b>				
	Л.Батзориг	ХШУС	Инерцийн ба гидродинамикийн хүчийг ашиглан цусан дахь микро эсүүдийг ялгах био-чипийн хөгжүүлэлтийн судалгаа	I
	Г.Ганзаяа	ХШУС	Хангайн бүсийн зарим ордын эмчилгээний шаврын судалгаа	II

### 2.3.3. Докторантурын сургалтын төгсөлтийн үйл ажиллагаа

2020-2021 оны хичээлийн намрын улиралд докторантын сургалт, судалгааны ажлын явцын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах удирдамжийг батлуулан, докторантын сургалт, судалгааны ажлын түвшнийг тогтоож, мэргэжлийн нэгдсэн шалгалт авах ажлыг хичээлийн жилийн явцад 2 удаа зохион байгуулсан.

Докторантурын сургалт дүүргэсэн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан докторант нарын материалыг хүлээн авч хяналтын магадалгаа хийн, их сургуулийн Захирлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А-145 тоот тушаалаар 2, 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн А-20 тоот тушаалаар 25, 2021 оны 7 сарын 02-ны өдрийн А-127 тоот тушаалаар 31 докторантад доктор (Ph.D)-ын сургалтыг дүүргэснийг гэрчлэх гэрчилгээ олгож, нийт 58 докторантыг 2020-2021 оны хичээлийн жилд горилогчоор баталсан.



**Зураг 2.17. Докторантурын сургалт дүүргэж гэрчилгээ авсан горилогчдын судалгаа (бүрэлдэхүүн сургуулиар)**

### 2.3.4. Докторын (Ph.D) зэрэг хамгаалж, төгссөн эрдэмтдийн мэдээлэл

Сүүлийн 5 жилийн байдлаар ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, төвийн докторантурын сургалтыг дүүргэж, 94 горилогч докторын (Ph.D) зэрэг хүртсэн байна.

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/170 тоот тушаалаар 2, 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/1807 тоот тушаалаар 3, 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/86 тоот тушаалаар 2 нийт 7 горилогч докторын зэрэг хамгаалуулах 5 зөвлөл дээр докторын диссертация амжилттай хамгаалан, доктор (Ph.D)-ын зэрэг хүртсэн.

### ШУТИС-ийн докторантур төгсөгчдийн тоо (2015-2020 оны байдлаар)

Хүснэгт 2.33

Бүрэлдэхүүн сургууль	Хичээлийн жил /он/					Нийт
	2016/ 2017	2017/ 2018	2018/ 2019	2019/ 2020	2020/ 2021	
БАС	2	3	0	0	0	5
БАТС	5	5	4	3	3	20





БуХС	1	1	0	2	0	4
ГХС	0	1	1	4	0	6
ГУУС	2	5	1	1	0	9
МехТС	2	1	4	6	0	13
МХТС	0	3	1	0	1	5
ҮТС	1	0	2	0	0	3
ХШУС	4	1	6	1	1	13
ЭХС	1	1	1	5	1	9
НБТ	0	2	3	1	1	7
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>23</b>	<b>23</b>	<b>23</b>	<b>7</b>	<b>94</b>

БШУС-ын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/181 тоот тушаалаар “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”, БШУС-ын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/92 тоот тушаалаар “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм” тус тус шинэчлэн батлагдаж, 2021 оны 6 дугаар сараас эхлэн докторын зэргийн хамгаалалт үргэлжлэн явагдаж байна.


**2020-2021 оны хичээлийн жилд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтэд**

*Хүснэгт 2.34*

д/д	Овог, нэр	Докторын зэрэг	Мэргэжлийн чиглэл	Судалгааны ажлын сэдэв
1	Баастын Баттулга	Бизнесийн удирдлагын	Үйлдвэрлэл, технологийн менежмент	Технологийн түвшний үнэлгээний арга зүйн асуудал (Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн жишээн дээр)
2	Агваанжигмэдийн Болормаа	Бизнесийн удирдлагын	Хүний нөөцийн менежмент	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн судалгаа (Төрийн захиргааны байгууллагын жишээн дээр)
3	Аюушийн Юмчмаа	Техникийн ухааны	Мэдээллийн технологи	Эмнэлгийн оношилгооны эксперт системийн боловсруулалт
4	Хүдэрийн Отгондорж	Математикийн ухааны	Хэрэглээний математик	Шугаман биш тэгшитгэлийн системийг бодох



				өндөр эрэмбийн нийлэлттэй интеграцийн аргууд байгуулах
5	Амарсайханы Түвшинбаяр	Боловсрол судлалын	Боловсрол судлал	Сургалтад виртуал лаборатори ашиглах нь (MT-ийн хичээлд ашигласан виртуал лабораторийн жишээн дээр)
6	Бат-Очирын Батзаяа	Менежмент ийн ухааны	Менежмент	Эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх боломжийн судалгаа
7	Пүрэвжавын Эрхэмтөр	Техникийн ухааны	Цахилгаан станц, шугам сүлжээ, ЦЭХ-ний систем ба түүний удирдлага	Хуваарилах цахилгаан шугам сүлжээний эрчмийн алдагдлын математик статистик загварууд



**Зураг 2.18. 2020-2021 оны хичээлийн жилд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтдийн судалгаа (бүрэлдэхүүн сургуулиар)**

### 2.3.5. Докторантурт суралцагчдын үнэлгээний голч дүнгийн судалгаа

2020-2021 оны хичээлийн жилд докторантурт суралцагчдын голч дүнд шинжилгээ хийж үзэхэд доктор оюутны голч дүнгийн дундаж 3.73 байна.



### Доктор оюутны голч дүнгийн судалгаа

Хүснэгт 2.35

д/д	Бүрэлдэхүүн сургууль	2020-2021 Намар	2020-2021 Хавар	Үнэлгээний голч дүн
1	БАС	3.71	3.69	3.70
2	БАТС	3.42	3.77	3.60
3	БУХС	-	3.79	3.79
4	ГХС	3.40	2.88	3.14
5	ГУУС	3.62	3.76	3.69
6	МехТС	3.88	3.73	3.80
7	МХТС	3.96	3.96	3.96
8	ҮТС	4.0	3.89	3.94
9	ХШУС	-	3.90	3.90
10	ЭХС	3.83	3.77	3.80
11	НБТ	3.54	3.74	3.64
<b>ШУТИС-ийн дундаж гол дүн (GPA)</b>				<b>3.73</b>

#### 2.4. АХИСАН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДЭЭР БОЛОВСРОЛЫН СУДЛАЛЫН ЧИГЛЭЛИЙН ХИЙГДСЭН АЖЛУУД

1. Магистр, докторын сургалтын 2020/2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд хичээл заах багш нарыг сонгон, хуваарь боловсруулах ажлыг удирдан зохион байгуулав.
2. Боловсролын удирдлага, Боловсрол судлалын магистр, докторын хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлэн "Хөтөлбөрийн үзэл баримтлал"-ыг НБТ-ийн багш нарын хамт боловсруулж дууссан. Боловсролын удирдлага, Боловсрол судлалын магистр хөтөлбөрийн Д.Бадарч багшийн "Дээд боловсролын онол арга зүй" номын "Парадигмийн шилжилт, багшлахуй, суралцахуй" цувралын агуулгыг Боловсрол судлал, Боловсролын удирдлага магистрын хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгад тусгахаар ажиллаж байна.
3. Боловсролын удирдлага, Боловсрол судлалын магистрын хичээлийн хөтөлбөрийг НБТ-ийн багш нарын хамт шинэчлэн боловсруулж эхлээд S.HE718, S.HE719, S.HE720, S.HE7238 S.HE729 хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийг UNIMIS баазад оруулсан.
4. 2020/21 оны намрын улиралд магистрантурт 3, докторантурт 3 элсэгч элсэж, хаврын улиралд магистрантурт 4 шинээр элссэн оюутны дэлгэрэнгүй мэдээллийг UNIMIS программд оруулан бүртгэв.
5. 2020/21 оны хичээлийн жилд магистрантур, докторантурт суралцагч 22 оюутны 253 кредитийн хичээл сонголт, хичээлийн хуваарийг хийн UNIMIS



программд оруулан, баталгаажуулснаар хичээл сонголтууд хийгдэн сургалт зохион байгуулагдаж, багшийн кредит цагийн тооцоо хийгдсэн.

6. 2020/21 оны намрын улирлын кредит баталгаажуулах тушаалаар баталгаажсан 9 оюутны 91 кредитийн 12'185'051 төгрөгийн төлбөрийн 1'475'192 төгрөгийн төлөлт хийгдээгүй ба төлбөр төлөлт 87,9 хувьтай байна.
7. 2020/21 оны хаврын улирлын кредит баталгаажуулах тушаалаар баталгаажсан 13 оюутны 162 кредитийн 21'323'569 төгрөгийн төлбөр нь хувиараа болон боловсролын зээлийн сангаас орж ирсэн орлогын бүрдүүлэлтээр 100% төлөгдлөө.
8. 2020/2021 оны намар, хаврын улирлын магистр, докторын дипломын явцын үзлэгийн хуваарь гарган, семинарыг тогтмолжуулах ажлыг удирдан, Боловсролын удирдлага, Боловсрол судлал хөтөлбөрийн 15 магистрант, 4 докторант оюутан, 4 удирдагч багштай уулзалт хийн, төгсөлтийн ажлын явцтай танилцаж, НБТ-ийн болон ДаТС-ийн багш нарын хамт сэдэв, удирдагчийг эцэслэн шийдвэрлэв. Семинарын хуваарийн дагуу Лхагва гараг бүрийн 16:20-17:50 цагт төгсөх оюутнуудын судалгааны ажилд зөвлөн ажилласан.

		A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L	M	N	O	P	Q	R	S	T	U	V	W	X
		Судалгааны ажлын семинар-III																							
		Тайлбар: Өөрсдийн судалгааны сэдвээр, хувиарын дагуу илтгэл хэлэлцүүлэн																							
		4 судалгааны ажлын явц, үр дүнгээ сайжруулах																							
		2021.02.01																							
Д/д	Оюутны мэдээлэл			Багшийн мэдээлэл		Судалгааны сэдэв	Илтгэлийн хувиарь																	Ургалжаж хугацаа /минут/	
	Овог	Нэр	Код	Удирдагч	Зөвлөх		III/3	III/10	III/17	III/24	III/31	III/10	III/17	III/24	III/31	IV/7	IV/14	IV/21	IV/28	V/5	V/12	V/19			
9	1	Дэлгэрсайн	Батболд	N.HJ19E200																					
10	2	Савдасүрэн	Атгалмаас	N.HJ19E201																					
11	3	Машбат	Одгуу	N.HJ19E203																					
12	4	Бат-Очир	Оптонкарал	N.HJ19E205																					
13	5	Болдбаатар	Ариунсарнай	N.HJ19E206																					
14	6	Доржсүрэн	Бямбадорж	N.HJ19E207																					
15	7	Лхагвасүрэн	Соронзонболд	N.HJ19E209																					
16	8	Түвшинбар	Энхшаран	N.HJ19E150																					
17	9	Будрагчаа	Соёлмаа	N.HE19E200																					
18	10	Ууган-Баяр	Самданмаа	N.HE19E201																					
19	11	Баларч	Бямба	N.HE19E202																					
20	12	Лувсандорж	Олонтүмэн	N.HE19E203																					
21	13	Гантулга	Дашжаргал	S.HE20E012																					
22																									

**Зураг 2.19. Боловсролын удирдлага, Боловсрол судлал хөтөлбөрийн хуваарь**

9. Магистрантур, докторантурт суралцаж байгаа нийт оюутнуудыг аттестатчлалд хамруулан, судалгааны ажлын явцыг чиглүүлэн, чанаржуулах ажлыг 4-р сарын 8-ны өдөр зохион байгуулан, магистрант, докторант оюутнуудын үргэлжлүүлэн суралцах, гэрчилгээ авсан



- суралцагчдыг судалгааны ажилд нь чиглүүлэх, сураггүй оюутнуудыг хугацаанаас хамааран чөлөөлөх тушаал гаргуулахаар ажиллаж байна
10. Сургалтын үйл ажиллагааны болон элсэлт, төгсөлтийн тайлан мэдээ, намар, хаврын улирлын хичээл сонголт, магистрант, докторант оюутнуудын GPA голч дүн, төлбөр төлөлт, зээл, ДБ тайлан мэдээ гаргаж, оюутны хөгжлийн зээлд 5 оюутныг хамруулсан. Өмнө нь зээлд хамрагдаж төгссөн оюутнуудын ажил эрхлэлт, амьжиргаа, орлогын судалгааг дэлгэрэнгүй маягтаар хийж холбогдох газарт хүргүүлэв. 2019/20В, 2020/21А улирлын төгсөгчдийн мөшгөх судалгаа болон ДБ35, ДБ36 судалгаануудыг хийж байна.
  11. 2020/21 оны намрын улиралд НБТ-өөс 1, хаврын улиралд НБТ-ийн болон ДаТС-ийн 13 магистрантын төгсөлтийн ажлын урьдчилсан хамгаалалтыг 2021 оны 6-р сарын 5-нд, жинхэнэ хамгаалалтыг 14-нд хийж нийт 14 магистр төгсөв.
  12. Төгсөх оюутнуудын судалгаа, үнэт цаас, хавтас захиалга, дүн тулгалт, судалгааны ажлын хамгаалалтын үйл ажиллагааг хуанлийн дагуу хийж гүйцэтгэв.
  13. Оюутны хөгжлийн зээлээр суралцаж төгсөөд зээлийн эргэн төлөлт хийгээгүйгээс эргэлзээтэй, хэвийн бус, найдваргүй ангилалд орсон оюутнуудын судалгааг гаргаж, оюутан тус бүртэй холбогдон шалтгааныг тодруулан Боловсролын зээлийн санд явуулсан.
  14. Өмнөх жилүүдийн сургалтын төлбөрийн өр авлагатай холбоотойгоор ДарТС болон бусад суралцагчдаас нийт 13.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг хийж дуусгалаа.
  15. Доктор, магистр оюутнуудын өр, авлага барагдуулах ажлын хэсэг нийт 64 оюутны 2013-2018 онуудад суралцсан хугацааны 77'195'694 төгрөгийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлэхээр материал бүрдүүлэлтэд шаардлагатай 1500 хуудас бичиг баримтыг ШУТИС-ийн архиваас шүүн хувилж бэлтгэн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд Хөвсгөл аймагт-29, Хэнтий аймагт-6, Өвөрхангай аймагт-5, Говьсүмбэр аймагт-4, Дархан-Уул аймагт-10, Улаанбаатар хотод-10 хүргүүлсэн





# ГУРАВДУГААР БҮЛЭГ

---

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ




## ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

### 3.1 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭ

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, профессор, багш, судлаачдын судалгааны ажлын ололт, амжилтыг хэлэлцүүлэх, урамшуулах, эрдмийн цол олгох, судалгааны бүтээлийг олон улсад таниулах, эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг нэмэгдүүлж, олон улсад индекслүүлэх, эрдэм шинжилгээний мэдээллийн санг хөгжүүлэх, инновац, энтрепренер соёлыг хэвшүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. (Хүснэгт 3.1).




#### Зохион байгуулсан арга хэмжээ, онцлох үйл явдал /2020-2021/

Хүснэгт 3.1

Д.д	Огноо	Арга хэмжээ	Хамтарч ажилласан сургууль, байгууллага, үр дүн
1	2020/09/14-18	“ICMC-2020” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ 	МХТС, Австрийн Венийн технологийн их сургууль: ICMC – “International Conference on Membrane Computing” хуралд 27 багш судлаачдын 31 илтгэлийг хэлэлцүүлэв.
2	2020/11	“MONGOLIAN GEOSCIENTIS” СЭТГҮҮЛ DIMENSIONS-Д БҮРТГЭГДЛЭЭ.	ГУУС: Геологийн салбарын эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлыг хэвлэн нийтэлдэг энэхүү сэтгүүл нь 2020 онд олон улсын томоохон мэдээллийн сан болох Dimensions-д бүртгэгдсэн амжилт гаргалаа. Тус сэтгүүлийн нийт 35 бүтээл энэхүү





			<p>мэдээллийн санд бүртгэгдсэн бөгөөд 2020 онд №50,51, 2021 онд №52-р дугаар онлайнаар гарсан.</p>
<p>3</p>	<p>2020/09/28 2021/07/01</p>	<p><b>ЭРДМИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ</b></p> 	<p><b>ЭШИГ, ТДТ:</b> Монгол улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, боловсролыг хөгжүүлэхэд төдийгүй ШУТИС-ийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан 1 хүнд Хүндэт доктор, 5 хүнд Хүндэт профессор, 24 багшид профессор цол, 50 багшид дэд профессор цол олгох, Хүрээлэн, төвүүдийн тайлан, төслүүдийн тайлан хэлэлцүүлэх, журмын төсөл хэлэлцүүлэхээр холбогдох дэд зөвлөлүүдийн хурлыг 6 удаа зохион байгуулсан.</p>
<p>4</p>	<p>2020-2021</p>	<p><b>ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ</b></p> 	<p><b>ЭШИГ, ТДТ:</b> Эрдэм шинжилгээний мэдээллийн системийг улам боловсонгуй болгож хөгжүүлэх инновацын төслийг ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлж 2020-2021 он хүртэл хэрэгжүүлж байна. Тайлант онд вебийн контентыг гаргаж, туршилтын ажил хийгдэж байна.</p>

5	2019/12/09	<b>ХАМТАРСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b> 	<b>ЭШИГ, ИТДБ төслийн нэгж, Зөвлөх баг:</b> ИТДБ төслийн хүрээнд ШУТИС дээр хэрэгжиж буй хамтарсан судалгааны 10 багийн ажлын тайланг хэлэлцүүлж, үнэлэн, баг тус бүр дээр зөвлөмж гаргасан.
6	2020-2021	<b>ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ</b> 	<b>ЭШИГ, ТДТ:</b> Бүрэлдэхүүн сургуулиуд дотоод, гадаадын их дээд сургууль, байгууллагатай 38 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилласны заримыг дурдвал: <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл</li> <li>- Багануур ХХК</li> <li>- ЛІСА олон улсын байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газар</li> <li>- Рио Тинто Монгол ХХК, Оюутолгой ХХК .</li> </ul>
7	2020/09/28, 2021/07/01	<b>ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН</b> 	<b>Эрдмийн зөвлөл, ЭШИГ:</b> 2020/09/28: Тус цахим хуралдаанаар ШУТИС-ийн Эрдмийн ба хүндэт цол олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. 2021/07/01: Цахим хуралдаанаар ШУТИС-ийн мэргэжлийн зарим



			салбаруудыг өөрчлөн зохион байгуулах тухай, Сургалтын хөтөлбөртэй холбоотой асуудал, ШУТИС-ийн Эрдмийн ба Хүндэт цол олгох зэрэг асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлэсэн.
8	2021/04/26	<b>ШУТИС-ИЙН СУДЛААЧДЫН ЧУУЛГАН-2021”</b> <b>БАГШ, “ЭРДМИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ</b>	<b>ЭШИГ:</b> I үе шат бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгүүд дээр зохион байгуулагдсан бөгөөд тэдгээрээс шалгарсан 38 илтгэлийг техник технологи, хэрэглээний шинжлэх ухаан, нийгэм-хүмүүнлэгийн салбар хуралдаанаар II шатанд цахим хэлбэрээр хэлэлцүүлж, нийт 8 шилдэг илтгэл шалгарсан.
9	2021/03	<b>“MINERAL RESOURCES OF MONGOLIA” БҮТЭЭЛ “SPRINGER NATURE” -Т ХЭВЛЭГДСЭН.</b>	<b>ГУУС, Springer Nature:</b> “Springer Nature” -т Монгол улсаас анх удаа ШУТИС-ийн профессор О.Гэрэл ахлагчтай эрдэмтэн, судлаачид “Mineral resources of Mongolia” бие даасан бүтээлийг хэвлүүлсэн. Уг бүтээл нь Монголын геологи, металлогени, Металл ашигт малтмал, Металл бус ашигт малтмал, Энергийн ба шатах ашигт малтмал гэсэн 4 үндсэн хэсэгтэй, 14 бүлэгтэй, 461 хуудастай, 132 зураг

			<p>схемтэй нэг сэдэвт бүтээл юм. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар энэхүү бүтээл дэлхийн 96 номын сангийн сан хөмрөгт орж, судлаач, уншигчдын хүртээл болсон.</p>
<p>10</p>	<p>2021/05/13-20</p>	<p><b>“ИННОВАЦИЙН 7 ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭ</b></p>	<p><b>ХҮХААХҮЯ, ШУТИС:</b>          ”Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын шинжлэх ухаан, технологи, инновац” салбар хуралдааныг амжилттай зохион байгууллаа.</p>
<p>11</p>	<p>2021/05/06-07</p>	<p><b>ICIED-2021: “ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕШИПИЙН ХӨГЖИЛ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ</b></p>	<p><b>ЭШИГ, БуХС, БАТС:</b>          “International Conference on Innovation and Entrepreneurship Development” Магистрант, докторант оюутны шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.</p>




ШУТИС-ийн хэмжээнд тайлант онд бүрэлдэхүүн сургуулиудаас зохион байгуулсан арга хэмжээ: Олон улсын эрдэм шинжилгээний 16 хурал, улсын хэмжээний хурал 18, профессор, багш нарын ЭШ-ний хурал 12, ахисан түвшний оюутны хурал 16, оюутны ЭШ-ний хурал 14, үзэсгэлэн 5, олимпиад 5, уралдаан тэмцээн 19, бусад сургалт семинар 9 тус тус зохион байгууллаа (хүснэгт 3.2).

### Бүрэлдэхүүн сургуулиудын зохион байгуулсан арга хэмжээ /2020-2021/

Хүснэгт 3.2

БС	ОУ-ын ЭШХ	Улсын хэмжээний ЭШХ	Багш эрдэмтдийн ЭНХ	Ахисан түвшний судлаачдын	Оюутны ЭШХ	Үзэсгэлэн	Олимпиад	Уралдаан тэмцээн	Бусад арга хэмжээ	нийт
БАС	0	2	1	1	1	0	0	4	0	9
БАТС	2	1	0	0	0	0	0	0	0	3
БуХС	4	5	2	3	3	2	0	7	1	27
ДаТС	1	1	1	1	1	1	1	2	0	9
ГХС	1	0	1	1	0	0	3	5	4	15
ГУУС	2	2	2	3	4	2	1	0	0	16
МехТС	0	1	1	1	0	0	0	0	0	3
МХТС	1	1	1	2	1	0	0	1	0	7
ҮТС	2	1	1	1	1	0	0	0	0	6
ХШУС	3	2	1	1	2	0	0	0	3	12
ЭХС	0	2	1	2	1	0	0	0	1	7
Нийт	16	18	12	16	14	5	5	19	9	98



Зураг 3.1. Бүрэлдэхүүн сургуулиудын зохион байгуулсан арга хэмжээ



### 3.2 СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

2020-2021 оны хичээлийн жилд “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам”, “ШУТИС-ийн Технологийн сангийн журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн төсөл хэрэгжиж буй бүрэлдэхүүн сургуулиуд, бүрэлдэхүүн болон харьяа хүрээлэнгүүдийн эрдмийн зөвлөлөөр гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийн явц, үр дүнг хэлэлцүүлэх, төслийн даалгавар, санхүүгийн гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр ажиллав.


#### 2020-2021 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хөтөлбөрийн статистик мэдээлэл

Тайлангийн хамрагдах хугацаанд ШУТИС-ийн хэмжээнд дотоод, гадаадын санхүүжилттэй нийт 95 судалгааны төсөл хэрэгжүүлсэн байна. Үүнээс

2020-2021 онд ШУТИС-ийн хэмжээнд дотоод, гадаадын санхүүжилттэй нийт 90 төслийг 2.9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. Эдгээр 90 төслөөс 53 төсөлд санхүүжилт орж ирэлгүй өмнөх оны санхүүжилтээр төслийг хэрэгжүүлсэн болон шинээр гэрээ байгуулсан төслүүд байна. Харин үлдсэн 37 төсөл 2021 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 1.23 тэрбум төгрөгийн санхүүжилт авч эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж байна.

Санхүүжилтийн төрлөөр авч үзвэл:

- БШУЯ-ны ШУТСангийн санхүүжилттэй-34 төсөл,
- Инженер технологийн дээд боловсрол /МЈЕЕД/-10 төсөл,
- ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй-14 төсөл,
- Гадаадын их дээд сургууль, ОУБ-ын санхүүжилттэй төсөл-22 төсөл,
- Дотоодын үйлдвэр ААН, бусад эх үүсвэрийн санхүүжилттэй-10 төсөл



**Зураг 3.2. ШУТИС-ийн профессор, багш нарын хэрэгжүүлсэн төслийн тоо**




Дээрх төслүүдийг төслийн төрлөөр авч үзвэл:

- Суурь судалгааны-16 төсөл,
- Шинжлэх ухаан технологийн захиалгат төсөл-13 төсөл,
- Гадаадтай хамтарсан-42 төсөл,
- Инновацын-9 төсөл,
- Бусад төрлийн-10 төсөл хэрэгжүүлснийг дээрх графикаас харж болно.

Хэрэгжүүлсэн төслүүдийг бүрэлдэхүүн сургууль тус бүрээр дүгнэвэл ГУУС, ҮТС, БАС, ХШУС, ХҮСХХ-ийн профессор багш, судлаачид идэвхтэй төсөл хэрэгжүүлсэн байна. Сургууль тус бүрийн хэрэгжүүлсэн төслийн тоо, төрлийг доорх графикаас харна уу.

Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжүүд хэрэгжиж буй төслүүдийн явц, үр дүнг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, төслийн даалгавар, санхүүгийн гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр ажиллав.



**Зураг 3.3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлсэн төслийн тоо, төрөл**




### Төсөл хөтөлбөрийн санхүүгийн мэдээлэл

ШУТИС-ийн хэмжээнд хэрэгжүүлсэн 90 төсөл хөтөлбөрөөс 2020.07.01-2021.06.30-ний хооронд нийт 37 төсөлд санхүүжилт олгогдсон байна. Эдгээр 37 төсөлд дотоод гадаадын санхүүжилтээр нийтдээ 1.23 тэрбум төгрөгийн орлого ШУТИС-д төвлөрсөн байна. Үүнээс санхүүжилтийн эх үүсвэрээр задалж харвал:

- БШУЯам-ШУТСангийн санхүүжилтээр: 387.00 сая төгрөг,
- Инженер технологийн дээд боловсрол /МJEED/-35.90 сая төгрөг,
- ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилтээр-9.14 сая төгрөг,
- Гадаадын болон бусад эх үүсвэрийн санхүүжилтээр-800.96 сая төгрөг.

Эдгээр төслүүдийн орлогоос “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам”-ын 4.4-т заасны дагуу ШУТИС-ийн Технологийн санд нийт 38.47 сая, бүрэлдэхүүн сургуулиудад 45.94 сая ШУТИС-ийн хэмжээнд нийт 84.41 сая төгрөгийн шимтгэл дараах эх үүсвэрийн санхүүжилтээс төвлөрсөн.



**Зураг 3.4. 2020-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрөөс төвлөрүүлсэн шимтгэл /сая.төг/**

- БШУЯам-ны ШУТСангийн санхүүжилтээр хэрэгжсэн төслөөс: 32.81 сая төгрөг,
- Бусад эх үүсвэрийн санхүүжилтээр хэрэгжсэн төслөөс: 51.61 төгрөг.

Төслийн санхүүжилтийн гэрээнд онцгойлон заасан инженер технологийн дээд боловсрол төсөл болон ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлсэн төслүүдээс шимтгэл тооцож төвлөрүүлдэггүй болно.





### 3.2.1. БШУЯ-ШУТС-ИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ

ШУТИС-ийн 2020.07.01-2021.06.30 хүртэлх хугацаанд БШУЯ-ны Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй улсын захиалгат төслүүдийн мэдээллийг бүрэлдэхүүн сургуулиуд болон холбогдох эх үүсвэрүүдээс авч мэдээллийн бааз үүсгэж ажиллалаа.


#### Улсын захиалгаар ШУТИС-д 2020-2021 онд хэрэгжиж байгаа судалгаа боловсруулалтын ажлын жагсаалт /төслийн төрлөөр/

Хүснэгт 3.3

№	Төслийн төрөл	Төслийн тоо	Гэрээний дүн /сая.төг	2020-2021 санхүүжилт /сая.төг/
1	Суурь судалгааны төсөл	13	373.39	387.00
2	ШУТ-ийн Захиалгат төсөл	8	644.20	
3	Гадаадтай хамтарсан төсөл	11	501.96	
4	Инновацийн төсөл	2	161.50	
<b>НИЙТ</b>		<b>34</b>	<b>1,681.05</b>	<b>387.00</b>

2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-д суурь судалгааны-13, захиалгат-8, гадаадтай хамтарсан-11, инновацын-2, нийт 34 төслийг 1.68 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээ хэрэгжүүлж байгаагаас тус хичээлийн жилд нийт 387.00 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

#### ШУТСангийн санхүүжилттэй ШУТИС-д хэрэгжиж байгаа төслүүд




Зураг 3.5. 2020-2021 оны хичээлийн жилд ШУТС-ийн санхүүжилттэй ШУТИС-д хэрэгжиж байгаа төслүүд (төслийн төрлөөр)



Дэлхий нийтэд тархсан цар тахлын улмаас Монгол улсын хэмжээнд төсвийн хязгаарлагдмал байдал үүсэж БШУЯ-ны Шинжлэх ухаан технологийн сангаас 2020 онд суурь судалгааны болон бусад төрлийн зарим төсөлд гэрээний санхүүжилтийг олгоогүй. Энэ нь судлаачдын хувьд гэрээний дагуу судалгааны ажлаа гүйцэтгэхэд хүндрэл үүсэж, зарим төсөл зогсонги байдалд орсон бол зарим төслүүд өмнөх жилийн үлдэгдэл санхүүжилтээр судалгааны ажлаа хэрэгжүүлсэн.

2020.07.01-2021.06.30 хооронд улсын захиалгаар гүйцэтгэсэн төслийн нийт мөнгөн дүн, тоо, түүнээс ШУТИС-д төвлөрүүлсэн шимтгэлийн мэдээллийг бүрэлдэхүүн сургууль тус бүрээр боловсруулж доорх графикт үзүүлэв.



**Зураг 3.6. Бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлсэн улсын захиалгат төслийн мэдээлэл**

Дээрх графикаас харахад ХШУС 129.5 сая төгрөгийн дүн бүхий 8 төсөл, ГУУС 119.8 сая төгрөгийн дүн бүхий 8 төсөл, ҮТС нийт 110.8 сая төгрөгийн дүн бүхий 5 төсөл санхүүжилт авч, төсөл хэрэгжүүлэн бусад сургуулиудаа манлайлан ажилласан байна.

Тус төслүүдийн санхүүжилтээс Технологийн санд 13.41 сая, бүрэлдэхүүн сургуулиудад 19.4 сая төгрөг, ШУТИС-д нийт 32.8 сая төгрөгийн шимтгэл төвлөрсөн байна. ГУУС-иас хэрэгжүүлсэн төслүүдээс ШУТИС-ийн Технологийн санд журмын дагуу төвлөрүүлдэг 5 хувийн шимтгэлийг олгоогүй байна.



Мөн 2020.07.01-2021.06.30 хоорондох хугацаанд ШУТС-ийн санхүүжилтээр дараах төслүүдийн гэрээ шинээр байгуулагдан төсөл хэрэгжүүлж эхлээд байна.

### ШУТСангийн санхүүжилттэй шинээр гэрээ байгуулагдсан төслийн мэдээлэл

Хүснэгт 3.4


Д.д	Төслийн нэр	Төслийн төрөл	Бүрэлдэхүүн сургууль	Төслийн удирдагчийн нэр
1	Монгол орны хэмжээнд тархсан “Критикал металл” –уудын хүдэржилт, хэтийн төлөвийн судалгаа	Захиалгат төсөл /УУХҮЯ/	ГУУС	С.Жаргалан
2	Нүүрсний давирхайнаас түлш, шатахуун болон замын битумын чанар сайжруулах нэмэлт гарган авах судалгаа	Суурь судалгааны төсөл	ХШУС	Э.Бат-Эрдэнэ
3	Арьс шир боловсруулах технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх нь	Суурь судалгааны төсөл	ХҮСХХ	Н.Өлзийбямба С.Цэрэндулам
4	Хүн амын өргөн хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн амин хүчил тосны хүчлийн найрлага	Захиалгат төсөл	ҮТС	М.Пүрэвжав
5	Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгал	Захиалгат төсөл	БуХС	Ц.Бямба-Очир
6	Нэг бүс нэг замын орнуудын адуун сүргийн бүтэн геномын секвенсийг тодорхойлох	Гадаадтай хамтарсан төсөл	ҮТС	Ж.Туяацэцэг
7	Олон өгөгдлийн уусалд суурилсан синергистик эмийн хослолын ухаалаг таамаглалын загвар боловсруулах, турших судалгаа	Гадаадтай хамтарсан төсөл /БНХАУ/	МХТС	И.Цэрэн-Онолт



### 3.2.2. ШУТИС-ИЙН ТЕХНОЛОГИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ

ШУТИС-ийн Технологийн сангаас 2020-2021 оны хичээлийн жилд нийт 14 төсөл хэрэгжиж байгаагаас 4 төсөлд 9.14 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Үүнээс 1 төсөл нь шинээр хэрэгжиж эхэлж байгаа төсөл буюу шинэ санхүүжилт, харин 3 төсөл нь ШУТИС-ийн 60 жилийн ойг угтан зохион байгуулсан “ШУТИС-ийн багш судлаачдын 2IP уралдаан”-д шалгарч хэрэгжиж байсан шилжих санхүүжилттэй төслүүд юм. Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төслүүдийн ерөнхий мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.



**Зураг 3.7. ШУТИС-ийн Технологийн сангаас хэрэгжүүлж буй төслүүдийн тоо**

Дээрх графикаас харахад ШУТИС-ийн бүрэлдэхүүн 9 нэгж дээр нийт 14 төсөл хэрэгжиж байгаагаас ҮТС-ийн профессор, багш судлаачид 4 төсөл хэрэгжүүлж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. ШУТехнологийн сангаас 2020-2021 оны хичээлийн жилд санхүүжүүлсэн 4 төслийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.



## ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлсэн төслийн мэдээлэл

Хүснэгт 3.5

№	Төслийн нэр (Гэрээний дугаар, хугацаа)	Төслийн удирдаг ч	Батлагдсан төсөв /сая.төг/	2020-2021 оны санхүүжилт /сая.төг/	Сургуулийн нэр
1	Монгол хүүхдийн тавхайн антропометрийн судалгаа	Л. Удвал	5.00	1.50	ҮТС
2	Ноолууран дотуур сүлжмэл бүтээгдэхүүний эрүүл ахуйн тааламжтай байдлын судалгаа	Д.Энхтуяа	10.00	0.86	ҮТС
3	Эрчим хүчний хэмнэлттэй нэг айлын сууцны зураг төсөл	Э.Пүрэв-Эрдэнэ	7.00	0.60	БАС
4	ШУТИС-ийн ЭШ-ний мэдээллийн нэгдсэн системийг боловсронгуй болгох төсөл	Р.Төрбат	32.00	6.18	Мэдээлэл технологийн төв
<b>Нийт</b>			<b>54.00</b>	<b>9.14</b>	

Технологийн сангаас 2020-2021 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн нийт төслүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

**ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй  
төслийн мэдээлэл**

Хүснэгт 3.6

Д.д	Төслийн нэр	Гэрээний хугацаа	Төслийн удирдагч	Баглагдсан төсөв /сая.төг/	Сургуулийн нэр
1	Бэлчээрийн малын баасаар шахмал түлш үйлдвэрлэх	2018.10.01-2019.12.31	Ч.Ганбаатар	10.0	ОМССХ
2	Цайрын оксидын хэт ягаан гэрлийн мэдрэгчийг хөгжүүлэх боломжийн судалгаа	2018.10.01-2021.12.31	Х.Загарзүсэм	15.0	МХТС
3	Задлан шинжилгээний дэвшилтэт технологид тулгуурласан хүнсний ургамлыг зохицуулах үйлчлэл-технологийн судалгааг хэрэгжүүлэх нь	2018.10.01-2020.06.01	Э.Энхцэцэг	10.0	ҮТС
4	Машин сургалтыг үйлдвэрлэлд ашиглах, их сургуулийн жишиг хөгжүүлэлт	2018.10.01-2020.04.31	Ц.Мөнх-Эрдэнэ	10.0	ХШУС
5	Түүхийн дурсгалт зүйл, археологийн олдворыг гурван хэмжээст дижитал технологи ашиглан хадгалах, хамгаалах, судлах	2018.12.01-2021.12.31	Э.Наранбаатар	20.0	МехТС
6	ШУТИС-ийг Олон улсын их дээд сургуулиудын эрэмбэ тогтоох үйл явцад хамруулах	2018.07.01-2019.12.31	Ж.Арслан	19.8	ЭШИГ
7	Монгол гэрийн цахилгаан халаагуурын системд дулааны багтаамж өндөртэй чулуулгийн	2019.12.01-2020.12.01	Ч.Мангалжалав	5.0	ЭХС



	төрлүүдийг ашиглах боломжийн судалгаа				
8	Зохицуулах үйлчлэлтэй цагаан идээний технологи хөгжүүлэлт, чанарын судалгаа	2019.12.01-2021.12.31	Ч.Цэнд-Аюуш	10.0	ҮТС
9	Монгол хүүхдийн тавхайн антропометрийн судалгаа	2019.12.01-2021.12.31	Л. Удвал	5.0	ҮТС
10	Ноолууран дотуур сүлжмэл бүтээгдэхүүний эрүүл ахуйн тааламжтай байдлын судалгаа	2019.12.01-2021.12.31	Д.Энхтуяа	10.0	ҮТС
11	Хүний биеийн хөдөлгөөн таних дохио боловсруулалтын судалгаа	2019.12.31-2021.12.31	Д.Эрдэнэчимэг	7.0	МХТС
12	Эрчим хүчний хэмнэлттэй нэг айлын сууцны зураг төсөл	2020.01.15-2021.01.15	Э.Пүрэв-Эрдэнэ	7.0	БАС
13	ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн системийг боловсронгуй болгох нь	2020.10.01-2021.12.01	Р.Төрбат	32.0	ЭШИГ
14	“Суралцахуйд суралцах нь” сэдэвт нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээл (МООС) бэлтгэх”	2021.05.01-2021.12.31	Р.Найдандорж	50.0	НБ-ын төв
<b>Нийт</b>				<b>210.8</b>	<b>-</b>

Дээрх 14 төслөөс гэрээний хугацаа нь дуусаж байгаа 12 төсөл байгаагаас Х.Загарзүсэм, Э.Наранбаатар, Д.Энхтуяа, Л.Удвал, Д.Эрдэнэчимэг, Ч.Цэнд-Аюуш удирдагчтай төслүүд Ковид-19 цар тахлын улмаас судалгааны ажил гүйцэтгэх хүндрэл үүссэн, лабораторийн шинжилгээ гадаад улс руу явуулах боломжгүйд хүрсэн зэрэг хүндэтгэх шалтгаанаар төслийн хугацааг 1 жилээр



сунгуулах хүсэлтийг харьяа сургуулийн Эрдмийн зөвлөлийн санал дүгнэлтийг хамт Эрдэм шинжилгээ инновацын газарт ирүүлсэн.

Тус хүсэлтүүдийг ЭШИГ хүлээн авч ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөлийн хурлаар 2021 оны 01 сарын 26-ны өдөр хэлэлцэж төслийн гэрээг 2021 оныг дуустал үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн.

Бусад 6 төслийн үр дүн, тайланг "Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөл"-өөр хэлэлцүүлж хүлээн авах шийдвэрийг гаргаж, төслийн тайлан, актыг үйлдэж хүлээлцэх ажил үргэлжилж байна.

### 3.2.3. ОЛОН УЛСЫН САНХҮҮЖИЛТТЭЙ БУСАД ТӨСӨЛ

ШУТИС-ийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд гадаадын санхүүжилттэй нийт 32 төсөл хэрэгжиж байгаагаас ИТДБ төслийн 10 төсөл, бусад эх үүсвэрийн 22 төсөл байна. ИТДБ төслөөс 4 төсөлд 35.9 сая төгрөг, гадаадын санхүүжилттэй бусад 22 төслөөс 9 төсөлд 800.96 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

Санхүүжилтээ авч судалгааны ажлаа гүйцэтгэж буй төслүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

#### Гадаадын санхүүжилтээр 2020-2021 онд санхүүжилт авч хэрэгжүүлсэн төслүүдийн жагсаалт

Хүснэгт 3.7

Д. д	Төслийн нэр (Гэрээний дугаар, хугацаа)	Төслийн удирдагч	Батлаг дсан төсөв /сая.төг /	Санхүүжилт /сая.төг/	Шимтгэл төвлөрүүлэлт		Сургуулийн нэр
					ШУТИС Тех сан	Бүрэлдэхүүн Сургууль	
1	Баянхонгор аймаг дахь гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах, хоол бэлтгэх халаалт дулаалгын бүтээгдэхүүн үйлчилгээний цэвэр хэмнэлттэй хүртээмжтэй багцыг хөгжүүлэх таниулах төсөл /2020-06-2021-06/ НҮБ Хүүхдийн сан MGLA/2880/2019/00 1-PCA	Б.Мөнхбаяр	159.13	169.51	4.03	1.60	ШУТИС БАС





2	Гадаад төсөл Berg Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн ашигт малтмалд хэрэгдэх аргачилсан зөвлөмж төсөл	Г.Ухнаа	200.00	184.10	9.20	9.20	ШУТИС ГУУС
3	Гадаад төсөл АМЕР II 7 ашигт малтмалын аргачилсан зөвлөмж	Г.Ухнаа	231.25	223.75	11.19	11.19	ШУТИС ГУУС
4	Сумдын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах. 2020.01.10-2021.03.20	Ц.Банзрагч	78.30	66.50		3.92	ШУТИС ОМССХ
5	Монгол улсын ногоон ICT хөгжүүлэлт төслийн санал бичгийн ТЭЗҮ бэлтгэл	Г.Хишигжаргал	12.70	12.70	0.64	0.64	ШУТИС МХТС
6	Erasmus PLUS	Б.Мөнх-Үжин	180.00	45.10			ШУТИС ЭШИГ
7	Erasmus UNIVERSITA DEGLI STUDI DELL'AQUILA, I INSATLLMENT	Т.Намнан	60.00	28.20			ШУТИС ЭШИГ
8	Ашигт малтмалын салбарын сургалтын цогц хөтөлбөр	Т.Намнан	150.00	42.30			ШУТИС ЭШИГ
9	Erasmus CC water төсөл	Б.Аюурзана	200.00	28.80			ШУТИС ЭШИГ
<b>Нийт</b>			<b>1,271.38</b>	<b>800.96</b>	<b>25.06</b>	<b>26.55</b>	

Эдгээр төслүүдээс 2021.07.05-ны өдрийн урьдчилсан дүнгээр гадаадын санхүүжилтээр 2020-2021 оны хичээлийн жилд нийт 800.96 сая төгрөгийн санхүүжилт авч ШУТИС-ийн Технологийн санд 25.06 сая, бүрэлдэхүүн сургуулиудад 26.55 сая төгрөг, ШУТИС-ийн хэмжээнд нийт 51.66 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрсөн байна.


Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд 2020-2021 онд гэрээний санхүүжилтээ авч судалгааны ажлаа гүйцэтгэж буй төслүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.



**ИТДБ төслийн хүрээнд 2020-2021 онд санхүүжилт авч хэрэгжүүлсэн  
төслүүдийн жагсаалт**

Хүснэгт 3.8

Д.д	Төслийн нэр (Гэрээний дугаар, хугацаа)	Төслийн удирдагч	Батлагдсан төсөв /сая.төг/	Санхүүжилт /сая.төг/	Сургуулийн нэр
1	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацын судалгаа	Б.Сэргэлэн	80.00	10.00	ШУТИС-ЭХС
2	Дижитал технологид суурилсан судалгаа хөгжүүлэлт	Г.Хишигжаргал	80.00	5.90	ШУТИС-МХТС
3	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Д.Ганбат	80.00	10.00	ШУТИС-МехТС
4	Монголын тэнгэрийн дэд бүтэц: Аэро хөдөлгүүр, байгаль орчны мониторинг, механик болон тээврийн инженерчлэлийн хэрэглээний ШУ, холбооны технологи ба боловсрол	Б.Эрдэнэбат	80.00	10.00	ШУТИС-МехТС
<b>Нийт</b>			<b>320.00</b>	<b>35.90</b>	



**Зураг 3.8. Бүрэлдэхүүн сургуулиудын гүйцэтгэсэн гадаадын их дээд сургууль, ОУБ болон дотоодын ААН, бусад эх үүсвэрийн санхүүжилттэй төслүүд**

Гадаадын их дээд сургууль, ОУБ-ын санхүүжилттэй болон Дотоодын үйлдвэр ААН, бусад эх үүсвэрийн санхүүжилтээр бүрэлдэхүүн сургуулиудын хэрэгжүүлсэн төслүүдийн тоон мэдээллийг дээрх зураг 3.8-д харуулав.

### 3.2.4. "ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ" (МЈЕЕD)ТӨСӨЛ

ШУТИС-ийн тэргүүлэх чиглэл болох:

- Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл,
- Эрчим хүч байгаль орчны инженерчлэл,
- Автоматжуулалт, системийн инженерчлэл,
- Био инженеринг чиглэлүүдээр

“Инженер технологийн дээд боловсрол” төслийн хамтарсан судалгааны төслүүд тус сургууль дээр хэрэгжиж байна. Уг төслийн хүрээнд 2014-2021 он хүртэл Япон улсын шилдэг 20 орчим их, дээд сургуульд зэргийн ба зэргийн бус хөтөлбөрт 225 судлаач, Япон улсаас 151 зочин судлаачид урт, богино хугацаатай ШУТИС дээр ирж ажилласан. Хамтарсан судалгааны үр дүнд эрдэм шинжилгээний гадаад өгүүлэл 130, дотоод өгүүлэл 141, эрдэм шинжилгээний гадаад, дотоодод илтгэл 244 орчим хэлэлцүүлж, зохиогчийн эрх 3, ашигтай загвар 18, шинэ технологи 3, стандарт 1, хамтын ажиллагааны сургууль хоорондын 8 санамж бичиг тус тус байгуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажилласан байна.

Хамтарсан судалгааны багууд “Судалгаа дэмжих сан”-гаас жил бүр 10 сая төгрөгийн санхүүжилт авдаг ба эрдэм шинжилгээ, сургалт, туршилт судалгаа болон бусад үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.



## ШУТИС-ийн хамтарсан судалгааны 10 төсөл

Хүснэгт 3.9

Д.д	Төсөл, ажлын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Удирдагч	Хэрэгжих хугацаа	Санхүүжилт ₮
1	Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	Геологи, уул уурхайн сургууль	С.Жаргалан	2015-2023	Өмнөх оны санхүүжилт зарцуулагд аж дуусаагүй
2	Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй төсөл	Барилга, архитектурын сургууль	Д.Сүнжидмаа	2016-2023	10,000,000
3	Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт	Механик тээврийн сургууль	М.Дэлгэрмаа	2016-2023	10,000,000
4	Монголын тэнгэрийн дэд бүтэц	Механик тээврийн сургууль	Б.Эрдэнэбат	2015-2023	10,000,000
5	Хүрээлэгч орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр	Геологи, уул уурхайн сургууль	О.Мөнхцэцэг	2015-2023	Өмнөх оны санхүүжилт зарцуулагд аж дуусаагүй
6	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн	Эрчим хүчний сургууль	Б.Сэргэлэн	2015-2023	Өмнөх оны санхүүжилт зарцуулагд



	инновацийн судалгаа				аж дуусаагүй
7	Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа	Барилга, архитектурын сургууль	Ц.Цоггэрэл	2015-2023	10,000,000
8	Дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ ба ахуйн ухаалаг системийн хөгжүүлэлтийн судалгаа	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Г.Хишигжаргал	2015-2023	10,000,000
9	Монголын хүнсний зарим бүтээгдэхүүний хатаах аргын харьцуулсан судалгаа	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Ц.Одбаяр	2015-2023	10,000,000
10	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Механик тээврийн сургууль	Д.Ганбат	2015-2023	10,000,000
11	<b>Нийт</b>		<b>7 баг</b>		<b>70,000,000</b>

Хамтарсан судалгааны 10 төслийн үйл ажиллагааны үр дүнг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын Эрдмийн зөвлөлийн хурлаар 2 удаа, Эрдэм шинжилгээ инноваци хамтын ажиллагааны дэд зөвлөл, “ИТДБ” төслийн нэгж (ТХН), Зөвлөх баг (Asia SEED), Сургуулийн ажлын хэсэг (САХ) хамтран 2020/2021 оны хичээлийн жилд 1 удаа төслийн явц, үр дүнг тус тус хэлэлцэж үнэлж, дүгнэн, зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллалаа. 2021 оны 01-р сарын 26-ны өдөр хамтарсан судалгааны 10 багийн үйл ажиллагааны үр дүн, судалгаа дэмжих санхүүжилтийн зарцуулалтын тайланг тус дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үнэлгээг нэгтгэн гаргав.

Нэгдсэн үнэлгээн дээрээс харахад 10 төслийн явцын хэрэгжилт 74-89 хувьтай дүгнэгдсэн. Үнэлгээний хувийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан үнэлгээний хувийн дагуу коэффициентоос тооцсон.



Үнэлгээний журмын дагуу 74-89 хувь нь төслүүд “**тодорхой үр дүнд хүрсэн**” (төслийн зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан, хэрэгжилт, үр дүнг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай) гэсэн ангилалд багтаж байгаа.

МЖЕЕД-ийн төслүүдийн хувьд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хамтарсан судалгааны ажлууд удааширсан, зэргийн бус болон зочин судлаач хөтөлбөрүүд бүрэн зогссон, судалгааны лабораторийн тоног төхөөрөмжүүд төлөвлөгөөний дагуу монголд ирсэн боловч, суурилуулалт, сургалт хийх гаднын инженерүүд ирж чадахгүйн улмаас ашиглалтад ороогүй зэрэг шалтгаанууд 2020-2021 оны төслийн үйл явцад нөлөөлсөн.

Төслүүдийн явцыг ямар үзүүлэлтүүдээр, хэрхэн дүгнэсэн зэргийг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

**Зэргийн /магистр, доктор/ хөтөлбөрт:**

2021 оны 4 дүгээр сараас Япон улсын их, дээд сургуульд суралцах багш, судлаачдын материалыг хянан магадалж, Сургуулийн ажлын хэсэг (САХ) хэлэлцэн шийдвэрлэж, Төслийн нэгж (ТХН)-д хүргүүлсэн ба 2021 оны 02 сарын 10-ны өдрийн БШУЯ-ны Сайдын А/45 тоот тушаалаар 9 багш, судлаачийг докторын хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэсэн.

2021 4-р сарын байдлаар зэргийн хөтөлбөрөөр магистрт 1, докторт 35 багш, судлаач суралцаж байгаа бөгөөд 2 магистр, 3 доктор сургалт, судалгааны ажлаа амжилттай хамгаалж ирсэн үр дүнтэй байна.

**2021 оны 04-р сараас Япон улсад докторын хөтөлбөрт хамрагдах багш, судлаачид**


*Хүснэгт 3.11*

№	Овог, нэр	Суралцах хөтөлбөр	Суралцах хугацаа	Суралцах сургууль
1.	Ж.Ням	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Рьюкюү их сургууль
2.	М.Цолмон	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Кюүшноү сургууль
3.	Г.Цэнд-Аюуш	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Күмамото сургууль
4.	С.Өлзийбаяр	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Токүшима сургууль
5.	Б.Намжилдорж	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Күмамото сургууль
6.	Н.Баяржавхлан	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Тохокү сургууль
7.	Б.Мөнхпүрэв	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Нийгата сургууль
8.	Б.Солонго	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Үцүномияа сургууль
9.	О.Төмөртогтох	Доктор	2021.04.01-ээс 3 жил	Китакюүшү сургууль



**Зураг 3.9. Магистрын зэрэг хамгаалсан С.Сүнжидмаа, Б.Пүрэв-Эрдэнэ нар Япон профессоруудын хамт**


ШУТИС-ийн БАС-ийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбарын судлаач С.Сүнжидмаа Япон Улсын Нихон Их Сургуульд “A study of use of fly ash in production of eco-friendly Geopolymers as construction materials” сэдвээр, Б.Пүрэв-Эрдэнэ нь “Development of Energy Efficient Building Material Using Phase Change in Fly Ash Foam Concrete” сэдвээр магистрын зэргээ тус тус амжилттай хамгаалсан. Судлаач С.Сүнжидмаа нь магистрын дипломын сэдвээрээ “Yoshio Kasai” шагналыг хүртсэн бол Б.Пүрэв-Эрдэнэ нь Нихон Их Сургуулийн □н мастерын шилдэг диссертацийн ажлын "Saito" шагналыг хүртсэн байна.




**Зураг 3.10. Докторын хөтөлбөрийн төгсөчид Д.Гомбосүрэн, М.Амгалан нар**



ШУТИС-ийн БАС-ийн Барилгын инженерийн салбарын багш Д.Гомбосүрэн нь Япон Улсын Сайтамагийн Их Сургуульд “Prediction of Joint Shear Deformation of Reinforced Concrete Interior Beam Column Joints” сэдвээр, ШУТИС-ийн ХШУС-ийн Физикийн салбарын Сургалтын мастер М. Амгалан нь Китаюүшүгийн Их Сургуулийн Хүрээлэн Буй Орчны Инженерийн Факультетад “Application of Remote Sensing and GIS Techniques for Analysis of Lake Water Fluctuations and the Potential Impact of Human Activities: Case Study on Ogi Lake Basin in Mongolia” сэдвээр докторын зэргээ тус тус амжилттай хамгаалсан.




**Зураг 3.11. Зэргийн /магистр, доктор/ хөтөлбөрөөр суралцагч болон төгсөгчдийн тоон үзүүлэлт**



**Зураг 3.12. Магистрын хөтөлбөрийн төгсөгчдийн үзүүлэлт**



Дээрх графикаас харахад магистрын хөтөлбөрийн төгсөгчид гэрээний дагуу ШУТИС-д ажиллах байдал харьцангуй бага байна. Япон улсад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3-р зүйлд ШУТИС нь төгсөж ирсэн суралцагчийг ажлын байраар хангах буюу 5 жил тогтвор сууршилтай ажиллуулах, мөн 4-р зүйлд суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд зээлийг Боловсролын зээлийн санд буцааж төлөх үүрэгтэй гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, ямар нэг шалтгаанаар ШУТИС-д ажиллахгүй байгаа явдал нь гэрээний үүргээ зөрчиж байгаа явдал юм. Дээрх ШУТИС-д ажиллахгүй байгаа 8 төгсөгчийн хувьд төгсөөд ирэхэд ажлын байр байхгүй байсан, гэрээний дагуу ажиллах хүсэлтээ ШУТИС-д өгөөгүй, ажлын байрны цалин хөлс хангалтгүй гэсэн шалтгаантай байна.



*Зураг 3.13. Докторын хөтөлбөрийн төгсөгчдийн үзүүлэлт*

Докторын хөтөлбөрийн хувьд одоогоор бүх төгсөгчид гэрээний дагуу ШУТИС-д ажиллаж байгаа үзүүлэлт графикаас харагдаж байна.

**Зэргийн бус хөтөлбөрт:**

Зэргийн бус хөтөлбөр нь 1-3 сарын буюу богино хугацааны сургалтууд байдаг ба Ковид-19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалан Япон талын сургуулиуд багш, судлаачдыг хүлээн авахыг түр хугацаагаар хойшлуулсан.

**Зочин судлаач хөтөлбөрт:**

Мөн Ковид-19 өвчний нөхцөл байдалтай холбоотой Зочин судлаачийг хүлээн авахыг түр хугацаагаар хойшлуулсан болно.



**Зураг 3.14. Хамтарсан судалгааны зарим багаас зэргийн хөтөлбөрт хамрагдах багш, судлаачдын тоон үзүүлэлт (2020/2021 оны хичээлийн жил)**

**Хамтарсан судалгааны зарим багаас зэргийн хөтөлбөрт хамрагдах багш, судлаачдын тоон үзүүлэлт**

Хүснэгт 3.12

Судалгааны тэргүүлэх чиглэл	Судалгааны сэдэв, Бүрэлдэхүүн сургууль	Доктор	Зэргийн бус	Зочин судлаач
<b>1.Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл</b>	Д.Сүнжидмаа: Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй төсөл (БАС)	1		
	М.Дэлгэрмаа: Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт (МехТС)	1		
<b>2.Эрчим хүч, байгаль орчны инженерчлэл</b>	Б.Сэргэлэн: “Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн инновацын судалгаа” (ЭХС)	2		
	Ц.Цоггэрэл: Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа (БАС)	1		
<b>3.Автоматжуулалт, эмбедэд технологи</b>	Г.Хишигжаргал: “Дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ ба ахуйн ухаалаг системийн хөгжүүлэлтийн судалгаа” (МХТС)	3		



ШУТИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусган оюутанд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгууллаа.

**Сургалт, семинар, аян***Хүснэгт 5.1*

д/д	Сургалтын нэр	Илтгэгч	Оролцсон оюутны тоо
1	Танд тусалъя аян	ОСҮА, клубүүд, шинэ элсэгчид	Шинээр элсэгч 2100 оюутанд зөвлөгөө өгөв.
2	Амжилттай суралцах нь	Бүрэлдэхүүн сургуулиудын эрдэмтэн багш нар	648 оюутанд эрдэмтэн 8 багш лекц оров.
3	Хотын соёл аяны хүрээнд (Гэмт хэрэг, хэв журмын зөрчил, Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх лекц, )	Монголын түүхийн багш нар НЗЦГ, НЦГ, НПГ-ын албан хаагчид болон мэргэжилтэн	1600 оюутан 12 багш, НЦУГ-ын олон нийттэй харилцах албаны хамт олон

**5.1.1. “Танд тусалъя аян”, “Чиглүүлэгч оюутан” аян**


“Оюутны хөгжил” хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд нэгдүгээр курсийн оюутнуудад “ШУТИС 2020-2021 элсэгчид” групп нээж ажиллав. Нэгдүгээр курсийн оюутнуудыг зөвлөн чиглүүлэх зөвлөх багш нарт чиглэсэн “2020-2021 нэгдүгээр курсийн зөвлөх багш нар” группийг тус тус нээн ажиллуулав. Мөн энэ ажлуудыг чанартай сайн хөгжүүлэх зорилгоор нийт 8 цахим сургалтыг ХААИС-ийн бичлэгийн студид бичүүлж профайл үүсгэв. Мөн ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвд сургалтын талаарх зөвлөгөө болон номын сангийн үйлчилгээний танилцуулгыг хийв. Эдгээр цахим сургалтуудаа оюутнууд, зөвлөх багш нарт оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгасан хуваарийн дагуу холбогдох группүүддээ тавьж хүргэн ажиллав.

Сошиал группүүдээр дамжуулан дараах сургалтуудыг хийсэв. Үүнд:

- Танд тусалъя- Чиглүүлэгч оюутан
- “Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт” арга хэмжээ
- Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли
- “Амжилттай суралцах” тухай лекц



- ШУТИС-ийн клубүүдийн танилцуулга
- “Хувь хүний ёс зүй, төлөвшил”
- “Эрүүл зөв хооллолт” цахим сургалт зэрэг сургалт, семинар багтана.
- Оюутан оролцоо идэвхийг дүгнүүлэх дүгнэх хуудсаа бөглөх



ЗӨВЛӨМЖ

*Зураг 5.1. ШУТИС-ийн шинэ элсэгчдийн групп*

### 5.1.2. “Хотын соёл” аян

Нэгдүгээр курсийн оюутнуудад оюутан болсон эхний цаг мөчөөс эхлэн нийслэлийн соёлтой иргэн болох, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс өөрийгөө болон бусдыг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг жигд хүргэдэг “Хотын соёл” ажлыг БУХС-ийн ХҮУС-ын Монголын түүхийн багш нарын лекцийн хичээлээр дамжуулан Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Олон нийттэй харилцах албаны хамт олонтой хамтран хүргэсэн бөгөөд тус сургалтыг нийт 12 багшийн 12 удаагийн лекцийн цагаар 1600 гаруй оюутанд хүргэсэн.



*Зураг 5.2. МХТС-ийн 150 оюутанд хотын соёл сургалт оржэ буй байдал.*

### 5.1.3. Нэгдүгээр курсийн зөвлөх багш нарт зориулсан цахим сургалт

Зөвлөх багш нарт “2020-2021 Нэгдүгээр курсийн зөвлөх багш нар” группээр “Оюутны хөгжилд багшийн оролцоо түүний үр дүн” сэдэвт сургалтыг амжилтай зохион байгуулан хүргэснээс гадна “Бид оюутан боллоо” нэгдсэн уулзалт, лекцийг МехТС-ийн багш нартай хамтран амжилттай зохион байгууллаа.





*Зураг 5.3. МехТС-ийн “Бид оюутан боллоо” арга хэмжээ*

#### **5.1.4. ШУТИС-ийн оюутны клубүүдийн үйл ажиллагаа**

2020-2021 оны хичээлийн жилд клубийн үйл ажиллагааг танхим болон цахимаар хослуулан зохион байгуулалт хийж ажиллалаа. Шинээр элссэн оюутнуудад зориулан Клубийн нэгдсэн зөвлөлийн дарга Б.Бат-Ирээдүйтэй хамтран элсэгчдэд фэйсбүүк групп нээж “Танд тусалъя” арга хэмжээг цахимаар хүргэн мэдээлэл өгч, тулгамдсан асуудлуудыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн оюутнуудын хичээлийн бус цагаар өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгодог “Клубүүдийн нээлттэй өдөрлөг”-ийг Ковид-19 халдвартай холбоотойгоор Монгол улсад хөл хорионы дэглэм тогтоон олон хүн бөөгнөрүүлж үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосон шийдвэр гаргасан тул танхим, цахимаар хослуулан клубүүдийн танилцуулга, сурталчилгааг хийлгэлээ. Цахим сурталчилгаагаар ШУТИС-ийн томоохон фэйсбүүк группүүдээр дамжуулан түгээсэн нь зорилтод бүлгийн оюутнуудад хүрэхэд үр дүн сайтай байсан. Нээлттэй өдөрлөгийг амжилттай зохион байгуулж 11 клуб 300 гаруй оюутныг элсүүлж байна.



*Зураг 5.4. Оюутны соёл, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн /Ph.D/ Д.Цогзолмаа болон клубийн ахлагч нар “Клубүүдийн нээлттэй өдөрлөг”*

Хорио цээрийн дэглэм тавигдсаны дараа оюутнуудын хичээл танхимаар хэсэгхэн хугацаанд орж клубүүдийн үйл ажиллагаа идэвхжиж клубүүд төлөвлөсөн ажил болох хичээлийн хоцрогдол арилгах, зарим клубүүд мэргэжлийн хичээлээр сургалт явуулах, ЕБС-ийн сурагчдад мэргэжлээ таниулах, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэргээр нийтэд үйл ажиллагаагаа хүргэх томоохон ажлуудаа хийж эхэлсэн боловч хорио цээртэй холбоотойгоор үргэлжлүүлэн цахимаар үйл ажиллагаагаа хүргэж байна. Мөн “E-MUST” клубийг шинээр байгуулан тодорхой ажлуудыг хийж амжуулсан байна. “E-MUST” клубийн зорилго нь оюутан залуусын цахим спортын талаарх буруу ойлголтыг залруулах, давуу талыг нь тэдэнд сурталчлахаар төлөвлөсөн.

#### **5.1.5. Клубүүдийн үйл ажиллагаа.**

1. Энэ намрын улиралд “**Багшийн туслах оюутан**” клуб нь нэгдүгээр курсийн суурь хичээлийн хоцрогдол арилгахад туслах зорилгоор, “Sys&CoTech” клуб нь 1-2 курсийн оюутнуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулсан байна.



**БЛОК-05 “Оюутан хөгжил” танхимд хичээлдэх клубүүдийн цагийн хуваарь.**  
2019-2021 оны хичээлийн жилийн намрын улирал  
(2020 оны 09 сарын 28- 12 сарын 15 хүртэл)

Гариг Цаг	ДАВАА	МЯГМАР	ЛХАГВА	ПҮРЭВ	БААСАН	БЯМБА
2-р пар 9:10-10:50	Хичээл	Хичээл	Хичээл	Хичээл	Хичээл	“AIESEC-MUST” клуб
3-р пар 11:00-12:30		Солонгос хэлний клуб	Герман хэлний клуб	Аянга аялалын клуб	БТОК Ерөнхий хими	
4-р пар 13:00-14:30	БТОК Математик 1	БТОК Физик 1	БТОК Физик 1	БТОК Дүрслэх геометр	Нитопен Япон хэлний клуб	Залуучууд Улаан загалмайн клуб
5-р пар 14:40-16:10	Газрын тос клуб	БТОК Математик 1	БТОК Харилцааны англи хэл	БТОК Харилцааны англи хэл	Хятад хэлний клуб	
6-р пар 16:20-17:50	Нитопен Япон хэлний клуб	Хятад хэлний клуб	Англи хэл орчуулгын клуб	Герман хэлний клуб	Солонгос хэлний клуб	
7-р пар 18:00-19:30	“Багшийн туслах оюутан” клуб (БТОК)	MUST Comedy	Англи хэл орчуулгын клуб	Empowerment – мэтгэлдэний клуб	E-MUST клуб	
8-р пар 19:40-21:10						

**Speaking club:** E-404 (A) тоот танхимд Мягмар гараг бүр 5 пар, Баасан гараг бүр 5 парын цагуудад хичээллэнэ. Хичээлийг АНУ-ийн мэргэжилтэн багш Скот Путийт (цахимаар) болон монгол багш нар удирдан явуулна.


**Empowerment** Мэтгэлдэний клуб: TV зааланд Пүрэв гараг бүр 7,8 парын цагуудад үйл ажиллагаа явагдана.

**Мэргэжлийн харьяа клуб:** Блок-03 танхимд Мягмар гараг 6,7 н пар, Пүрэв гараг 6, 7 парын цагуудад хичээллэнэ.

**Звёздочка** Орос хэлний клуб: Е-Русский центр Лхагва гараг 5 пар, Баасан гараг 4 парын цагт хичээллэнэ.

**БТОК-ийн** сургалт БУХС-д математик, МехТС-д математик, хими, физикийн хичээлүүд тусгай хуваарын дагуу явагдана.

**Зураг 5.5. Багшийн туслах оюутан клубийн сургалт хуваарь**



**Зураг 5.6. “Sys&CoTech” клубийн хичээлийн явц, төрөл хуваарь**

2. “Сэргээгдэх эрчим хүч клуб” нь ерөнхий боловсролын 84, 33 дугаар сургуулийн сурагчдад “Сэргээгдэх эрчим хүч”-ийг танилцуулах өдөрлөгийг зохион байгуулсан.



*Зураг 5.7. СЭХ клуб 84, 33 дугаар сургуулийн сурагчдад мэргэжил сурталчилж байна*

3. “Empowerment клуб”-ийн гишүүдэд гэрээт багш ажиллуулсан. Мэтгэлцээний холбооны сургагч багш: Ч.Сайхнаа 2020 оны 10-р сарын 1-ээс эхнээс 12-р сарын 15-ыг хүртэл сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулан идэвхтэй ажилласан. Сургалтаар клубийн гишүүдэд мэтгэлцэх арга техникээс гадна цаг баримтлал, багаар ажиллах ур чадвар, харилцааны арга техникүүд, үнэт зүйлээ тодорхойлох зэрэг мэдлэг олгогдсон.
4. ШУТИС-ийн КООСЭН 1000 инженерийн төгсөгч оюутнуудад ажлын байр зуучлах нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд Finde, Sys&CoThech, INSPIRATION, Соёмбо, Хятад хэл, Англи хэл, EMPOWERMENT, Экологийн клубүүд хичээлийн 8 дугаар байранд танилцуулга хийж оролцсон ба Finde, Соёмбо клубүүд телевизүүдэд ярилцлага өгч, клубүүд хийж бүтээсэн бүтээлүүдээ танилцуулах, зарж борлуулах зэргээр ажиллав.



*Зураг 5.8. Клубүүдийн танилцуулгын үйл ажиллагаа*



## 5.2. ШУТИС-ИЙН КЛУБУУДИЙН ӨДӨРЛӨГ /НАМРЫН УЛИРАЛ/

ШУТИС-ийн оюутнууд клубийн системээр хамтдаа хөгжин, хамтын хүчээр олон ур чадварыг хөгжүүлж бүтээн бий болгож буй явдал нь их сургуулийн сурталчилгааны томоохон үйл ажиллагааны нэг хэсэг болох юмаа гэдэг үүднээс Клубүүдийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор клубүүдийн нэгдсэн зөвлөлтэй (КНЗ) хамтран хол хорио тавигдсантай холбоотойгоор 10-р сарын 30-нд өдөрлөгийг зохион байгуулсан. Уг үйл ажиллагааны хүрээнд клубүүд нэгдэн өдөрлөгийн бүхий л чимэглэл, анонс хэвлэл, богино хэмжээний кино гаргах зэрэг ажлуудыг хамтдаа амжилттай гүйцэтгэсэн.



*Зураг 5.9. Өдөрлөгийн чимэглэл  
бэлтгэлийн ажил*

Мөн салбар сургууль болон клубийн танилцуулга хийсэн. Энэхүү үйл ажиллагаа нь клубүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, клубүүдийг сурталчлан таниулах, оюутнуудын идэвх санаачилгыг нэмэгдүүлж, идэвхжүүлэх, дэмжих чухал ач холбогдолтой байсан гэж үзэж байна. Сайн дурын болон мэргэжлийн клубүүд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах бусдад танин мэдүүлэх зорилгоор онцлог шинжүүдээ тодотгохуйц бүтээлийн үзэсгэлэнгээ гаргасан нь онцлог байлаа.



Энэ ажиллагааны үеэр ШУТИС-ийн КНЗ-ийн ахлагч БАС-ийн оюутан Б.Бат-Ирээдүй болон ёс зүйн “Соёмбо” клубийн ахлагч ГУУС-ийн оюутан Н.Баяраа нар МҮОНТ-ийн өглөөний зочны цагаар 2020 оны 10-р сарын 28, 29-ний өдөр орж ШУТИС-ийн оюутнууд клубээр хэрхэн хөгжиж хамтран ажиллаж буй ямар үйл ажиллагаа зохион байгуулж байгаа, оюутнууд хэрхэн чадваржиж байгаа талаар дэлгэрэнгүй ярилцлага өгөв.



*Зураг 5.10. Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн ахлагч БАС-ийн оюутан Б.Бат-Ирээдүй*



*Зураг 5.11. “Соёмбо” клубийн ахлагч ГУУС-ийн оюутан Н.Баяраа*

## Өдөрлөгт оролцсон клубүүд

Хүснэгт 5.2

д/д	Мэргэжлийн клуб	№	Сайн дурын клуб
1	CCS клуб	1	AIIESEC клуб
2	Finde клуб	2	Хятад хэл клуб
3	Inspiration клуб	3	Meine Zukunft клуб
4	WHIZZ клуб	4	Дуулаачийн клуб
5	СЭХ клуб	5	Соёмбо клуб
6	Энергетик клуб	6	Hitonin клуб
7	Залуу экологич клуб	7	Empowerment клуб
8	SySCo Tech клуб	8	Хос уянга клуб
9	Зөв зохистой хооллолт клуб	9	Багшийн туслах оюутан клуб
10	D-Art клуб	10	Орос хэлний клуб
		11	Шагай харваа клуб
		12	English speaking club





*Зураг 5.12. Клубийн танилцуулга*



*Зураг 5.13. Өдөрлөгийн хаалт.*

Өдөрлөгийн үеэр урлагийн тоглолт, циркийн үзүүлбэл, богино хэмжээний кино үзүүлж, хөгжөөнт тоглоом, шилдэг дүр хувиргалтын тэмцээн зохион байгуулав. Энэхүү тэмцээнд эрэгтэй 9 оюутан, эмэгтэй 14 оюутан оролцож, ялагчдыг тодруулж, ШУТИС брендийн гарын бэлгээр шагнасан.

Клубүүдийн 2020-2021 оны намрын улирлын тайланг хүлээн авч үйл ажиллагаатай нь нэг бүрчлэн танилцаж хангалттай сайн ажилласан клубийн ахлагч, идэвхтэй гишүүдэд кредитийн урамшуулал олгож байна. Клубүүдийн хийсэн ажлын тайланг эмхэтгэн цахимд байршуулна. Энэ өдөрлөгийн арга хэмжээг ШУТИС-ийн НБТ-ийн мэргэжилтэн Н.Төгөлдөр бичлэг хийж КНЗ-ийн ахлагч, клуб тус бүрийн ахлагч нар бага хэмжээний шторк танилцуулга бичлэг хийж архив үүсгэсэн.



### 5.3. ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

#### 5.3.1. Төр болон нийгмийн үйлчилгээнд оюутныг хамруулсан байдал

##### Сан, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байдал

Хүснэгт 5.3

д/д	Тэтгэлгийн нэр	Тэтгэлэг авсан оюутны тоо	Нийт тэтгэлгийн хэмжээ /төгрөг/
1	Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	1	1,200,000
2	Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	2	2,000,000
3	Ректорын нэрэмжит тэтгэлэг	39	6,305,200
4	Голомт банкны тэтгэлэг	14	14,000,000
5	Хаан банкны нэрэмжит тэтгэлэг	7	7,000,000
6	Оюутолгой ХХК-ийн тэтгэлэг	10	27,180,000
7	Эрдэнэс таван толгой ХХК-ийн тэтгэлэг	30	30,000,000
8	Кредитийн урамшуулал	1111	168,324,500
	нийт	1214	256,009,700

#### 5.3.2. Ректорын нэрэмжит тэтгэлэг

“Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу оюутны амжилт, амьдралын боломж бололцоо муу буюу санхүүгийн дэмжлэг зайлшгүй авах шаардлагатай, 2020-2021 оны хичээлийн жилд шинээр элсэгч 14 оюутанд 30 кредитийн хөнгөлөлт буюу 38 сая 163 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгов.

##### “ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан шинээр элсэгч оюутнууд

Хүснэгт 5.4

д/д	Овог	Нэр	Мэргэжил
1	ШАГДАРСҮРЭН	ТӨГСЖАРГАЛ	АРХИТЕКТУР
2	ЛАМЖАВ	БАТЗОРИГ	УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ
3	ЛУВСАНЖАРГАЛ	УЛАМБАЯР	СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ (Хамтарсан)
4	ОТГОНБАЯР	ТАМИР	ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ /ЯПОН ХЭЛ, БАРИЛГЫН ИНЖЕНЕР/
5	ЭРДЭНЭБОЛД	ДОРЖБАТ	ГАЗРЫН ТОСНЫ ИНЖЕНЕР
6	АРИУНАА	ТҮМЭННАСАН	ЦАХИЛГААН СИСТЕМ



7	БАТМӨНХ	МӨНГӨНШАГАЙ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ
8	МЯГМАР	ОЮУН-ЭРДЭНЭ	СЭТГЭЛ СУДЛАЛ
9	ХАЛИУН	ЭРХЭМБАЯР	ПРОГРАММ ХАНГАМЖ
10	ГАНБАТ	НОМИНЧУЛУУН	ГРАФИК ДИЗАЙН
11	ГАНХУЯГ	АНУДАРЬ	Химийн инженерчлэл /БНХАУ-ын ӨМӨЗО-ны Технологийн Их Сургуультай хамтарсан/
12	САРАН	ЦЭЛМЭГ	ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (Хамтарсан)
13	БААСАНХҮҮ	НОМИН	АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ
14	ЭНХТӨР	ОТГОНСҮХ	АВТО ИНЖЕНЕР

### 5.3.3. Нийтийн тээврээр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/740 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6/21 тогтоолоор батлагдсан “Цахим карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн “Их, дээд сургуулийн оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, сунгах ажлыг зохион байгуулах удирдамж”-ын дагуу 2020-2021 оны намрын улиралд 3763 оюутан автобусны хөнгөлөлттэй картаар зорчиж байна.

#### 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улиралд автобусны карт захиалсан оюутны тоо

Хүснэгт 5.5

д/д	Сургууль	Шинээр карт захиалсан оюутны тоо	Карт сунгуулсан оюутны тоо	Нийт
1	БАС	216	435	651
2	БуХС	116	262	378
3	ГХС	38	54	92
4	ГУУС	93	202	295
5	МехТС	116	322	438
6	МХТС	302	390	692
7	ҮТС	148	308	456
8	ХШУС	61	73	134
9	ЭХС	211	416	627
	<b>ДҮН</b>	<b>1315</b>	<b>1119</b>	<b>3763</b>

### 5.3.4. Төгсөгч оюутны анкет

Хичээлийн жилийн намар, хаврын улиралд төгсөгч оюутан “Төгсөгч оюутан анкет”-ийг бөглөдөг. Ингэснээр ажил олгогч, боловсон хүчнээ хайж

байгаа байгууллагуудтай холбож өгөх, төгсөгч оюутнуудыг мэргэжлийн дагуу ажлын байранд зуучилж байна.

**2020-2021 оны хичээлийн жилд Төгсөгч оюутны  
анкет бөглөсөн оюутны тоо**

*Хүснэгт 5.6*

д/д	Сургууль	2021 оны 01 сар	2021 оны 06 сар	Нийт
1	БАС	97	187	284
2	БаТС	45	23	68
3	БуХС	64	138	202
4	ДаТС	84	107	191
5	ГХС	15	40	55
6	ГУУС	74	159	233
7	МехТС	73	169	242
8	МХТС	86	125	211
9	ҮТС	74	210	284
10	ХШУС	13	57	68
11	ЭХС	126	160	286
	<b>ДҮН</b>	<b>751</b>	<b>1375</b>	<b>2108</b>

## 5.4. НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

### 5.4.1. 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа

ШУТИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн намрын төгсөлтийн цахим хэлбэрээр зохион байгуулалт хийж ажилласан. ШУТИС-ийн бакалаврын 85, магистрын 47 дахь удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагааг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Докторын зэргийн дипломтой 5, магистрын зэргийн дипломтой 266, бакалаврын зэргийн дипломтой 1068 төгсөгч төгссөнөөс онцлох дипломтой 28, дипломын зэрэгтэй 44 төгсөгч байна.



*Зураг 5.14. Эрдмийн баяр*



Мөн суралцах хугацаандаа сурлага, эрдэм шинжилгээ, спорт урлагаар бусдыгаа манлайлсан бакалаврын “Шилдэг төгсөгч” шагналаар 10 төгсөгч, магистрын “Шилдэг судлаач” шагналаар 1 төгсөгчийг тус тус шагнаж урамшуулав.

**Бакалаврын “Шилдэг төгсөгч” намрын улирлын оюутны нэрс**

*Хүснэгт 5.7*

д/д	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	АРХИТЕКТУР	НЯМЖАВ	ТҮВШИНЗАЯА	3.73	161
2	ОЛОН УЛСЫН БИЗНЕСИЙН МЕНЕЖМЕНТ	ГАНБААТАР	НЯМАА	3.73	128
3	УУЛ УУРХАЙН ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ	БААСАНЖАВ	ОТГОНЦАГААН	3.66	131
4	ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	БАТСҮХ	АЛТАНГЭРЭЛ	3.79	130
5	НИСЭХ ТЕХНИКИЙН МЕХАНИК	БАЯНМӨНХ	БУЛГАНБАЯР	3.64	130
6	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	ДАНГААСҮРЭН	БАЯРЖАРГАЛ	3.6	125
7	ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ	БАЯРСАЙХАН	БАЯРЦЭЦЭГ	3.59	123
8	ЦАХИЛГААН СИСТЕМИЙН АВТОМАЖУУЛАЛТ	БААТАРЖАВ	ГАНЦООЖ	3.54	130
9	ЦАХИЛГААН СИСТЕМ	ЧУЛУУН	АМАРСАЙХАН	3.8	130
10	ТТО	СОСОРЗАГД	ӨЛЗИЙБТ	3.7	128

**Магистрын “Шилдэг судлаач” оюутны нэр**

*Хүснэгт 5.8*

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	Геологи уул, уурхайн сургууль	ГЕОЛОГИ	ГАНСҮХ	ГАНТУЛГА	3.86	34



### 5.4.2. 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын бакалаврын 86, магистрын 48 дахь удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдөр цахимаар зохион байгуулагдлаа.



*Зураг 5.15. Төгсөлтийн ёслолын ажиллагаа*

Энэ удаа докторын зэргийн дипломтой 10, магистрын зэргийн дипломтой 252, бакалаврын зэргийн дипломтой 1673 оюутан төгссөнөөс онцлох дипломтой 82, Монгол-Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд 53 төгсөгч хос дипломтой, инженер дипломын зэрэгтэй 39, ШУТИС-Коосэн технологийн коллежийн дипломын зэрэгтэй 19 төгсөгч байна. Түүнчлэн гадаадын их, дээд сургуультай хамтарсан бакалаврын хөтөлбөрөөр 14 төгсөгч, магистрын хамтарсан хөтөлбөрөөр 7 төгсөгч тус тус төгсөн гарлаа.

Нийт Төгсөгчдөд зориулан УИХ гишүүн, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын байнгын хорооны Дарга Г.Дамдинням цахимаар мэндчилгээ хүргэлээ.

Мөн суралцах хугацаандаа сурлага, эрдэм шинжилгээ, спорт урлагаар бусдыгаа манлайлсан бакалаврын “Тэргүүний төгсөгч оюутан” шагнаалаар 4



төгсөгч, “Шилдэг төгсөгч” шагналаар 12 төгсөгч, магистрын “Шилдэг судлаач” шагналаар 1 төгсөгчийг тус тус шагнаж урамшуулав.

### Бакалаврын “Шилдэг төгсөгч” хаврын улирлын оюутны нэрс

Хүснэгт 5.9

д/д	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	ИРГЭНИЙ БА ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА	БУЯНДЭЛГЭР	ЭНХПҮРЭВ	3.72	130
2	САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ	РАДНААЖАМБ А	МӨНХНАРАН	3.83	128
3	УУЛ УУРХАЙН ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ	ЖАМСРАНЖАВ	МӨНХБАТ	3.71	131
4	САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ	БАТ-ЭРДЭНЭ	ЭРДЭНЭЧИМЭ Г	3.77	128
5	ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН АВТОМАТЖУУЛАЛ Т	БАЯРСАЙХАН	АМАР	3.8	138
6	ПРОГРАМ ХАНГАМЖ	БАТБИЛЭГ	ХҮСЛЭН	3.83	125
7	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДИЗАЙН	БОЛДБААТАР	УРАНГОО	3.68	128
8	ЦАХИЛГААН СИСТЕМИЙН АВТОМАТЖУУЛАЛ Т	ХҮРЭЛЧУЛУУН	ХЭРЛЭНЗОРИГ	3.73	131
9	ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ОРЧУУЛГА /ХЯТАД ХЭЛ/	ТӨМӨРБААТАР	ОДОНЦЭЦЭГ	3.82	130
10	АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	БАЯРСАЙХАН	ЧИМЭГЛХАМ	3.61	128
11	ҮЙЛДВЭРИЙН ЭКОЛОГИЙН ИНЖЕНЕР	ЭНХБААТАР	ТҮВШИН- УНДРАЛ	3.68	128
12	ГЕОДЕЗИ	НОРЖМАА	БАЯРАА	3.06	134

### “Шилдэг судлаач” магистр оюутан

Хүснэгт 5.10

д/д	Мэргэжил	Овог	Нэр	Голч	Кредит
1	ХОТ БАЙГУУЛАЛТЫН АРХИТЕКТУР	АЛТАНТУУЛ	САРУУЛ	3.87	34

#### 5.4.3. ШУТИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хурал “Эрдмийн ХХ чуулган”


Эрдэм шинжилгээний хурлыг 2 үе шаттай зохион байгуулсан бөгөөд бүрэлдэхүүн сургуулиудаас шалгарсан тэргүүний илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд 4 салбарт 51 илтгэлээр 81 оюутан илтгэл хэлэлцүүлэв. Мөн манай төгсөгч тус чуулганыг анхлан санаачлан зохион байгуулагчдын нэг “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаанд “Монгол home dicoration” сэдэвт бүтээлийн уралдааныг тусгайлан зарлаж шилдэг оюутнуудыг шагнаж урамшуулж шилдэг бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр хамтран ажиллав.



Зураг 5.16. Эрдмийн чуулган

Техник, технологийн; Байгалийн ухаан, экологийн; Нийгэм, хүмүүнлэг, дизайны; Эдийн засаг, менежментийн гэсэн 4 салбар зөвлөл хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Тэргүүний шилдэг илтгэл шалгарсан оюутнууд, Шилдэг удирдагч багш нарыг шалгаруулж шагналыг оюутанд кредитийн урамшууллаар багш нарт ажилласан цагаар тооцож олгохоор шийдвэрлэсэн.



Зураг 5.17 “Эрдмийн XX чуулган”-ны хуралдаан  
“Эрдмийн XX чуулган”-ы шилдгүүд

ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН САЛБАР ХУРАЛДААН		
ТЭРГҮҮН БАЙР	ДЭД БАЙР	ГУТГААР БАЙР
ЭЦДС-ийн Мэдээллийн технологийн III курсийн оюутан М.Амарзаяа “Оюутны туслах гар утасны программ хөгжүүлэх судалгаа” сэдвээр, удирдсан багш ЭЦДС-ийн Эрчим хүч, мэдээллийн технологийн багш У.Баттулга	ЭЦДС-ийн Цахилгаан системийн автоматжуулалт III курсийн оюутан Б.Нарангарав, Б.Мөнхжаргал нар “Ардуино ашиглан 1 фазын цахилгаан хөдөлгүүрийн давтамжийн хувиргагчийг хийж туршсан зарим үр дүн” сэдвээр, удирдсан багш ЭЦС-ийн Эрчим хүч, мэдээллийн технологийн багш А.Түвшинжаргал	МХТС-ийн ЭСА-III курсийн оюутан А.Мөнх-Эрдэнэ, Б.Билгүүн, Г.Гантулга нар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан lego роботын хөгжүүлэлт” сэдвээр, удирдсан багш МХТС-ийн ЭС-ын дэд профессор, Доктор (Ph.D), дэд проф Ц.Хүрэлбаатар
БАЙГАЛИЙН УХААН, ЭКОЛОГИЙН САЛБАР ХУРАЛДААН		
ТЭРГҮҮН БАЙР	ДЭД БАЙР	ГУТГААР БАЙР
МХТС-ийн УХ-IV курсийн оюутан Г.Уртнасан, С.Тэмүүлэн нар “Арвайхээр хотод агаарын чанарын хяналтын сүлжээ байгуулах төсөл” сэдвээр, удирдсан багш МХТС-ийн дэд захирал, доктор, дэд проф Н.Эрдэнэхүү	МехТС-ийн Логистикийн менежмент -III курсийн оюутан Б.Хулан “Нийслэлийн хэмжээнд цахилгаан автобус, тэдгээрийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн судалгаа” сэдвээр, удирдсан багш МехТС-ийн Механик, Мехатроникийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) Ц.Баярсайхан, Тээврийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) С.Уянга	ГУУС-Геологи-IV курсийн оюутан Б.Эрдэнэ “Бага-онгон алт агуулсан цул сульфидын ордын геологийн тогтоц, хүдэржилтийн судалгаа” сэдвээр, удирдсан багш ГУУС-ийн ПГ салбарын ахлах багш, доктор (Ph.D) С.Оюунгэрэл



<b>НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГ, ДИЗАЙНЫ САЛБАР ХУРАЛДААН</b>		
<b>ТЭРГҮҮН БАЙР</b>	<b>ДЭД БАЙР</b>	<b>ГУТГААР БАЙР</b>
ҮТС-ийн, ИД-III курсийн оюутан Г.Ариунбулаг, Г.Хүслэн, А.Мөнхмаа, Г.Номин-Эрдэнэ нар <b>“ШУТИС-ийн хичээлийн 2-дугаар байрны ТВ заалны лекцийн танхимын дизайны шийдэл”</b> сэдвээр, удирдсан багш ҮТС-ийн ДС-ын Багш Б.Энхжаргал	ГХС-ийн АХ-III курсийн оюутан Т.Хүслэн <b>“Soft skill” гэдэг үгийг монгол хэлнээ орчуулах нь</b> ” сэдвээр удирдсан багш ГХС-ийн ХХШС-ын ахлах багш, доктор /PhD/ Ц.Мөнхдэлгэр	БАС-ийн Архитектур-V курсийн оюутан Д.Чинзориг <b>“Орон сууцны гаднах хүүхдийн амралт, тоглоомын талбайн орон зайн судалгаа”</b> сэдвээр удирдсан багш БАС-ийн Архитектурын салбарын ахлах багш Д.Өлзийсүрэн
<b>ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ХУРАЛДААН</b>		
<b>ТЭРГҮҮН БАЙР</b>	<b>ДЭД БАЙР</b>	<b>ГУТГААР БАЙР</b>
БуХС-ын Олон улсын бизнесийн менежмент мэргэжлийн III курсийн оюутан О. Даваа-Очир, Л. Нямбадам нар <b>“Боловсролын салбарт дижитал шилжилтийн нөлөө”</b> сэдвээр, удирдсан багш БуХС, БУС, Ахлах багш Г.Цолмон	БуХС-ын Олон улсын бизнесийн менежмент мэргэжлийн III курсийн оюутан Ц.Пүрэвсүрэн <b>“Зайн сургалтын чанарын үнэлгээ”</b> сэдвээр, удирдсан багш БуХС, БУС, Доктор (Ph.D)., дэд профессор Х.Ариунаа	БуХС, (БуХС-ийн Олон улсын бизнесийн менежмент мэргэжлийн IY курсийн оюутан Т.Энхмаа, Ө.Анужин нар <b>“Y болон Z үеийн ажлын үнэт зүйлийн судалгаа”</b> сэдвээр удирдсан багш БуХС, БУС, Доктор (Ph.D)., дэд профессор Х.Ариунаа нар шалгарлаа.


<b>ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШ</b>			
<b>Техник, технологийн салбараас</b> ЭЦДС-ийн Эрчим хүч, мэдээллийн технологийн багш У.Баттулга	<b>Байгалийн ухаан, экологийн салбараас</b> ХШУС-ийн ХИС-ын багш, доктор (Ph.D) Ц.Баяртсайхан	<b>Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбараас</b> ҮТС-ийн Дизайны салбарын багш Б.Энхжаргал	<b>Эдийн засаг, менежментийн салбараас</b> БуХС-ийн Бизнесийн Удирдлагын салбарын Ахлах багш Г.Цолмон

Оролцсон дээрх илтгэлийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний эмхэтгэлийн 21(3)280 дугаарт хэвлэн нийтэллээ.

#### **5.4.4. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаан**

Цар тахлын цаг үед ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган” шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээ 2021 оны 04 дүгээр сарын 30-нд


цахимаар зохион байгуулагдлаа. Энэ жил шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээг Техник технологи, байгалийн ухааны салбарын бүтээл, Дизайны салбар “Монгол home decoration” уралдаанаар зохион байгууллаа.



*Зураг 5.18. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаан*

Уралдаанд нийт 23 бүтээлээр 81 оюутан, 16 багш оролцлоо. Техник, технологи, байгалийн ухааны салбарын бүтээлээс шүүгчдийн үнэлгээгээр дараах бүтээлүүд шалгарсан.

ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ХУРАЛДААН		
ТЭРГҮҮН БАЙР	ДЭД БАЙР	ГУТГААР БАЙР
<p>“Модны нүх ухах экскаваторын шингэнт шахуурга бүхий нэмэлт төхөөрөмжийн зохион бүтээлт” сэдвээр ГУУС-ийн Уул уурхайн машин тоног, төхөөрөмж-IV курсийн оюутан Б. Базарваань, Б. Тасхын нар, <b>Удирдагч багш:</b> Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын багш Г.Энхжаргал</p>	<p>“Амьсгалын аппарат” сэдвээр ЭХС-ийн Био инженерчлэл-III курсийн оюутан Б.Өлзийхишиг, <b>Удирдагч багш:</b> ЭХС-ийн ЦТС-ын дэд профессор, Доктор (Ph.D), дэд проф. Д.Пүрэвдаш</p>	<p>“Бөмбөг шидэгч программын удирдлагатай автомат төхөөрөмж” сэдвээр МехТС-ийн үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн III, IV курсийн оюутан Н.Ирээдүй, Б.Ариунаа нар, <b>Удирдагч багш:</b> Механик, Мехатроникийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) Ц.Баярсайхан</p>





**Зураг 5.19. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаанд оролцсон бүтээлүүд**

**Шилдэг удирдагч багшаар** ЭХС-ийн ЦТС-ын дэд профессор, Доктор (Ph.D), дэд профессор Д.Пүрэвдаш, YTC-ийн Дизайны салбарын багш С.Өлзиймаа нар шалгарлаа. Шилдэг удирдагч багшийн шагналыг ажилласан цагаар дүйцүүлэн тооцож, батламжийн хамт олгов.

Дизайны салбар “Монгол home decoration” уралдааныг “Nomuda Home” ХХК ивээн тэтгэн зохион байгуулж дараах бүтээлүүдийг сонгон шалгаруулав. Бүтээлийн сайжруулалтыг инновацын 7 хоног арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах сургалтаар сайжруулж шалгаруулалтаа хийв. Сургалтад дараах 5 бүтээлийн оюутнууд хамрагдаж бүтээлийн сайжруулалтаа хийж дахин бүтээлүүдийн сайжруулалттай танилцаж дүгнэх арга хэмжээг зохион байгуулсан. Шалгарсан 5 бүтээлийн оюутнуудад Батламж, мөнгөн шагнал олгосон болно.

Дизайны салбар “Монгол home decoration” уралдааны шагналтнууд			
“Мөнхөд оршихуй” бүтээлийн П.Нансалмаа, О.Буянхишиг, Д.Хэрлэн,	“Буган брэнд” бүтээлийн Д.Уранчимэг (График дизайны 3-р	“Галт шувуу” бүтээлийн Д.Лүйжинхорол (График дизайны 3-р курс (D-art	“Монгол гоёл” монгол гэрийн текстил бүтээгдэхүүний иж бүрдлийн

<p>Б.Хонгорзул (Хувцасны дизайны 3 курс) удирдсан багш: П.Болормаа (ҮТС, Дизайны салбарын ахлах багш)</p>	<p>курс (D-art клуб), удирдсан багш: С.Өлзиймаа (ҮТС, Дизайны салбарын багш)</p>	<p>клуб), удирдсан багш: С.Өлзиймаа (ҮТС, Дизайны салбарын багш)</p>	<p>загвар бүтээлийн О.Саруул (Хувцасны дизайны 1 курс), удирдсан багш: Б.Гэрэлмаа (ҮТС)</p>
---	--	--	---



*Зураг 5.20. ШУТИС-ийн оюутны “Эрдмийн ХХ чуулган”-ы шилдэг бүтээлийн уралдаанд оролцсон бүтээлүүд*

**5.4.5. Оюутны Урлагийн бага наадам**

Бүрэлдэхүүн сургуулиудын урлагийн бага наадам 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал үргэлжлэн зохион байгуулагдсан. Урлагийн бага наадам нь дараах 10 төрлөөр шилдгүүдээ шалгаруулав. Оюутны урлагийн бага наадамд бүрэлдэхүүн сургуулиудаас 2000 орчим оюутан оролцов.

- |                  |                        |
|------------------|------------------------|
| 1. Хамтлаг дуу   | 6. Гоц үзүүлбэр        |
| 2. Гоцлол дуу    | 7. Жүжигчилсэн тоглолт |
| 3. Хамтлаг бүжиг | 8. Уран уншлага        |
| 4. Гоцлол бүжиг  | 9. Цэнгээнт бүжиг      |
| 5. Гоцлол хөгжим | 10. Тайзны соёл        |





*Зураг 5.21. ШУТИС-ийн оюутны урлагийн бага наадам*

## 5.5. ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АЖИЛ

### 5.5.1. “Сүүдэр бүү тусга” аян

ЦЕГ-аас эхлүүлсэн “Сүүдэр бүү тусга” аяны хүрээнд, “Лантуун дохио” ТББ-аас эхлүүлсэн ХҮН БАЙ аяны арга хэмжээг дэмжин сургуулийн нийт оюутан залуусын дунд гар зураг, эсээ бичлэгийн уралдаан зарлаж, уралдаанд ирүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, зурагт постеруудыг хэвлүүлж сургуулийн үүд, мэдээллийн самбаруудад байршуулан, цахим орчинд мэдээлэн ажилласан.



*Зураг 5.22. “Сүүдэр бүү тусга” аяны шилдэг оролцогчид*

Гар зураг, эсээ бичлэгийн уралдаанд нийт гар зураг 16, эсээ бичлэг 42 ирүүлснийг хүлээн авч төрөл тус бүрд эхний 3 байр шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.



### ЭСЭЭ БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ

ТЭРГҮҮН БАЙР	ДЭД БАЙР	ГУТГААР БАЙР
БУХС I курсийн оюутан Б.Янжинлхам	БАС I курсийн оюутан А.Билгүүн	БУХС БУ-I курсийн оюутан Б.Сэрчмаа

### ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

ТЭРГҮҮН БАЙР	ДЭД БАЙР	ГУТГААР БАЙР
ҮТС ГД-III курсийн оюутан Т.Цэлмэг	БАС АРХ-IV курсийн оюутан А.Лиона	ҮТС ҮД-I курсийн оюутан Г.Номин

## 5.5.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

Төгсөх курсийн оюутнуудад ажлын байранд тавигдах шаардлага түүнийг ханган биелүүлэхэд чиглэсэн “Ажлын байрны чиг баримжаа олгох” цуврал сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтыг намар, хаврын улиралд цахим хэлбэрээр зохион байгуулав.


- **2020-2021 оны хичээлийн жилийн намрын улиралд:**

Төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх зөөлөн ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн цуврал сургалтыг оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгасан цаг хугацаандаа сургалтын төлөвлөгөөний дагуу БУХС-ийн менежментийн салбарын багш нарын Алтангадас клуб, MSDI proHR консалтинг компанитай хамтран зохион байгуулсан. Тус сургалтыг цахим болон танхимаар хүргэсэн. Цахимаар хүргэхийн тулд “2020-2021 төгсөгч сургалт” групп үүсгэн ажилласан. Тус группэд нийт 1200 гаруй оюутан хамтрагдсан (Сургалтын явцад тогтмол 500-600 оюутан хамрагдаж явсан бол цар тахал хорио цээрийн үед сургуулийн удирдлагаас төгсөх оюутнуудад нэгдсэн мэдээлэл хүргэх зорилгоор төгсөх оюутнуудаа автоматаар хүсэлт



- **2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улиралд:**

Төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх зөөлөн ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн цуврал сургалтыг хүргэхийн тулд “ШУТИС 2020-2021 хавар төгсөгч сургалт” группийг үүсгэн төгсөх оюутнуудаа бүрэн хамруулахаар ажилласан. Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн багш нар болон консалтинг компанитай хамтран боловсруулсан. Энэ ажлын хүрээнд нийт 10 удаагийн цахим сургалт явагдсан.



*Зураг 5.25. 2020-2021 оны намрын улиралд төгсөх оюутнуудын групп*

Сургалтад нийт 611 оюутан хамрагдсан. Эдгээр оюутнуудаас 159 оюутан сургалтын шаардлага ханган батламж авах болзол хангасан. Батламжийг дипломыг хамт монгол шуудангаар хүргүүллээ.

“ШУТИС 2020-2021 хавар төгсөгч сургалт” группэд сургалт дууссанаас хойш бүх төгсөгчийг нэмж нийт 1400 гаруй оюутантай болсон ба энд төгсөлтэй холбоотой мэдээлэл оруулж, ажлын байрны талаарх мэдээлэл, төгсөгчдөөс авах судалгаа зэргийг авч СБЗГ-тай хамтран ажиллаж байна.

### **5.5.3. Төгсөгч оюутныг мөшгөх судалгаа**

БШУЯ-ны гаргасан ДБ мэдээний загварт тохируулж зарим өөрчлөлтийг оруулж нэгтгэлийг шинэчлэн өөрчлөв. Дээд боловсролын сургалтын өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь жил бүрийн 2 сарын 25, 7 сарын 25-ны дотор мэдээллийг ДБУМС-д оруулахаар ДБ35, ДБ36 статистик мэдээ, тайланг гаргав.




**Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн статистик мэдээ**

*Хүснэгт 5.11*

Д.Д	Сургууль	2019 оны 06 сар	2020 оны 01 сар	Нийт
1	БАС	140	131	271
2	БуХС	108	96	204
3	ГХС	8	4	12
4	ГУУС	100	57	157
5	МехТС	177	43	220
6	МХТС	117	82	199
7	ҮТС	178	52	230
8	ХШУС	40	14	54
9	ЭХС	190	170	360
	<b>ДҮН</b>	<b>1058</b>	<b>649</b>	<b>1707</b>


Хурлын танхимд хурал зөвлөгөөн, лекц семинар, урлагийн тоглолт, сургалт гэх мэт 17 удаагийн 151 цагийн арга хэмжээ зохион байгуулагдсан.



*Зураг 5.26. Зохиогдсон арга хэмжээ*




## 5.7.ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ



**Зураг 5.27. 2020-2021 оны хичээлийн жилийн 09, 10, 11 сарын үзлэгийн мэдээ**

*/ЭМТ, БуХС, МехТС, МХТС/*

Зураг 5.27-оос 10 сард цаг агаар хүйтэрч амьсгалын замын өвчлөл ихэссэнтэй холбоотой ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвийн үйлчлүүлэгчдийн тоо ихсэж ачаалал нэмэгдэж байгаа нь харагдаж байна.



**Зураг 5.28. Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн үзлэгт хамрагдалт**



ШУТИС-ийн эрүүл мэндийн төвд анхан удаа үзлэгт хамрагдсан хүмүүсийн дунд өвчлөл их байгаа нь улирлын өвчлөлтэй холбоотой байна. Давтан үзлэг нь 2,3-р шатлалын нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, эмчилгээ бичүүлсэн оюутан, багш ажилчдын эмчилгээг хийж гүйцэтгэсэн байна. Урьдчилан сэргийлэлт нь вирусийн вакцинжуулалтад хамруулсан байна (зураг 5.28).

### 5.7.1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүснэгт 5.12

д/д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	Үр дүн
1	Томуугийн эсрэг вакцин	08 сарын 26-наас 10 сарын 01 хүртэл	ОМД 3-р байр	БуХС-ийн их эмч Б.Энхтуяа, Азифарм, Жи Ди Би ХХК	200	Азифарм, Жи Ди Би ХХК-тай гэрээний дагуу ШУТИС-ийн 200 багш, ажилтанд томуугийн эсрэг вакцин хамруулсан.
2	Багш ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	09 дүгээр сар	СБДЭМТ	СБДЭМТ	26	СБДЭМТ-ийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвд хамтын гэрээний дагуу ШУТАС-ийн 26 багш, ажилтныг үзлэгт хамруулсан.
3	Сахуу татрангийн эсрэг вакцин	09 дүгээр сарын 09, 12-нд	ОМД 5-р байр	МехТС-ийн их эмч Д.Отгонхишиг, Энх титэм ӨЭМТ	15	Дархлаажуулалтын товлолын дагуу МСҮТ-ийн 15 сурагчийг Сахуу татрангийн эсрэг вакцин хамруулсан
4	В, С вирус тодорхойлох	09 дугаар сарын 26	ОМД 3-р байр	БуХС-ийн их эмч Б.Энхтуяа, Элэг бүтэн монгол хөтөлбөр	56	Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд 56 оюутан хамрагдсанаас В вирус тэй 3, С вирус тэй 1 хүн



						илэрсэн.
5	2020-2021 оны хичээлийн жилийн намрын II-р ээлжийн эмэгтэй спорт явган аяллын хичээл	10 дугаар сарын 11-нд	Буянт ухаа спорт ордноос Жаргал антын ам	ХШУС БТСТ	380	Үүнээс 10 эрэгтэй оюутанд анхны тусламж үзүүлж ажилласан.
6	Оюутны 3-р байрны урьдчилан сэргийлэх үзлэг	10 сард	ОМД 3-р байр	БуХС-ийн их эмч Б.Энхтуяа, ЭМТ-ийн сувилагч Ч.Доржпалам	296	Нийт 296 оюутан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсанаас ЗСӨ 11, ЧХХӨ 22, ҮХӨ 8, ХБЗЭ 22, АХӨ 155, БШДЗӨ 4, АЗӨ 15, ЦБ 6, МТӨ 5 тус тус оношлогдож, ХДХВ, Тэмбүүгийн сорилд сөрөг гарсан.
7	Оюутны 4-р байрны урьдчилан сэргийлэх үзлэг	10 сард	ОМД 4-р байр	МХТС-ийн их эмч Мөнхзаяа, Б.Сугирдорж	175	Нийт 175 оюутан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан бөгөөд ХДХВ/Тэмбүүгийн шинжилгээнд сөрөг гарсан
8	Оюутны 5-р байрны урьдчилан сэргийлэх үзлэг	10 сард	ОМД 5-р байр	МХТС-ийн их эмч Д.Отгонхишиг	112	Нийт 112 оюутан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан бөгөөд ХДХВ/Тэмбүүгийн шинжилгээнд сөрөг гарсан
9	МСҮТ-ийн 1-2-р курсийн оюутан	11 дүгээр сарын 7-нд	ОМД 5-р байр	МехТС-ийн их эмч Д.Отгонхишиг	615	ХУДЭМТ-ийн өсвөрийн эмч, сурьээгийн эмч, ДОХ/ХДХВ





	сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулав					нийгмийн ажилтан, эмэгтэйчүүдийн эмч нарын үзлэгээр МСҮТ-ийн 1-2-р ангийн сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулж, 48 сурагчдад жирэмсний түргэвчилсэн сорил тавьсан.
10	КОВИД-19 PCR шинжилгээг зохион байгуулах	10 дугаар сарын 08, 11 сарын 09-нд	ЭМТ алжаал тайлах өрөө, тарианы өрөө	ИТДБ-ийн багш нар, ЭМТ, ХӨСҮТ	50	ИТДБ-ийн төслийн хүрээнд Япон улс руу явах 50 оюутанг” КОВИД-19” PCR шинжилгээнд 2 удаагийн сорьцоор сөрөг гарсан.
11	АШУҮИС-ийн эмнэлзүйн кохорт судалгаанд хамрагдсан	11 дүгээр сарын 04-нд	ОМД 4-р байр	МХТС-ийн их Б.Сугирдорж АШУҮИС	175	ОМД-ын 175 оюутанд Эрүү нүүрний гажиг, нойрны эмгэгийн үзлэг, оношилгоо хийж зөвлөгөө өгч ажилласан.
12	Багш ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	10, 11 сар	УХТЭ	ЗАА, УХТЭ, БУХС	151	БУХС-ийн 151, МехТС-ийн 138, ГУУС-ийн 125 багш, ажилтан УХТЭ-ийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвд зохион байгуулсан
14	Оюутны байрны КОВИД 19 шинжилгээ	12 сарын 07-нд	ОМД 1,3,4,5-р байр	ЭМЯ, БСШУЯ, ШУТИС	839 оюутан, 22 ажилтан	Түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан оюутан, ажилчдын КОВИД 19 хариу сөрөг гарсан.
15	КОВИД 19 Дархлаажуулалт	03, 04 сар	3-р сургууль	СБД ЭМТ ШУТИС ЭМТ	759	ШУТИС-ийн эрүүл мэндийн төвийн ажилчид бүртгэл дээр ажилласан.



						Вероцелл вакцины 1-р тунд хамрагдсан
16	Ковид-19 дархлаажуу лалт	04 дүгээр сарын 07	Фамил а медикл ” клиник		БАТС- 11, БуХС-68	Вероцелл вакцины 1-р тунд хамрагдсан
17	Эсрэг биетийн шинжилгээ	04 дүгээр сарын 17,18	ШУТИ С ЭМТ	ШУТИС Захиргаа	551	КОВИД 19-ын 2 тун вакцинд хамрагдаад 14 болон түүнээс дээш хоносон ШУТИС-ийн багш, ажилчдыг эсрэг биетийн шинжилгээнд хамруулж ажилласан





Зураг 5.29. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

## 5.7.2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүснэгт 5.13

д/д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамраг дсан хүний тоо	Үр дүн
1	Хичээл эхлэхтэй холбогдуулан хичээлийн байруудын ариун цэвэр бэлэн байдлыг хангах	09 сарын 16	Хичээлийн 1,2,3, 4, 8-р байр	ШУТИС ЗАА, ЭМТ, СБЗА		ШУТИС-ийн хэмжээнд шинэ короно вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу хяналт тавин зохих журмын дагуу заавар зөвлөгөөг өгч ажилласан



2	Тусгаарлах өрөө тохижуулалт бэлэн болгох	09 сарын 25-аас 10 сарын 07-нд	Хичээлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8-р байр	ШУТИС ЗАА, ЭМТ		КОВИД-19 цартахлын үед бэлэн байдлыг хангаж хичээлийн байр тус бүрд орох гарах хэсэгтэй ойр тусгаарлах өрөөг тохижуулан халдваргүйтгэл хийж, иж бүрдлүүдийг байрлуулан ажилласан.
3	Боловсролын цахим шилжилт арга хэмжээ	10 дугаар сарын 02-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БШУЯ	180	Тухайн өдөрлөгт оролцсон бүх хүмүүсийн биеийн температурыг үзэж, гар халдваргүйтгэлд хяналт тавин оролцсон.
4	Фармавишин ХХК-ийн Эмийн сургалт	10 дугаар сарын 20-нд		Фармавишин ХХК		ЭМТ-ийн сувилагч Б.Эрдэнэчимэг, Ч.Доржпалам нар хамрагдсан.
5	“Тамхины хор уршиг, Тамхины агуулж, тамхи эрүүл мэндэд нөлөө, тамхинаас гарах арга” сургалтыг зохион байгуулсан	10 сард	БАС	Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг, ЭМТ	240	“Тамхинд амьсгалах агаараа бүү алд” аяны хүрээнд БАС-ийн нийт 240 оюутанд “Тамхины хор уршиг, эрүүл мэндийн нөлөө, тамхинаас гарах арга” сургалт орсон.
6	“Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мэдлэг	10 дугаар сарын 20	Япон монголын төв	Хууль зүй, дотоод хэргийн яам	25	“Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мэдлэг



	олгох сургалт					олгох сургалтад хамрагдсан.
7	Нэн түрүүнд ХАБ-2020 бага хурал	11 дүгээр сарын 05, 06-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	WOSHPA, ШУТИС	23	Тухайн өдөрлөгт оролцсон бүх хүмүүсийн биеийн температурыг үзэж, гар халдваргүйтгэлд хяналт тавин оролцсон.
8	ШУТИС-ийн “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй, анхаарах асуудал” сэдэвт сургалт	11 сарын 06-нд	Номын сангийн 401	ШУТИС Захиргаа		ШУТИС-ийн “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй, анхаарах асуудал” сэдэвт сургалтад хамрагдсан.
9	“Тамхины хор нөлөөлөл”	11 дүгээр сарын 7-нд	ОМД 5-р байр	МехТС-ийн их эмч Д.Отгоншиг	150	ХУДЭМТ-ийн өсвөрийн эмч “Тамхины хор нөлөөлөл” сэдвээр сургалтыг МСҮТ-ийн 2,3-р ангийн сурагчдад явуулсан.
10	Элсэлтийн ерөнхий шалгалт хэвлэлийн бага хурал	01 дүгээр сарын 13-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа		Арга хэмжээнд оролцсон хүмүүсийн биеийн хэм үзэж, QR код уншуулан нэвтрүүлж, Хичээлийн 8-р байранд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.
11	БСШУЯ-ы боловсролын үнэлгээний хурал	03 дугаар сарын 24-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа	18	Арга хэмжээнд оролцсон хүмүүсийн биеийн хэм үзэж, QR код уншуулан нэвтрүүлж, Хичээлийн 8-р байранд



						ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.
12	БуХС-ийн хичээлийн анги танхимд ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэн	03 дугаар сарын 25-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа		Халдваргүйжүүлэлт хийлгэсэн.
13	УУГТ-ын мэргэжилтнүүдийн чадамжийг дээшлүүлэх хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагаа	04 дүгээр сарын 01-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа	34	Арга хэмжээнд оролцсон хүмүүсийн биеийн хэм үзэж, QR код уншуулан нэвтрүүлж, Хичээлийн 8-р байранд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.
14	Хувьсах зардал болон сургалтын төлбөрийн агуулгаар мэдээлэл	04 дүгээр сарын 02-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа	50	Халдваргүйжүүлэлт хийлгэсэн.
15	“Ахуйн бохир усыг 97% цэвэрлэх ХБНГУ-ын WSB технологи арга хэмжээ	04 дүгээр сарын 07-нд	Хичээлийн 8-р байр	ЭМТ	20	Арга хэмжээнд оролцсон хүмүүсийн биеийн хэм үзэж, QR код уншуулан нэвтрүүлж, Хичээлийн 8-р байранд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан
16	Ариутгал, халдваргүйтгэл хийгдсэн	05 дугаар сарын 19-нд	ШУТИС-ийн хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	МехТС-ийн их эмч Д.Отгоншиг		Мананцар, автомаксаар ариутгал халдваргүйтгэл хийсэн.

17	2021 оны ЭЕШ тухай хэвлэлийн бага хурал	05 дугаар сарын 13-нд	Хичээлийн 8-р байр 12 давхарт	БСШУЯ, ШУТИС захиргаа	31	Халдваргүйжүүлэлт хийлгэсэн.
----	---	-----------------------	-------------------------------	-----------------------	----	------------------------------



*Зураг 5.30. Эсрэг биетийн шинжилгээ*



*Зураг 5.31. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ*



### **5.7.3. КОВИД-19 КОРОНА ВИРУСИЙН ХАЛДВАРТ ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХЯНАЛТ ТАНДАЛТ**

Дэлхий дахинд Ковид-19 халдвар дэгдсэнтэй холбоотой ШУТИС-ийн Захиргаа, Эрүүл мэнд, спортын төвөөс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн билээ. Үүнд:

- Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас өгсөн чиг үүргийн дагуу хичээлийн байр, дотуур байруудад анхааруулах хуудас, зөвлөмж тарааж байршуулсан.
- Хичээлийн байр, дотуур байруудын ОО-ийн өрөөнд гар халдваргүйтгэл, гадаргуу халдваргүйжүүлэх уусмал байршуулсан.
- Үйлчилгээний ажилчдад халдваргүйжүүлэх уусмалыг хэрэглэх зааврын талаар сургалт орсон
- Цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж ажилласан
- Хичээлийн 2,3, номын сангийн хаалга хааж зөвхөн 1-р байрны хаалгаар халуун хэмжүүлж, тандалт судалгааны тэмдэглэл хөтлүүлж, маск зүүн, гар халдваргүйжүүлэн оруулж байв.
- Монгол улсад анхны тохиолдол бүртгэгдэхэд хичээлийн 2,3-р байрыг “Улаанбаатар ариутгал”, “Ууган хангай” ХХК компаниар халдваргүйжүүлж ажилласан
- Цаашид хөл хорионы дэглэмийн үед хичээлийн байр, дотуур байруудад тодорхой давтамжийн дагуу халдваргүйтгэлийг тогтмол хийж ажилласан.
- ШУТИС-ийн багш, ажилчдыг КОВИД-19 вакцинжуулалтын 1-р тунд нэгдсэн зохион байгуулалтаар хамруулсан
- КОВИД-19 вакцинжуулалтад хамрагдаад 14 ба түүнээс дээш хоносон багш, ажилчид Sars-covid эсрэг биетийн шинжилгээнд хамруулсан.
- Халдварын тохиолдлыг бүртгэж, хавьтлуудыг эрт илрүүлж, гэрийн тусгаарлалт ажиглалт дараагийн шатны заавар зөвлөгөөг өгч ажилласан





*Зураг 5.32. Дотуур байрны оюутнуудын КОВИД-19 шинжлгээ*



*Зураг 5.33. Хичээлийн байр, оюутны байруудад халдваргүйтгэл, ариутгал хийж байгаа байдал*

**5.7.4. Орчны эрүүл ахуй ариутгал, халдваргүйжүүлэлт**

Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, НМХГ-ын заавар, зөвлөмжийн дагуу Klocept бодисыг зааврын дагуу найруулж ШУТИС-ийн хичээлийн байр болон дотуур байруудад тодорхой давтамжтай хийж гүйцэтгэсэн

**ЭМТ-ийн ажилчдын хичээлийн байруудад ариутгал,  
халдваргүйтгэл хийсэн тоон мэдээлэл**

*Хүснэгт 5.14*

Д/д	Хичээлийн байр	01 сар	02 сар	03 сар	04 сар	05 сар	06 сар	НИЙТ
1	1-р байр	15	11	22	7	15	11	81
2	2-р байр	15	11	22	7	15	11	81
3	Т байр	15	11	22	7	15	11	81
4	Номын сан	15	11	22	7	15	11	81
5	4-р байр	1	1	1	1	3	0	7
6	БуХС	15	11	22	7	15	11	81
7	8-р байр	15	11	22	7	15	11	81
8	11-р байр	1	1	1	1	1	1	6
9	МТС	15	15	22	7	15	11	81
10	МХТС	15	15	22	7	15	11	81
11	ОМД 1-р байр	1	2	0	0	0	0	3
12	ОМД 3-р байр	3	5	1	1	1	1	12
13	ОМД 4-р байр	2	3	1	1	1	1	9
14	ОМД 5-р байр	2	3	1	1	1	1	9

ШУТИС-ийн хичээлийн 2,4,8-р байруудад КОВИД-19 халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой Улаанбаатар ариутгал ХХК-аар ариутгал халдваргүйтгэл хийлгэж ажилласан.



# ЗУРГААДУГААР БҮЛЭГ

---

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



## ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### 6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН

ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн номын сан нь 2020-2021 оны хичээлийн жилд нээлттэй нөөц материалын сангийн бүрдүүлэлт, цахим үйлчилгээг уншигчдад хүргэх, олон улсын мэдээллийн санг таниулан сурталчлах, уншигчдад цахим үйлчилгээг чанартай хүргэх, номын санч үйлчилгээний ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран ажиллалаа.

Дэлхий нийтээр COVID-19 цаг тахал гарсантай холбогдуулан сургалтын үйл ажиллагаа цахимаар үргэлжлэн явагдсан тул ШУТИС нь СБЗГ-тай хамтран нийт оюутан суралцагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан шаардлагатай цахим ном, сурах бичиг, гарын авлагын хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулахад анхаарч ажиллалаа.

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийг тус тус үндэслэн шаардлагатай мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг ШУТИС-ийн электрон каталогид веб хувилбараар оруулж суралцагчдад онлайнаар судлах боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Веб хувилбартай материалыг зөвхөн ШУТИС-ийн уншигч /нийт профессор багш, ажилтан, ажилчид, оюутнууд/ өөрийн нэвтрэх эрхээр үзэх боломжтой ба гадны уншигчид хаалттай, хамгаалалттай хийгдсэн. Энэ нь номын сангаас ном авч уншдагтай адил үйлчилгээг гэрээсээ авч байна гэсэн үг юм.

2020-2021 оны хичээлийн жилд аудит, санхүүгийн бичиг баримтын шалгалтад баримт бүрдүүлэх, тайлан мэдээ, бичиг хэрэг хөтлөлт, номын тооллого, номын сангийн уншлагын танхимуудын ачаалал, оюутны тоог үндэслэн уншлагын танхимуудын байршлыг сольж, давхар хооронд нүүлгэх ажлуудыг хийлээ. Номын сангийн нэг цэгийн үйлчилгээгээр профессор багш нарын ном сурах бичиг, хүрээлэнгүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гэрээний дагуу хэрэглэгчдэд хүргэж байна.

Тус хичээлийн жилд номын сангийн хурлын танхимд халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан захиргаа, бүрэлдэхүүн сургуулиас зохион байгуулсан 60 орчим оролцогчийг хамарсан (давхардсан тоогоор) 5 удаагийн хурал, албан уулзалт, докторын зэргийн хамгаалалтыг зохион байгуулсан байна.




Номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулж, докторантурт 2, СУИС-д 2 номын санч Номын санч-мэдээллийн ажилтан мэргэжлээр элсэн орж, 1 номын санч магистрын сургалтад хамрагдан зэргээ амжилттай хамгааллаа.


## 6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Төв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БуХС, БАТС, МХТС, МехТС, ДаТС, ОрТС/ номын сангаас бүрдсэн 7 салбар номын сан цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан танхимын болон цахим үйлчилгээг хүргэж ажиллалаа. Уншлагын танхимаар болон гэрээр ном олгох фондоор давхардсан тоогоор 13,118 уншигчид 50,011 ном, сурах бичгийг олгож үйлчилсэн байна. Цахим ном, сурах бичиг болон судалгааны сангаас давтагдсан тоогоор 22,100 уншигч 73,448 цахим ном, судалгааны ажлыг цахимаар үзэж, үйлчлүүлсэн байна.


Электрон каталогид гадны уншигч 42,311 удаа, ШУТИС-ийн профессор багш, оюутан, судлаачид 114,101 удаа хандаж, нийт 324,892 удаа хайлтын хийгдсэн байна.



**Зураг 6.1. ШУТИС-ийн электрон каталогийн хайлтын үр дүн**



**Зураг 6.2. ШУТИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн үйлчилгээний статистик үзүүлэлт**



**Зураг 6.3. Цахим ном, сурах бичиг, судалгааны сангийн үйлчилгээний статистик үзүүлэлт.**

**а-вэб материалын хэрэглээний харьцуулсан судалгаа /2019-2021/, б-вэб материалын хэрэглээ /Төрлөөр/**

\*-Статистик мэдээллийг номын сангийн үйлчилгээний "Lib4u" программаас гаргасан болно

Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 39 нэр төрлийн гадаад сэтгүүл, 15 нэр төрлийн монгол хэвлэл захиалан уншигчдын хүртээл болгож байна.




Ном сэргээн засварлах, хувилах үйлчилгээгээр эргэлтэд их гарсан 90 гаруй ном, сурах бичгийг сэргээн засварлаж үйлчилгээнд гаргаж, багш нарын захиалгын дагуу зохиогчийн эрх нь шийдвэрлэгдсэн 38 ном, сурах бичгийг хувиалан олшруулах үйлчилгээ үзүүлээ.

**Фонд бүрдүүлэлт:** ШУТНС-ийн фонд бүрдүүлэлт нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн хийгддэг. Тус журмын дагуу бүрэлдэхүүн сургуулиуд 2020 онд профессор багш нарын сурах бичиг, гарын авлага болон техник технологийн сургалт, судалгааны номыг 112 сая гаруй, 2021 оны эхний хагас жилд 46 сая гаруй төгрөгөөр тус тус худалдан авч, уншигчдын хүртээл болгож байна.

**ШУТНС-ийн номын фонд бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт  
/Сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгаа/**

*Хүснэгт 6.1*

№	Номын сан	2019 он			2020 он			2021 оны эхний хагас жил		
		Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	ШУТТөв номын сан	185	3,670	82,938,480	246	3291	2,610,922	73	1428	35,108,715
2	БУХС номын сан	46	453	9,697,586	40	215	7,590,271	15	56	3,358,700
3	БАТС-ийн номын сан				11	60	1,705,000	3	58	1,775,000
4	МехТС номын сан	72	1,594	17,445,000	19	358	6,563,500	3	60	1,400,000
5	МХТС номын сан	18	289	5,612,200	781	868	10,985,440	6	79	2,267,000
6	ДаТС номын сан	129	352	4,754,200	26	220	4,400,000	2	40	467,000
7	ОрТС номын сан	73	1,546	29,693,300	32	445	8,996,200	1	20	2,000,000
<b>НИЙТ :</b>		<b>523</b>	<b>7,904</b>	<b>150,140,766</b>	<b>1155</b>	<b>5457</b>	<b>112,851,333</b>	<b>103</b>	<b>1,741</b>	<b>46,376,415</b>



Зураг. 6.3. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа

### 6.3. САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан тус хичээлийн жилд цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нээлттэй нөөц материалын санг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа. COVID-19 цаг тахал гарсантай холбогдуулан МУ-ын засгийн газар, ШУТИС-ийн захиргаанаас гаргасан шийдвэрийн дагуу энэ хичээлийн жилд төлбөртэй олон улсын мэдээллийн сангийн эрх авч чадаагүй боловч үнэгүй ашиглах боломжтой мэдээллийн сангуудын тоог нэмэгдүүлж уншигчдад сурталчлан, таниулж, мэдээлэл хүргэж ажиллалаа.

**Цахим сан хөмрөгийн баяжилт:** Цахим санг нэмэгдүүлэх үүднээс судалгааны ажил /магистр, докторын бүтээл/, эрдэм шинжилгээний бичиг, уншигчдын хэрэгцээ шаардлага, хүсэлтийн дагуу мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагын зохиогчийн зөвшөөрлийг авч тухай бүрд нь PDF хэлбэрт хөрвүүлж ШУТИС-ийн электрон каталогид оруулж веб сайт, цахим хуудсаараа дамжуулан уншигчдад мэдээлэл хүргэж, таниулан сурталчиллаа.

ШУТИС номын сангийн Lib4u программ хангамжийг үйлчилгээнд ашиглаж нэгдсэн каталогтой болсон нь цахим сургалтын үед давуу талтай байгаа бөгөөд уншигчид нь каталогид орсон веб хувилбартай номыг бүрэн эхээр нь бүх төрлийн төхөөрөмж /компьютер, гар утас, таблет г.м/ ашиглан унших, гэрээр авсан ном, материалын хугацааг онлайнгаар сунгуулах хүсэлт явуулах, мэдээлэл авах зэргээр цахим үйлчилгээг тогтмол авч байв.

**Мэдээллийн сангуудыг ашигласан байдал:** Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном, сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн олон улсын мэдээллийн сангийн эрхийг жил





бүр авч ашигладаг байсан боловч энэ хичээлийн жилд зөвхөн үнэгүй мэдээллийн сангуудыг ашигласан байна. Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалт, статистик, татгалзлын судалгааг тогтмол гарган үр дүнгээс хамаарч цаашид ямар төрлийн мэдээллийн сан эрэлт хэрэгцээтэй байгаад дүгнэлт хийж, тухайн салбарын мэдээллийн сангийн эрх авах, е-номын захиалгад тусган ажиллаж байна.

Дэлхий нийтээр цахим сургалт явуулж байгаатай холбогдуулан EBSCO-оос ШУТИС-ийн уншигчдад зориулан тусгай <http://ebSCO.cc/musteBook> линк гарган шинжлэх ухааны бүхий л салбарын 210000 орчим цахим ном бүхий мэдээллийн санг 2021 оны 6 дугаар сарын 30-ыг хүртэл үнэ төлбөргүйгээр үзэх боломжийг олгосон нь судлаачдад маш их эрэлттэй, хандалт ихтэй байлаа. Мөн дараах сангуудыг онлайн үйлчилгээндээ ашиглалаа. Үүнд:

- DOAJ - Directory of Open Access journals нь дэлхийн 82 орчим хэлээр 15631 орчим эрдэм шинжилгээний сэтгүүлээс 5,523,239 орчим эрдэм шинжилгээний бүтээлүүдийг онлайннар, үнэ төлбөргүй үзэх боломжтой. Тус платформд Монгол улсаас 4-н эрдэм шинжилгээний сэтгүүл одоогоор бүртгэлтэй байдаг.
- DOAB - Directory of Open Access Books нь дэлхийн 408 эрдэм шинжилгээний салбарын хэвлэлийн газрын 33,731 орчим номыг онлайннар, үнэ төлбөргүй орж үзэх, татаж үзэх боломжтой. Тус платформд Монгол улстай холбоотой 18 ном одоогоор бүртгэлтэй байдаг.
- Theses - Тус платформд 40,175 гаруй эрдмийн зэрэг хамгаалсан дипломыг онлайннар үнэ төлбөргүй орж үзэх, татаж авах боломжтой.
- Springer Nature - TopResearch2020 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ашигласан. Тус сангаас шинжлэх ухааны 60 орчим салбараар 2020 оны шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, номыг үнэгүй үзүүллээ.
- Dimensions – Open access filter ашиглан 30 гаруй сая мэдээллээс хайлт хийж, үзэх боломжтой.
- Hindawi - Үнэгүй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг үзэх боломжтой.

Онлайннар шинэ хэрэглэгчийн бүртгэл болон нууц үг сэргээх үйлчилгээ, заавар, зөвлөмж, мэдээллийг тогтмол өгч ажиллав. Мөн веб сайт, нийгмийн сүлжээний хэрэгслээр электрон каталог, мэдээллийн санг хэрхэн ашиглах зөвлөмж, шинээр нэмэгдсэн веб хувилбартай е-Ном, ашиглах боломжтой мэдээллийн сангуудын мэдээллийг тухай бүрд нь мэдээлэл бэлтгэн хүргэв.

### Соёлын хөтөлбөрт ажлууд:

2020-2021 оны хичээлийн жилийг тохиолдуулан уламжлал ёсоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2020 оны 9 дүгээр сарын 21-ээс 10 дугаар сарын 16-ныг хүртэл уншлагын танхимуудад зохион байгуулж, элсэгчдэд зориулсан танилцуулга сургалт, ерөнхий эрдмийн болон мэргэжлийн номын үзэсгэлэн, шинэ ном, цахим ном, сэтгүүлийн үзэсгэлэнг гаргалаа.



*Зураг 6.4. ШУТИС-ийн “Нээлттэй хаалганы өдөр” үзэсгэлэн.*

Жил бүр “Монголын соёл, урлагийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан Монголын номын сангуудын консорциумаас зохион байгуулсан “Library update-2020” хэлэлцүүлэг-хуралд ШУТИС-ийн мэргэжилтнүүд, номын санчид оролцож, санал солилцлоо. Тус хэлэлцүүлгийн үеэр оролцогч номын сангууд өөр өөрийн онцлогийг харуулсан үзэсгэлэнг гаргасан ба ШУТИС-ийн Үндсэн сурах бичгүүдээр үзэсгэлэн гаргаж, сурталчлав.



*Зураг 6.4. ШУТИС-ийн Үндсэн сурах бичгийн үзэсгэлэн*



Тус хичээлийн жилд ШУТТНС-ийн мэргэжилтнүүд Монголын номын сангуудын дунд зохион байгуулагдсан "Цахим номын сангийн үйлчилгээ" сэдэвт онлайн хэлэлцүүлэгт оролцож “ШУТИС-ийн номын сан цахим сургалтын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, уншигчдад үзүүлж буй онлайн үйлчилгээ”-ний талаар мэдээлэл хийж, туршлага солилцлоо. Мөн 2021 оны 6 дугаар сарын 2-ны өдөр EBSCO-оос зохион байгуулсан онлайн сургалтад идэвхтэй оролцлоо.





## ДОЛООДУГААР БҮЛЭГ

---

ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ




## ДОЛОО.ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МАРКЕТИНГ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 7.1.ШУТИС-ИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Тайлант хугацаанд ШУТИС-ийн захирлын 2021 оны 04 сарын 07-ны өдрийн Б/87 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургуулиудад чанарын менежерүүд томилогдсон. Шинээр томилогдсон чанарын менежерүүд нь Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албаны үйл ажиллагааг дэмжиж, бүрэлдэхүүн сургуулиудад хүрч ажиллахад том хөшүүрэг болж байна.

Ингэснээр ШУТИС-д чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтэц нь дараах байдлаар өөрчлөгдөж байна. Үүнд:



*Зураг 7.1. ШУТИС-д чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтэц*

#### Чанарын менежерийн үндсэн чиг үүрэг:


- ШУТИС-ийн чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид дэмжин туслал
- Сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээ судалгааны ажлын дотоод чанарын баталгаажуулалтыг хангах, хянах, дүн шинжилгээ хийх
- Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл явцыг бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд зохион байгуулж, манлайлах

- Сонирхогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, холбогдох мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцэх ажлыг зохион байгуулах
- Их сургуулийн нэр хүндийг өсгөх нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх, нийтэд түгээх
- Бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхимийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянах, үнэлэх, түүнийг сайжруулахад шаардлагатай ажлыг зохион байгуулах

### 7.1.1. ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 -ын хэрэгжүүлэлт

2020-2021 оны хичээлийн жилд Монгол улсад тархсан цар тахал Ковид-19 өвчний улмаас их сургуулийн хэмжээнд чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитыг ажлын байран дээр явуулах ажлыг хойшлуулсан.

Чанарын менежментийн тогтолцоо болон “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан ШУТИС-ийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг шинэчлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 28 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Шинэчлэлийн ажлыг дараах 6 үе шаттай байхаар төлөвлөн, зохион байгуулсан ба одоогоор ихэнх өөрчлөхөөр төлөвлөсөн дүрэм, журмууд 2,3-р үе шатанд явж байна.



**Зураг 7.2. ШУТИС-ийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг шинэчлэх ажлын дараалал**



Тус ажлын хүрээнд баримт бичгийн өөрчлөлт, шинэчлэлийг төлөвлөж, боловсруулалтад хяналт тавьж ажиллаж байна. Баримт бичгүүдийг шинэчлэхэд “ШУТИС-ийн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журам”-ын дагуу нэгдсэн загварт оруулж, үйл явцуудыг уялдуулах байдлаар ажилласан.

[https://www.must.edu.mn/mn/barimt\\_bichig\\_juram/](https://www.must.edu.mn/mn/barimt_bichig_juram/)

Үүнд:

- Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг зохицуулах чиглэлд:
  1. Авьяасыг дэмжих хөтөлбөр – *Батлагдсан*
  2. Авьяастныг дэмжих түр журам – *Батлагдсан*
  3. Эрдэм шинжилгээ, инновацын талаар баримтлах бодлого - *Батлагдсан*
  4. ШУТИС-ийн эрдмийн ба хүндэт цол олгох журам – *Батлагдсан*
  5. ШУТИС-д төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам
- Сургалт, оюутны үйл ажиллагааг зохицуулах чиглэлд:
  1. Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
  2. Ахисан түвшний сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
  3. Карьер хөгжлийн хөтөлбөр
  4. Суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам
- Захиргаа, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлд:
  1. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам
  2. ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм
  3. Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам
  4. ШУТИС-ийн Оюутны байрны журам
  5. Горхи дахь дадлагын полигоны үйл ажиллагааг зохицуулах журам

Шинэчлэн боловсруулж буй баримт бичгийг эцэслэж, албажуулахад тухайн үйл ажиллагааг хариуцсан нэгж буюу үйл явцыг хариуцагчийн оролцоо чухал байдаг. Иймд баримт бичгийн шинэчлэлийн ажил нь зарим ажил хариуцсан нэгжүүдийн гүйцэтгэлээс шалтгаалан удааширч байна.






### 7.1.2. ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааны гүйцэтгэл, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээ

ШУТИС-ийн салбар, тэнхимийн 2017-2020 оны 3 хичээлийн жилийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэлийн мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, үнэлэн цаашдын өөрчлөлт, сайжруулалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор шинжилгээ, үнэлгээг хийсэн. Тус ажлын хүрээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын 43 салбар, тэнхимийг хамруулан ажлын хэсэг байгуулан ажилласан ба дараах зорилтуудыг тавьж, арга хэмжээг авсан. Үүнд:

- Хариуцсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, хөгжүүлэлт
- Эрдэм шинжилгээ, инновацын ажлын амжилт
- Салбар, тэнхимийн хүний нөөцийн чадамж, ачаалал
- Суралцагчийг дэмжиж, хамтран ажиллах байдал
- Хамтын ажиллагаа, нийгэмд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа
- Санхүү, хөрөнгө оруулалтын өгөөж
- Салбар, тэнхимийн бүтэц, бүрэлдэхүүний оновчтой байдал
- Эрхлэгчийн мэдлэг, ур чадварын түвшин зэргийг тогтооно.

Салбар, тэнхимүүдийн 2017-2020 оны 3 хичээлийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ:



**Зураг 7.3. Салбар тэнхимийн нийт үнэлгээ, үнэлгээний ангилал**



Сүүлийн 3 жилийн хугацаанд салбар, тэнхимүүдийн үнэлгээний нийт дүнгээр 47% нь тодорхой үр дүнтэй ажиллаж байгаа ч гүйцэтгэл, үр дүнг сайжруулах шаардлагатай, 51% нь хэрэгжилт хангалтгүй буюу удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг дээшлүүлж, эрчимжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна. Иймд цаашид салбар, тэнхимүүд гүйцэтгэлээ дээшлүүлэх хүрээнд дараах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Салбар, тэнхимүүдийн гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор одоогийн бүтэц, зохион байгуулалтыг оновчлон, нөөцийг зөв зохистой хуваарилах. ШУТИС-ийн салбар, тэнхимийн зохион байгуулалтын бүтэц нь их сургуульд ашиг тусаа өгдөг төдийгүй суралцагчийн амжилтыг нэмэгдүүлж, багш, ажилтны гүйцэтгэл, бүтээлч чадварыг дээшлүүлэхэд дэмждэг, тохирсон байх ёстой.
2. ШУТИС-ийн стратегийн чиглэл, зорилт болон чанарын шалгуур үзүүлэлттэй уялдуулан газар албад, бүрэлдэхүүн сургууль болоод салбар, тэнхимүүдийг хөгжүүлэх төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, тайлагналын үйл явц, загвар форматыг цэгцлэх, сайжруулах
3. Нэгжүүдийн уялдаа холбоо, хариуцлага, зохион байгуулалтыг дэмжих эрхзүйн орчин бүрдүүлж, дүрэм журмын шинэчлэлийг эрчимжүүлэх
4. Гүйцэтгэлийн үзүүлэлтийн хяналтын тоог чанартай, хурдан шуурхай гаргахад UNIMIS системийн өгөгдөл мэдээллийг бодит гүйцэтгэлтэй нийцүүлж, засварлах
5. Бүрэлдэхүүн нэгжүүд ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөнд тусгагдсан түвшинд хүрээгүй үзүүлэлт болон ШУТИС-ийн дунджаас доош түвшинд байгаа үзүүлэлтүүдийг анхаарч, үе шаттай дээшлүүлэх залруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх
6. Цаашид салбар, тэнхимүүдийн гүйцэтгэлийн үнэлгээг 2-3 жил тутам тогтмол хийж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг улам нарийвчлан боловсруулж, сайжруулах шаардлагатай.

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний үндсэн зорилгод хүрэх замын зураглалын 20 KPI-аас сургалт, судалгааны зарим үндсэн үзүүлэлтүүдээр 2020 оны 06 сарын байдлаар гүйцэтгэлийг хэмжихэд дараах түвшинтэй байна.



## “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний үндсэн зорилт

Хүснэгт 7.1

Д.д	Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин 2019	Гүйцэтгэлийн түвшин 2020	Хүрэх түвшин 2022
1	Гадаад суралцагчдын (оюутан солилцоогоор ирсэн тоо орно) эзлэх хувь	<0.2%	0.5%	0.5%
2	Гадаад хэлээр явагдах бакалаврын сургалтын хөтөлбөрийн тоо	0	0	10
3	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	39%	47%
4	Нэг багшид оногдох олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо	0.6	0.06	2
5	ШУТИС-ийн эзэмшилтэй оюуны өмчийн тоо	12	20	150
6	Лицензийн гэрээний тоо	0	0	2
7	Гарааны бизнесийн тоо	2	0	5
8	Бакалавр, магистр, доктор оюутны тооны харьцаа	9:1	9:1	9:2
9	Багш, суралцагчийн тооны харьцаа	1:16	1:17	1:15

### 7.1.3. “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл”-өөс зохион байгуулж буй сургалт

Боловсрол шинжлэх ухааны яам, Сингапурын Темасек сан, Политехникийн их сургуультай ШУТИС хамтран “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл” -ийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд “Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо” хөтөлбөрийн 5 багц сургалтад 2020.11 сараас хойш ЧХШҮА-ны дарга, мэргэжилтнүүд болон бүрэлдэхүүн сургуулийн төлөөлөл, чанарын менежерүүдээс бүрдсэн баг хамтран ажиллаж, суралцаж байна. Тус хөтөлбөрийн зорилго нь:

1. Дээд боловсролын чанарыг баталгаажуулах арга, зарчим, онцлог шилдэг туршлагаудын үндсэн мэдээллийг оролцогчдод өгөх
2. Монголын дээд боловсролын орчинд тохирох чанарын баталгаажуулалтын хүрээ, аргуудыг тодорхойлох, загварчлах, тогтоох, боловсруулахад оролцогч талд туслах



3. Хамаарал бүхий оролцогч талуудад чанарын баталгаажуулалтын сургалтыг зохион байгуулж, мэдлэг түгээх мастер багш нарыг сонгож бэлтгэх юм.

Дээрх зорилгын хүрээнд Дээд боловсролын байгууллагын чанарын баталгаажуулалтыг дараах үндсэн 5 чиглэлд тодорхойлох, загварчлах, тогтоох, хөгжүүлэх үе шаттайгаар бид боловсруулж, ажиллаж байна.



**Зураг 7.4. Дээд боловсролын байгууллагын чанарын баталгаажуулалтын үндсэн үе шатууд**

Тус төслийн хүрээнд Сингапурын Темасек сан, Политехникийн их сургуулийн Чанарын баталгаажуулалтын арга туршлагаас суралцаж, мэргэжилтнүүдээс зөвлөгөө мэдээлэл авч байгаа нь цаашид Монголын дээд боловсролын байгууллагуудын чанарын баталгаажуулалтыг бий болгох болон өөрийн сургуулийн Чанарын менежментийн тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэртэй ажил болж байна.



**Зураг 7.5. "Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг дэмжих төсөл" –ийн сургалт**

#### **7.1.4. ЭХС, БАС-ийн 2019-2020 оны сургалтын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийв.**

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын цагийн тооцооны үйл явцад хяналт шинжилгээг 2018 оноос хойш хийж байна. Тус хичээлийн жилд ЭХС, БАС-уудын 2019-2020 оны хичээлийн жилийн доктор, магистр, бакалавр, эчнээ ангийн хичээлийн хуваарийг сургалтын төлөвлөгөөтэй тулган, багш нарын А, Б, В цагийн тооцоо, санхүүгийн баримт зэргийг “Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын дагуу шалгаж, тайлан боловсруулсан.

#### **Хяналт шинжилгээний үр дүн**

*Хүснэгт 7.2*

Д.д	Алдаа, зөрчлийн төрөл	Эрчим хүчний сургууль		Барилга архитектурын сургууль	
		Илүү олгосон мөнгөн дүн	Дутуу олгосон мөнгөн дүн	Илүү олгосон мөнгөн дүн	Дутуу олгосон мөнгөн дүн
1	Багшийн цагийн тооцоо	(1,723,804.00)	194,100.00	(1,100,667.00)	
2	Судалгааны семинар	(594,000.00)			



3	Сургалтын мастер	(884,400.00)		(251,220.00)	
4	Гадны гэрээт багш	(87,553.00)			
5	Суутгал	(1,729,498.00)			
6	Гэрээт багш			(598,500.00)	202,251.00
7	Амралт, цалин		639,369.00	(764,625.00)	28,316.00
<b>Нийт</b>		<b>(5,019,255.00)</b>	<b>833,469.00</b>	<b>(2,715,012.00)</b>	<b>230,567.00</b>

Эндээс үзэхэд сургуулиудын цагийн тооцоон дээр үүсэж буй төлбөр тооцооны зөрүү нь дараах нийтлэг алдаанаас болсон байна. Үүнд:

- “Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам” 2018 онд өөрчлөгдсөн. Гэтэл журмын өөрчлөгдсөн заалтуудыг мэдээгүй, ойлгоогүй зэргээс болж мөрдөлгүй хуучин заалтаар тооцоо хийсэн.
- Төгсөгчийн дипломын ажил удирдсан, зөвлөсөн, шүүмжилсэн, комисст суусан зэргийн цагийн тооцоог диплом олгосон төгсөгчийн тоогоор тооцох ёстой байтал, төгсөхөөр төлөвлөсөн хүнээр тооцоог хийсэн.
- Нормоо бүрэн биелүүлээгүй багшаас албан тушаалын 1кр-ийн дундаж үнэлгээгээр тооцож цалингаас суутгал хийх ёстой байтал илүү цагийн үнэлгээгээр тооцож, суутгалыг дутуу авсан.
- Гаднын болон гэрээт багшийн 1кр-ийн үнэлгээг буруу бодож илүү олгосон зэрэг байна.

### 7.1.5. ШУТИС-ийн захирлын тушаалаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Багш, оюутнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаарх мэдээллийг түгээх зорилтын хүрээнд S.SS115 кодтой 3 кредитийн Хүний хөгжил хичээлийн хөтөлбөрт авлигал ба эрх зүйн бусад асуудал сэдвээр лекц, шударга ёсны асуудлууд сэдвээр семинарын хичээл орохоор туссан. Хүний хөгжил хичээлийг 2020/2021 оны хичээлийн жилийн намрын улиралд 316 оюутан, хаврын улиралд 317 оюутан, нийт 633 оюутан сонгон авлигын тухай ойлголт, түүний хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зохицуулалтыг судалсан байна.



ШУТИС-ийн удирдах албан тушаалд 2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш томилогдсон 4 албан тушаалтанд ЭБАТ-ийн зүгээс зохих заавар зөвлөгөөг өгч, мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон хууль тогтоомжийн гарын авлагыг тараасан.

ШУТИС-ийн хэмжээнд 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2021 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2021 оны 2 дугаар сарын 15-ны дотор /хуулийн хугацаанд/ сургуулийн мэдүүлэг гаргагч 72 албан тушаалтнуудын 2020 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргаж, мэдүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан. Улмаар хуулийн хугацаанд багтааж 2020 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайланг гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлсэн. 2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаагүй, хууль зөрчсөн асуудал гараагүй.

2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хяналт шалгалт хийх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гэрээ хэлцэл байгуулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон ажилтан ажилчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 58 мэдэгдлийг сургуулийн ЭБАТ-д хүлээн авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэсэн. 2020 оны мэдүүлэг, мэдэгдлийг цаасан сууриар болон мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүрэн бүртгэн хууль, журмын дагуу хадгалж байна. Мөн 2020 оны ЭБАТ-ын бүртгэлүүд цаасан болон цахим системийн бүртгэлүүд бүрэн хийгдсэн болно.

ШУТИС-ийн хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар Авлига ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулан өргөдөл /санал мэдэгдэл/ гомдол ирээгүй болно.

## **7.2. ШУТИС-ИЙН ДОТООД АУДИТ**

### **7.2.1. Хяналт шалгалтын ажлын талаар**

2021 онд тусгагдсан төлөвлөгөөний дагуу ШУТИС-ийн удирдлагын өгсөн үүрэг, зөвлөмжийн дагуу

- Механик тээврийн сургууль
- Гадаад хэлний сургууль
- Барилга архитектурын сургуулийн санхүүгийн ерөнхий байдал, нийтлэг гарч байгаа зөрчлүүдийг илрүүлэх зорилгоор сүүлийн 2-3 жилийн



санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж холбогдох зөвлөмж зааврыг тухай бүрт нь өгч ажилласан.

2020-2021 оны шалгалтад хамрагдсан сургуулиудад төсвийн төлөвлөлт, зарцуулалт, санхүү нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, төсөл гэрээт ажил, сургалтын төлбөр, профессор багш нарын ажлын гүйцэтгэл гэсэн зургаан чиглэлд удирдамж гарган дотоод аудитыг хийж, аудитын шалгалтын үр дүнгийн тайланг захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, цаашид сайжруулах зөвлөмжийг сургуулийн удирдлагууд болон санхүүгийн ажилтнуудад өгч тухай бүрт нь танилцуулсан.

- Дотоод аудитын үр дүнгээр Үйлдвэр Технологийн сургууль, Гадаад хэлний сургууль, Механик тээврийн сургуулиудад нийтдээ
  - Үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, зардалтай хамааралтай 3 зөвлөмж
  - Нягтлан бодох бүртгэл тайлагнал -6 зөвлөмж
  - Үндсэн хөрөнгө, бараа материал- 4 зөвлөмж
  - Худалдан авалттай холбоотой -4 зөвлөмж
  - Үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, зардалтай хамааралтай 3 зөвлөмж
  - Төсөл гэрээт ажил -3 зөвлөмжийг өгч ажилласан.

### **7.2.2. Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн талаар**

1. ШУТИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.6-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилт, шимтгэл төлөлтийг бодитой гаргах, төслийн үр дүнгийн хэрэгжилтийг сайжруулах” ажлын хүрээнд 2020 онд хэрэгжсэн. Механик тээврийн сургууль, Үйлдвэр Технологийн сургуулиудад шалгалт хийж үр дүнг тооцож цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулсан .
2. Барилга, архитектурын сургуулийн захирал М.Нарантуяагийн гаргасан хүсэлтийн дагуу 2014-2020 онуудад хэрэгжсэн төсөл гэрээт ажилд ажилласан ажилтнуудын цалинд хяналт хийж дүгнэлт гаргасан.
3. ШУТИС-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Авлага өр төлбөрийг бууруулах” чиглэлээр санхүү нягтлан бодох бүртгэлийн албатай хамтран бүрэлдэхүүн сургууль салбар нэгжүүдийн санхүүгийн тайлан балансын бүртгэлтэй авлага өр





төлбөрийг бууруулах удирдамжийн дагуу ажлын явцыг хэлэлцүүлж дүгнэлт зөвлөмж өгсөн.

4. Үндэсний аудитын газрын 2020 оны шалгалтын багтай хамтарч ажилласан ба шаардлагатай тоо мэдээлэл, хийсэн шалгалтын үр дүнг танилцуулсан .
5. БСШУЯ-ны Дотоод Аудитын газрын шалгалтад
  - Бүрэлдэхүүн сургуулиудын анхан шатны бүртгэл хөтлөлтийн товчоо,
  - Аудитын дүгнэлт тайлангуудын түүвэр,
  - Өмч хөрөнгийн ашиглалтын байдал,
  - Дотоод аудитаар илэрсэн зөрчлийн түүвэр судалгаа
  - Бүрэлдэхүүн сургуулиудын 2019-2020 он нь шалгалтын түүвэр судалгаа зэргийг бэлтгэн өгсөн.
6. Төлөвлөгөөний тусгай ажил үйлчилгээний хэсэгт тусгагдсан ажлын дагуу шалгалтын явцад бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн ажилтнуудад нийтлэг алдаа, зөрчил дутагдлын шалтгааны талаар мэдээлэл хийж цаашид анхаарах зөвлөмжийг өгөв.

### **7.3. МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь 2020-2021 оны хичээлийн жилд их сургуулийн сургалт судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд танилцуулан сурталчлах, байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны хамрах хүрээг тэлэх, байнгын болон зорилтот хэрэглэгчийг сэдэлжүүлэх зорилго дэвшүүлэн ажиллав.


2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн үйл ажиллагааны давуу талыг таниулах, нэр хүндийг өсгөх, тодорхой имижийг бүрдүүлэх зорилгоор телевизийн цаг үеийн мэдээ, мэдээлэл 15, телевизийн ярилцлагын нэвтрүүлэг 24, сонин, сэтгүүлийн ярилцлага 12, сайтын мэдээлэл 9, ШУТИС-ийн албан ёсны цахим хуудсаар хийсэн шууд дамжуулалт нэвтрүүлэг 16, радиогийн цуврал нэвтрүүлэг 21, подкаст 21, мэргэжил сурталчилсан видео бичлэг 11, элсэлтийн зөвлөмж видео 2, мэргэжлийн чиг баримжаа цахим контент 25 гаруй нийт 375 контент хүргэсэн байна.



**ШУТИС-ийн маркетингийн үйл ажиллагааны үзүүлэлт  
2020-2021 оны хичээлийн жилд**

Хүснэгт 7.3

Чиглэл	2018-2019	2019-2020	2020-2021
Телевизийн мэдээ, мэдээлэл	91	53	15
Телевизийн ярилцлага	3	0	24
Сонин сэтгүүлийн ярилцлага	3	11	12
Сайтын мэдээлэл	0	15	9
Телевизийн цуврал нэвтрүүлэг	13	20	0
Радиогийн нэвтрүүлэг	0	24	21
Подкаст	0	62	21
Шууд дамжуулалт	0	0	16
Сошиал контент	0	131	250
<b>Нийт</b>	<b>110</b>	<b>316</b>	<b>368</b>



**Зураг 7.5. 2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн маркетингийн үйл ажиллагааны үзүүлэлт**



### 7.3.1. Мэргэжил сурталчлах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Тус хичээлийн жилд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой хөл хорионы улмаас мэргэжил сурталчлах чиглэлээр төлөвлөсөн үйл ажиллагаанууд цахимаар зохион байгуулагдсан болно. Үүнд:

1. Цахим уулзалт семинар зохион байгуулах
2. Мэргэжил сонголтод зориулсан цахим шууд дамжуулалт хийх
3. Мэргэжлийн чиг баримжаа олгох цахим контент хөгжүүлэх

**а. Цахим уулзалт семинар:** ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын хүсэлтийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Оюутан, залуусын хөгжлийн орон тооны бус зөвлөлөөс зохион байгуулдаг “Залуустаа хэлэх үг цуврал уулзалт”-ыг хамтран зохион байгуулж, зочин илтгэгчээр 2020 оны 12 сарын 18-ны өдөр оролцож их сургуулийн сургалтын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн. Тус ажлын хүрээнд “Бяцхан туслагч” математикийн томъёоны эмхэтгэл, “Бяцхан туслагч” англи хэлний дүрмийн эмхэтгэлүүдийг ШУТИС-ийн товч мэдээллийг оруулан Улаанбаатар хотын 9 дүүрэг, хөдөө орон нутгийн 21 аймгийн ЕБС-ийн сурагчдад түгээсэн. Орчлон олон улсын сургуультай хамтран "Боловсролд Хамтдаа" уриан дор 2 өдөр цахимаар зохион байгуулагдсан "Монголын Их сургуулиудын танилцуулга" өдөрлөгт сургуулиа төлөөлөн оролцож, их сургуулийн сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн танилцуулгыг хийсэн. Хөдөө орон нутгийн сурагчидтай цахимаар холбогдож мэргэжил сонголтын зөвлөгөө өгсөн. Мэргэжил сонголт, дараагийн шатанд суралцах бэлтгэх хангах зорилгоор Edu Expo-2021 төслийн багтай хамтран ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэгчдэд их сургуулийн инфографик мэдээлэл, оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэл, босго оноо бүлэгт харгалзах ЭЕШ-ын хичээлүүдийн мэдээллийг хүргэж ажилласан. Тус ажлын хүрээнд Edu Expo сэтгүүл хэвлэгдэн тараагдсан болно.

**б. Мэргэжил сонголтод зориулсан цахим шууд дамжуулалт:** ШУТИС-ийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан цахим шууд дамжуулалтыг хийж байна. Тус цахим шууд дамжуулалтад ШУТИС-ийн Элсэлтийн комисс болон бүрэлдэхүүн сургуулийн удирдлагууд, профессор, багш нар оролцон ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг өгч ажилласан болно. Одоогийн байдлаар нийт

14 удаагийн цуврал лайвыг <https://www.facebook.com/www.must.edu.mn> хаягаар дамжуулж байна.

- с. **Мэргэжлийн чиг баримжаа олгох цахим контент хөгжүүлэх:** 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн үйл ажиллагаанд зориулан цахимаар мэргэжил танилцуулах сурталчлах зорилготой 250 гаруй инфографик, постер хийгээд байна. Үүнд:

Мэргэжлийн танилцуулга постер – 141

Бүрэлдэхүүн сургуулийн танилцуулга постер – 11



*Зураг 7.6. Мэргэжлийн чиг баримжаа олгох цахим контент*

Мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө өгөх постер 110, элсэлтийн үйл ажиллагааны талаар чиглэл өгөх постерууд, ШУТИС-ийн үйл ажиллагаатай холбоотой постерыг тус тус хийсэн байна.

4



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 52 ДУГААР ДУНД  
СУРГУУЛЬ

*Ирээдүйн мэргэжилтэн – Бидний оролцоо*

### “ШУТИС-ТУР” ТАНИЛЦАХ АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР

<b>Зорилго:</b>	Сурагч бүр өөрсдийн хэрэгцээ, сонирхолд тулгуурлан ирээдүйн мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх, нээлттэй хүртээмжтэй мэдээлэл өгөх, суралцах идэвхийг дэмжих, их сургуулийн сургалт, судалгааны орчинтой танилцуулах зорилготой.
<b>Зохион байгуулагч:</b>	ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба
<b>Хэзээ:</b>	2020 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр (Даваа), 15:00-17:00 цаг
<b>Хаана:</b>	ШУТИС-ийн Хичээлийн I, II, VIII, ШУТТС
<b>Оролцогч:</b>	<b>Нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар дунд сургууль</b>
<b>Хамтран ажиллагч:</b>	Нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар дунд сургуулийн багш Б.Ариунаа, М.Шинэцэцэг
<b>Давуу тал:</b>	Орон зай, цаг хугацаанаас үл хамаарах нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл Бүх шатны боловсролын байгууллагын уян хатан хамтын ажиллагаа

### ХӨТӨЛБӨР

СЭДЭВ	Байршил	
15:00-15:20	ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааны танилцуулга Х.Отгон-Эрдэнэ, Маркетинг, олон нийттэй харилцах албаны дарга, доктор (Ph.D)	ШУТИС-ийн Төв номын Сан 4 давхар 405 тоот
15:20-15:30	ШУТИС-ийн оюутанд чиглэсэн үйлчилгээ Б.Анударь, Оюутны соёл үйлчилгээний албаны мэргэжилтэн	ШУТИС-ийн Төв номын Сан 4 давхар 405 тоот
15:30-16:30	ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургалт, судалгааны орчны танилцуулга Б.Тунгалаагтамир, ХШУС-ийн дэд захирал доктор (Ph.D) ШУТИС-ийн ХШУС-ийн Салбарын эрхлэгч, профессор бөгш нар	ШУТИС-ийн хичээлийн I байр 4 давхар 411
16:30-17:00	“ШУТИС-ийн музей” үзэх Л.Гүрбазар, Музейн эрхлэгч	ШУТИС-ийн хичээлийн VIII байрны 11 давхар
17:00-17:00	“ШУТИС-ТУР” дүрсгалын зураг (бүх оролцогчид)	ШУТИС-ийн хичээлийн VIII байр

Холбоо барих утас: 99247798, 94953773

ШУТИС-ийн вэб хуудас: [must.edu.mn](http://must.edu.mn)

ШУТИС-ийн онлайн бүртгэлийн хуудас: [www.elselt.edu.mn](http://www.elselt.edu.mn)

ШУТИС-ийн пэйж хуудас, facebook хаяг: Шинжлэх ухаан, технологийн их сургууль



### Зураг 7.7. “ШУТИС-ТУР” аяллын хөтөлбөр

- d. “ШУТИС-ТУР” арга хэмжээ: Тайлант хичээлийн жилд Маркетинг, олон нийттэй харилцах алба нь “ШУТИС ТУР” уламжлалт арга хэмжээг 1 удаа зохион байгуулсан. Тус аяллын зорилго нь их сургуулийн орчин үеийн сургалт, судалгааны орчныг сурагчдад танилцуулах, их сургуулийн хичээлийн явцтай биечлэн танилцах, хичээлд оролцож үзэх боломжийг бүрдүүлэх, суралцах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, улмаар инженер, технологийн мэргэжил сонгож ШУТИС-д суралцах хүсэл сонирхлыг төрүүлэх, мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм. “ШУТИС-ТУР” танилцах аялалд 2020-2021 оны хичээлийн жилд

Нийслэлийн Ерөнхий боловсролын 52-р дунд сургуулийн сурагчид оролцсон бол цахим хэлбэрээр Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сумын сурагчид оролцсон байна.




*Зураг 7.8. “ШУТИС-ТУР” аялалд оролцож буй сурагчид*

### **7.3.2. ШУТИС-ийн сурталчилгааны контент бэлтгэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил**

ШУТИС-ийн сургалтын хөтөлбөр, оюутанд үзүүлэх үйлчилгээ, сургалтын орчин нөхцөлийн талаар хэрэглэгч, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготойгоор сурталчилгааны контентыг цахим сургалт, шинээр нээгдэж буй мэргэжил, сургалтын орчин, цахим төгсөлтийн талаар нийт 15 видео бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна. Үүнд: ШУТИС-ийн элсэлтийн үйл ажиллагааг танилцуулах 2 видео, бакалаврын мэргэжил танилцуулах 11 видео, элсэлтийн бүртгэл, ур чадварын шалгалтын талаар видео зааварчилгаа тус бүр 1-ийг бэлтгэн дамжуулаад байна. Тус видео бичлэгүүдийг ШУТИС-ийн албан ёсны YOUTUBE видео сувагт бүрэн байршуулсан болно.

1. ШУТИС-ийн танилцуулга – <https://youtu.be/yzzx9mZuICs>
2. БАС-ийн танилцуулга - <https://youtu.be/pPAn3S6keOA>
3. БУХС-ийн танилцуулга - [https://youtu.be/Lb\\_obyDS4uw](https://youtu.be/Lb_obyDS4uw)
4. ГУУС-ийн танилцуулга - <https://youtu.be/XApcRkag9U0>
5. МТС-ийн танилцуулга - <https://youtu.be/SjPRsPm4hNI>
6. МХТС-ийн танилцуулга - <https://youtu.be/vWFhcD7VLtQ>
7. ХШУС-ийн танилцуулга - [https://youtu.be/J5\\_HslyHpok](https://youtu.be/J5_HslyHpok)
8. ЭХС-ийн танилцуулга - <https://youtu.be/ECRcrZs0afw>
9. ДарТС-ийн танилцуулга <https://youtu.be/cR1ZDulMpg4>
10. ГХС-ийн танилцуулга - <https://youtu.be/YkXpvp29PSc>
11. ЭрТС-ийн танилцуулга <https://youtu.be/xzC9P6Z8F5c>



*Зураг 7.9. ШУТИС-ийн албан ёсны YOUTUBE видео сувагт бүрэн байршуулсан нэвтрүүлэгүүд*

### 7.3.3. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр (сонин, телевиз, сайт г.м) дамжуулан сурталчлах арга замыг сонгон ажилласан бөгөөд олон хүнд нэг зэрэг хүрэх боломжтой, нэг сонсогч, үзэгч, уншигчдад ноогдох зардлын хэмжээ бага гэсэн давуу талтай байлаа. Тус ажлын хүрээнд мэдээллийн илгээлтийг бэлтгэхдээ 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтийн үйл ажиллагаанд чиглүүлэн ШУТИС-ийн үйл ажиллагааны давуу талыг таниулах, нэр хүндийг өсгөх, тодорхой имиджийг бүрдүүлэх, хоногшуулах гэсэн чиглэлээр ажилласан. Нийт бэлтгэсэн телевизийн мэдээ 15 мэдээ (EAGLE TV, NTV, МҮОНРТ, Mongol HD TV, TV6, ETV), телевизийн ярилцлагын



нэвтрүүлэг 24, сонин, сэтгүүлийн ярилцлага 12, сайтын мэдээлэл 9, шууд дамжуулалт 16 бэлтгэн хүргэсэн байна.

**Телевизийн мэдээний жагсаалт**

*Хүснэгт 7.4*

Д.д	Суваг	Огноо	Агуулга	Оролцсон	Байгууллага
1.	TB-5	VIII-27	1000 инженер төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөрийн анхны төгсөгчид хос дипломоо гардан авлаа.	Б.Очирбат Д.Намсрай	ШУТИС
2.	EAGL E	VIII-27	1000 инженер төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөрийн анхны төгсөгчид хос дипломоо гардан авлаа.	Д.Намсрай Б.Очирбат	ШУТИС
3.	MNB	IX-3	Цахим сургалтын нээлт	Д.Гэрэлт-Од	ШУТИС
4.	MNB	IX-07	ШУТИС-ийн цахим сургалтын мэдээлэл	Д.Гэрэлт-Од	ШУТИС
5.	MNB	IX-21	ШУТИС-ийн сургалтын талаар	Д.Батдорж	ШУТИС
6.	EAGL E	I-22	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа	Х.Энхжаргал	ШУТИС
7.	NTV	I-22	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа	Х.Энхжаргал	ШУТИС
8.	EAGL E	IV.01	Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуульд уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах хамтын ажиллагааны гэрээ	Rio tinto, Оюу Толгой, ШУТИС	ШУТИС
9.	MNB	IV.01	Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуульд уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах хамтын ажиллагааны гэрээ	Rio tinto, Оюу Толгой, ШУТИС	ШУТИС
10.	NTV	IV.01	Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуульд уул уурхайн геотехник мэргэжлээр инженер бэлтгэх, олон улсын судалгааны төв байгуулах хамтын ажиллагааны гэрээ	Rio tinto, Оюу Толгой, ШУТИС	ШУТИС
11.	NTV	VI.20	ШУТИС-ийн 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийн талаар	Д.Батдорж	ШУТИС
12.	MASS TV	VI.28	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн	ШУТИС	ШУТИС





			жилийн хаврын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа		
13.	EAGLE	VI.28	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа	ШУТИС	ШУТИС
14.	NTV	VI.28	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа	ШУТИС	ШУТИС
15.	EAGLE	VII.3	ГУУС-ийн Геотехник мэргэжлийн талаар	Rio tinto, Оюу Толгой, ШУТИС	ШУТИС



Зураг 7.9. Телевизийн мэдээний зургууд

### Ярилцлага, нэвтрүүлэг

### Хүснэгт 7.5

Д.д	Огноо	Нэвтрүүлэг	Цаг	Албан тушаал	Нэр	Суваг
1	V.21	Зочны цаг	30 минут	МТС-ийн дэд захирал	Ж.Хашбат	EAGLE TV
2	V.24	Зочны цаг	30 минут	ЭХС-ийн захирал	Ч.Мангалжалав	EAGLE TV
3	V.28	Зочны цаг	30 минут	БАС-ийн захирал ГУУС-ийн захирал	Б.Нарантуяа Л.Пүрэв	EAGLE TV



4	V.31	Зочны цаг	30 минут	БУХС-ийн захирал МХТС-ийн захирал	А.Энхбат Н.Чулуунбанди	EAGLE ТВ
5	VI.4	Зочны цаг	30 минут	ҮТС-ийн захирал ХШУС-ийн захирал	Ж.Туяацэцэг Д.Ганхуяг	EAGLE ТВ
6	VI.7	Зочны цаг	30 минут	“ШУТИС-КООСЭН” технологийн коллежийн захирал Шинжлэх ухаан, технологийн ахлах сургуулийн захирал	Д.Болдбаатар Д.Буянтогтох	EAGLE ТВ
7	2020.X .15	Өргөн сэдэв	30 минут	Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын эрхлэгч	Д.Батбаяр /Доктор/	Малчин ТВ
8	2020.X .22	Өргөн сэдэв	30 минут	Биотехнологи, шим тэжээлийн салбарын багш	Б.Сугар /Магистр/	Малчин ТВ
9	2020.X .29	Өргөн сэдэв	30 минут	Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын эрхлэгч	Ц.Батсайхан Дэд профессор, Ph.D	Малчин ТВ
10	2020.X I.04	Өргөн сэдэв	30 минут	Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын профессор /Доктор Ph.D/	Ч.Ганбаатар Дэд профессор, Ph.D	Малчин ТВ
11	2020.X I.11	Өргөн сэдэв	30 минут	Хүнсний инженерчлэлийн салбарын профессор /Доктор Ph.D/	Я.Алтанцэцэг /Профессор, Ph.D	Малчин ТВ
12	2020.I. 06	Өргөн сэдэв	30 минут	Биотехнологи, шим тэжээлийн салбарын профессор	С.Дэлгэрмаа Дэд профессор, Ph.D	Малчин ТВ
13	2020.I. 13	Өргөн сэдэв	30 минут	Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын эрхлэгч	Д.Батбаяр /Доктор/	Малчин ТВ
14	2020.I. 20	Өргөн сэдэв	30 минут	Биотехнологи, шим тэжээлийн салбарын багш	Б.Сугар /Магистр/	Малчин ТВ
15	2021.V .19	Өргөн сэдэв	30 минут	ҮТС-ийн багш	М.Пүрэвжав	Малчин ТВ
16	2021.V .26	Өргөн сэдэв	30 минут	ХШУС-ийн Химийн инженерчлэлийн салбарын багш	А.Сарнай	Малчин ТВ
17	2021.V I.02	Өргөн сэдэв	30 минут	ХШУС	Ц.Мөнх-Эрдэнэ	Малчин ТВ
18	2021.V I.9	Өргөн сэдэв	30 минут	Математикийн тэнхимийн Эрхлэгч	Г.Батдэмбэрэл	Малчин ТВ
19	2021.V I.16	Өргөн сэдэв	30 минут	ХШУС-ийн Физикийн тэнхимийн профессор	Д.Батбаяр Д.Буяндэлгэр Б.Цолмон	Малчин ТВ
20	2021.V I.23	Өргөн сэдэв	30 минут	Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын эрхлэгч, багш нар	Ж.Хашбат	Малчин ТВ



21	2021.V I.30	Өргөн сэдэв	30 минут	Механик, тээврийн сургуулийн	Э.Чимэдлхам	Малчин ТВ
22	2021.V II.07	Өргөн сэдэв	30 минут	Дэд захирал	Б.Батдэмбэрэл	Малчин ТВ
23	VI.9	Боловс ролын хэлэлц үүлэг	60 минут	<b>Сэдэв: “Инженер, технологийн боловсролын хөгжил”</b> ШУТИС-ийн ЭХС-ийн зөвлөх, профессор Академич С.Батмөнх, ШУТИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Доктор Д.Гэрэлт-Од, ШУТИС-ийн нээлттэй боловсролын төвийн захирал Доктор Д.Ганбат, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэл инженерчлэлийн салбарын дэд профессор доктор Р.Мядагмаа		
24	VI.16	Боловс ролын хэлэлц үүлэг	60 минут	<b>Сэдэв: “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлт”</b> ШУТИС-ийн СХБА-ны дарга Д.Батдорж, ШУТИС-ийн МТС-ийн захирал Д.Цолмонбаатар, ХШУС-ийн захирал Д.Ганхуяг		

### Өдөр тутмын сонинд хэвлүүлсэн сонины ярилцлага, мэдээ мэдээлэл

Хүснэгт 7.6

Д.д	Сонин	Дугаар	Сэдэв	Холбогдох ажилтан
1.	Өдрийн сонин	2020.06.29 №131	Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн бакалаврын хөтөлбөр	Д.Батдорж
2.	Зууны мэдээ	2020.06.03 №109	ШУТИС Дэлхийн шилдэг 1000 сургуулийн нэг боллоо	Ч.Мангалжалав
3	Өнөөдөр	2020.10.20 №205	Японд 1000 инженер бэлтгэх төсөл өгөөжтэй байна	Б.Очирбат
4	Нээлттэй хаалга	2020.06.12-19 №20	Оюутны байраа цахилгаанаар хангасан профессор	Б.Хээрийнбаатар
5	Нээлттэй хаалга	2020.05.22- 06.05 №18	Эрхэмсэг амьдрахуй уламжлалаас эхтэй	Ц.Батсайхан
	Өнөөдөр сонин	2020-10-26	Японд 1000 инженер бэлтгэх төсөл өгөөжтэй байна.	ШУТИС-ийн Ректор Б.Очирбат
6	Зууны мэдээ	2021.01.13№9	Цахим сургалт боловсролын хөгжлийн чиг хандлага	ШУТИС-ийн Ректор Б. Очирбат
7	Зууны мэдээ	2021.01.21	ШУТИС-ийн ЭХС-ийн “Цахилгаан хангамж” Мэргэжлийн хөтөлбөрүүд олон улсад болон европод магадлан итгэмжлэгдлээ.	Б.Сэргэлэн
8	Зууны мэдээ	2021.04.01 №65	Монголын 6 их сургууль сургалт, судалгааг хөгжүүлэхэд хамтарна	А.Эрдэнэбаатар ШУТИС-ийн зөвлөх профессор МУ-ын гавьяат багш
9	Өнөөдөр	2021.4	Эрчим хүчний тулгуур баганын сайжруулалтад Монголын нөхцөлд зохицсон хийц, бүтцийн оновчтой шийдэл чухал	ЭХС-ийн ахлах багш Н.Жигжидсүрэн
10	Өнөөдөр	2020-3-23	Цахим сургалтыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил нэгдэх хэрэгтэй	НБТ-ийн захирад Д.Ганбат

**7.3.4. “ШУТИС-ийн ЦАГ” радиогийн цуврал нэвтрүүлэг, подкаст**

2020-2021 оны хичээлийн жилд цахим сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор “ШУТИС-ийн цаг” радиогийн 21 цуврал нэвтрүүлэг, подкастыг бэлтгэж, МҮОНР дамжуулан, социал медиа ашиглан олон нийтэд хүргээд байна.

**“ШУТИС-ийн цаг” радиогийн 21 цуврал нэвтрүүлэг***Хүснэгт 7.7*

Д.д	Ярилцлага	Сэдэв, агуулга	Оролцсон хүмүүс
1	2020-10-19	ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан
2	2020-10-26	ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааны үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Х.Энхжаргал
3	2020-11-9	ШУТИС-ийн харьяа Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн үйл ажиллагаа	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, академич С.Батмөнх
4	2020-11-23	ШУТИС-ийн харьяа Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	Захирал Т.Төрмөнх
5	2020-12-14	ШУТИС-ийн харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн	Захирал Ц.Банзрагч
6	2020-12-28	ШУТИС-ийн ГХС-ийн сургалтын үйл ажиллагааны талаар	ГХС-ийн багш С.Туяа
7	2021-1-11	Хөл хорионы үед сургалтын үйл ажиллагааг хэрхэн явуулж буй талаар	СБЗГ-ын дарга Д.Гэрэлт-Од
8	2021-1-25	Цахим сургалт, нээлттэй боловсролын төвийн үйл ажиллагааны талаар	Захирал Д.Ганбат
9	2021-3-15	Барилга, архитектурын сургуулийн сургалтын үйл ажиллагааны талаар	дэд захирал М.Сугар
10	2021-3-29	Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулганы талаар	дэд захирал Б.Тунгалагтамир
11	2021-4-5	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал Д.Ганбаатар
12	2021-4-12	Эрчим хүчний сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал Б.Пүрэвсүрэн
13	2021-5-3	ШУТИС-ийн Ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	захирал Д.Буянтогтох

14	2021-5-10	“ШУТИС-Коосэн” технологийн коллежийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	захирал Д.Болдбаатар
15	2021-5-17	Механик, тээврийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал Ж.Хашбат
16	2021-5-24	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал Н.Эрдэнэхүү
17	2021-6-8	ШУТИС-ийн элсэлтийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл	албаны дарга Д.Батдорж
18	2021-6-15	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал П.Булга
19	2021-6-22	Геологи, уул уурхайн сургуулийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүдийн танилцуулга	дэд захирал Б.Батдэмбэрэл
20	2021-6-29	ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаа	СБЗГ-ын дарга Д.Гэрэлт-Од
21	2021-7-6	ШУТИС-ийн оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа	ОСҮА-ны дарга Н.Санчирбаатар



*Зураг 7.10. “ШУТИС-ийн ЦАГ” радиогийн цуврал нэвтрүүлэг, подкастын постерууд*


### 7.3.5. ШУТИС-ийн албан ёсны цахим хуудас хөгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

ШУТИС-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг бага зардлаар олон нийтэд таниулах, сурталчлах, улмаар бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, шинэ хэрэглэгчдийг татах, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг цаг алдалгүй олон нийтэд хүргэх зорилгоор




“Шинжлэх ухаан, технологийн их сургууль” цахим хуудсыг хөгжүүлж байна. Тус цахим хуудсыг 2018 оны 6 дугаар сарын 6-наас эхлэн идэвхжүүлэн хөгжүүлсэн бөгөөд 2018 оны 7 дугаар сарын 4-ний байдлаар нийт 11,163 дагагчтай, хуудас таалагдсан хүмүүсийн тоо 10,966 байсан 2021 оны 6 сар буюу одоогийн байдлаар 39,841 дагагчтай, цахим хуудас таалагдсан хүний тоо 36,879, нэг өдөрт цахим хуудсанд хандаж буй хүний тоо 1067, Нэг долоо хоногт цахим хуудсанд хандаж буй хандалтын тоо 6247 байна. Үүнээс гадна Өсвөр насны хүүхдүүд болон залуучууд ихээр ашигладаг Инстаграмд ШУТИС-ийн аккаунтыг үүсгэсэн. Мөн Youtube channel-ийн идэвхжүүлэлтийг хийж байгаа. Одоогийн байдлаар нийт 27 видео, шторк нийтэлсэн байна. Youtube channel-ийн дагагчдын тоо идэвхжүүлэлт хийгдсэн нэг сарын хугацаанд нэг видео дунджаар 131 үзэлттэй байна.


Зураг 7.8. ШУТИС-ийн албан ёсны фэйсбүүк хуудас



**Зураг 7.9. Долоо хоногт цахим хуудасны хандалтын харьцуулсан тоон үзүүлэлт**



**Зураг 7.10. Долоо хоногт хуудас дагаж буй дагагчдын тоон үзүүлэлт**



Зураг 7.11. Youtube сувгийн идэвхэжсэн байдал

### 7.3.6. SCEINCE FM 94.1 ФМ радио

**SCEINCE FM 94.1 ФМ-ийн үндсэн зорилго нь ШУТИС-ийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах, шинжлэх ухааны олон салбар чиглэлийн мэдлэгийг олны хүртээл болгох, сургалт судалгааны ажил, зар сурталчилгаа, хөгжингүй орнуудын туршлагаар, нээлттэй, судалгааны Их Сургууль болоход радио өргөн нэвтрүүлгийг ашиглахад оршино. Үүний хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.**

- Их сургуулийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, Олон нийттэй харилцах,
- Сургалт судалгааны ажил, зар сурталчилгаа, шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээ мэдээлэлд чанарын ахиц гаргах,
- Радио өргөн нэвтрүүлгийг өргөжүүлэн хөгжүүлэх

Ингэснээр шинэлэг, шинжлэх ухааны үндэслэлтэй танин мэдэхүйд чиглэсэн уриатай ажиллаж хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, нэвтрүүлгийг сонсогчдын сонорт хүргэх юм.





**ШУТИС-ийн ФМ94.1 радио өргөн нэвтрүүлгийн  
жагсаалт /Даваа гараг бүр/**

*Хүснэгт 7.8*

Д д	Ерөнхий хөтөлбөр	Цаг	Хөтөлбөрийн задаргаа	Хамтра н ажилла х	Харнуцах эзэн
1	Радио уриа "ШУТИС Бидний бахархал"	8:00	Радио уриа "Төрийн дуулал" "ШУТИС Бидний бахархал"	МОНХ А	Э.Баярмаа
2	Өглөөний мэдээ	8:05	Өдрийн хөтөлбөр танилцуулах ШУТИС- ийн түүхэн замнал №01		Э.Баярмаа
3	"Өдрийн зурхай"	8:15	Өрнө, дорнын зурхай	МОНХ А	Сайтуудаас
4	Эрүүл хооллолт	9:15	Эрүүл амьдрахын үндэс суурь, зөв хооллолт	ҮТС	М.Пүрэвжав ЭНБД
5	Хөгжмийн цаг	10:15	Монгол дууны аялгуу	МОНХ А	Өөрийн фондоос
6	Шинжлэх ухаан бидний амьдралд	11:20	Шинжлэх ухаан таны амьдралд яаж нөлөөлж байна.	Бүрэлдэ хүүн сургуул ь	ГУУС О.Мөнхцэцэг А/Б 88056491, Дүгэржав багш
7	Хөгжмийн цаг	12:30	Гадаад дууны аялгуу	МОНХ А	Өөрийн фондоос
8	MUST-н онцлох мэдээ мэдээлэл	13:00	ШУТИС дээр энэ 7 хоногт болох онцлох үйл явдал, мэдээ мэдээлэл	ЗХНГ	MUST-ийн мэдээнээс
9	НОМ СОНСОХ ЦАГ	13:30	Монголын шилмэл богино өгүүллэгийн уран уншлага байна. Эерэг хандлага төлөвшүүлэх, гэрэл гэгээтэй сайхан өгүүллэг зохиолыг мэргэжлийн түвшинд сонгож оруулна. Оюутнууд өөрсдөө уншвал тэдний оролцоог илүү нэмэгдүүлэх боломжтой.	МОНХ А	ОСҮА
1 0	Эфир хаах	15:00			

**ШУТИС-ийн ФМ94.1 радио өргөн нэвтрүүлгийн жагсаалт****/Лхагва гараг бүр/***Хүснэгт 7.9*

Д.д	Ерөнхий хөтөлбөр	Цаг	Хөтөлбөрийн задаргаа	Хамтран ажиллах	Хариуцах эзэн
1	Радио уриа "ШУТИС Бидний бахархал"	8:00	Радио уриа "Төрийн дуулал" "ШУТИС Бидний бахархал"	МОНХА	Э.Баярмаа
2	Өглөөний мэдээ	8:05	Өдрийн хөтөлбөр танилцуулах ШУТИС-ийн түүхэн замнал №01	МОНХА	Э.Баярмаа
3	"Өдрийн зурхай"	8:15	Өрнө, дорнын зурхай	Google-ээс	Сайтуудаас
4	Хувь хүний нөөц чадавх	9:15	Цуврал сэдэв	БУХС	багш О.Нямдорж
5	Хөгжмийн цаг	10:15	Монгол дууны аялгуу	МОНХА	Өөрийн фондоос
6	Өдрийн зочин	11:20	Ахмад үеэсээ суралцахуй	Ахмадын зөвлөл	Тэргүүн Д.Чулуун
7	Хөгжмийн цаг	12:30	Гадаад дууны аялгуу	МОНХА	Өөрийн фондоос
8	MUST онцлох мэдээ мэдээлэл	13:00	ШУТИС дээр энэ 7 хоногт болох онцлох үйл явдал, мэдээ мэдээлэл	ЗХНГ	MUST мэдээнээс
9	Их хотын иргэн-Ток шоу	13:30	Хотын соёлд хувь хүний оролцоог чухалчилна. Зорилтот бүлэг бүх насныханд	ЗХДХ	ГУУС-ийн багш Б.Улаанбаатар
10	Эфир хаах	15:00			

**ШУТИС-ийн ФМ 94.1 радио өргөн нэвтрүүлгийн жагсаалт****/Баасан гараг бүр/***Хүснэгт 7.10*

Д.д	Ерөнхий хөтөлбөр	Цаг	Хөтөлбөрийн задаргаа	Хамтран ажиллах	Хариуцах эзэн
1	Радио уриа "ШУТИС Бидний бахархал"	8:00	Радио уриа "Төрийн дуулал" "ШУТИС Бидний бахархал"	МОНХА	Э.Баярмаа
2	Өглөөний мэдээ	8:05	Өдрийн хөтөлбөр танилцуулах ШУТИС-ийн түүхэн замнал №01	МОНХА	Э.Баярмаа
3	"Өдрийн зурхай"	8:15	Өрнө, дорнын зурхай	МОНХА	Сайтуудаас



4	Эрүүл мэндийн хөтөлбөр	9:15	Эрүүл мэндийн боловсрол	Мэргэжлийн байгууллагууд	ЭМТөв
5	Хөгжмийн цаг	10:15	Монгол дууны аялгуу	МОНХА	Өөрийн фондоос
6	Зарын цаг	11:20	Төлбөртэй мэдээлэл	МОНХА	Гадны байгууллага
7	Хөгжмийн цаг	12:30	Гадаад дууны аялгуу	МОНХА	Өөрийн фондоос
8	MUST онцлох мэдээ мэдээлэл	13:00	ШУТИС дээр энэ 7 хоногт болох онцлох үйл явдал, мэдээ мэдээлэл	ЗХНГ	MUST мэдээнээс
9	Залуус-ток шоу	13:30	Ёс суртахуун, хүн чанар, амьдралын утга учрын тухай ярилцана. Зорилтот бүлгийн хувьд 18-30 насныхан	Оюутны холбоо	Тэргүүн Б.Мягмарренчин
10	Эфир хаах	15:00			

## 7.4. НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛ

### 7.4.1 ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА, АРГА ЗҮЙ, ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН СТАНДАРТЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

Инженерийн боловсролын шинэчлэлийн арга туршлага, шинэ арга зүйг хэлэлцэх CDIO2020 Азийн бүсийн онлайн хурлыг зохион байгуулав. Ази, Европын 10 гаруй их дээд сургуулийн төлөөлөл 60 орчим өгүүлэл, 30 гаруй илтгэл хэлэлцүүлсэн 3 өдрийн 6 салбар хуралдаантайгаар 9-р сарын 23-25-ны өдрүүдэд онлайнгаар зохион байгуулав. Хуралд Монголын 14, Японы 4, Вьетнамын 1, Кувейтын 1, Сингапурын 2, Германы 1, БНХАУ-ын 2, ҮДСБ Монгол хэл дээрх салбар хуралд 12 илтгэл, нийт 37 илтгэл хэлэлцүүлэв. Гадаад дотоодоос 61 өгүүллийн хураангуй ирүүлснийг шүүн 32 илтгэлийн өгүүллийг Монгол хэл дээр эмхэтгэн хэвлүүлэв. БНХАУ-3, Герман-1, Тайван-1, Иран-2, Япон-5, Кувейт-7, Монгол-290, Сингапур-5, Тайланд-7, АНУ-аас-Монгол-1, Вьетнам-2, Нидерланд-1, Филиппин-7 төлөөлөгч нийт 332 хүн оролцлоо. Урилгын зочин илтгэгч-3, Үндсэн илтгэгч- 30, оролцогч 299 байв.



### Зураг 7.12. CDIO2020 Азийн бүсийн онлайн хурал

Багш нарын багшлахуйн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх”, “Багшийн хөгжил, идэвхтэй сургалтын арга зүйг нэвтрүүлэх”, “Суралцагчийн ур чадварыг хөгжүүлэх”, “Хөтөлбөр, хичээлийн үнэлгээг сайжруулах” сэдвийн хүрээнд CDIO2020 Азийн бүсийн олон улсын хурлын “Үр дүнд суурилсан боловсрол 2020” Эрдэм шинжилгээний салбар хуралдаанд оролцсон багш нарын бүтээлээс нийт 34 эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл бүхий 6 дахь удаагийн ээлжит эмхэтгэлийг 2021 оны 2-р сард хэвлүүлэн, ХААИС, ТТДС, ҮБХИС, МУБИС, ШУТИС, СУИС-дад тараан багшийн хөгжлийн төвүүд болон номын санд байрлуулахаар тараах ажлыг 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулав. Цаашид өмнөх эмхэтгэлийн бүтээлүүдийг цахим хэлбэрт шилжүүлэн [cdio.edu.mn](http://cdio.edu.mn) веб сайтад байрлуулж улсын хэмжээнд багш нарын бүтээлийг олны хүртээл болгохоор төлөвлөн ажиллаж байна.





**Зураг 7.13. "Чанарын баталгаажуулалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх цахим сургалт**

Багшийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор АХБ-ны ДБШТ-ийн нэгжид удаа дараа төслийн санал боловсруулан хүргүүлсний дүнд 2020 оны 11-р сараас эхлэн “21-р зууны дижитал технологи ба их сургуулийн багш”, “Боловсролын хөтөлбөрийг загварчлах, шинэчлэх нь”, “Багшийн судалгааны чадавхыг хөгжүүлэх нь”, “Хүн төвтэй өөрчлөлтийн менежмент”, “Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилтийг хурдасгах нь”, “Боловсролын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах нь” 6 багц 30 модуль бүхий нээлттэй хичээлийн (МООС) иж бүрэн бэлтгэж, ИДС-ийн багш нарт зориулан багц сургалтуудыг явуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Энэ төслийн гүйцэтгэгчээр ажиллахаар БМДИ-тэй хийсэн гэрээний хүрээнд ИДС-ийн багш нартай хамтран 6 багц нээлттэй хичээлийг бэлтгэх ажил үргэлжлэн хийгдэж байна.

Дээд боловсролын сургалтын арга зүйн шинэчлэлийн хүрээнд багш нарын ур чадварыг хөгжүүлэх, хөтөлбөрийн шинэчлэлийн ажлыг дэмжих зорилгоор олон улсын CDIO байгууллагын санаачлагчдын багаас эмхэтгэн боловсруулсан, гадаадын ИДС-ийн хөтөлбөрүүдэд хэрэглэгдэж буй “Rethinking Engineering Education” номын орчуулгын эрхийг ШУТИС-ийн нэр дээр авсан ба орчуулга хийх ажлыг удирдан зохион байгуулсан. Энэхүү номын орчуулгыг АХБ-ны санхүүжилтээр 1000 хувь хэвлүүлэн, ИДС-дад тараах ажлыг удирдан хийж байна.

1. ИДС-ийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийхэд хэрэглэх иж бүрэн аргачлалыг нэгтгэл боловсруулж "Сургалтын хөтөлбөрт CDIO-ийн 12 стандартын дагуу үнэлгээ хийх нь" сэдэвт материал бэлтгэн “ҮДСБ-2020” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн.

2. Боловсролын онол, боловсрол судлал, сургалтыг зохион байгуулах хэлбэрүүд, CDIO-ҮДСБ-ын арга зүйн материалуудыг нэгтгэн, багш нарын чадавхыг дээшлүүлэх сургалтын материал болгон бэлтгэж байна.
3. Суралцахуйн дизайныг судлан багшлахуй, суралцахуйн хэв шинж болон сургалтын үйл ажиллагааны зураглалыг боловсруулах шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.
4. Сингапур, Канад, Англи, Австрали болон бусад гадаадын их сургуулиудын багшийн мэргэшлийн стандарт тогтолцоог судлан мэдлэгээ сайжруулан, ажилдаа тусган, хэрэгжүүлж байна.

### 7.4.2. ШУТИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ШИНЭЧЛЭЛ ХИЙХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

ШУТИС-2030 хөгжлийн хөтөлбөр, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр "Боловсрол 4.0" хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт ажиллан ШУТИС, БОЛОВСРОЛ 4.0 хөтөлбөрийг боловсруулахад оролцон ажиллав.



#### Зураг 7.13. ШУТИС, БОЛОВСРОЛ 4.0 хөтөлбөрийн боловсруулалт


ҮДСБ хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх, ШУТИС-ийн Боловсрол 4.0 хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор МЈЕЕД төслийн хүрээнд ШУТИС-ийн 30 хөтөлбөрийг сайжруулах, багш нарын ур чадварыг сайжруулах сургалт явуулах, боловсролын хөгжил, хөтөлбөрийн агуулгыг дэмжих болон үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөний төслийг боловсруулан танилцуулсан..

ШУТИС-ийн профессор багшид тавигдах шаардлагыг боловсруулан ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр 2020 оны 6 ба 9-р сард хэлэлцүүлэн, багш нарын саналыг тусган, ШУТИС-ийн 2030 хөтөлбөрийн 5 үндсэн чиглэлийн дагуу ангилан, профессор багшийн албан тушаалын ангилал тус бүрд тавигдах нийтлэг шаардлагыг боловсруулан ажиллав.



Нэмэлт модуль НМ1: Дижитал контент бэлтгэх

Модуль	Сэдвийн товч	Кредит	А хувилбар	
			Сургалт явагдах өдөр	Вебинарын цаг
НМ1.	Онлайн сургалтын платформудыг MS Teams, Moodle (гагц) ашиглан видео үзүүлэх, явдан боловч урилын шалгалт авах, тестийн нэгдсэн сан, гичээлийн даалгавар үүсгэх, даалгаврын гүйцэтгэлийг тэмдэглэх, оюунуудын идэвхийг харах дүгнэх гэх мэт.	0.2	2021.01.14 нөөс 2021.01.20-ны өдөрүүдэд	09:00-10:00
НМ2.	ШУТИС-ийн Цэжим сургалтын систем, Цэжим сургалтанд ашиглах болох MS Office 365 болон Бусадангны хэрэглээ	0.2		
НМ3.	Adobe premiere pro, Adobe after effects мэт видео зөвлүүлийн програм	0.2		
НМ4.	Шилэн самбар Lightroom-ыг сургалтанд ашиглах нь QR code	0.2		
НМ5.	Онлайн сургалтанд, платформудыг ашиглаж цэжим янзалд дүр дүрс ооцлох боломжид	0.2		



Зураг 7.16. "Хүний нөөцийг чадавхжуулах" сургалт

“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Судалгааны чадавхыг дээшлүүлэх, эрдэмтэн судлаачдыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэл болон Хүний нөөцийг чадавхжуулах сургалтуудыг 2020-2021 оны хичээлийн жилд зохион байгуулсан 3 багц сургалтын 670 хүний /давхардсан тоогоор/ гэрчилгээг онлайн /PDF/ хэлбэрээр олгох ажлыг гүйцэтгэн бүрэлдэхүүн сургууль бүрд цахим шуудангаар хүргүүлсэн.

**7.4.3. БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР СУДАЛГАА ХИЙЖ, ГАДААД, ДОТООДЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ**

1. CDIO арга зүйг түгээн дэлгэрүүлэх багшлах үр чадварыг сайжруулах сургалт явуулах, боловсролын хөгжил, хөтөлбөрийн агуулгыг дэмжих ажлын хүрээнд Сингапурын Темасек сан болон Сингапурын зөвлөх багш нартай байнгын холбоотой ажилладаг.
2. АНУ-ын MIT-ийн MIT NEET /J-WEL Educational Envisioning & Planning Workshop-д 2021 оны 4 ба 5-р саруудын сургалтад оролцон, гадаадын их сургуулиудын хөтөлбөрийн хөгжлийн талаарх туршлагыг судлан,





тогтолцоог судлан мэдлэгээ сайжруулан, ажилдаа тусган ажиллаж байна. MIT NEET/J-WEL Educational Envisioning & Planning Workshop сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлж байна.

- Erasmus төслийн хүний нөөцийг бэлтгэх хэсгийн "Strategies development and methods of moderating trainings in leadership" 6 өдрийн сургалтад хамрагдан, төслийн хүрээнд Боловсрол судлал магистрын хөтөлбөрийг сайжруулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан Ерасмусын төслийн багт илгээн, хөтөлбөрт судалгаа хийх, сайжруулах ажлыг эхлүүлээд байна.
- Боловсролын онол, боловсрол судлал, сургалтыг зохион байгуулах хэлбэрүүд, CDIO-ҮДСБ-ын арга зүйн материалуудыг нэгтгэн, багш нарын чадавхыг дээшлүүлэх сургалтын материал болгон бэлтгэж байна.
- БШУЯ-ны сайдын өгсөн үүргийн дагуу Ерөнхий боловсролын хөгжил, хөтөлбөрийн агуулгыг дэмжих ажлын хүрээнд Сингапурын Темасек сан болон Сингапурын зөвлөх багш нартай байнгын холбоотой ажиллаж эхлэхээр судлах ажлыг эхлүүлээд байна.
- БМДИ-ийн ДББХА-гай хамтран ажиллах ажлын хүрээнд ИДС-ийн багшийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд хийгдэх цахим контент бэлтгэх ажлын үзэл баримтлал боловсруулах, контент бэлтгэхээр багш нарын хамт ажиллаж байна.
- БМДИ-ийн Дээд боловсролын багшийн хөгжлийн албанаас 2021 оны 02 сарын 19-ний өдрийн 14 цагт зохион байгуулсан "Их, дээд сургуулийн багшид ментор ба ментийгийн ойлголтыг бий болгох нь" сэдэвт цахим хэлэлцүүлгийн зар, мэдээллийг бүрэлдэхүүн сургуулиудад хүргэж багш нар идэвхтэй оролцлоо.

#### **7.4.4. БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, БАГШИЙГ БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАХ, ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СИСТЕМИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОН САЙЖРУУЛАХ**

- ШУТИС-ийн багшийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх анхан, дунд, ахисан түвшний хөтөлбөрийг боловсруулан Ректорын баталсан ба анхан шатны сургалтын хөтөлбөрийн дагуу “Багшлах эрхийн сургалт”-ын агуулгыг бүрэн шинэчилсэн.



Багшлахуйн үр чадварыг хөгжүүлэх сургалт											
Сургууль:		Нээлттэй боловсролын төв									
Тэнхим/салбар-ын нэр:		Дээд боловсролын судалгаа хөгжлийн лаборатори									
Мэргэжлэхтөлбөр:		Багшлахуйн үр чадвар хөгжүүлэх сургалт									
Хугацаа:		2020/2021 оны хичээлийн жилийн намрын улирал									
№	А	Үндсэн чиглэл	Ахицан шатны сургалт				Дунд шатны сургалт				
			Код	Сэдэв	Кредит	Код	Сэдэв	Кредит	Код	Сэдэв	Кредит
1	Чиглэл1	Боловсролын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх	M.OE101	1. Педагог, Андрагог, Хөлөөгч онол арга зүйн харьцуулалт, давуу ба сул талууд 2. Хичээлийн зорилго зорилт, суралцахуйн үр дүн тодорхойлох нь 3. Суралцахуйн зохиол /Constructive alignment, Хичээлийн хөтөлбөр боловсруулах аргачлал 4. Блүүмийн тавсааномийн хэрэглээ	2	M.OE201	1. Боловсролын хөтөлбөрийн зорилго зорилт, хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүн тодорхойлох 2. Суралцахуйн хөтөлбөрийн зорилго зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, үр дүнгийн хямаарал болон хөгжлийн шинэчлэлтэй хийх / GAAR 3. Блүүмийн тавсааномийн - 2 4. Хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүй 5. Боловсролын хөтөлбөр боловсруулах арга зүй	2	M.OE301	1. Ахицан түвшний шинэ хөтөлбөр боловсруулах арга зүй 2. Бакалаврын болон ахицан түвшний салбар дунд хөтөлбөр боловсруулах арга зүй	2
2	Чиглэл2	Үнэлгээний дэвшилтэт арга зүйг суралцах	M.OE102	1.Идэвхитэй сургалтын арга зүй 2. Суралцагчийн явцан болон эцсийн рубликсн үнэлгээ 3. Танин мэдэхүйн түвшний дагуу мэдлэг, чадвар хандлагын үнэлгээ	1	M.OE202	1. Суралцагчийн явцан болон эцсийн рубликсн үнэлгээ Үнэлгээний дэвшилтэт арга зүй 2. Танин мэдэхүйн түвшний дагуу мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх 4. Идэвхитэй сургалтын арга зүй	2	M.OE302	1. Хичээлийн үнэлгээ 2. Хөтөлбөрт хийх чанарын үнэлгээ 3. Сургалтын чадрын баталгаажуулалт	3
3	Чиглэл3	Сургалтын үйл ажиллагааг дэмжих	M.OE103	1. Сургалтын орчныг сургалтын арга зүйтэй холбох нь 2. Үнэлгээний дэвшилтэд арга зүйг суралцах нь 3. Бидеэ хичээл бэлтгэх нь 4. Хичээлийн явцад зохиох сургалтын /Edu Tech- Socrative, Kahoot, Quiz, Google classroom, QR код/ технологийн хэрэгсэлийг ашиглахад суралцах нь 5. Нээлттэй боловсрол, MOOC 6. Цахим сургалтын арга зүй 7. Дижитал оюутан 8. Дижитал профессор	1	M.OE203	1. Сургалтын орчныг сургалтын арга зүйтэй холбох арга зүй 2. Холлимог сургалтын арга зүй 3. Дижитал профессор 4. Дижитал оюутан 5. Хичээлийн явцад зохиох сургалтын /Edu Tech - Socrative, Kahoot, Quiz, Google classroom, QR код/ технологийн хэрэгсэлийг ашиглахад суралцах 6. Нээлттэй боловсрол (Дижитал профессор, онлайн сургалт) - 2	2	M.OE303	1. Магдлан итгэхэлдээ бэлтгэх 2. Сургалтын орчныг сургалтын арга зүйтэй холбох арга зүй 3. Цахим сургалт, MOOC	3
4	Чиглэл4	Батшийн хувь хүний зөвлөл	M.OE104	1. Боловсрол судлал 2. Сэтгэл судлал 3. Багшийн ёс зүй	2	M.OE204	1. Боловсрол судлал 2. Сэтгэл судлал 3. Батшийн ёс зүй 4. Гадаад хэл дээр хичээл заах арга зүйг суралцах 5. Хүн төвтэй хөгжлийн MARS загвар 6. 70-20-10 зарчмын буюу өнгөт дээр, ахлын орчим, ахлаас гадуус суралцах, дадлагажих арга	4	M.OE304	1. Манлайлал 2. Эхлэсн 3. Стратегийн төлөвлөлт 4. Өөрчлөлтийн ундарлага 5. ИДС-ийн зохион байгуулалтын дизайн 6. Ентерпренёр 7. Суралцагчийн ёс зүй	7
			Нийт		6			10			

**Зураг 7.18. Багшлах эрхийн сургалтын агуулга шинэчлэлт**

- Багшийн үр чадварыг хөгжүүлэх “21-р зууны дижитал технологи ба их сургуулийн багш”, “Боловсролын хөтөлбөрийг загварчлах, шинэчлэх нь”, “Багшийн судалгааны чадавхыг хөгжүүлэх нь”, “Хүн төвтэй өөрчлөлтийн менежмент”, “Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилтийг хурдасгах нь”, “Боловсролын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах нь” 6 багц сургалтуудыг 2020 оны 12-р сараас эхлэн онлайнаар зохион байгуулж эхлээд байгаа ба цаашид хичээлийн жилийн турш тодорхой хуваарийн дагуу зохион байгуулахаар БМДИ-ийн ДББХА-тай хамтран ажиллаж байна. “Багшийн үр чадварыг хөгжүүлэх” 6 МООС, 30 модуль сургалтын удирдамж, хөтөлбөр, төсвийн саналыг боловсруулан, эхний 2 МООС-ийг иж бүрэн дуусгаад edx.edu.mn платформ дээр байршуулан, БМДИ-тай хамтран ИДС-ийн 70 багшид 2020 оны 12-р сарын 7-18-ны өдрүүдэд сургалт явуулсан.
- "Багшийн судалгааны чадавхыг нэмэгдүүлэх нь" 3 өдрийн 3 модуль сургалтыг 2021 оны 6-р сарын 10-12-ны өдрүүдэд ИДС-ийн багш нарт зориулан зохион байгуулж байна.
- Багшлах эрхийн сургалтын S.HE601-S.HE606 хичээлүүдийн цахим файл бүрдүүлэх ажлыг эхлүүлэн, бэлтгэл хийгдэж байгаа ба хичээлүүдийн хөтөлбөр, агуулгыг шинэчлэн боловсруулж, "Боловсролын онол арга зүй", "Суралцахуйн дизайн" гэсэн 2 хичээлийн хөтөлбөр, PPT, бичвэр материал, даалгаврыг иж бүрэн бэлтгэв.
- Багшлах эрхийн сургалтыг намрын улиралд 9, 11 сард 2 удаа зохион байгуулж 65 хүнд, хаврын улиралд 1, 3, 4, 6-р саруудад 4 удаагийн

сургалтаар 144, нийт 209 суралцагчид багшлах эрх олгов. 55,8 сая төгрөгийн төлбөрийн орлогоос ШУТИС-ийн эрдэм шинжилгээний орлого бүрдүүлэлтэд 5,58 сая төгрөг, НБТ-д 18,0 сая төгрөгийн орлого оруулсан.



**Зураг 7.18. Баглах эрхийн сургалтын үнэмлэх**

6. Erasmus төслийн хүний нөөцийг бэлтгэх хэсгийн "Strategies development and methods of moderating trainings in leadership" төслийн 7 өдрийн сургалтын материалыг орчуулж бичвэр бэлтгэв.
7. Erasmus төслийн хүний нөөцийг бэлтгэх хэсгийн "Strategies development and methods of moderating trainings in leadership" төслийн сургалтын материалаар хичээлийн PPT 278 слайд бэлтгэн сургалтад ашиглахад бэлэн болгов.
8. Colin Latchem Using ICTs and Blended Learning in Transforming TVET, OER in TVET, "Teacher development: How will we support and train teachers" зэрэг номыг уншиж орчуулсан.



**Зураг 7.19. Орчуулсан ном**



## 2. Видео бичлэг, онлайн шууд дамжуулалтын техник хэрэгсэл, холболт, дамжуулалт зэрэг бусад олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



### ЦАХИМ ТӨГСӨЛТ

#### ШУТИС-ИЙН ЗАХИРГААНААС ӨГСӨН ҮҮРЭГ

- Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн 2019-2020 оны хаврын улиралын төгсөлтийн арга хэмжээг онлайн-аар зохион байгуулахтай холбоотойгоор Сургалтын бодлого зохицуулалтын албаны захиалгаар, Оюутны хөгжлийн төвтэй хамтран 2 цаг 30 минутын арга хэмжээг онлайн-аар зохион байгуулсан.

- Уг арга хэмжээний бичлэгийг бэлтгэн найруулж, монтаж графикийг гүйцэтгэн ажилласан.

- Уг арга хэмжээ нь ШУТИС-ийн Facebook хуудсаар **159000** хүнд хүрсэн. Мөн Икон сайтаар дамжуулагдсан.

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, О.Гантулга, Ж.Өлзийхутаг,  
Э.Ариунболд, Б.Төгөлдөр, Б.Лхам-Эрдэнэ

2020.09.18-2020.09.21

### ASIAN REGIONAL MEETING 2020

#### ХУРАЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН

CDIO Asian regional meeting 2020 хурлыг онлайн-аар зохион байгуулах ажилд оролцсон. Уг ажлын хүрээнд хурлын видео, хэвлэмэл ажлуудыг бэлтгэн, техник, технологийн шийдлийг хариуцан ажилласан.

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, О.Гантулга, Ж.Өлзийхутаг,  
Э.Ариунболд, Б.Төгөлдөр, Б.Лхам-Эрдэнэ

2020.10.01-2020.10.05

### БОЛОВСРОЛЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ

#### ХУРАЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН

БШУЯ наас зохион байгуулсан "Боловсролын цахим шилжилт" үзэсгэлэн яармагт ШУТИС-ийг төлөөлөн оролцсон. Энэхүү арга хэмжээний хүрээнд "Шинжлэх ухааны музейн" видео контентуудыг бэлтгэх

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, О.Гантулга, Ж.Өлзийхутаг,  
Э.Ариунболд, Б.Төгөлдөр, Б.Лхам-Эрдэнэ



# ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ-1

## ХУРАЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН

ШУТИС 2030 стратеги төлөвлөгөөний хүрээнд "Хүний нөөцийг чадваржуулах сургалт" багц 3 сургалтыг зохион байгуулсан. Нийт оролцсон багшийн тоо 800 гаруй байжээ. Microsoft Teams-ээр 2 meet хуваан явуулсан. Энэхүү сургалтын хүрээнд ШУТИС-УТС ийн дизайны салбарын багш нарын бүрэлдэхүүнтэйгээр MUST safe хэлбэрээр Багш нарын дигитал хэрэглээ ба эвб болон апп суретай сургалтуудыг хэрээн бэлтгэж, дүнгийн ажиллах програм хангамжуудын талаар сургалт орсон. Мөн Microsoft Office 365-ын тухай сургалтуудыг хэсэгчилэн орсон.


Хариуцаж амжилтсан: Б.Мэндсайхан, О.Гантулга, Ж.Өлзийтулга, Э.Ариунболд, Б.Төгөлдөр, Б.Лхам-Эрдэнэ



# START UP WEEKEND ИННОВАЦИЙН 7 ХОНОГ

- Инновацийн долоо хоногийн Start Up Weekend үйл ажиллагааны сурталчилгаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, Ж.Бат-Эрдэнэ



# ВИДЕО КОНТЕНТ НЭЭЛТЭЙ БОЛОВСРОЛЫН ТӨВ

- Дигитал профессорын видео хичээл: Онлайн зайн сургалтын хичээл бэлтгэх ажлын хүрээнд Гадаад хэлний сургуулийн 5 лекцийн сэдвийг бичин монтаж рендер хийсэн
- Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо сургалтын видео дүрс болон бусад мэдээллийг архивлан "youtube/Open Education Center" суваг дээр байршуулсан
- Ууганбяр багшийн видео хичээлийг хийж гүйцэтгэж өгсөн
- Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо сургалтын видео дүрс болон бусад мэдээллийг архивлан "youtube/Open Education Center" суваг дээр байршуулсан

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, Ж.Өлзийтулга, Ж.Бат-Эрдэнэ, Э.Ариунболд



## ХУРАЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН

- ШУТИС-ийн оюутны "Эрдмийн ХХ чуулган"-ны хурал цахимаар зохион байгуулсан.
- ШУТИС-ийн МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЦАХИМААР зохион байгуулсан.
- ШУТИС-ийн ПРОФЕССОР, БАГШ, СУДЛААЧДЫН ЭРДМИЙН ЧУУЛГАН-2021 цахимаар зохион байгуулсан
- ШУТИС-ийн оюутны "Эрдмийн ХХ чуулган"-ны шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээ цахимаар зохион байгуулсан.

Хариуцаж ажилласан: О.Гантулга, Ж.Өлзийтуга, Ж.Бат-Эрдэнэ, Б.Төгөлдөр, Э.Ариунболд



## МАРКЕТИНГ ШУТИС ЭЛСЭЛТИЙН LIVE

- ШУТИС элсэлттэй холбоотой FB хөвгүүлэх ажлыг эхлүүлэн хүлээлгэн өгсөн.
- ШУТИС элсэлттэй холбоотой бүрэлдэхүүн сургуулийн захиралуудын видео LIVE хийж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, О.Гантулга, Ж.Өлзийтуга, Ж.Бат-Эрдэнэ, Э.Ариунболд, Б.Төгөлдөр



## ТАЙЛАНГИЙН ХУРАЛ СУРГУУЛИУДЫН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ

- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн тайлангуудын хурлыг 3 хоногийн хугацаанд зохион байгуулсан.
- Нийт 12 сургуулийн хурал.

Хариуцаж ажилласан: Б.Мэндсайхан, Б.Төгөлдөр









# НАЙМДУГААР БҮЛЭГ

---

САНХҮҮ НЯГТЛАН, БОДОХ БҮРТГЭЛ



## НАЙМ. САНХҮҮ, БҮРТГЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАЙР АШИГЛАЛТ

### 8.1 САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛБА

ШУТИС-ийн санхүү нягтлан бодох бүртгэлийн алба нь НББОУС, УСНББОУС, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Татварын ерөнхий хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын их хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудын тушаал, тогтоолын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж, зохион байгуулдаг. Мөн Монгол улсын хууль, олон улсын стандарт, төрийн захиргааны байгууллагуудын тушаал, тогтоолуудад нийцүүлэн боловсролын байгууллагын онцлогийг харгалзсан санхүү, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой батлагдсан өөрсдийн 40 гаруй дүрэм журам, тушаалыг мөрдөн ажилласан.

ШУТИС-ийн хэмжээнд тайлант хугацаанд 2007 үндсэн орон тоотой ажилласнаас гүйцэтгэх ажилтан 1210, үйлчилгээний ажилтан 422, гэрээт болон цагийн багш 369 хүн байна. 2020-2021 оны хичээлийн жилд нийт оюутны тоо: идэвхтэй сурч буй сонголт хийсэн бакалавр 11901, магистр 1444, доктор 153, нийт 13498 оюутан суралцагчид суралцаж байна. Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны хувьд албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, бүрэлдэхүүн нэгжүүдийн ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав зэрэг нийт 54 орон тоотой ажилласан. Эдгээрээс дээрх хүснэгтэд хамаарагдсан 19 бүрэлдэхүүн нэгжүүдийн ахлах нягтлан бодогч нар санхүүгийн жилд санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн санхүүгийн тайлан баланс гарган ажилласан байна.

#### ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн ахлах нягтлан бодогч нарын судалгаа

*Хүснэгт 8.1*

Д.д	Нэгж	Албан тушаал	Нэрс	Мэргэшсэн нягтлан бодогч цол авсан огноо
1	ШУТИС	Санхүүгийн албаны дарга	Д.Барсболд	2008
2	Барилга архитектурын сургууль	Ахлах нягтлан бодогч	С.Бямбаа	2016



3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Ахлах нягтлан бодогч	Д.Төмөрөө	
4	Бизнесийн ахисан түвшний сургууль	Ахлах нягтлан бодогч	Д.Ундрах	2017
5	Геологи, уул уурхайн сургууль	Ахлах нягтлан бодогч	Н.Буянжаргал	2020
6	Гадаад хэлний сургууль	Ахлах нягтлан бодогч	Д.Долгорсүрэн	
7	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	Ахлах нягтлан бодогч	Т.Баярмаа	
8	Механик тээврийн сургууль	Ахлах нягтлан бодогч	Г.Балжинням	2012
9	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Ахлах нягтлан бодогч	Г.Саранцэцэг	2011
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Ахлах нягтлан бодогч	Ч.Оюун	2002
11	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Ахлах нягтлан бодогч	С.Алтантуул	
12	Эрчим хүчний сургууль	Ахлах нягтлан бодогч	Ж.Мандах	2010
13	Нээлттэй боловсролын төв	Ахлах нягтлан бодогч	Б.Алтантуяа	2005
14	“ШУТИС-Коосэн” технологийн коллеж	Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхтуяа	2014
15	Ахлах сургууль	Ахлах нягтлан бодогч	М.Батпүрэв	
16	Эрдэм шинжилгээ инновацын газар	Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхцэнгэл	2016
17	ШУТИС-ийн төв номын сан	Ахлах нягтлан бодогч	Ш.Эрдэнэцэцэг	
18	Хэвлэх газар	Ахлах нягтлан бодогч	Ш.Эрдэнэцэцэг	
19	Захиргаа	Ахлах нягтлан бодогч	Б.Алтантуяа	2005
20	Ой мод судалгаа хөгжлийн хүрээлэн	Ахлах нягтлан бодогч	Г.Жавзанбурмаа	2015



2020 онд санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн программд нэмэлт өөрчлөлтийг оруулж, санхүүгийн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, Захирлын зөвлөлийн хурлаар батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх, санхүүгийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхааран ажиллалаа. 2020 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн 11 сургууль, Ахлах сургууль, “ШУТИС-Коосэн” ТК, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, Ой мод сургалт судалгааны хүрээлэн, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаан технологийн номын сан зэрэг нийт 20 нэгжүүд үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “И-Finance” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. 2020 оны санхүүгийн жилийн тайланд Үндэсний аудитын газар, “Амгалан ахуй аудит” аудитын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийсэн.

## **8.2 БАЛАНСЫН ҮР ДҮН**

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 138,546.7 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 2.6% буюу 3.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эргэлтийн хөрөнгө 22.1 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 77.9 хувийг эзэлж эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 1.0 хувиар буурсан байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 6.9 хувь, эзний өмч 93.1 хувийг тус тус эзэлж эзний өмчийн дүн нийт хөрөнгөд эзлэх хувь өнгөрсөн оноос 1.1 хувиар өсжээ. Балансын бүтцийн харьцуулалт:



**ШУТИС-ийн 2020 оны санхүүгийн тайлан балансын үзүүлэлтүүд,  
балансын шинжилгээ  
/сая төгрөгөөр/**

*Хүснэгт 8.2*


д/ д	Балансын зүйл	2019 он		2020 он		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	абсол ют	хувь
1	Мөнгө ба түүнтэй адил хөрөнгө	24,656.96	17.3%	23,762.11	17.2%	-894.85	-3.6%
2	Авлага	2,864.31	2.0%	4,207.93	3.0%	1,343.62	46.9%
3	Бараа материал	1,900.06	1.3%	1,907.88	1.4%	7.82	0.4%
4	Урьдчилж гарсан зардал	651.19	0.5%	752.52	0.5%	101.34	15.6%
	Эргэлтийн хөрөнгийн дүн	30,072.52	21.1%	30,630.45	22.1%	557.93	1.9%
1	Биет хөрөнгө	104,671.49	73.6%	100,460.37	72.5%	-4,211.12	-4.0%
2	Биет бус хөрөнгө	7,516.99	5.3%	7,455.96	5.4%	-61.03	-0.8%
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	112,188.48	78.9%	107,916.33	77.9%	-4,272.15	-3.8%
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>142,261.00</b>	<b>100%</b>	<b>138,546.77</b>	<b>100%</b>	<b>-3,714.22</b>	<b>-2.6%</b>
1	Богино хугацаат өр төлбөр	11,307.11	7.9%	9,442.48	6.8%	-1,864.63	-16.5%
2	Урт хугацаат өр төлбөр	61.41	0.0%	57.16	0.04%	-4.25	-6.9%
	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>11,368.52</b>	<b>8.0%</b>	<b>9,499.64</b>	<b>6.9%</b>	<b>-1,868.88</b>	<b>-16.4%</b>
1	Засгийн газрын сан	30,748.33	21.6%	30,341.48	21.9%	-406.84	-1.3%
2	Хуримтлагдсан үр дүн	39,033.80	27.4%	37,597.38	27.1%	-1,436.42	-3.7%
3	Хөрөнгө дахин үнэлгээний зөрүү	61,110.36	43.0%	61,108.28	44.1%	-2.08	0.0%
4	Эзний өмчийн дүн	130,892.48	92.0%	129,047.14	93.1%	-1,845.34	-1.4%
	<b>Өр төлбөр ба эзний өмч</b>	<b>142,261.00</b>	<b>100%</b>	<b>138,546.78</b>	<b>100%</b>	<b>-3,714.22</b>	<b>-2.6%</b>

Эргэлтийн хөрөнгө мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 0.9 тэрбум төгрөгөөр буурсан бол авлага 1.4 тэрбум төгрөгөөр, урьдчилж гарсан зардал 101.4 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй гарсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 17.2% буюу 894.8 сая төгрөгөөр буурч, авлага 3.0% буюу 1,3 тэрбум төгрөгөөр, урьдчилж гарсан зардал 0.5% буюу 101.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



Өр төлбөр ба эзний өмч нь богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, засгийн газрын сан, хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү зэргээс бүрдэж байна. Богино хугацаат өр төлбөр 1,8 тэрбум төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 4,2 сая төгрөгөөр, засгийн газрын сан 406,8 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 1,4 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 2 сая төгрөгөөр буурсан. Бүтцийн хувьд богино хугацаат өр төлбөр 6,8 хувь, урт хугацаат өр төлбөр 0,04 хувь, засгийн газрын сан 21,9 хувь, хуримтлагдсан үр дүн 27,1 хувь, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 44,1 хувийг эзэлж байна.

ШУТИС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлаар нийт хөрөнгийн болон өр төлбөрийн дүн өмнөх оноос 3,714.2 сая төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 4 банкны нийт 59 дансны үлдэгдэл хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буурсан байна. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 62,151.53 ам.долларын үлдэгдэлтэй байсан ба Монгол банкны 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн хаалтын ханш 2,849.51 төгрөгөөр ханшийн тэгшитгэл хийж төгрөгт хөрвүүлж тайланд тусгасан. Нийт авлага 4,207,928.0 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,343,617.3 мянган төгрөгөөр буюу 46.3 хувиар өссөн байна. Авлагын 2,854,223.8 мянган төгрөг буюу 67.8 хувь нь хувийн зардлаар суралцагч оюутнуудаас авах сургалтын төлбөрийн дутуу, сургалтын төлбөрийн суутгал, 744,722.7 мянган төгрөг буюу 17.7 хувь нь боловсролын зээлийн сангаас авах буцалтгүй тусламжаар суралцагчдын сургалтын төлбөрийн санхүүжилт, байгууллага, хувь хүнээс авах авлага 14.5 хувийг эзэлж байна.



**Зураг 8.1. ШУТИС-ийн 2020 оны балансын бүтэц**

ШУТИС-ийн захирлын 2020 оны 06-р сарын 29-ний өдрийн А/104, 12-р сарын 25-ны өдрийн А/206 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хооронд 331,258,916.00 төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн, данс бүртгэлд бүртгэж, тайланд тусгасан. Тайлант хугацаанд гадаад, дотоодын байгууллага, хувь хүн, төслийн хөрөнгөөр бий болсон 959,996.7 мянган төгрөгийн хандивын үндсэн хөрөнгийг бүртгэж, ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А-1/955 албан тоот, 07 дугаар сарын 06-ны өдрийн 357, 395 тоот тогтоол, 09 дүгээр сарын 22-ны өдрийн 462 тоот тогтоол, 10 дугаар сарын 08-ны өдрийн 495 тоот тогтоол, 11 дүгээр сарын 02-ны өдрийн А-1/1914 албан тоот дагуу 2,026,866,361.89 төгрөгийн үндсэн хөрөнгө актлахаас давхардсан болон үнийн дүн зөрүүтэй 694,386.35 төгрөгийг хасаж тооцооноор 2,026,171,975.54 төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасаж, санхүүгийн тайланд тусгасан.

Мөн ТӨБЗГ-ын 2020 оны 11-р сарын 03-ны өдрийн 549 тоот тогтоол, 12-р сарын 01-ний өдрийн А-1/2080 албан тоотын дагуу 75,404,277.46 төгрөгийн үндсэн хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасаж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Тайлант хугацааны эцэст байгууллага, хүмүүст 627,297.4 мянган төгрөгийн өглөгийн, 8,938,537.8 мянган төгрөгийн урьдчилж олсон орлого



(сургалтын болон оюутны байрны төлбөр, бусад төлбөр, төсөл, гэрээт ажлын)-ын үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат зээлийн 57,158.0 мянган төгрөгийн өглөг нь Төрийн өмчийн хорооны 2011 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн тогтоолын дагуу УБ Дулааны Сүлжээ ТӨХК-аас балансаас балансад шилжүүлэн бүртгэж авсан Халаалтын цогц төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр бөгөөд 2032 онд төлөгдөж дуусах гэрээтэй болно. Өмнөх үеийн үр дүнг найдваргүй авлагаар тооцож хассан авлага эргэн төлөгдсөн, зардал, авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгө, элэгдэл, урьдчилгааны залруулга, балансаас балансад шилжүүлсэн өр төлбөр, өмч, акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжсэн дүн зэргээр нийт 639,390,118.30 төгрөгөөр нэмэгдүүлж, үндсэн хөрөнгийн элэгдэл, авлага, сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлогын залруулга, балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн дүн зэргээр нийт 373,034,241.66 төгрөгөөр бууруулан бичилт хийсэн.

### **8.3 ОРЛОГО ҮР ДҮН**

ШУТИС-ийн сургуулийн бүрэлдэхүүний 11 сургууль, Ахлах сургууль, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, ОМССХ, ШУТТНС, НБТ, Хэвлэлийн газар, 2 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 20 нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэгддэг байна. ШУТИС-ийн бүрэлдэхүүн ШУТИС-ийн харьяа Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн орлого, зардлын төлөвлөгөө нь ШУТИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулдаг боловч санхүүгийн тайланг Шинжлэх ухаан технологийн санд нэгтгэдэг байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 111 тоот тогтоол, БСШУСЯамны сайдын 2020 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн А/207 тоот тушаал, Эрдэмнэт сүлжээний төвийн Удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолын дагуу тус төвийн хөрөнгө, өр төлбөр, өмчийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлж, хаалтын санхүүгийн тайлан гаргасан.

Санхүүгийн тайлант жилд Санхүү эрхэлсэн дэд захирлын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн албан тоот бичгээр ШУТИС-ийн 2020 оны төсөвт байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг сургууль нэгжүүд өөрсдөө хариуцах болсон тул үр ашиггүй цахилгаан, бохир, цэвэр усны зарцуулалтыг хязгаарлах, орой, шөнийн цагаар тогтмол зардлын зарцуулалтыг хянахыг аж





ахуй дарга, нэгжийн удирдлагуудад чиглэл болгосон. Мөн худалдан авалттай холбоотой ШУТИС-ийн 2020 оны хөрөнгө оруулалт, бараа ажил үйлчилгээ, урсгал засвар, худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдсан бүрэлдэхүүн нэгжүүдийн урсгал засварын зардал, аж ахуйн эд хогшлын зардлыг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн урсгал санхүүжилтийн үлдэгдэл, өөрсдийн бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхийг даалган мөрдөж ажилласан.

Мөн 2020 оны 03 дугаар сарын 02-ны, 2020 оны 05 дугаар сарын 12-ны, 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар ШУТИС-ийн хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөлтийн байдал санхүүгийн нөхцөл байдлыг хэлэлцэн Засгийн Газрын 62 тоот “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх” тухай тогтоолын дагуу 3 дугаар сарын 1-ээс 10 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд цалин болон байр ашиглалтын холбоотой зардлыг санхүүжүүлэх, бусад сургалттай холбоотой зардлыг зогсоох, хөрөнгө оруулалт худалдан авалтыг царцаах, нэн шаардлагатай худалдан авалтыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу зардал зарцуулалтыг зогсоон ажилласан.

2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар санхүүгийн нөхцөл байдлыг хэлэлцэн ШУТИС-ийн Голомт банкны хадгаламжид байрлаж буй 6.1 тэрбум төгрөгийг урсгал санхүүжилтийн данс уруу шилжүүлэн 6 сард багш ажиллагчдын цалин, амралтын санхүүжилтийг хийсэн байна.

Мөн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар ШУТИС-ийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хийгдсэн арга хэмжээний тайланг хэлэлцэн Засгийн Газрын 159 тоот “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах” тухай тогтоолын дагуу 11 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд цалин болон байр ашиглалтын холбоотой зардлыг санхүүжүүлэх, бусад сургалттай холбоотой зардлыг зогсоох, хөрөнгө оруулалт худалдан авалтыг царцаах, нэн шаардлагатай худалдан авалтыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэхийг даалгасан байна. ШУТИС-ийн орлого нь татаас, санхүүжилтийн орлого, бараа үйлчилгээний орлого гэж ангилагддаг. Орлогын дүнг төсвийн гүйцэтгэлийн (СТ-5А) тайлангаас авч, тайлант онд үүссэн дүнг төсөв болон гүйцэтгэлтэй харьцуулан тооцсон.



**ШУТИС-ийн 2020 оны орлого, үр дүнгийн тайлангийн орлогын үзүүлэлтүүд, балансын шинжилгээ /сая. төгрөгөөр/**

Хүснэгт 8.3

№	Орлого үр дүнгийн үзүүлэлтүүд	2019 он	Эзлэх хувь	2020 он	Эзлэх хувь	Өөрчлөлт
A.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	45,596.36	79%	43,101.89	87%	-5%
<b>I.</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>	<b>38,195.18</b>	<b>66%</b>	<b>38,008.99</b>	<b>77%</b>	<b>0%</b>
	Бакалаврын сургалтын төлбөрийн орлого	32,379.86	56%	31,898.55	65%	-1%
	Магистрын сургалтын төлбөрийн орлого	3,019.85	5%	3,264.54	7%	8%
	Докторын сургалтын төлбөрийн орлого	474.12	1%	522.67	1%	10%
	Бусад сургалтын төлбөрийн орлого /орой, эчнээ, ахлах, МСҮТ/	2,321.33	4%	2,323.20	5%	0%
<b>II.</b>	<b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого</b>	<b>7,401.17</b>	<b>13%</b>	<b>5,092.90</b>	<b>10%</b>	<b>-31%</b>
	Эрдэм шинжилгээ, судалгааны орлого	3,481.14	6%	2,620.76	5%	-25%
	Бусад ажил үйлчилгээний орлого /оюутны байр, түр сургалт, хэвлэх/	3,920.03	7%	2,472.13	5%	-37%
<b>B.</b>	<b>Санхүүжилтийн орлого</b>	<b>1,613.34</b>	<b>3%</b>	<b>3,517.31</b>	<b>7%</b>	<b>118%</b>
	Улсын төвлөрсөн төсвийн орлого /Засгийн газрын хөнгөлөлт	0	0%	2,291.92	5%	
	Орон нутгийн төсвийн санхүүжилт /Дархан лицей/	129.24	0%	128.74	0%	0%
	Бусад төсвийн санхүүжилтийн орлого /МСҮТ/	358.54	1%	418.33	1%	17%
	Төслийн санхүүжилтийн орлого /ШУТСан/	1,037.69	2%	678.30	1%	-35%
	ДБШТөслийн санхүүжилт	399.97	1%	369.85	1%	-8%
<b>C.</b>	<b>Бусад орлого</b>	<b>10,608.17</b>	<b>18%</b>	<b>2,665.32</b>	<b>5%</b>	<b>-75%</b>
	Хүүгийн орлого	1,640.36	3%	1,475.76	3%	-10%
	Хандив тусламжийн орлого	8,824.26	15%	1,111.45	2%	-87%
	Түрээсийн орлого	138.94	0%	78.10	0%	-44%
	Татварын бус орлого	4.59	0%	6.30	0%	37%
	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>57,817.88</b>	<b>100%</b>	<b>49,290.83</b>	<b>100%</b>	<b>-15%</b>

ШУТИС-ийн нийт орлогын хүрээнд бакалаврын сургалтын төлбөрийн орлого 65 хувийг, магистрын орлого 7 хувийг, докторын орлого 1 хувийг, орой эчнээ, ахлах болон МСҮТ-ийн сургалтын төлбөрийн орлого 5 хувийг, эрдэм шинжилгээний орлого 5 хувийг, оюутны байр, түр сургалтын орлого, хэвлэхийн орлого 5 хувийг, улсын төвлөрсөн төсвийн Засгийн газрын хөнгөлөлт 5 хувийг, бусад төсвийн санхүүжилтийн орлого, ШУТСангийн төсвийн санхүүжилт,



ДБШТ-ийн санхүүжилт тус бүр нэг хувийг, хүүгийн орлого 3 хувийг, хандив тусламж 2 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас оюутны байрны санхүүжилтэд 44,954.6, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамнаас МехТС, УТС-ийн ОМССХ-гийн мэргэжлийн анхан шатны сургалтад 418,334.5, орон нутгийн төсвөөс ДарТС, Ахлах сургуулийн лицей сургалтад 128,747.5, Дээд боловсролын шинэчлэл, Инженер, техникийн дээд боловсрол төслөөс 245,269.9, ШУТСангаас 130,846.8, БЗС-аас буцалтгүй тусламжийн санхүүжилт 235,038.3, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлгийн 2,738.9, оюутны хөгжлийн зээлийн 1,071,264.9 мянган төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.


“Нийгмийн даатгалаас чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн дагуу 2020 оны 4-9 сарын ажил олгогчийн төлөх 2,246,972,783.87 төгрөгийн чөлөөлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр Засгийн газрын хөнгөлөлт дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2020 онд 45,040.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 43,078.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тус тус олсон байна. Тус сургууль 2020 оны 43,078.4 сая төгрөгийн орлогоос 77.0 хувь буюу 38,008.9 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны орлого болох бакалавр, магистр, докторын зэрэг сургалтын төлбөр, 5 хувь буюу 2,620.76 сая төгрөг нь эрдэм шинжилгээний орлого, 5 хувь буюу 2,472.13 сая төгрөг нь туслах үйл ажиллагааны орлого, 7 хувь буюу 3,517.3 сая төгрөг нь санхүүжилтийн орлого тус тус эзэлж байна.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүд болох Бизнесийн ахисан түвшний сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Гадаад хэлний сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Ахлах сургууль, Захиргаа төсөвлөсөн үйл ажиллагааны орлогоо бүрэн хангуулан ажилласан бол Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Эрчим хүчний сургуулиуд нь орлого 100 хувь хангуулаагүй боловч 90 хувиас дээш үр дүнтэй ажилласан байна. Харин Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, Эрдэм шинжилгээ инновацийн газар, ШУТИС-ийн төв номын сан, Хэвлэх газар, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн зэрэг



нэгжүүд батлагдсан төсвийн орлогоо бүрдүүлэн ажиллаагүй, төсвөө тасалсан сөрөг үр дүнтэй ажилласан байна. Бүрэлдэхүүн нэгжүүдийн төсвийн орлогыг гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:



**Зураг 8.2. ШУТИС-ийн 2020 оны бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын төсөв, гүйцэтгэл**

ШУТИС-ийн үйл ажиллагааны орлогыг бүрэлдэхүүн нэгжүүдийн үйл ажиллагааны орлоготой харьцуулахад Барилга, архитектурын сургууль 15.7 хувийг, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль 6.9 хувийг, Бизнесийн ахисан түвшний сургууль 2.6 хувийг, Геологи, уул уурхайн сургууль 10.6 хувийг, Гадаад хэлний сургууль 1.4 хувийг, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль 7.4 хувийг, Механик тээврийн сургууль 10.3 хувийг, Мэдээлэл, холбооны технологийн сургууль 12.5 хувийг, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль 2.6 хувийг, Үйлдвэрлэлийн технологийн сургууль 8.9 хувийг, Эрчим хүчний сургууль 15.1 хувийг, Нээлттэй боловсролын төв 0,1 хувийг, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж 1,2 хувийг, Ахлах сургууль 1,3 хувийг, Эрдэм шинжилгээ инновацын газар 0,7 хувийг, ШУТИС-ийн төв номын сан 0,01



хувийг, Хэвлэх газар 0,6 хувийг, Захиргаа 1,8 хувийг, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн 0,3 хувийг тус тус эзэлж байна.

Бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчийг дүгнэдэг гол үзүүлэлт тул бүрэлдэхүүн сургуулиуд тус бүрээр орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

**ШУТИС-ийн 2020 оны орлогын төсөв, төсвийн гүйцэтгэл, бүрэлдэхүүн нэгжүүдээр /төгрөгөөр/**

*Хүснэгт 8.4*

№	Бүрэлдэхүүн нэгжүүд	Орлого төсөв	Гүйцэтгэл орлого	хувь
1	Барилга, архитектурын сургууль	5,806,398,700	5,796,638,263	99.8%
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	2,595,038,500	2,558,166,747	98.6%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	961,600,000	972,041,357	101.1%
4	Геологи, уул уурхайн сургууль	3,660,540,300	3,906,984,161	106.7%
5	Гадаад хэлний сургууль	440,007,500	523,074,825	118.9%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,691,369,500	2,757,409,206	102.5%
7	Механик тээврийн сургууль	3,651,607,310	3,818,706,709	104.6%
8	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	4,461,429,580	4,607,033,193	103.3%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	1,240,962,100	967,809,882	78.0%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	3,951,434,600	3,295,734,755	83.4%
11	Эрчим хүчний сургууль	5,627,315,900	5,571,611,488	99.0%
12	Нээлттэй боловсролын төв	57,000,000	23,411,299	41.1%
13	“ШУТИС-Коосэн” технологийн коллеж	570,000,000	453,626,787	79.6%
14	Ахлах сургууль	450,000,000	491,864,768	109.3%
15	Эрдэм шинжилгээ инновацийн газар	510,741,000	266,652,529	52.2%
16	ШУТИС-ийн төв номын сан	22,000,000	6,601,852	30.0%
17	Хэвлэх газар	478,000,000	210,503,463	44.0%
18	Захиргаа	523,000,000	652,347,231	124.7%
19	Ой мод судалгаа хөгжлийн хүрээлэн	283,800,000	101,376,192	35.7%

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 тоот тогтоолоор ШУТИС-ийн үйл ажиллагааны орлогыг 59.07 тэрбум төгрөгөөр, үйл ажиллагааны зарлагыг 59.069 тэрбум төгрөгөөр, санхүүгийн үр дүнг 128.5 мянган төгрөгийн эерэг үр дүнтэй байхаар баталсан. Дээрх батлагдсан зарлагын төсвөөс 2020 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн 19 нэгжийн хүрээнд 134 ширхэг худалдан авах ажиллагаа болох 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал, 751 сая төгрөгийн урсгал засварын зардал, 802 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал, 232 сая төгрөгийн аж ахуйн эд хогшлын



зардал нийт 2,7 тэрбум төгрөгийн худалдан авалтын зардлын төлөвлөгөө баталсан байна. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2020 оны төсвийн тодотголыг баталсан. Төсвийн тодотголоор ШУТИС-ийн үйл ажиллагааны орлогыг 1.1 тэрбум төгрөгөөр бууруулан 57.91 тэрбум төгрөгөөр, үйл ажиллагааны зарлагыг 1.3 тэрбум төгрөгөөр бууруулан 57.79 тэрбум төгрөгөөр баталсан. Харин ШУТИС-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 600 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,3 тэрбум төгрөгөөр баталсан. Энэхүү тодотгон батлагдсан зарлагын төсөвт ШУТИС-ийн бүрэлдэхүүн 20 нэгжийн хүрээнд 148 ширхэг худалдан авах ажиллагааг дурдан 1,504 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал, 645 сая төгрөгийн урсгал засварын зардал, 1,014 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал, 205 сая төгрөгийн аж ахуйн эд хогшлын зардлыг баталсан.

Мөн ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 14 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2020 оны төсвийн 2 дахь тодотголыг баталсан. ШУТИС-ийн орлогыг 100 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 58.02 тэрбум төгрөгөөр, зарлагыг 900 сая төгрөгөөр бууруулан 56.85 тэрбум төгрөгөөр баталсан. ШУТИС-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 100 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,4 тэрбум төгрөгөөр баталсан. Энэхүү тодотгон батлагдсан хоёр дахь зарлагын төсөвт ШУТИС-ийн бүрэлдэхүүн 20 нэгжийн хүрээнд 168 ширхэг худалдан авах ажиллагааг дурдан 1,237 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал, 726 сая төгрөгийн урсгал засварын зардал, 1,292 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал, 227 сая төгрөгийн аж ахуйн эд хогшлын зардал баталсан.

#### **8.4 ЗАРЛАГА, ҮР ДҮН**

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2020 онд 55,937.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зарлага зарцуулалт хийхээр төлөвлөснөөс 43,973.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зарлагын хэмнэлттэй зарцуулалт хийсэн байна. Тус сургуулийн зарлагын зарцуулалтын хувьд 2020 онд 30,195.6 сая төгрөгийн цалин болон үндсэн үйл ажиллагааны зардал, 3,814.8 сая төгрөгийн ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл, 16,282.7 сая төгрөгийн бараа, үйлчилгээний урсгал зардал тус тус эзэлж байна. Зардлын гүйцэтгэлийг авч үзэхэд: 2020 онд үндсэн үйл ажиллагааны зардал 51,102.5 сая төгрөгт хүрч



өмнөх оноос 15.4 хувиар буюу 7,4 тэрбум төгрөгөөр буурч гарсан байна. Нийт зардлын гүйцэтгэлийг хүснэгт 8.5.-д үзүүлэв.

**ШУТИС-ийн 2020 оны орлого, үр дүнгийн тайлангийн зарлагын  
үзүүлэлтүүд, балансын шинжилгээ /сая. төгрөгөөр/**

Хүснэгт 8.5

№	Орлого үр дүнгийн Тайлангийн үзүүлэлтүүд	2019 он	Эзлэх хувь	2020 он	Эзлэх хувь	Өөрчлөлт
A	УРСГАЛ ЗАРДАЛ	56,231.44	95%	51,000.86	100%	-9%
I	Бараа, ажил үйлчилгээний зардал	55,500.88	94%	50,293.28	98%	-9%
	<b>1 Үндсэн болон нэмэгдэл цалин</b>	<b>31,242.18</b>	<b>53%</b>	<b>30,195.64</b>	<b>59%</b>	<b>-3%</b>
	Үндсэн цалин	25,925.53	44%	25,163.67	49%	-3%
	Нэмэгдэл, илүү цагийн нэмэгдэл	5,316.65	9%	5,031.96	10%	-5%
	<b>2 Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>3,925.31</b>	<b>7%</b>	<b>3,814.87</b>	<b>7%</b>	<b>-3%</b>
	<b>3 Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>20,333.38</b>	<b>34%</b>	<b>16,282.76</b>	<b>32%</b>	<b>-20%</b>
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,407.30	2%	1,155.99	2%	-18%
	Гэрэл, цахилгаан	653.91	1%	503.56	1%	-23%
	Түлш, халаалт	512.08	1%	512.51	1%	0%
	Цэвэр, бохир ус	241.30	0%	139.91	0%	-42%
	Хангамж бараа материалын зардал /бичиг хэрэг, тээвэр, холбоо, .../	657.46	1%	441.68	1%	-33%
	Норматив зардал /эм, бэлдмэл, нормын хувцас, хоол хүнс	89.53	0%	104.39	0%	17%
	Эд хогшил, урсгал засварын зардал /тавилга, хөдөлмөр хамгаалал, .../	934.21	2%	589.41	1%	-37%
	Томилолт, зочны зардал	369.90	1%	65.79	0%	-82%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,805.38	5%	1,332.72	3%	-52%
	Бараа, үйлчилгээний бусад зардал	14,069.57	24%	12,592.75	25%	-10%
	Хичээл, үйлдвэрийн дадлага хийх /Хичээл практик, сургалт тон/төх/	1,516.74	3%	1,251.69	2%	-17%
	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	4,739.06	8%	3,322.88	7%	-30%
	Бусад /үйлдвэрлэл, үйлчилгээ, элэгдэл .../	7,813.75	13%	8,018.17	16%	3%
<b>II</b>	<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг</b>	<b>730.55</b>	<b>1%</b>	<b>707.57</b>	<b>1%</b>	<b>-3%</b>



Б	Бусад зардал ба алдагдал /найдваргүй авлага, гадаад валют/	2,787.24	5%	101.66	0%	-96%
	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГА</b>	<b>59,018.69</b>	<b>100%</b>	<b>51,102.53</b>	<b>100%</b>	<b>-13%</b>

ШУТИС-ийн үйл ажиллагааны зардлыг урсгал зардал, бусад зардал гэсэн хоёр бүлгийн хүрээнд авч үзлээ. 2020 онд урсгал зардал 51.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 5,2 тэрбум төгрөгөөр, бусад зардал 101.6 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2,6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Урсгал зардал бараа, ажил үйлчилгээний зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг гэсэн зардлуудаас, бараа ажил үйлчилгээний зардал нь үндсэн болон нэмэгдэл цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бараа үйлчилгээний урсгал зардал гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Эдгээрээс бараа, ажил үйлчилгээний зардал нь 50.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 5.3 тэрбум төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэгийн зардал 707.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 23 сая төгрөгөөр буурсан байна.

Зардлын зүйл ангиар авч үзэхэд үндсэн болон нэмэгдэл цалин 30.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,1 тэрбум төгрөгөөр, нэмэгдэл, илүү цагийн нэмэгдэл 5,0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 300 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 100 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний урсгал зардал 16,2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 4.1 тэрбум төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 1,1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 300 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 441 сая төгрөгт хүрч өмнөх оноос 200 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 589,4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 345 сая төгрөгөөр, томилолтын зардал 65,7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 300 орчим сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,5 тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 12,5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин өмнөх оноос өссөн ганцхан зардал байгаа нь норматив зардал буюу эм бэлдмэл, нормын хувцас, хоол хүнсний зардал 104.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 20 орчим сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт зардлын дэд төрлүүдээс харахад бүх зардлууд өмнөх оноос буурсан ба зардал зарцуулалтыг хязгаарлан зогсоон ажилласан байна. Харин эм бэлдмэл, ариутгалын бодис болох норматив зардал өмнөх оноос өссөн байна. Нийтлэг зарцуулалт хийсэн зардлуудаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил,





үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын дэлгэрэнгүй задаргааг хүснэгт 8.6-д үзүүлэв.

**ШУТИС-ийн 2020 оны орлого, үр дүнгийн тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын үзүүлэлтүүд, балансын шинжилгээ /төгрөгөөр/**

*Хүснэгт 8.6*


№	Орлого үр дүнгийн Тайлангийн үзүүлэлтүүд	2019 он	Эзлэх хувь	2020 он	Эзлэх хувь	Өөрчлөлт
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,805,385,808	100%	1,332,720,287	100%	-52%
1	Мэдээлэл, сурталчилгааны зардал	117,746,659	4%	109,102,388	8%	-7%
2	Багшийг дэмжих	277,465,031	10%	46,400,465	3%	-83%
3	Мэргэжил дээшлүүлэх	254,016,019	9%	27,265,851	2%	-89%
4	Багш, ажилтны арга хэмжээ	199,691,446	7%	100,956,479	8%	-49%
5	Харуул хамгаалалтын зардал	304,996,800	11%	373,259,000	28%	22%
6	Оюутны эрдэм шинжилгээ, судалгаа	135,298,621	5%	19,404,625	1%	-86%
7	Оюутны спорт, урлагийн арга хэмжээ	144,750,458	5%	27,747,169	2%	-81%
8	Оюутны тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулал	37,161,197	1%	84,137,201	6%	126%
9	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,514,309	4%	28,301,317	2%	-77%
10	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,272,115	1%	32,036,695	2%	-9%
11	Төлбөр, хураамж татвар	270,891,497	10%	187,331,497	14%	-31%
12	Гадаад, дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	272,626,846	10%	174,191,757	13%	-36%
13	Ахмадын арга хэмжээ	72,890,298	3%	53,563,336	4%	-27%
14	Ойн арга хэмжээ	373,899,903	13%	4,015,365	0%	-99%
15	Оюутны унаа	87,848,600	3%	0	0%	-100%
16	Магистр, докторант оюутны арга хэмжээ	15,661,426	1%	4,378,185	0%	-72%
17	Байгууллагын гишүүний татвар	22,845,361	1%	16,580,409	1%	-27%
18	Бусад /аудит, даатгал, банк санхүү, .../	61,809,222	2%	44,048,548	3%	-29%

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын зүйл нэгжээр эзэлж буй хувийн жинг авч үзвэл мэдээлэл сурталчилгааны зардал 109 сая төгрөгт хүрч 8 хувийг, багшийг дэмжих зардал 46.4 сая төгрөгт хүрч 3 хувийг, мэргэжил дээшлүүлэх зардал 27,2 сая төгрөгт хүрч 2 хувийг, багш ажилтны арга хэмжээний зардал 100,9 сая төгрөгт хүрч 8 хувийг, харуул хамгаалалтын зардал 373,2 сая төгрөгт хүрч 28 хувийг, оюутны



эрдэм шинжилгээ судалгааны зардал 19,4 сая төгрөгт хүрч 1 хувийг, оюутны спорт урлагийн арга хэмжээний зардал 27,7 сая төгрөгт хүрч 2 хувийг, оюутны тэтгэлэг хөнгөлөлт урамшууллын зардал 84,1 сая төгрөгт хүрч 6 хувийг, аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал 28,3 сая төгрөгт хүрч 2 хувийг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 32 сая төгрөгт хүрч 2 хувийг, төлбөр хураамж татвар 187,3 сая төгрөгт хүрч 14 хувийг, гадаад дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зардал 174,1 сая төгрөгт хүрч 13 хувийг, ахмадын арга хэмжээний зардал 53,5 сая төгрөгт хүрч 4 хувийг, байгууллагын гишүүний татварын зардал 16,5 сая төгрөгт хүрч 1 хувийг тус тус эзэлж байна.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүд болох Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Гадаад хэлний сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, Ахлах сургууль, ШУТИС-ийн төв номын сан, Хэвлэх газар, Захиргаа нь төсөвлөсөн үйл ажиллагааны зарлага 50 ба түүнээс дээш хувиар зарцуулалт хийсэн байна. Харин Эрдэм шинжилгээ инновацын газар, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн зэрэг нэгжүүд батлагдсан төсвийн зарцуулалтаа 50 ба түүнээс доош хувиар зарцуулалт хийсэн байна. Бүрэлдэхүүн нэгжүүдийн төсвийн зарлага, зарцуулалтын гүйцэтгэлтэй нь харьцуулсан байдлыг зураг 8.3.-д үзүүлэв



**Зураг 8.3. ШУТИС-ийн 2020 оны бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын төсөв, гүйцэтгэл**

ШУТИС-ийн үйл ажиллагааны зарлагыг бүрэлдэхүүн нэгжүүдийн үйл ажиллагааны зарцуулалтай харьцуулахад Барилга, архитектурын сургууль 10.5 хувийг, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль 7.9 хувийг, Бизнесийн ахисан түвшний сургууль 1.8 хувийг, Геологи, уул уурхайн сургууль 9.2 хувийг, Гадаад хэлний сургууль 5.0 хувийг, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль 6.1 хувийг, Механик тээврийн сургууль 8.3 хувийг, Мэдээлэл, холбооны технологийн сургууль 8.5 хувийг, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль 7.3 хувийг, Үйлдвэрлэлийн технологийн сургууль 9.1 хувийг, Эрчим хүчний сургууль 7.4 хувийг, Нээлттэй боловсролын төв 1,7 хувийг, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж 1,1 хувийг, Ахлах сургууль 1,0 хувийг, Эрдэм шинжилгээ инновацын газар 0,5 хувийг, ШУТИС-ийн төв номын сан 1,5 хувийг, Хэвлэх газар 0,6 хувийг, Захиргаа 12,0 хувийг, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн 0,4 хувийг тус тус эзэлж байна.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн 2020 оны батлагдсан зарлагын төсөв, гүйцэтгэлийг авч үзэхэд зардал зарцуулалтаа хэтрүүлсэн бүрэлдэхүүн нэгжүүд байхгүй байна. Бүрэлдэхүүн нэгжүүдээс хамгийн өндөр гүйцэтгэлтэй



нь ШУТИС-ийн төв номын сан 90 хувийн, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулиуд 85 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Харин бүрэлдэхүүн нэгжүүдээс хамгийн бага гүйцэтгэлтэй нь ШУТИС-ийн эрдэм шинжилгээ инновацийн газар 39 хувийн, хэвлэх газар 51 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Бүрэлдэхүүн нэгжүүдийн зарлагын төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчийг дүгнэдэг гол үзүүлэлт тул бүрэлдэхүүн сургуулиуд тус бүрээр зарлагын төсөв, гүйцэтгэлийг хүснэгт 8.7-д үзүүлэв.

**ШУТИС-ийн 2020 оны зарлагын төсөв, төсвийн гүйцэтгэл, бүрэлдэхүүн нэгжүүдээр /төгрөгөөр/**

*Хүснэгт 8.7*

Д.д	Бүрэлдэхүүн нэгжүүд	Зарлага /төсөв/	Зарлага /гүйцэтгэл/	хувь
1	Барилга, архитектурын сургууль	5,597,760,500	4,600,773,742	82%
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	4,060,649,800	3,470,370,449	85%
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	1,079,210,100	793,527,762	74%
4	Геологи, уул уурхайн сургууль	5,045,933,600	4,045,694,961	80%
5	Гадаад хэлний сургууль	2,860,826,200	2,188,244,935	76%
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	3,447,439,330	2,689,431,529	78%
7	Механик тээврийн сургууль	4,742,090,800	3,621,447,849	76%
8	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	4,848,737,295	3,705,612,442	76%
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	3,764,060,600	3,194,483,676	85%
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	5,484,664,400	3,980,275,348	73%
11	Эрчим хүчний сургууль	4,002,595,200	3,241,610,777	81%
12	Нээлттэй боловсролын төв	1,172,699,400	750,930,920	64%
13	“ШУТИС-Коосэн” технологийн коллеж	589,308,000	480,162,032	81%
14	Ахлах сургууль	646,034,300	426,843,882	66%
15	Эрдэм шинжилгээ инновацийн газар	559,621,000	218,140,319	39%
16	ШУТИС-ийн төв номын сан	733,138,000	659,946,870	90%
17	Хэвлэх газар	524,554,700	267,956,504	51%
18	Захиргаа	6,382,229,500	5,251,393,697	82%
19	Ой мод судалгаа хөгжлийн хүрээлэн	382,183,400	184,661,679	48%

Зардлыг нийт дүнгээрээ хэмнэлттэй зарцуулсан ба 2020 онд Барилга, архитектурын сургууль 4,6 тэрбум төгрөгт хүрч 82 хувийн гүйцэтгэлтэй, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль 3,4 тэрбум төгрөгт хүрч 85 хувийн гүйцэтгэлтэй, Бизнесийн ахисан түвшний сургууль 793 сая төгрөгт хүрч 74 хувийн гүйцэтгэлтэй, Геологи, уул уурхайн сургууль 4,0 тэрбум төгрөгт хүрч



80 хувийн гүйцэтгэлтэй, Гадаад хэлний сургууль 2,1 тэрбум төгрөгт хүрч 76 хувийн гүйцэтгэлтэй, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль 2,6 тэрбум төгрөгт хүрч 78 хувийн гүйцэтгэлтэй, Механик тээврийн сургууль 3,6 тэрбум төгрөгт хүрч 76 хувийн гүйцэтгэлтэй, Мэдээлэл, холбооны технологийн сургууль 3,7 тэрбум төгрөгт хүрч 76 хувийн гүйцэтгэлтэй, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль 3,1 тэрбум төгрөгт хүрч 85 хувийн гүйцэтгэлтэй, Үйлдвэрлэлийн технологийн сургууль 3,9 тэрбум төгрөгт хүрч 73 хувийн гүйцэтгэлтэй, Эрчим хүчний сургууль 3,2 тэрбум төгрөгт хүрч 81 хувийн гүйцэтгэлтэй, Нээлттэй боловсролын төв 750 сая төгрөгт хүрч 64 хувийн гүйцэтгэлтэй, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж 480 сая төгрөгт хүрч 81 хувийн гүйцэтгэлтэй, Ахлах сургууль 426 сая төгрөгт хүрч 66 хувийн гүйцэтгэлтэй, Эрдэм шинжилгээ инновацын газар 218 сая төгрөгт хүрч 39 хувийн гүйцэтгэлтэй, ШУТИС-ийн төв номын сан 659 сая төгрөгт хүрч 90 хувийн гүйцэтгэлтэй, хэвлэх газар 267 сая төгрөгт хүрч 51 хувийн гүйцэтгэлтэй, захиргаа 5,2 тэрбум төгрөгт хүрч 82 хувийн гүйцэтгэлтэй, ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн 184 сая төгрөгт хүрч 48 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

## 8.5. САНХҮҮГИЙН ҮР ДҮН


ШУТИС-ийн бүрэлдэхүүн Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Гадаад хэлний сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, Ахлах сургууль, Эрдэм шинжилгээ инновацын газар, ШУТИС-ийн төв номын сан, Хэвлэх газар, Захиргаа, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн гэсэн нэгжүүдийн тайланг нэгтгэн нэгдсэн тайлан баланс гарсан. Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн хооронд үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн 487,768,243.00 төгрөгийн нэмэгдсэн, хасагдсан бичилтүүд хийгдсэн. Сургууль хоорондын тооцооны орлого, зарлага, өглөг, авлагыг бүрэлдэхүүн сургууль, нэгж бүрийн санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тусгасан. Сургууль хоорондын тооцооны дараах гүйлгээг устгах бичилт хийж, нэгтгэсэн тайланг гаргасан. Үүнд:

- Авлага, өглөгийн эхний үлдэгдэл 146,427,919.43 төгрөг, эцсийн үлдэгдэл 243,298,324.07 төгрөг (эхний үлдэгдлээс сургууль хоорондын



- тооцооны 1,361,302.48 оюутны хөгжлийн зээлийн эрсдэлийн 5% 145,066,616.95, эцсийн үлдэгдлээс сургууль хоорондын тооцооны 46,733,760.37 оюутны хөгжлийн зээл, эрсдэлийн 5% 196,564,563.70)
- Үндсэн хөрөнгө анхны өртгөөр 331,258,916.00 төгрөг, хуримтлагдсан элэгдэл 206,016,247.05 төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 125,242,668.95 төгрөг (Засгийн газрын хувь оролцоо данс)
  - Дахин үнэлгээний нөөц данс 487,768,243.00 (Сургууль хооронд шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр)
  - Бараа материал бэлтгэх урьдчилгаа, бусад урьдчилгаа, төсөл, гэрээт ажлын зардлын урьдчилгаа, бусад төлбөрийн урьдчилж орсон орлогын эхний үлдэгдлээс 14,418,000.00 төгрөг, эцсийн үлдэгдлээс 11,580,500.00 төгрөг (ҮТС, ХШУС, Хэвлэлийн газар)
  - Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого, зардал сургууль хоорондын тооцооны 71,907,361,770.59 төгрөг, Хэвлэлийн газрын 41,444,945.00 төгрөг
  - Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, зардал сургууль хоорондын 71,908,723,073.07 төгрөг, Хэвлэлийн газрын 73,759,745.00 төгрөг

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн хувьд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Барилга, архитектурын сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Ахлах сургууль, Эрдэм шинжилгээ инновацийн газар эерэг буюу орлого зардлын харьцаа хэвийн гарсан бол Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Гадаад хэлний сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ий төв номын сан, Хэвлэх газар, Захиргаа, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн нь хасах үр дүнтэй буюу орлого зарлагын харьцаа алдагдсан байна. Бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүүгийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг харьцуулан харуулбал:



**Зураг 8.4. ШУТИС-ийн 2020 оны бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэл (төг)**

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн хувьд орлого үр дүнгийн тайлангаар Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Гадаад хэлний сургууль, Механик тээврийн сургууль, Эрчим хүчний сургууль, Нээлттэй боловсролын төв, Ахлах сургууль, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн санхүүгийн үр дүнгийн хувьд эерэг гарсан бол Барилга, архитектурын сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Мэдээлэл холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, Эрдэм шинжилгээ инновацын газар, ШУТИС-ий төв номын сан, Хэвлэх газар, Захиргаа нь санхүүгийн үр дүн буюу үйл ажиллагааны орлого нь зарлагаа нөхөж чадаагүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

**ШУТИС-ийн 2020 оны үр дүнгийн үзүүлэлтүүд, бүрэлдэхүүн нэгжүүдээр /төгрөгөөр/**

Хүснэгт 8.8

Д.д	Бүрэлдэхүүн нэгжүүд	Үр дүн		
		Орлогын тайлан/	/Мөнгөн тайлан/	/Төсвийн тайлан/
1	Барилга, архитектурын сургууль	- 86,759,237	- 25,953,832	1,195,864,522
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	335,405,657	114,696,656	- 912,203,702
3	Бизнесийн ахисан түвшний сургууль	150,839,132	- 20,884,569	178,513,595



4	Геологи, уул уурхайн сургууль	- 101,722,328	284,036,263	- 138,710,799
5	Гадаад хэлний сургууль	151,068,950	70,700,587	1,665,170,110
6	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	- 279,124,191	25,353,610	67,977,677
7	Механик тээврийн сургууль	303,614,254	431,565,740	197,258,860
8	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	- 126,107,136	- 138,606,510	901,420,751
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	- 15,968,188	- 14,899,984	2,226,673,794
10	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	- 35,024,793	38,832,751	- 684,540,593
11	Эрчим хүчний сургууль	47,756,773	45,166,025	2,330,000,711
12	Нээлттэй боловсролын төв	320,885,889	- 72,663,988	- 727,519,621
13	“ШУТИС-Коосэн” технологийн коллеж	- 697,161,579	- 13,769,120	- 26,535,245
14	Ахлах сургууль	158,343,121	165,248,875	65,020,886
15	Эрдэм шинжилгээ инновацын газар	- 135,097,568	56,887,210	48,512,210
16	ШУТИС-ийн төв номын сан	- 50,190,978	- 281,419	653,345,019
17	Хэвлэх газар	- 140,082,942	- 57,453,041	- 57,453,041
18	Захиргаа	- 356,031,385	96,892,422	- 4,599,046,466
19	Ой мод судалгаа хөгжлийн хүрээлэн	889,414	- 12,894,327	- 83,285,487

ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн хувьд мөнгөн гүйлгээний үр дүнгийн тайлангаар Бизнесийн, удирдлага хүмүүнлэгийн сургууль, Гадаад хэлний сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик тээврийн сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Ахлах сургууль, Эрдэм шинжилгээ инновацын газар, Захиргаа мөнгөн гүйлгээний орлого зарлагын хувьд эерэг гарсан бол Барилга, архитектурын сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Мэдээлэл холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ийн төв номын сан, Хэвлэх газар, Ой модны судалгаа хөгжлийн хүрээлэн нь мөнгөн гүйлгээний орлого зарлагын хувьд хасах буюу өөрт байгаа мөнгөн хөрөнгөөр зарлага зарцуулалт гаргах боломжгүй болсон байгааг харж болно.





**ШУТИС-ийн 2020 оны үр дүнгийн үзүүлэлтүүд**  
**/сая.төгрөгөөр/**

Хүснэгт 8.9

<b>ШУТИС САНХҮҮГИЙН ҮР ДҮН, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГААР</b>				
<b>№</b>	<b>Орлого үр дүнгийн үзүүлэлтүүд</b>	<b>2019 он</b>	<b>2020 он</b>	
I	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	57,817.88	49,290.83	
II	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГА	59,018.69	51,102.53	
III	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-1,200,81	-1,939,62	
<b>ШУТИС ҮР ДҮН, МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГААР</b>				
<b>№</b>	<b>Орлого үр дүнгийн үзүүлэлтүүд</b>	<b>2019 он</b>	<b>2020 он</b>	
I	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	61,716.79	48,154.24	
II	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	62,245.86	46,774.22	
III	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-529,07	1,380,02	
<b>ШУТИС ҮР ДҮН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ТАЙЛАНГААР</b>				
<b>№</b>	<b>Орлого үр дүнгийн үзүүлэлтүүд</b>	<b>төсөв</b>	<b>гүйцэтгэл</b>	<b>хувь</b>
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	45,683.32	43,078.46	94.3 %
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРЛАГА	55,937.74	43,973.22	78.6 %
III	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-10,254.42	-894,76	

ШУТИС-ийн санхүүгийн орлого үр дүнгийн тайлангаар санхүүгийн үр дүнг тооцон гаргасан. 2019 онд үндсэн үйл ажиллагааны орлого 57,8 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны зарлага 59,0 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн 1,2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлого 49,2 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны зарлага 51,1 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн 1,9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Энэ нь өмнөх оноос 700 сая төгрөгөөр алдагдал нэмэгдсэн байна. ШУТИС-ийн мөнгөн гүйлгээний тайлангаар санхүүгийн үр дүнг тооцон гаргасан. 2019 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 61,7 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага 62,2 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн 529 сая төгрөгийн алдагдалтай гарсан. 2020 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 48,1 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага 46,7 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн 1,38 тэрбум төгрөгийн эерэг үлдэгдэлтэй гарсан. Энэ нь өмнөх оноос 1,8 тэрбум төгрөгийн өөрчлөлттэйгөөр алдагдлыг эерэг үр дүнтэй болж гарсан байна.

ШУТИС-ийн төсвийн гүйцэтгэлээр тайлангаар санхүүгийн үр дүнг тооцон гаргасан. 2019 онд үйл ажиллагааны мөнгөн орлого 45,6 тэрбум төгрөг, үйл ажиллагааны нийт зарлага 55,9 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн -10,2 тэрбум төгрөгийн төсвийн алдагдалтай гарсан. 2020 онд үйл ажиллагааны мөнгөн орлого 43,0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны нийт



зарлага 43,9 тэрбум төгрөгт хүрч үндсэн үйл ажиллагааны үр дүн 894 сая төгрөгийн алдагдалтай гарсан. Энэ нь өмнөх оноос төсвийн алдагдлын дүн 10,4 тэрбум төгрөгөөс алдагдлыг бууруулсан байна.

## 8.6. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН АУДИТЫН ҮР ДҮН

ШУТИС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн САГ-2021/79/СТА-ТӨҮГ код бүхий аудитын тайланг Үндэсний аудитын газраас 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу ШУТИС-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлагналын аудит хийгдэж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн. Санхүү нягтлан бодох бүртгэлийн албанаас 2020 оны ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу 2021 оны 2 дугаар сарын 04-нд ҮАГ/АА202017 тоот гэрээ байгуулан ҮАГ болон Амгалан ахуй аудит ХХК-нд санхүүгийн тайлангаа хүргүүлсэн. Аудитын байгууллагаас НББОУС, СТОУС, УСНББОУС, АОУС, АДБОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Аудитын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын үйл ажиллагаатай холбоотой алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулсан. Тухайлбал түр сургалтын орлого 123,4 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэснийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгүүлэх, үндсэн хөрөнгийн 5.1 сая төгрөгийг зардлаар бүртгүүлэх, эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй 53.5 сая төгрөгийг залруулах тус тус залруулга хийсэн.

Зөрчлүүд: Төлбөрийн акт, албан шаардлага

- ҮАГ-ын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 337/АО170083 САГ 2021/78/СТА-ТӨҮГ тоот зөрчил арилгах тухай албан шаардлагыг гарган өгсөн. Албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн шалгалтын хүрээнд ШУТИС нь байгууллагаас авах нийт 57,790,198 төгрөгийг авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй зөрчлийг гаргасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж,



байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” ... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах“ гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тиймээс авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулах

- ҮАГ-ын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 338/АО170083 САГ 2021/78/СТА-ТӨҮГ тоот зөрчил арилгах тухай албан шаардлагыг гарган өгсөн. Албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн шалгалтын хүрээнд ШУТИС нь байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 526 мэдээлэл байрлуулахаас 59 мэдээллийг хугацаа хоцроож байршуулаагүй зөрчлийг гаргасан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тиймээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх

- ҮАГ-ын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 339/АО170083 САГ 2021/78/СТА-ТӨҮГ тоот зөрчил арилгах тухай албан шаардлагыг гарган өгсөн. Албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн шалгалтын хүрээнд ШУТИС нь Бест буйдан ХХК-тай 2020 оны 02 сарын 21-ний өдөр “Нанотехнологиор материал боловсруулах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд хамтран ажиллах” гэрээ байгуулж, тус гэрээний дагуу авах тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөр нийт 25 сая төгрөгийг санхүүгийн бүртгэлд тусгаагүй зөрчлийг гаргасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус



хэрэгжүүлээгүй байна. Тиймээс гэрээний дагуу тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрийг санхүүгийн бүртгэлд тусгаж, гэрээнд тодотгол хийж, зөрчлийг арилгуулах

Дээрх албан шаардлагуудыг Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны өдрийн А95 дугаар тушаалаар баталсан, “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг ШУТИС-ийн захирал, санхүүгийн албаны дарга нарт хариуцуулсан байна.

Зөвлөмжүүд: ҮАГ-ын санхүүгийн тайлагналын аудитын хүрээнд менежментийн захидлыг хүргүүлсэн. Уг захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн зөвлөмж хэлбэрээр хүргүүлсэн байна. Үүнд:

- Балансын данстай холбоотойгоор ШУТИС-ийн 19 бүрэлдэхүүн нэгжүүдийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11677 ширхэг хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь үнэлээгүй байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэхүү асуудал нь хараат бус байдал алдагдах, мэргэжлийн бус шийдэл гаргах, дотоод хяналт сулрах, хуулийн хэрэгжилтийг хангуулахгүй байх эрсдэл учирсаар байна. Тиймээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр үнэлэх, ашиглагдах жилийг шинэчлэх талаар санал боловсруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй.



- Дотоод хяналттай холбоотойгоор ШУТИС-ийн 9070002100 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэж бүтгэгдсэн байгаа бөгөөд тус сургуулийн санхүүгийн тайлан, төсөв нь ТӨҮГ-ын статуст тохирохгүй байна. Жишээ нь: Удирдах зөвлөлөөс баталсан төсөв нь мөнгөн сууриар хийгдсэн нь ТӨҮГ-ын санхүүгийн төсөв, төлөвлөлттэй уялдаагүй байна. Иймд төсөв төлөвлөгөө үндэслэлгүй боловсруулагдан, санхүүгийн үр дүнгийн тайлан, шинжилгээний мэдээлэл уялдаагүй байх эрсдэл үүсэх байна. Тиймээс сургуулийн статусын асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай.

- Балансын данстай холбоотойгоор санхүүгийн тайланд олон жилийн насжилттай 188.4 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-д заасан “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуул” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд авлага найдваргүй болох, залилан, ашиглан гаргах эрсдэлтэй байна. Тиймээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, тооцоо нийлсэн актыг ажил гүйлгээ гарахаас өмнө баталгаажуулах. Мөн насжилт өндөртэй авлагыг барагдуулах журам гаргах хэрэгтэй байна.

Мөн зөвлөмжүүдээс гадна дараах анхаарах асуудлыг оруулж өгсөн байна. Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, хөрөнгийн биет тооллого хийх, хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарч дараагийн аудитаар авлага, бараа материал, үндсэн хөрөнгийг тусгайлан авч үзэх нь зүйтэй хэмээн үзсэн. Арилжааны банкныг сонгон шалгаруулахдаа Монгол банкнаас гаргасан зохистой шаардлага шалгуурыг хангасан банканд данстай байж, үйлчилгээг авах шаардлагатай. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 101/ШШ2016/03558 шийдвэрээр 109305100 төгрөгийг гаргуулах шийдвэр хэрэгжээгүй, харилцагчийн тооцоогоор дамжуулаагүй ашиглалтын зардлын бүх



гүйлгээг мөнгөн сууриар бүртгэсэн, авлагын өмнөх үлдэгдэл хуримтлагдсан, дэлхий нийтийг хамарсан цар тахал, боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжаар санхүүжилт орж ирээгүйгээс авлага өссөн, арилжааны банканд хадгаламжтай, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг БШУЯ гаргахаар ажлын хэсэг ажиллаж одоогоор мөрдөөгүй байгаа зэрэг асуудлууд байна.

## **8.7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖИЙН ТАЛААР**

ШУТИС-ийн Хөрөнгө оруулалт, хангамж, байр ашиглалтын чиглэлээр холбогдох хууль, журам, дүрмийн хүрээнд дараах чиг үүргийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- I. ШУТИС-ийн төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн батлуулах, батлагдсан төсвийг хуваарилах, төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих*
- II. ШУТИС-ийн хэмжээнд худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцыг хянан шалгаж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах*
- III. Өмч хөрөнгийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах*
- IV. Сургалтын төлбөрийн болон бусад авлагыг барагдуулах үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд явуулах.*
- V. Хичээлийн болон оюутны байрны орчин, инженерийн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, Төрийн өмч хөрөнгийг түрээслэх түрээслүүлэгчийг сонгон шалгаруулах, гэрээний биелэлтийг хангуулах.*

2021 оны төсвийн төсөөлөл, 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах төсөл арга хэмжээний санал болон урсгал зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээнд холбогдох маягтын дагуу санал боловсруулан илгээсэн.

ШУТИС-ийн хэмжээнд 2021 онд нийт 3,9 тэрбум төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөөг удирдах зөвлөлөөр батлуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвлөлөөр оруулан хянуулж, хөрөнгө олж авах, худалдан авалт хийх зөвшөөрөл бүхий тогтоолыг батлуулсан.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 17-ны өдрийн 16 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2020 оны 12 сарын 28-ны өдрийн 724 тоот



тогтоолуудаар батлагдсан 2021 оны төлөвлөгөөг Худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яамаар батлуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийн хүрээнд цахим худалдан авалтын системээр зарлагдах нийт 54 нэр төрлийн хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээг зохион байгуулан ажиллав.

**2020-2021 оны хичээлийн жилд хийгдсэн хөрөнгө оруулалт  
(сая.төг)**

*Хүснэгт 8.10*

Үзүүлэлт	2020-2021 он
Өөрийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө	2,274.9

Томоохон хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авалтаас дурдвал:

- Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн дизайны салбарт сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ШУТИС/202101110 тоот 60 сая төгрөгийн,
- МТТөвийн дата центр тоног төхөөрөмж худалдан авах ШУТИС/202101065 тоот 125,9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан.

**Тоног төхөөрөмжийн худалдан авалт**

2021 онд нийт 660,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдэхээр төсөвт тусгагдсан.

Томоохон тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тоочвол:

- ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн виртуал лабораторид тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ШУТИС/202101070 тоот 43,4 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан.
- Геологи, уул уурхайн сургуульд дадлагын виртуал тоног төхөөрөмж, Барилга Архитектур сургуульд Жэрэс төслийн хөрөнгөөр сургалтын төхөөрөмж, техник хэрэгсэл, Инженерийн Ахисан Түвшний сургуулийн Европын холбооны төслийн хүрээнд сургалтад зориулан нээлттэй лабораторийг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, Эрчим хүчний сургуульд сургалтын тоног төхөөрөмж, Ухаалаг ногоон их сургуулийн дэд бүтцийн төслийн төсвөөс “Эрчим хүчний хэмнэлт” төслийн цахилгааны хэрэглээний зардлыг бууруулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг



нийлүүлэх, бүрэлдэхүүн сургуулиудын хооронд татагдсан шилэн кабелийг сувагчлалаас чөлөөлөх зэрэг ажлуудыг холбогдох хууль дүрэм журмын хүрээнд зохион байгууллаа.

### **8.7.1. АЖ АХУЙ, ЭД ХОГШЛЫН ХУДАЛДАН АВАЛТ**

2021 онд нийт 243.8 сая төгрөгийн аж ахуйн эд хогшил худалдан авахаар төсөвт тусгагдсан. Зарим худалдан авалтыг цар тахлын нөхцөл байдлаас хамааран хойшлуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2020 онд 8 буюу засварын ажлын нийт 56-н тендерийг зохион байгуулан, холбогдох баримт бичгийг электрон хэлбэрт шилжүүлэн архивласан байна. Төсөв боловсруулалтын хүрээнд:

- Бүрэлдэхүүн сургуулиудын хүсэлтээр ирүүлсэн төсвийг газар дээр нь очиж хэмжилт хийн тоо хэмжээг хянан, төсвийн мэргэжилтэн тусгагдсан материалын үнэ, ажилбар, норм дүрмийн дагуу бодогдсон эсэхэд хяналт хийн баталгаажуулдаг.
- ШУТИС-ийн дараагийн жилийн хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд бүрэлдэхүүн сургуулиудын засвар тохижилтын ажлын хүсэлтийг үндэслэн газар дээр нь төсвийн мэргэжилтэн, барилгын хөрөнгө оруулалтын инженер болон БАНА-ны холбогдох инженерүүд хамтарсан үзлэг хийн, зайлшгүй засвар шаардлагатай эсэх, мөн зайлшгүй засах шаардлагатайг байр ашиглалтын менежерүүд, анги танхим хариуцсан багш нартай зөвшилдсөний үндсэн дээр хэмжилт хийн, урьдчилсан төсвийн тооцоог гарган тусгадаг.
- ШУТИС-ийн тухайн жилийн батлагдсан хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу газар дээр барилгын хөрөнгө оруулалтын инженер, төсвийн мэргэжилтэн нар шаардлагатай холбогдох инженерүүдийн хамт хэмжилт хийн ажлын тоо хэмжээг боловсруулан, хяналтын төсвийг боловсруулдаг.
- Бүрэлдэхүүн сургуулиудын хүсэлтийн дагуу байр ашиглалтын болон эдийн засгийн хувьд хэмнэлттэй гэсэн үндэслэлээр ажилчдынхаа дотоод нөөц бололцоог ашиглан, засвар тохижилтын ажлыг аж ахуйн аргаар гүйцэтгэхээр төсвийг боловсруулдаг.





**Хянасан төсөв**  
(сая.төг)

Хүснэгт 8.10

д/д	Хамрах он	Төсвийн тоо	Анхны төсөвт өртөг	Хянасан төсөв өртөг	Зөрүү дүн
1	2020	5	10,122.5	9,284.2	838.3
2	2021 эхний хагас жил	3	15,2	10,1	5,1
	<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>10,137.7</b>	<b>9,294.3</b>	<b>843.4</b>

**Аж ахуйн болон хяналтын боловсруулсан төсөв /сая.төг/**

Хүснэгт 8.11

д/д	Хамрах он	Хяналтын төсөв /ш/	Төсөвт өртөг/төг/	Аж ахуйн төсөв /ш/	Төсөвт өртөг/төг/
1	2020	29	494.5	4	68.9
2	2021 эхний хагас жил	15	871.1	4	72.1
	<b>НИЙТ</b>	<b>44</b>	<b>1365.6</b>	<b>8</b>	<b>141.0</b>

**Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороо ажилласан байдал**

Хүснэгт 8.12


№	Нэр	Хэмжих нэгж	Тоо
1	Үнэлгээний хорооны тушаал	ширхэг	16
2	Цахим тендер	ширхэг	8
3	Уламжлалт тендер шалгаруулалт	ширхэг	5
4	Зарлаагүй тендер	ширхэг	3
5	Амжилтгүй тендер	ширхэг	1
6	Шууд гэрээ	ширхэг	2



## ЗАСВАРЫН АЖЛУУДААС:



*Засварын өмнө*



*Засварын дараа*  
**Зураг 8.5. Хичээлийн I байрны төв шат засвар**



*Засварын өмнө*



*Засварын дараа*

***Зураг 8.6. Хичээлийн 2 дугаар байрны спорт заалны засвар***

*тохижилтын ажил*



*Засварын өмнө*




*Засварын дараа*

**Зураг 8.7.Хичээлийн II байрны спорт заалны агуулахын засвар**



*Засварын өмнө*



*Засварын дараа*

***Зураг 8.8. Оюутны "Student Lounge" чөлөөт бүс байгуулах***



*Засварын өмнө*



*Засварын дараа*

**Зураг 8.9. Оюутны 3 дугаар байрны нийтийн шүршүүр**



*Засварын өмнө*



*Засварын дараа*

**Зураг 8.10. Хичээлийн II байрын В1 давхрын ариун цэврийн өрөө**



### 8.7.2. Өмч хөрөнгийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай өмчийг эзэмшүүлэх гэрээ-2018 байгуулж, өмнөх Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хавсралт мэдээлэл, тайланг хянаж, нэгтгэн 2020 онд 95 онооны үнэлгээтэйгээр дүгнүүллээ. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн өмчийн программын ашиглалт, цахимд оруулсан мэдээллийн иж бүрдлийг хянаж шалган, уг мэдээллийг үндэслэн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж баталгаажуулсан.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дүгээр тушаалын дагуу жил бүр тайлагнадаг төрийн өмчийн мэдээллийн болон захиргааны статистикийн мэдээ, тайлангуудыг жил бүр цаг хугацаанд нь бүрэн хүргүүлэн ажиллалаа. Жил бүр жилийн эцсийн тооллогын дүнгээрх актлагдах хөрөнгийн жагсаалтыг нэгтгэж хянан, ШУТИС-ийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох дээд газруудад хандаж, үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрлийг авч, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн.

#### Акталж, данснаас хассан үндсэн хөрөнгө (сая.төг)

Хүснэгт 8.13

Үзүүлэлт	2020 он	2021 оны эхний хагас жилд
Акталж, данснаас хассан үндсэн хөрөнгө	2,026.2	985.8

2020 оны ТӨБЗГ-тай хийсэн түрээсийн гуравласан гэрээний дагуу бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 12 хувь хүн, албан байгууллагын түрээсэлсэн нийт 477 м2 талбайн байгуулсан гэрээний биелэлтийг хянаж, түрээсийн төлбөрийн тооцоог хянан баталгаажуулж, ТӨБЗГ-тай тооцоо нийлсэн акт үйлдэж ажилласан. Цар тахлын улмаас цайны газрууд болон хичээлийн байран дах 9 түрээслэгч ажиллаагүй.

#### Түрээсийн орлого (мян.төг)

Хүснэгт 8.14

Үзүүлэлт	2020 он	2021 оны эхний хагас жил
Түрээсийн орлого / шимтгэл хассан/	78,103.10	65,003.4
ТӨБЗГ-т төвлөрүүлсэн / 40 хувь/	67,215.0	29,447.0





Сургууль хооронд шилжих хөрөнгийн хөдөлгөөнийг ШУТИС-ийн захирлын тушаалаар тухай бүр шуурхай шийдвэрлэв. 2020 оны жилийн эцэст 37,2 сая төгрөгийн, 2021 оны эхний хагас жилд 103,4 сая төгрөгийн хөрөнгө тус тус шилжсэн байна.

### **8.7.3. Газрын бүртгэлийн талаар хийгдсэн ажлууд**

БАС- Дадлагын полигоны газар, Захиргаа- Баянголын амын газруудын улсын бүртгэлийн Э дугаар авсан. Одоогоор доорх газруудад доорх шалтгааны улмаас Э дугаар аваагүй байна. Үүнд:

- БУХС- газрын хэмжээг нэмэх хүсэлт өгсөн боловч нэмэгдүүлэх талбайг хариуцах газрын алба бусдын эзэмшилд өгсөн.
- Оюутны 2-р байрны газар: Барилга үл хөдлөх хөрөнгө байхгүй.
- Оюутны 4-р байрны газар: Үнэлгээнд ороогүй тул.
- МехТС-ийн авто дром: Цахилгааны өндөр хүчдэлийн дор байрласан.

Мөн Хэнтий аймагт байрлах БАС-ийн Хэрлэн дахь дадлагын полигоны газар /60000м<sup>2</sup>/, Налайх дүүрэг, Горхи тэрэлжийн газрын /180000м<sup>2</sup>/, Баянзүрх дүүрэгт байрлах Оюутны 2 дугаар байрны газрын /1517 м<sup>2</sup>-ээр нэмсэн/ хэмжээг тус тус нэмэгдүүлэн, баримт бичгийг баталгаажуулсан. Сонгинохайрхан дүүрэгт байрлах Баянголын амын 1 гэрчилгээ 2 кадастр бүхий 2 тусдаа газрын гэрчилгээг салган, тус бүрд нь баримт бичгийг баталгаажуулж, хүчинтэй хугацааг сунгуулсан зэрэг ажлууд хийгдээд байна.

### **8.7.4. Сургалтын төлбөрийн болон бусад авлагыг багасгах тал дээрх ажлыг эрчимжүүлж бүрдэлдэхүүн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.**

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болж гэрээ байгуулагдаж уг гэрээ нь шүүхийн захирамжаар баталгаажиг байна. 2020 онд 613 өргөдөлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэж, 72.9 сая төгрөг бүхий маргааныг шүүхийн эвлэрүүлэн зуучлалаар гэрээ байгуулж, 48.4 сая төгрөг төлөгдсөн. 2020 онд 17 хүний 13.7 сая төгрөгийн нэхэмжлэл гаргаж, 6.7 сая төгрөг төлөгдсөн. ШУТИС хариуцагчаар татагдаж, 6.2 сая төгрөг нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн.

2020 онд 24 худалдан авах ажиллагааны гэрээ боловсруулж, бакалаврын оюутны суралцах гэрээнд нэмэлт өөрчлөлт орууллаа.



Тайлант онуудад Удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан жил жилийн хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажилладаг.

## **8.8. БАЙР АШИГЛАЛТЫН ТАЛААР**

2020-2021 оны хичээлийн жилд байр ашиглалтын нэгдсэн алба нь Дээд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд, коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комисс болон төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан тогтоол, тушаал, стандарт, ШУТИС-ийн дүрэм, журмуудыг мөрдөн ажиллалаа.

ШУТИС-ийн барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийлгэх, хяналт тавих, орчны /гадаад, дотоод/ тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах, хичээлийн болон оюутны байруудын дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай зарцуулах, түрээслэгчдийн түрээсийн гэрээний биелэлтэд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

### **8.8.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний чиглэлээр**

“ШУТИС-ийн хамтын гэрээ”-ний өөрийн үйл ажиллагааны холбогдох бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтийг зохих төвшинд хангуулахад анхаарч ажиллалаа. Бүрэлдэхүүн сургууль, эрүүл мэндийн төвтэй хамтран цар тахлаас (КОВИД-19) урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах чиглэлээр орчны эрүүл ахуйг сайжруулах, гар халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, халдваргүйжүүлэлтийг хийлгэх, зөвлөгөө мэдээллээр хангах, биеийн халууныг хэмжих нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. Үйлчлэгч нарт ариутгах, халдваргүйжүүлэх цэвэрлэгээний бодис материалыг зөв хэрэглэх дадал олгох сургалтыг явуулав. Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг үйлчилгээний ажилчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтийг хангуулж ажиллаа. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж



“Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж мөрдөн ажиллалаа.

### **8.8.2. Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын талаар**

Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон халаах хэрэгслийн хаалт винтель, сгон контур, муфьтийг шинэчлэн солилоо.

Хичээлийн I,II,III,VIII байр орчмын гадна ариутгах татуургын 250 гаруй у/м шугамыг улирал тутам угаах, 16ш худгийг лайдах ажлыг хийлээ.

Эрчим хүчний хэрэглээнд судалгаа, тооцоо хийж эрчим хүч хэмнэх “Эрчим хүч хэмнэлт” төсөл боловсруулж захирлын зөвлөлөөр батлууллаа.

ШУТТНС, хичээлийн II,VIII байрны нийт 9ш цахилгаан шатны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан техникийн үзлэг, үйлчилгээг гэрээт байгууллагаар хийлгэж гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллав. Лифтний ээлжит магадлалыг Улаанбаатар НӨҮГ-аар хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгах талаар гэрээт байгууллагатай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хичээлийн I,II,III,IV,V,VIII байр, ШУТТНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, лавлагаа мэдээлэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллаа. Оюутны байруудын хяналтын камеруудыг шинэчлэх, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хичээлийн болон оюутны байрнуудын цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан, цахилгаан системийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цахилгааны 28ш ерөнхий, 74ш групп щитэнд техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Тайлант онд разетка, унтраалга, гэрэл солих, цахилгаан хэрэгсэл суурилуулах, тэжээл татах, сургуулийн гадна орчинд зохиогддог арга хэмжээний үеэр цахилгаан тэжээл татах зэрэг ажлуудыг ямар нэг гомдол чирэгдэлгүй гүйцэтгэж ажилласан байна.

“Соргог” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн Дорнод монгол секьюрити байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна. Харуулын албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулан холбогдох үүрэг чиглэлийг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.



Хичээлийн I, II, III байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг гаргаж, автомашин нэвтрүүлэх зөвшөөрлийг шинэчлэн автомашин эзэмшигчдэд олгож зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав. Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.


**8.8.3. Тайлант онд Удирдах зөвлөлийн 2020 оны 16 тоот тогтоолоор батлагдсан 2021 оны хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллалаа.**

#### **8.8.4. Оюутны байр ашиглалт**

2020-2021 оны хичээлийн жилд оюутны 4 байранд 943 оюутан хүлээн авч тав тухтай сурч, амьдрах орчныг бүрдүүлэв.


Тус хичээлийн жилд оюутнууд оюутны байранд амьдрахтай холбоотой харилцааг зохицуулах журмыг шинэчлэн боловсруулж, захирлын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/18 тоот тушаалаар баталгаажууллаа.

Мөн оюутныг оюутны байранд хүлээн авах бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж 2021-2022 оны хичээлийн жилээс мөрдөн ажиллах бэлтгэлийг хангаж ажиллав (зураг 8.11 ба зураг 8.12).



- ШУТИС-ийн оюутны 1-р байр
- ШУТИС-ийн оюутны 3-р байр
- ШУТИС-ийн оюутны 4-р байр
- ШУТИС-ийн оюутны 5-р байр

**Зураг 8.11. Оюутны байрнуудын оюутны судалгаа**



**Зураг 8.12. Оюутны байранд амьдардаг оюутнууд  
(аймгуудаар)**

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед БШУЯ, УОК-ын гаргасан шийдвэрт нийцүүлэн оюутны байранд амьдарч байгаа оюутнуудад хөл хорио тогтоох, хоол хүнсээр хангах, халдвар хамгааллын дэглэмийг өндөр түвшинд баримтлан орон нутаг буцаах ажлыг зохион байгуулсан.

Оюутны I байрыг УОК-ын шийдвэрээр “Тусгаарлах байр” болгон ашиглах бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Оюутнууд орон нутаг буцаж байрны төлбөрийн буцаан олголт хийгдсэнтэй холбогдуулан оюутны байрны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 325,4 сая төгрөгийн зардлыг захирлын 2021 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн А/96 тоот тушаалаар “Төвлөрсөн сан”-аас гаргаж зохицуулалт хийв.

